Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар
2025 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ 2019-03-27 Дугаар 2023_10	8.5.. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн[4] 6.2-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг Засгийн газар, мөн хуулийн 6.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.3-т заасан холбогдох зөвшөөрлийг олгоход тус хуулиар шууд тогтоосон хураамжийн хэмжээг нэгмөр мөрдөн ажиллаж байна. Харин хуульд сонгох боломжтой тогтоосон хураамжийн хэмжээг хуульд заасан бага хэмжээ /үнийн дүн/-гээр мөрдөн ажиллаж байгаа тул тусгайлан эрх бүхий байгууллагаас хураамжийн хэмжээ тогтоосон шийдвэр гаргаагүй байна.	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	
2	2	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 2021-07-07 Дугаар 2021.07.07	9.18. Аймаг, нийслэлийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах бол Санхүүгийн зохицуулах хороонд хялбаршуулсан журмаар бүртгүүлэх бөгөөд үүнтэй холбоотой журмыг Хороо батална.	Орхон аймаг нь орон нутгийн үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд үнэт цаас гаргахаар Засгийн газраас дэмжигдсэн даруйд журмын дагуу бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.	Х.Б	Х.Б	
УИХ-ын тогтоол							
3	3	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга	1.2/. Монгол орны болон Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилт, цаашдын төлөв байдал, аюулын үнэлгээний судалгаа болон мониторингийн ажлыг өргөжүүлж	Одон орон геофизикийн хүрээлэнгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2016-2017 онуудад тус аймагт судалгаа шинжилгээг хийж 2018 онд Одон орон геофизикийн хүрээлэнгийн мэргэжилтнүүд ирж Орхон аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалыг гарган хүлээлгэн өгсөн. 2025 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн хурлын шийдвэрээр Баян-Өндөр, Жаргалант сумдад газар хөдлөлтийн чичирхийллийг бүртгэх, мэдээлэх	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	эрчимжүүлэх, томоохон хот, суурин газрын газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг хийж гүйцэтгэх;	тоног төхөөрөмжийг авч байрлуулах шийдвэр гарсны дагуу аймгийн Засаг даргын 2025 оны А/186 дугаар захирамжаар төсвийг шийдвэрлүүлэн тус төхөөрөмжийг авч Одон орон геофизикийн хүрээлэнтэй байгуулсан гэрээний дагуу төхөөрөмж байрлуулах газрыг сонгон байршуулсан. Ингэснээр аймгийн хэмжээнд 3 төхөөрөмжөөр газар хөдлөлтийн чичирхийлэлтийг бүртгэх боломж бүрдсэн. Тус систем нь цахилгаан тасрахад 24 цагийн турш ажиллах чадвартай, RG45 сүлжээний кабелаар мэдээллээ дамжуулах боломжтой бөгөөд олон улсад хэрэглэгдэж байгаа Seedlink протоколыг дэмжиж ажилладаг. Одон орон геофизикийн хүрээлэнгийн мэдээлэл хүлээж авах дотоод сүлжээнд VPN төхөөрөмжөөр мэдээллээ шууд дамжуулдаг. Хавсралт : 1 файл			
	4		1.5/. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;	Монгол улсын Шадар сайдын 2018 оны 78 дугаар тушаалд заасныг үндэслэн Орхон аймгийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа бүх төрлийн барилга, байгууламжуудыг паспортжуулах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус паспортжуулах зөвлөлийг 2018 онд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Паспортжуулалтыг барилгын үйл ажиллагаа явуулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж ашиглагдаж байгаа барилга, байгууламжийг тодорхой үнэ тарифаар барилга, сан техник, цахилгаан, холбоонд үзлэг хийж паспорт олгосон. Шинээр баригдсан барилгад ногоон, засвар шинэчлэл хийсэн цаашид ашиглах боломжтой барилгад шар, ашиглалтын шаардлага хангахгүй барилгад улаан гэсэн ангиллаар нийт 71 барилгад ногоон гэрчилгээг олгоод байна. Аймгийн хэмжээнд байгаа барилга байгууламжийн ашиглалтын байдалд иргэдийн өргөдөл гомдлын дагуу 37 орон сууцны барилга болон бусад барилгуудад үзлэг шалгалт хийж 14 дүгнэлт, 5 албан бичиг хүргүүлсэн. Үүний дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар 15 барилгын ашиглалтыг сайжруулсан. 2025 онд барилгын ашиглалтын төлөв байдалд дүгнэлт гаргуулах, паспортжуулах зөвлөх үйлчилгээг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн барилгын материалын судалгааны төвөөр гүйцэтгүүлэх ажлыг хэрэгжүүлснээр 2	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				сургууль, 3 цэцэрлэгийн барилга байгууламжид ашиглалтын төлөв байдлыг тогтоох паспортжуулах ажлыг хийлгэсэн. Болзошгүй аваарын зардлаар хамар хана, шаланд суулт үүссэн 26-р цэцэрлэгийн барилгад хүчитгэл хийх ажлыг улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн засварлах ажлын зураг төслийг гаргуулж хүчитгэл хийлгэх ажлыг Мөнгөн орхон Хавсралт : 2 файл			
	5		1.3. Газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах.	Гамшигт тэсвэртэй хотууд төслийн хүрээнд аймгийн хэмжээнд суурилагдсан нийт 12 гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дуут дохионуудыг нэгдсэн удирдлагын радио системийг 2022 оноос суурилуулан ашиглаж байна. Энэ нь цаг хугацаа алдалгүй гамшгийн аюулыг иргэдэд эрт зарлан мэдээлэх боломж бүрдэж байгаагаараа ач холбогдолтой төдийгүй улсын хэмжээнд радио системээр холбогдсон анхны аймаг болсон. Мөн гамшгаас хамгаалах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн тоног төхөөрөмжүүдэд хэт богино долгионы радио станцууд иридиум утас, нисдэг камер буюу дрон (MAVIC2), бүс нутгийн хэмжээнд яаралтай шуурхай цахим хурал зохион байгуулах орчин үеийн дэлгэцийн өргөтгөл зэргийг хийсэн. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн даргаар 2025 оны "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан, хэрэгжүүлэн ажилласнаар 97.9 хувийн хэрэгжилттэй байа. Орхон аймгийн төв Эрдэнэт хотыг хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг Нью урбанизм ХХК гүйцэтгэж байгаа ба ажил 35 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.Одоогийн байдлаар орон нутагт төрийн байгууллагуудтай уулзаж санал авч, Эрдэнэт хотын байрзүйн геодезийн зураглалын алдааг засаж шинэчлэн хийх, бүс нутгийн асуудлаар Булган аймагтай санал солилцож хөрш зэргэлдээх сумдын суурьшлын бүс эдийн засгийг тэлж хамтран ажиллах санал гарсны дагуу хотын баруун талыг дулаанаар хангах Дулааны станцын байршил нь Булган аймгийн Орхон сумын Халиун багт байхаар тооцоологдон Дулааны станцыг байршлын талаар аймгийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 10-р сард Булган аймгийн Орхон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай хэлэлцээр хийснээр Булган аймгийн Орхон сумаас дараагийн уулзалтыг зохион байгуулах зэрэг судалгааны ажлууд хийгдэж байна. Хавсралт : 1 файл			
4	6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.10.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг хөгжүүлэх төвүүдийг аймаг, дүүрэгт байгуулах;	Орхон аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүдэд тусгайлан зориулсан хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, сэтгэл засал, сэргээн засах, нийгмийн хөгжлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хөгжлийн цогц төв байгуулахаар 2024 онд 8.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн зураг,төсвийг "ЭМ ЭМ ЭЛ" ХХК-иар гүйцэтгүүлж Барилгын хөгжлийн төвд 2024 оны 07 дүгээр сарын 26-ны өдрийн 1272/2024 дугаар магадлалын дүгнэлт гаргуулсан. Улсын төсөвт тусгуулахаар 2025, 2026 онд санал өгсөн боловч хасагдсан. Барилгыг барих газрыг Орхон аймгийн Засаг даргын захирамж 2024 оны А/36 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Нэгдсэн хөгжлийн төв байхгүй хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залууст, иргэдэд чиглэсэн сэргээн засалтын болон хөгжүүлэх үйлчилгээг 7 ТББ-д гэрээлэн гүйцэтгүүлж орон нутгийн төсвөөс 347.5 сая төгрөгийг зарцуулж 180 гаруй хүүхэд, залуусын нийгмийн идэвх оролцоог хангах, сэргээн засалт, хөгжлийн үйлчилгээг хүргэж байна. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	
5	7	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ	1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны	"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээнээс аймагт хамаарах 18 арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгужлж ажилласнаар 91.1 хувийн хэрэгжилттэйгээр хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан "Катодын зэсийн үйлдвэр" байгуулах ажлын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын захиалгаар "Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлыг "Майнинг Шорт Лонг Терм" ХХК	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2022-11-11 Дугаар 2022 №72	хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	гүйцэтгүүлж, гүйцэтгэгч компани ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. ТЭЗҮ-ээр 109.2 $ буюу 362.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 мян.тн/жил катодын зэс үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай байхаар байна. “Майнинг Шорт Лонг Терм" ХХК-иас "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байдлаар боловсруулсан зураг төслийг дүгнүүлэн гэрээг дуусгавар болгох саналыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т ирүүлсний дагуу тус ажлыг хянаж үзээд "Иж бүрдэл дутуу, төрийн захиргааны холбогдох байгууллагуудаар хянуулан баталгаажуулаагүй зураг төслийг цаашид "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т ашиглах боломжгүй" гэж шийдвэрлэсэн тул 2024 оны 7 дугаар сард гэрээ цуцлах саналыг гүйцэтгэгч компанид хүргүүлсэн. Мөн “Үүсмэл орд”-той холбоотой тус төслийг цаашид “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ санхүүжүүлэх шаардлагатай эсэх талаар “Чиглэл хүсэх тухай” 2024 оны 08 дугаар сарын 16-ны ГЁ-69-12/5420 дүгээр албан бичгийг АҮЭБ-ийн сайдад хүргүүлсэн. Ажлын явц 63.8%-тай байна. Катодын зэсийн үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажлыг "Төгрөг баян хангай" ХХК -тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, БОАЖЯ-ны мэргэжлийн комиссын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Хавсралт : 1 файл			
	8		1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан	Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах чиглэлийг өгч хяналт тавин ажиллаж байна . Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад тусгагдах ажлын ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулсан байхаар тооцон 2025 оны орон нутгийн төсөвт зөвлөх үйлчилгээний зардлын 6.0 тэрбум төгрөгийг тусган ажилласан. 2026 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 3.2 тэрбум төгрөгийн зөвлөх үйлчилгээ тусгагдан батлагдсан байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			тохиолдолд боловсруулах;				
6	9	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59	3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тус бүр авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр зорилт, арга хэмжээг тусгахаас гадна төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг сайжруулах, хүний нөөц, худалдан авах ажиллагааны болон төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн сахилга батыг дээшлүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтад иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Мөн жил бүр аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан харьяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-нд 3 зорилт 16 арга хэмжээг тусган аймгийн Засаг даргаар батлуулж, холбогдох байгууллага /төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд/-уудад хүргүүлэн нэгдсэн удирдлагаар ханган хэрэгжилтийг зохион байгуулж ажилласнаар 93 хувийн хэрэгжилттэй байна. Авлигатай тэмцэх газраас хийсэн 2024 оны шударга байдлын үнэлгээгээр аймгуудын хэмжээнд 9-т эрэмбэлэгдэж дунджаас дээгүүр үнэлгээ авсан. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор өмгөөллийн “Миранда Партнерс” хуулийн фирмтэй хамтран Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар болон багуудын ажлын албаны нийт 250 албан хаагчдад Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын дарга, албан хаагчдыг хамруулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
7	10	МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93	1.2. хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх;	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Уртын гол багт оролгод нийцсэн орон сууцны 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлснээр одоогийн байдлаар 4 блок 100 хувь ашиглалтад орж 17 иргэн түрээсээр, 184 иргэн хөнгөлөлттэй үнээр худалдан авч нийт 201 айл тус орон сууцанд орсон. Тус төслийн хүрээнд Ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөөний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Орлогод нийцсэн орон сууцны үнэ зах зээлийн үнээс 30-40%-иар хямд байна. Мөн орон сууцны 7-р хороололд Төрийн албан хаагчдад хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр 72 айлын орон сууцыг "Хэрлэн зураглал" ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 20 хувьтай явагдаж байна. Цагаанчулуут багт төрийн албан хаагчийн 56 айлын орон сууцыг "Тэнүүн төвөргөөн" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалтаар шинэ суурьшлын бүсүүдэд орон сууцны төслүүд хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант хугацаанд 1327 айлын орон сууц ашиглатад оруулаа. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	11		1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн нэгдүгээр хавсралт, аймгийн Засаг даргын А/580 захирамжаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах байнгын комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл оролцуулан ажиллаж байна. 2025 онд Орон сууц нийтийн дэд бүтцийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах 26 комисс ажиллаж ногоон байгууламжийн болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартын шаардлагыг хангуулж ажилласан. Нийтийн орон сууцны зориулалттай барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх хүртээмжийн үнэлгээний судалгааг хийж цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллэл бүхий судалгааг нэгтгэн гаргасан. Орон	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 232 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг мөрдүүлэх шаардлагыг тавьж хяналт тавин ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
8	12	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_05	1.6. төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.	Аймгийн хэмжээнд "Цахим аймаг" болох зорилт дэвшүүлж "Цахим Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн ЗДТГ-ын дэргэд "Цахим төв"-ийг шинээр ашиглалтад оруулж төрийн 215 үйлчилгээг 24/7 цагийн турш үзүүлж байна. "Цахим төв"-өөс иргэн, хуулийн этгээд 16 төрлийн 37 үйлчилгээ, "E-Mongolia"- Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс 73 төрлийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаас 9 төрлийн 72 үйлчилгээг үзүүлж байна. Төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, хүнд сурталгүйгээр иргэд олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор Баян-Өндөр, Жаргалант суманд E-Mongolia төвийг 2021 оноос ажиллуулж байна. 2024 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд аймгийн алслагдсан гэр хорооллын үйлчилгээний нэгдсэн төвийн нэг давхарт иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулан хүргэх зорилгоор "Хурдан" төвийн байр талбайг тохижуулан байгуулж шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр ханган шинэ төвийг нээн ажиллуулсан. Баян-Өндөр сумын захын бүсийн иргэд Төрийн мэдээллийг "Хурдан" төвөөр дамжуулан 86 байгууллагын 1173 төрлийн лавлагаа тодорхойлолтыг холбогдох Төрийн байгууллага дээр очихгүйгээр хурдан шуурхай чирэгдэлгүйгээр авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн 2024 онд И-Монгол лавлагааны киоск машин 3 ширхгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авч Жаргалант сум, Баян-Өндөр сумын ЗДТГ, Гэр хорооллын нэгдсэн байрны ХурДан төвийн үйлчилгээний хэсэгт тус тус байршуулан хэвийн үйл ажиллагааг ханган лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Мөн 2025 онд хүн ам ихээр төвлөрдөг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт үйлдвэрийн АБК цех, аймгийн Автотээврийн төв болон Баян-Өндөр сумын Дэнж, Оюут багт шинээр багийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				байр ашиглалтад орсонтой холбогдуулан төрийн цахим үйлчилгээний маншинуудыг шинээр 10 цэгт нэмж байршуулсан. 2025 онд аймгийн хэмжээнд ажиллаж буй Хурдан төвүүдээс нийт 35030 иргэн, төрийн үйлчилгээний цахим төвөөр 78550 иргэн үйлчлүүлж үйлчилгээ авсан байна. Хавсралт : 1 файл			
9	13	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024-01-17 Дугаар 2024_11	1.2. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авах.	Аймгийн хэмжээнд төрийн 30 байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний нэгдсэн судалгааг 2 удаа гаргалаа. Судалгаагаар нийт 406 төрлийн үйлчилгээг үзүүлж байгаагаас төлбөр хураамжгүй 237, төлбөр хураамж бүхий 169 үйлчилгээ үзүүлж байгаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
10	14	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг өгч арга зүйн удирдлагаар ханган 72 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 305 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулах үеэр Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах салбар хэлэлцүүлгийг хийн Орхон, Булган, Хөвсгөл аймгийн нийт 100 төрийн албан хаагчийг хамруулсан. Үүнд Орхон аймгаас төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын төлөөлөл болох 30 төрийн албан хаагч болон Ёс зүйн хорооны дарга, ажлын албаны хамт олон оролцож ёс зүйн гомдол мэдээллийг шалган шийдвэрлэх, ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, ёс зүйн цахим санг ашиглах талаар мэдээллээр хангагдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчиддаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Монгол улсын Ёс зүйн хороотой холбогдож ёс зүйн цахим системд бүртгэлээ үүсгээгүй гэх 23 байгууллагын мэдээлийг авч тухайн байгууллагуудад цахим системд бүртгэл үүсгэн ёс зүйн зөрчлийн мэдээ, хийх ажлын төлөвлөгөө, тайлан зэргийг оруулж ажиллах үүрэг чиглэлийг өгч хяналт тавин ажилласнаар одоогийн байдлаар 9 байгууллага цахим бүртгэлээ үүсгээгүй байна. Хавсралт : 5 файл			
11	15	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37	2.а. а/бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;	Тайлант хугацаанд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчны стандартын чиглэлээр Боловсролын ерөнхий газраас ирүүлсэн удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу 2025 оны 03 дугаар сард политехник коллежид сурагч, багш, түншлэгч байгууллагын төлөөлөл 3, 05 дугаар сард 24 ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд сурагч, эцэг эх, багш, Боловсролын газрын арга зүйчийн төлөөлөл бүхий 68, нийт 71 иргэн сургалтын байгууллагын орчны байдалд үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүнгээр I түвшинд 9 сургууль буюу нийт сургуулийн 53%, II түвшинд 6 сургууль буюу нийт сургуулийн 35%, III түвшинд 1 сургууль буюу нийт сургуулийн 6% нь тус тус үнэлэгдсэн байна. Төрийн болон хувийн хэвшлийн 24 сургууль, 2 дотуур байранд 2025-2026 оны хичээлийн жил эхлэхээс өмнө гадаад болон дотоод орчны эрсдэлийн үнэлгээг хийж зөрчлийг арилгаж, эрсдэлийг бууруулсан. Ингэснээр Боловсролын ерөнхий газраас ирүүлсэн удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу ерөнхий боловсролын 21 сургууль, 1 дотуур байр орчны эрсдэлийн үнэлгээгээр бүгд бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Эрсдэлийн үнэлгээгээр илрүүлсэн зөрчлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг эрэмбэлж, эрсдэлийг бууруулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	16		2.б. б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;	Аймгийн хэмжээнд 1,2,6,7,8,13,17,18,20 дугаар сургуулиудад "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-ыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан. 2025 онд шинээр 2 сургуульд тус танхимыг байгуулахаар орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөг тусгагдаж 3,5 дугаар сургуулиудад байгуулагдсан байна. Эдгээр төвүүдэд ажиллах багш нарын цалин, урамшуулал, чадавхижуулах үйл ажиллагаа, хөгжлийн ялгаатай хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр 2025 оны орон нутгийн төсөвт 50.0 сая төгрөг батлагдсан бөгөөд зардлыг аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ны А/397 дугаар захирамжаар шийдвэрлэж Боловсролын газарт шилжүүлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	17		3.в. в/аймаг, дүүрэг бүрд байгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.	Нийгмийн халамжийн сангаас 16 хүртэлх насны байгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох тэтгэмж нийт 504 хүүхдэд 1.7 тэрбум төгрөгийн тэтгэмжийг олгосон. Засгийн газрын 247 дугаар тогтоолын дагуу хүнд хэлбэрийн болон хавсарсан оноштой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалж байгаа асран хамгаалагч нарт олгох асаргааны тэтгэмжийн хэмжээ 30 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан 189 хүүхдийн асран хамгаалагч нарт 1-5 сарын зөрүү нэмэгдэл болох 134.6 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас нөхөн олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Гэрэл, Найдвар, Сорхугтани, Пондолдой зэрэг нийт 4 төвтэй 233.2 сая төгрөгийн гэрээ байгуулан, нийгэмшүүлэх, өдөр өнжүүлэх, сэргээн засах үйлчилгээнүүдийг хүргэж байна. Эдгээр төвүүдэд нийт 15 багш, ажилтнууд ажиллаж нийт 80 гаруй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхэд, залууст төрийн үйлчилгээг гэрээгээр үзүүлж байна. 2025 онд нийт 35 төрлийн арга хэмжээнд хүүхэд, залуус, асран хамгаалагчид, албан хаагчид зэрэг 600 гаруй хүнийг оролцуулан зохион	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				байгуулсан Аймгийн хэмжээнд 1,2,6,7,8,13,17,18,20 дугаар сургуулиудад "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-ыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан. 2025 онд шинээр 2 сургуульд тус танхимыг байгуулахаар орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөг тусгагдаж худалдан авах ажиллагаа хийгдсэн байна. Эдгээр төвүүдэд ажиллах багш нарын цалин, урамшуулал, чадавхижуулах үйл ажиллагаа, хөгжлийн ялгаатай хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр 2025 оны орон нутгийн төсөвт 50.0 сая төгрөг батлагдсан бөгөөд зардлыг аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ны А/397 дугаар захирамжаар шийдвэрлэж Боловсролын газарт шилжүүлж сургалт, уулзалт, туршлага судлах, зөвлөгөөн зохион байгуулах, илтгэлийн уралдаан, зөвлөн туслах үйлчилгээ, явуулын багш зэрэг нийт 20 гаруй удаагийн ажлуудыг зохион байгуулсан. Хавсралт : 1 файл			
12	18	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2024-08-27 Дугаар 2024_21	2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхэд шаардлагтай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн аймгийн 2026-2030 оны үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг тусган боловсрууллаа. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 103 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэгчээр хэрэгжүүлж 2025 оны байдлаар 83.7 хувийн хэрэгжилттэйгээр тайлагналаа. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	19		2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан аймагт хамаарах 103 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэгчээр хэрэгжүүлж 2025 оны байдлаар тайланг нэгтгэн гаргаж хяналт-шинжилгээ хийж 83.7 хувийн хэрэгжилттэйгээр тайлагналаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Хавсралт : 1 файл			
13	20	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-06-05 Дугаар 2025 №53	1.3/. 3/агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсийг тодорхойлж, тухайн бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх;	Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журмыг БОАЖ-ын сайд, аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/441/ А/724 дугаар тушаал, захирамжаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Агаарын чанарын үнэлгээгээр Булаг, Баянбулаг, Цагаанчулуут, Наран Рашаант, Шанд, Даваат, Яргуйт, Их залуу, Уртын гол багийн 11575 өрх, 259 аж ахуйн нэгж агаарын чанарыг сайжруулах 1 дүгээр бүсэд хамрагдаж байна. Сургууль, цэцэрлэг орчмын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр НҮБ-ын Хүүхдийн Сангийн "Барилгын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах" төслийн хүрээнд Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх нийт 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийн ажил хийгдэж, төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллан туршилт тохируулгын ажил явагдаж байна. Туршилт тохируулгын үеэр уурын зуухны галлагаа хийгдээгүй ба Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн халааж байна. Тайлант хугацаанд орчны агаарын чанарыг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэгүүдийн анги танхим, заал, өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн коридорт нүүрстөрөгч шингээж хүчилтөрөгч ялгаруулдаг цэцэгт болон модлог тасалгааны ургамлыг барйлуулж усалгаа, арчилгааг тогтмол хийж байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсээр сургуулиудын дотоод агаарын чанарын хэмжилтүүдийг хийлгэж, тус үйлдвэрээс бохирдолттой хэмжигдсэн 2-р сургууль, 24-р цэцэрлэгийн бүх цонхонд нано шүүлтүүрийг байрлуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
	21		1.6/. 6/агаарын бохирдлын талаарх мэдээллийг өдөр тутам олон нийтэд тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, (олон нийтийн радио, телевизийн цаг агаарын мэдээтэй хамтатган Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн агаарын бохирдлын хэмжээг мэдээлэх) зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх;	Аймгийн агаарын чанарыг хотын төв болон гэр хороолол орчмоос хүхрийн давхар исэл 1218 удаагийн давталттай, азотын давхар исэл 1218 удаагийн давталттайгаар сорьц авч хяналт-шинжилгээ хийж, агаарын чанарын тайлан мэдээг https://orkhon.weather.gov.mn/ сайт, orkhon.namem.gov.mn сайт, и-оффис систем, Орхон аймгийн Ус цаг уур орны шинжилгээний төв facebook пэйж хуудсаар аж ахуйн нэгж, ард иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн Эрдэнэт хотын хэмжээнд Говил багийн нутаг дэвсгэрт болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн далан дээр суурилуулсан тоосны автомат 2 станцын хэмжилтийн дүн мэдээг www.Agaar.mn-д сайтад 7 хоног тутамд мэдээлж ирсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
14	22	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зоригоор аймгийн Засаг даргын А/363 захирамжаар "Хүүхэд-Хайр-Ирээдүй" уриан дор "Бүх хайраа гэр бүлдээ" сарын аяныг зохион байгуулж орон нутгийн төсвөөс 23.6 сая төгрөгийг зарцуулан төрийн болон төрийн бус 20 байгууллагатай хамтран 7 арга хэмжээг зохион байгуулж нийт 11056 гаруй иргэнийг хамруууллаа. Үүнд: "Өглөөний эвент" сургалтыг 12 удаа зохион байгуулж 480 гаруй гэр бүл оролцож гэр бүлийн эерэг харилцаа, заавал хэвшүүлэх 8 дадал арга зүйг суралцсан. Насан туршийн боловсролын төвтэй хамтран байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг зохион байгуулж 604 иргэнийг хамруулсан. Мөн жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг төрийн болон төрийн өмчит 13 байгууллагатай хамтран "Супер аав", "Зоригтой хайр", "Ээж охидын болзоо" уулзалтууд, гэр бүлийн өдөрлөг, сэтгэлзүйн өдөрлөг, "Өглөөний эвент" уулзалтуудыг хийж 62 удаагийн сургалт, нөлөөллийн арга	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	хэмжээг зохион байгуулж, 15000 иргэн, 5000 гаруй өрх хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад сургалтад хамрагдсан иргэдийн тоо 100 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах зорилгоор түүвэр судалгаагаар нийт гэр бүлийн 1.2 хувь буюу 361 өрхийг хамруулан гэр бүлийн суурь судалгааг явуулж, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээний хэрэгцээг үнэлэн салбар дундын оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Бүх хайраа гэр бүлдээ" зорилтот төслийг боловсруулан батлуулж хэрэгжүүлж эхлээд байна. Цагдаагийн газартай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор цахим орчин дахь хүчирхийлэл, хорт зуршил, "Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй", "Үе тэнгийн дээрэлхэлт түүний хор нөлөө", "Харах өнцөгтэй хайр нэмье" зэрэг сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан нийт 815 сурагчийг хамруулж дээрэлхэлт, хүчирхийллийн үр дагавар, нөлөөллийг ухааруулсан арга хэмжээ болсон. Хавсралт : 2 файл			
15	23	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26 №01 ИЦББХ	3. Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах	Боловсролын байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, судалгааг 2 удаа гаргасны дагуу боловсролын байгууллагуудын сүлжээ хариуцсан ажилтнуудыг 2 удаагийн сургалтад хамруулж, 22 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Мөн "Мобинэт" ХХК-тай хамтран ажиллаж, тус компаний интернэтийн үйлчилгээг ерөнхий боловсролын 17 сургуульд нэвтрүүлж 100% утасгүй интернэтийн орчин бүрдүүлсэн. Үүний үр дүнд тайлант хугацаанд зохион байгуулагдсан гүйцэтгэлийн үнэлгээ, "ПИСА" үнэлгээнүүдийг цахимаар ямар нэгэн хүндрэлгүй амжилттай зохион байгуулсан. Мөн 100-тай свичийг тус бүр 1.0 сая төгрөгийн үнэтэй 1000-тай свичээр сольж, ашиглалтын хугацаа дууссан шилэн кабелийн баганаудаар татагдсан шилэн кабелийг сувагчлалаар болон шинээр суурилагдсан холбооны бетонон баганаар шилжүүлэн татаж төрийн өмчийн ерөнхий боловсролын 17 сургуулиудын цахим сургалтын дэд бүтцийн бэлэн байдлыг хангасан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

16	24	Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ	1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;	Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх 3, мах, махан бүтээгдэхүүний 8 үйлдвэр ажиллаж байна. Энэ онд мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 1 аж ахуйн нэгжийн хүсэлтээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөх болон гадаад оронд экспортлоход нь дэмжлэг үзүүлсэн. 2025 онд мах экспортлох эрх бүхий 3 махны үйлдвэр үйл ажиллагаа явуулж, 116 тн үхрийн мах, 1720 тн хонины мах, 9250 тн адуу, нийт 110.8 мянган тн махыг Иран, Хятад, Орос улсуудад экспортлоход мах, махан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтаар махан бүтээгдэхүүнд тавих шаардлагыг хангуулан ажилласан. Мал төхөөрөх, мах боловсруулах 3 үйлдвэр, малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг 2 худалдааны төв, махны төрөлжсөн 14 дэлгүүрт хяналт тавьж, зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	25		1.5/. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх;	Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх 3, мах, махан бүтээгдэхүүний 8 үйлдвэр ажиллаж байна. Мал төхөөрөх үйлдвэрүүдийн үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөх болон гадаад оронд экспортлоход нь дэмжлэг үзүүлсэн. Тайлант онд “Эрдэнэт мах маркет” ХХК-ийн үйлдвэрийн 3 нэр төрлийн буюу үхэр, хонь, ямааны хэсэглэж ангилсан бүтээгдэхүүнд "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэг хэрэглэх эрх олгосон. Махны 3 үйлдвэрт техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж, аюулгүйн тэмдэг авах тухай мэдэгдэл хүргүүлснээр "Эрдэнэт мах маркет" ХХК, "Жаргалант мах импекс" ХХК-д үнэлгээ хийж, махны техникийн зохицуулалтын шаардлага хангах үүрэг даалгавар өгч сайжруулалт хийлгэж байна. Мах экспортлох эрх бүхий 3 махны үйлдвэр 2486 тн малын мах бэлтгэн Иран, Хятад, Орос, улсуудад экспортлосон нийт	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				110.8 тн мах экспортлоход Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтаар махан бүтээгдэхүүнд тавих шаардлага”-ыг хангуулан ажилласан. Мал эмнэлгийн ерөнхий газрын улсын ахлах байцаагчийн 2025 оны 08-03-03/180-04 дугаартай "Мал төхөөрөх, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, худалдаалалтад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг мал төхөөрөх, мах боловсруулах 3 үйлдвэр, махны төрөлжсөн 14 дэлгүүрт хяналт шалгалт хийж, 31 зөрчил илрүүлэн газар дээр нь 22 зөрчил арилгуулж, 30 иргэнд зөвлөмж хүргүүлж 10 зөрчилд "Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу 1.5 сая төгрөгийн торгууль ноогдуулсан. Хавсралт : 2 файл			
17	26	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ	1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;	Тайлант хугацаанд төрийн өмчийн 17 сургуулийн 14 сургууль зориулалтын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байранд, 3 сургууль зориулалтын бус засаж тохижуулсан байранд хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулсан. 2025 оны орон нутгийн төсөвт 15 дугаар сургуулийн гал тогооны өргөтгөлийн барилга барихад 282.0 сая төгрөгийг тусган батлуулж, барилгын ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авснаар тус сургуулийн 1500 гаруй сурагч стандартын шаардлага хангасан цайны газарт хооллох боломж бүрдсэн. Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн хоол үйлдвэрлэлийн танхимд дутагдалтай байсан тоног төхөөрөмжийг "Дезерит" ОУБ-ын дэмжлэгээр 5 нэр төрлийн 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна. 2026 оны орон нутгийн төсөвт зориулалтын хоол үйлдвэрлэлийн байргүй 17,18 дугаар сургуулиудын гал тогоог өргөтгөхөд 967.3 сая төгрөгийг батлуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	27		1.10/. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган	Сургууль, цэцэрлэгийн хоолны түүхий эд материалын тендер шалгаруулалт болон шууд худалдан авалтын гэрээг хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичиг, үнийн саналын хамт аймгийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;	Боловсролын газрын дарга баталж, тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2025 онд амжилттай тендер шалгаруулалтаар 29 цэцэрлэг, 14 сургууль, шууд худалдан авалтаар 2 цэцэрлэг, 3 сургууль хүнсний гэрээ байгуулж, 31 цэцэрлэг, 17 сургуульд орон нутгийн аж ахуй нэгж байгууллага хүнсний түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлж байна. Төрийн худалдан авах ажиллагааны ерөнхий гэрээнд шилжих хүсэлт, үндсэн нэр төрлийн түүхий эд бараа бүтээгдэхүүний техникийн шаардлага, үнийн судалгааг гаргаж Боловсролын ерөнхий газарт болон орон нутгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 5 сургууль, 9 цэцэрлэг өөрийн эзэмшлийн хүлэмжид төмс, хүнсний ногоо тариалж хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх хэмжээний нөөц бүрдүүлж байна. Хүүхдийн хоолны түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтад тогтмол хяналт хийснээр эрүүл, аюулгүй хүнсээр үйлчлэх боломж, нөхцөлийг бүрдүүлсэн. Хавсралт : 1 файл			
18	28	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ	1.5/. бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тайлант онд аймгийн хэмжээнд спортын цогцолбор 1, цэнгэлдэх хүрээлэн бүхий гадаа талбай 1, усан бассейн 2, спортын 38 зааланд биеийн тамир, спортын 30 төрлөөр 5000 орчим хүүхэд, залуус, иргэд секц дугуйланд тогтмол хичээллэж байна. Үүнээс биеийн тамир, спортын газрын А, Б заал болон Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд спортын 14 төрлийн секц дугуйланд 800 гаруй хүүхэд, залуус, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг заал талбайгаар ханган ажиллаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд спортын заал 1-ээр, фитнес клуб 1-ээр тус тус нэмэгдүүлж, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг нэмэгдүүлсэн. Спортын А, Б заалны урсгал зардал 163,0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн хүүхэд, залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэхэд заал талбайн үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн Аймгийн Засаг даргын тамгын газрын спорт зааланд 7 хоног бүр 2 багшийн секц дугуйлан, 23 байгууллага тогтмол зааланд хичээллэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
	29		1.6/. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тайлант онд дасгалжуулагч, шүүгч бэлтгэх, арга зүйч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх 19 удаагийн сургалтад 210 албан хаагч, биеийн тамирын багш нарыг хамруулсан. Үүнд - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт болон Биеийн тамир, спортын байгууллагуудын улсын зөвлөгөөнд ад нийт 19 албан хаагч; - Хойд бүсийн эдийн засгийн форумд 8 албан хаагч; -Монголын ахмад мастеруудын нэгдсэн волейболын холбоо Орхон аймгийн Волейболын холбооноос "Волейболын шүүгч бэлтгэх анхан шатны сургалт"-д 9 биеийн тамирын багш, - Сагсан бөмбөгийн В, С зэрэглэлийн дасгалжуулагч, хөл бөмбөгийн шүүгч бэлтгэх сургалтад нийт 38 биеийн тамирын багш; - Спорт холбоодыг чадавхжуулах сургалтад 34 салбар холбоодын удирдах ажилтан; -Анхны тусламж үзүүлэх дадлага олгох, Бие бялдрын түвшин тогтоох аргачлалын сургалтад сургалтад 92 арга зүйч, багш, дасгалжуулагч, - Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан Дархан-Уул аймагт төвийн бүсийн спортын байгууллагуудын биеийн тамирын арга зүйч нарыг чадавхжуулах "Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэв маяг" сэдэвт сургалтад 10 албан хаагч тус тус оролцож туршлага солилцож, мэдлэг мэргэшлээ дээшлүүлсэн байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
19	30	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ	1.5/. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15	Аймгийн хэмжээнд энэ онд нийт 5156 га талбайд тариалалт хийснээс таримлын зохистой сэлгээг нэвтрүүлэх, цулгуй уриншийн хэмжээг бууруулах зорилгоор малын тэжээл 598 га, тосны ургамал 746 га, вандуй 120 га төмс 65 га талбайд тариалан сэлгээнд оруулснаар цулгуй уриншийн хэмжээ 40 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Рапсын тариалалт нийт талбайн 14.1 хувийг эзэлж байна. Энэ онд 598 га талбайд тэжээлийн ургамал тариалж 1007 тонн буюу 16.8 цн/га ургац хураасан. Атар-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран өвөлжөө, хаваржааны бууцны хөлд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	ногоон тэжээл тариалах сургалт зохион байгуулж 112 малчин өрхөд 100 сая төгрөгийн олон наст тэжээлийн ургамлын үр олгосноор 78 га талбайд тариалж 220 тн тэжээл хураан авсан нь тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдүүлсэн. Хавсралт : 1 файл			
	31		1.7/. Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр Алтан ширээгийн Гарн тос боловсруулах үйлдвэрийн дэргэд азотын бордооны, Эрдэнэт үйлдвэрийн зэс хайлуулах үйлдвэрийг түшиглэн фосфорын бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, цаашид хэрэгжилтийг хангаж ажиллах;	Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын дэргэд "Инноваци, технологийн Эрдэнэт төв" байгуулагдан ажиллаж чийгийн улаан хорхой, цаас ашиглан 10 тн бордоо үйлдвэрлэж өөрсдийн хэрэгцээнд гаргасан. Цаашид малын өтөг, бууц, модны навч, дулаан цахилгаан станцын үнс, үртэс зэргийг ашиглан органик бордоо бэлтгэхээр ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	ТЭЗҮ боловсруул агдсан эсэх талаар тодорхой тайлагнах
	32		1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар	Аймгийн хэмжээнд нийт 60.98 га талбайд 20 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж, нийт 24 төрлийн модны 3.0 сая ширхэг тарьц суулгацын нөөц бүрдүүлээд байна. Баян-Өндөр суманд 25 га талбай, Жаргалант суманд 7 га талбайг мод үржүүлгийн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад эзэмшүүлсэн. Тариалангийн талбайн хөрс хамгаалах арга хэмжээний хүрээнд төмөр бетон шонг тариаланчдын эзэмшилд шилжүүлж, ашиглалтын гэрээг 9 аж ахуйн нэгж, 3 иргэнтэй байгуулсан. Үүний үр дүнд 4100 га	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	талбайг хашиж хамгаалан ойн зурвас байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Талын нуур ХХК, Хангарьд Ажнай ХХК нь 30 гаруй мянган ширхэг улиасны суулгац үржүүлж, өөрийн эзэмжлийн тариалангийн зориулалттай талбайд хамгаалалтын зурвас байгуулах бэлтгэл хангасан. Энэ онд 598 га талбайд тэжээлийн ургамал тариалж 1007 тонн ургац хураасан. Атар-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуульстай хамтран өвөлжөө, хаваржааны бууцны хөлд ногоон тэжээл тариалах сургалт зохион байгуулж 112 малчин өрхөд 100.0 сая төгрөгийн олон наст тэжээлийн ургамлын үр олгосноор 78 га талбайд тариалж 220 тн тэжээл хураан авсан нь тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдүүлсэн. Хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн 176.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6*10 м-ийн харьцаатай 50 ширхэг хүлэмж худалдан авч олгох ажлыг зохион байгуулан Жаргалант суманд 29, Баян-Өндөр суманд 21 ширхэг хүлэмжийг иргэдэд олгосон. Үүний үр дүнд хүлэмжийн талбай 3000 м.кв талбайгаар нэмэгдэх боломж бүрдсэн. Аймгийн хэмжээнд нийт 223 иргэн, 6 аж ахуйн нэгж 37.8 мян.м.кв хүлэмжийн талбайд тариалалт эрхэлж 439.6 тн ургац хураан авсан нь хүнсний ногооны нийт ургацад хамгаалагдсан хөрсний ургац 4 хувийг эзэлж байна. Хүлэмжийн аж ахуй эрхлэгч 2 аж ахуйн нэгж, 1 иргэний 1450 м.кв бүхий 3 ширхэг нарлаг хүлэмжид 8.6 сая төгрөгийн цахилгааны хөнгөлөлт үзүүлсэн. Хавсралт : 1 файл			
20	33	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13	1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга	Бусад аймаг орон нутгаас шилжин ирж байгаа болон дамжин өнгөрч байгаа малын хөдөлгөөн, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавьж 2025 онд Мал эмнэлгийн цахим системд нийт 1365 гэрчилгээ бичигдсэн. Үүнээс: Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 987, амьд малын шилжилт хөдөлгөөнд 378 цахим гарал үүслийн гэрчилгээ олгосон. Манай аймгаас бусад аймаг руу адуу 656, үхэр 384, хонь 111, ямаа 867 нийт 2018 мал отор нүүдэл, үржлээр гарч, манай аймагт адуу 390, үхэр 324, ямаа 92, хонь 35 нийт 841 мал бусад аймаг, орон нутгаас шилжин	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		Дугаар 2022 №04 БОХХААБХ	хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах;	ирсэн. Цахим системээр бусад аймаг орон нутгаас шилжин ирж байгаа болон дамжин өнгөрч байгаа малын хөдөлгөөнд, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавьж ажилласнаар хүн амыг эрүүл аюулгүй бүтэгдэхүүнээр хангах нөхцөл бүрдэж, малын халдварт, гоц халдварт өвчнөөр эрүүл тайван байдлыг хадгалж байна. Хорио цээр гарсан тохиолдолд байнгын болон түр хяналтын цэгийг аймгийн Онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу тухай бүрт ажиллуулахаар бэлэн байдал хангасан. Хавсралт : 1 файл			
	34		1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох;	Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шүлхий өвчний дархлаажуулалтад 35.8 мянган толгой мал, амьтан хамруулж гүйцэтгэл 96.4 хувь, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 25.1 мянган бог малын төл хамруулж гүйцэтгэл 100 хувь хэрэгжсэн. Тус ажилд улсын төсвөөс 44.5 сая төгрөг зарцуулсан. Мөн бусад аймаг орон нутгаас шилжин ирж байгаа болон дамжин өнгөрч байгаа малын хөдөлгөөн, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавьж 2025 онд Мал эмнэлгийн цахим системд нийт 1365 гэрчилгээ бичигдсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	35		1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тайлант онд малын тоо толгойн албан татвараар 658 татвар төлөгчийн 74.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөг 281% гүйцэтгэсэн байна. Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах ажлын хүрээнд сумдын ЗДТГ-тай хамтран ажиллаж тус ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгсэлд шаардагдах зардлыг шуурхай шийдвэрлэн ажиллаж, дархлаажуулалттай холбоотой материалыг бүрдүүлж, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргаас үүрэг болгосон. Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд сумдын ЗДТГ-аас нийт 60.0 сая төгрөг зарцуулсан нь малын тоо толгойн албан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				татварын 80.7 хувийг зарцуулсан байна. Хавсралт : 1 файл			
	36		1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 5-6 төрлийн мал амьтны халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 84.8 сая, халдваргүйтгэлийн 4 төрлийн бодис авахад 30.0 сая, нийт 114.0 сая төгрөгийг улсын төсөвт тусгуулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа. Халдваргүйтгэл хийхэд шаардагдах тоног төхөөрөмж, тусгай зориулалтын 1 автомашины бэлэн байдлыг хангаж, ажиллах бие бүрэлдэхүүнийг томилгоожуулсан. Одоогийн байдлаар Мал эмнэлгийн бэлэн байдлын нөөцөд халдвар хамгааллын нэг удаагийн хувцас 700 ширхэг, ариутгалын бодис 160 кг, хлорын шохой 100 кг, новасид 72 литр халдваргүйтгэлийн бодис байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
21	37	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	Орхон аймгийн хэмжээнд ахмадын 2 ордоныг ажиллуулж 2025 онд урсгал зардалд 114.6 сая төгрөг орон нутгийн төсөвт тусган батлуулж зориулалтын дагуу зарцууллаа. Тайлант онд дээрх ахмадын ордоноор давхардсан тоогоор 14000 орчим ахмадууд үйлчлүүлж, тэдний идэвхтэй насжилтыг дэжин ажилласан байна. Мөн Баян-Өндөр суманд байрлах Ахмадын ордоны өрөө тасалгааны зохион байгуулалтыг шинэчлэн нэмэгдүүлж засварлахад орон нутгийн төсвөөс 2.5 сая, төгрөг зарцуулсан. Ахмадын ордон ажиллуулах төдийгүй 17 багийн ахмадын зөвлөл тусдаа өөрийн ажлын байранд үйл ажиллагаа явуулж ахмад настныг дэмжих үйлчилгээг үзүүлж байна. Тайлант онд аймгийн хэмжээнд 29 багийн ахмадын зөвлөлийн дарга нарын урамшууллын зардалд орон нутгийн төсөвт нийт 68.0 сая төгрөгийг батлан, ахмадын зөвлөлийн дарга нарт сар бүр 170.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
22	38	Чиглэл өгөх тухай 2022-06-15	1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг	Аймгийн хэмжээнд энэ онд салбарт 13 аж ахуйн нэгж, байгууллага, 272 өрх нийт 5691 га талбайд тариалалт хийснээс 598 га талбайд малын тэжээл тариалж 1007 тонн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		Дугаар 2022 №07 ҮББХ	нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	ургац хураасан. Мөн Атар-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд өвөлжөө, хаваржааны бууцны хөлд ногоон тэжээл тариалах сургалт зохион байгуулж 112 малчин өрхөд 100.0 сая төгрөгийн олон наст тэжээлийн ургамлын үр олгосноор 78 га талбайд тариалж 220 тн тэжээл хураан авсан нь тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдүүлсэн. Өвлийн улиралд малчид, фермерүүдээс шингэн сүү хүлээн авч, боловсруулах үйлдвэрийн сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж "Баяжуулагч Одод" ХХК-ийн сүү боловсруулах үйлдвэр шалгарч, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 3 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 2 аж ахуйн нэгж, 35 малчин, фермерээс нийт 153.5 мянган литр сүү хүлээн авсан. Сүү нийлүүлсэн малчид, фермерүүдэд төрөөс нийт 153.5 сая төгрөгийн сүүний урамшуулал олгосон нь өмнөх оноос үйлдвэрт тушаасан сүү 8.5 мянган литр, урамшуулал 8.5 сая төгрөгөөр нэмэгдсэн. Харин 2025 оны 11-р сарын 1-нний өдрөөс Баяжуулагч одод ХХК-ийн 2 аж ахуйн нэгж, 37 малчид, фермерээс сүү хүлээн авч, үйлдвэртээ боловсруулж байна. Одоогийн байдлаар орон нутгийн малчид, фермерүүдээс өдөрт 2.5-3.0 тн сүү хүлээн авч нийлүүлэлтээ бүрэн ханган ажиллаж байна. Ингэснээр тус компани 2025 онд боловсруулсан шингэн сүү 571.2 мян.л, тараг 267.1 мян.л, зайрмаг 280.4 мян.ш буюу сүүнд шилжүүлснээр 1020.5 мян.л сүүг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрийн аргаар бэлтгэсэн сүүний хэмжээ 65.7 хувиар нэмэгдсэн байна. Засгийн газрын 2020 оны "Журам батлах тухай" 130 дугаар тогтоолоор батлагдсан "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Орхон аймгаас 2025-2026 онд сүүний урамшуулалд "Баяжуулагч Одод" ХХК шалгарсан. Хавсралт : 2 файл			

23	39	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №02 БОХХААБХ	1.2/. Итпортлогч улсын хорио уээрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа мал төхөөрөх 3 үйлдвэр, мах, махан бүтээгдэхүүний 8 үйлдвэр ажиллаж байна. Мах экспортлох эрх бүхий 3 махны үйлдвэр энэ онд 2486 тн малын мах үйлдвэрлэсэн. Үүнээс 25 тн үхрийн мах, 600 тн хонины мах, 1095 тн адууны мах, нийт 1720 тн мах экспортлоход Иран, Хятад, Орос, улсуудад Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтаар махан бүтээгдэхүүнд тавих шаардлага"-ыг хангуулан ажилласан. Мал төхөөрөх үйлдвэрүүдийн үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгон, бүтээгдэхүүнээ тохирлын баталгаатайгаар хэрэглэгчдэд нийлүүлэх, тендерт өрсөлдөх болон гадаад оронд экспортлоход нь дэмжлэг үзүүлсэн. Энэ онд "Эрдэнэт мах маркет" ХХК-ийн үйлдвэрийн 3 нэр төрлийн буюу үхэр, хонь, ямааны хэсэглэж ангилсан бүтээгдэхүүнд "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэг хэрэглэх эрх олгосон. Мал эмнэлгийн ерөнхий газрын улсын ахлах байцаагчийн 2025 оны 08-03-03/180-04 дугаартай "Мал төхөөрөх, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, худалдаалалтад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг мал төхөөрөх, мах боловсруулах 3 үйлдвэр, махны төрөлжсөн 14 дэлгүүрт хяналт шалгалт хийж, 31 зөрчил илрүүлэн газар дээр нь 22 зөрчлийг арилгуулж, 30 иргэнд зөвлөмж хүргүүлсэн. 10 зөрчилд "Зөрчлийн тухай хуулийн дагуу 1,.5 сая төгрөгийн шийтгэл ноогдуулсан. Энэ онд "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт" батлагдсантай холбогдуулан махны 3 үйлдвэрт техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж, аюулгүйн тэмдэг авах тухай мэдэгдэл хүргүүлснээр "Эрдэнэт мах маркет" ХХК, "Жаргалант мах импекс" ХХК-д үнэлгээ хийж, шаардлага хангах үүрэг даалгавар өгч сайжруулалт хийлгэлээ. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

24	40	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ	1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;	Орхон аймагт газрын нэгдмэл сангийн ангиллаар тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй байна.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Х.Б	
25	41	Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ	1.1.9/. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах;	Аймгийн Цагдаагийн газарт 2022 оноосс хойш хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдээс мэдүүлэг авах өрөөг тусгайлан бэлтгэн тохижуулж хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/01 дугаартай тушаалаар батлсан "Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага"-ын дагуу 2025 онд 1 өрөөг стандартад нийцүүлэн тохижуулснаар Цагдаагийн газрын 1 дүгээр байранд уулзалт, мэдүүлгийн 7, Жаргалант сумын хэсгийн төлөөлөгчийн уулзалт, мэдүүлгийн 1, Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангийн Цагдан хорих байрны уулзалт, мэдүүлгийн 1, нийт 9 өрөөг тогтмол ашиглаж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулж хэвшүүлсэн. Шүүхийн тамгын газраас хэрэгжүүлдэг Гэр төслийн хүрээнд гэр бүл цуцлуулж буй иргэдийн хүүхдүүдээс асран хамгаалагчаа сонгох санал асуух үед хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд хүүхдэд анхан шатны сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлэх үйлчилгээг үзүүлсэн ба тайлант хугацаанд 62 хүүхдээс санал асууж 7 хүүхдийг сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтанд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				холбон зуучлан, 8 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад гэр бүл салалтыг хүүхдэд тайлбарлан ойлгуулах, хүүхдийн сэтгэл зүйг хэрхэн бэлтгэх тухай зөвлөмж өгч дэмжлэг үзүүлэн ажиллалаа. 2025 онд эрсдэлт нөхцөлд байгаа гэмт хэргийн, хүчирхийллийн хохирогч, гэрч, яллагдагч 54 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр хүүхдийн байцаагч томилогдон ажиллаж, хүүхдийн эрхийг хамгаалж, эцэг эх асран хамгаалагч нарт хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилж, өмгөөллийн үйлчилгээнд 90 хүүхдийг хамруулж ажилласан. Хууль ёсны төлөөлөгчийг мөрдөн байцаах, шүүхийн шатанд томилон оролцуулахдаа тусгайлан бэлтгэсэн өрөө, хүйсийн ижил тэгш байдлыг харгалзан ижил хүйсийн албан хаагчийг томилон ажиллуулдаг. Хавсралт : 1 файл			
	42		1.1.12/. “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх.	Аймгийн хэмжээнд нийт 121 байгууллага нь эцэг эхийн зөвлөлтэй 20 байгууллага хүүхдийн өрөөтэй ажиллаж байна. Одоогийн байдлаар 112 байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байгаа ба 28 байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл 2 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлж 2300 иргэнийг хамруулсан. Насан туршийн боловсролын төв, байгууллын эцэг эхийн зөвлөлтэй хамтран өсвөр үе хүүхэд залуучуудад шүд ам, гарын эрүүл ахуй, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалтыг үе шаттай зохион байгуулж 380 гаруй хүүхэд залуучуудыг хамруулснаар өсвөр үе залуучуудын эрүүл мэндийн боловсрол дээшилсэн. Мөн хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдаанаас гарсан зөвлөмжийн дагуу цэцэрлэг сургууль амарсантай холбоотой "Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан заалтыг хангаж ажиллах зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 4 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж, 12 удаагийн сургалтад 192 иргэнийг хамруулсан. Тухайлбал 27 сүм хийдэд хяналт шалгалт хийж багш, пасторуудыг сургаж, 9 сүм хийдэд хүүхдийн мэдээллийн сантай болж, Жаргалант сумын ЕБС, Политехник коллеж, Орхон Эмпати сургуулийн дотуур байранд 4 удаагийн сургалт зохион байгуулж 41	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				багшийг хамруулж, 58 байгууллагад хяналт үнэлгээ хийж 2 удаагийн сургалтад 120 гишүүн оролцсон. Мөн аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд 24 байгууллагын бодлогын хэрэгжилттэй танилцсан. Ингэснээр хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлсэн байгууллагын тоо өмнөх оноос 17-оор буюу 15.1 хувиар, хүүхдийн өрөөтэй байгууллагын тоо 2-оор буюу 20 болж нэмэгдсэн үр дүнтэй ажил болсон. Хавсралт : 1 файл			
	43		1.2.1/. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;	Хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хүүхдийн ордонд урлаг, уран сайхан, урлах эрдэм, гадаад хэл, оюуны хөгжлийн чиглэлийн 22 хөгжлийн хөтөлбөр хичээллэж байгаа бөгөөд сард дунджаар 350-400 орчим хүүхэд хамрагдаж байна. Хүүхдийн ордонд үйл ажиллагаа явуулж байгаа хөтөлбөрийн багш нартай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Мөн хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууламжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын хуучин номын сангийн засварын ажлыг орон нутгийн төсвийн 450.0 сая төгрөгөөр хийж номын сангийн орчин нөхцөлийг сайжруулсан. Хүүхэлдэйн театртай хамтран үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Бидний дунд" жүжигчилсэн тоглолтыг 16 сургуулийн 2400 гаруй хүүхдэд, Янзага хүүхдийн зусланд амарсан 400 хүүхдэд Номын төвтэй хамтран зөөврийн номын үйлчилгээ үзүүлж, хүүхэд багачуудын унших соёлыг дэмжин ажиллалаа. Баян-Өндөр сумын 480.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нийтийн номын сангийн хуучин барилгын дотор, гадна засварын ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажил 40%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Мөн аймгийн Нийтийн номын сангийн дэргэд "Америк соёл, мэдээллийн төв"-ийг 2024 оноос ажиллуулж байгаа бөгөөд тус 2025 онд 6 чиглэлээр 10033 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Тус төвийн 3 ажилтны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг аймгийн Засаг даргын 2025 оны А/211 дүгээр захирамжаар шийдвэрлэж олгосон.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
	44		1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах;	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, түүний дотор цахим орчинд эсхүл гэр бүлийн хүрээнд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тайлант хугацаанд эрсдэлт нөхцөлд амьдарч буй 452 хүүхдийг шинээр илрүүлэн бүртгэж, нийт бүртгэлтэй 1247 хүүхдийг хяналтад авч ажилласан. Үүнээс 42 өрхийн 145 хүүхдэд кейс нээн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан. Эрсдэлийн программд бүртгэлтэй хүүхдүүдэд шаардлагатай хамгааллын үйлчилгээг үзүүлж, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд - "Сэтгэл зүйн цогц боловсрол" НҮТББ-тай хамтран "Гэр бүлд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 16 багийн эрсдэлийн программд бүртгэлтэй 38 хүүхэд, 30 эцэг эхийг хамруулан нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн. Мөн өндөр эрсдэлтэй 107 өрхийн 297 хүүхдэд эргэн хяналт хийж, эрсдэлийн үнэлгээг дахин шинэчилж 42 өрхийн 145 хүүхдэд кейс нээн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 29 багт Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулж хүүхдийг эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус 20 байгууллагатай хамтран 173 удаагийн сургалт, олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийт 38324 иргэнийг хамруулсан. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн 316 мэдээ, сургалт зохион байгуулсан чиглэлээр 207 постер, 75 зурган мэдээ бэлтгэн цахимаар сурталчилснаар давхардсан тоогоор 97000 хандалттай байна. Мөн хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 94 зөвлөмжийг бэлтгэн байгууллагын фэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран "Анзаар" аяныг зохион байгуулж, өсвөр үе, хүүхэд залуучуудад цахим гэмт хэрэг, залилангаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, хүүхдийн оролцооны байгууллагын 250 гаруй өсвөр үеийн хүүхдийг хамруулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
	45		1.2.6/. Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх.	Хүүхдийн эрхийн улсын байцаагч чиг үүргийн дагуу сүм хийд, дотоор байр, хүүхдийн тоглоомын талбай, худалдаа үйлчилгээний газрууд зэрэг 66 байгууллагад хяналт шалгалтыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж, 7 байгууллагад зөвлөмж хүргүүлэн зөрчлийг арилгуулж ажиллалаа. Мөн Баян-Өндөр сумын гудамж, чөлөөт цагийг өнгөрүүлэх талбайн 150 байршилд хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчин, ашиглалтын байдалд үзлэг, шалгалт хийж, хүүхдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эрсдэл үүсгэж болзошгүй нөхцөл бүхий тоглоом, тоног төхөөрөмжийг илрүүлж, засвар, шинэчлэлт хийлгэх, сургууль, цэцэрлэг болон холбогдох байгууллагуудад 57 зөвлөмж, шаардлага өгч зөрчлийг арилгуулсан. Мөн хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан сургууль, цэцэрлэгийн орчны байдалд эрсдэлийн үнэлгээ хийсэн ба Боловсролын газар, Номын төв зэрэг байгууллагууд болон эцэг эхийн зөвлөлүүдэд хичээлийн жил эхлэхтэй холбоотой хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж хүргүүлж, хяналт тавин ажилласан. Хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, сумдын Морин спорт уяачдын холбоонд 4 удаагийн зөвлөмж хүргүүлж, хурдан морины уралдааны үеэр хяналт тавин Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр 5 удаагийн сургалтыг зохион байгуулж 78 байгууллагын 150 гаруй удирдлага албан хаагч хамрагдсан. Мөн 58 өрхийн 100 хүүхдийн хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой өргөдөл хүсэлтийн дагуу хариу арга хэмжээг авч ажилласнаар 79 хүүхдийн тэтгэмжийг сэргээн шийдвэрлэж, 21 хүүхдийн тэтгэмжийн асуудалд ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
26	46	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай	6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн	Төсвийн төслийг мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн тооцоо судалгаа, саналд үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулалтыг хийж гүйцэтгэж байна. Жил бүр	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ	судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтын ажлыг сонгохдоо иргэд, төрийн бус байгууллагын дунд хэлэлцүүлэг, уулзалт хийх, цахимаар санал авах ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн саналд үндэслэн хөрөнгө оруулалтын ажлыг эрэмбэлэн төсвийн төсөлд тусгаж хэвшсэн. Аймгийн төсвийн төслийг шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд ил тод байршуулан мэдээлж ажиллаж байна. Батлагдсан төсөв болон түүний өөрчлөлтийн талаарх мэдээлэл, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг шилэн дансны цахим хуудас, эрдэнэт.мн цахим хуудсуудад ил тод байршуулан ажиллаж байна. Төсвийн талаар иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээлэл хүргэх зорилгоор "Иргэдийн төсөв" эмхэтгэлийг жил бүр боловсруулан түгээн ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
27	47	Чиглэл өгөх тухай 2024-05-24 Дугаар 2024 №07 ТББХ	1.1/. Монгол Улсын Их Хурлын тухай хууль/ шинэчисэн найруулга/ 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан, Монгол Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах зорилгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаанд "D-Parliament" болон "D-өргөдөл" цахим системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт чиглэл болгосугай: 1/Монгол Улсын Их Хурлын "D-	Швейцарын хөгжлийн агентлаг Монгол Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хууль батлагдахаас өмнөх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дэмжиж, идэвхжүүлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан хууль тогтоомжийн хүрээнд санал хэлэлцүүлэг өрнүүлэх, санал хүсэлтээ D-parliament болон бусад олон хэлбэрээр илэрхийлэх боломжийг нь хангах замаар хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Хууль тогтоомж сурталчлах төв"-ийг Баян-Өндөр сумын Зэст багийн нэгдсэн байрны 1 давхарт байгуулж, "D-Parliament" болон "D-өргөдөл" цахим системийг иргэд олон нийтэд тайлбарлан танилцуулж, сурталчлах ажлыг улсын өмгөөлөгч, эрх зүйн хөтөч нараар дамжуулан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд хууль тогтоомж сурталчлах төвд хүрэлцэн ирсэн 215 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичиг 27 хүнд боловсруулж өгсөн. Мөн D-Parlament" болон "D-Өргөдөл" цахим системийн талаар танилцуулгыг Орхон аймгийн ИТХ-ын ын веб сайтад 3 удаагийн шторк бэлтгэн байршуулах төдийгүй орон нутгийн дагагч олонтой сайтуудаар түгээн ажилласан. Уурхайчин багийн нутаг дэвсгэрт байрлах ИТХ-ын гадна самбар 2024.11.30-	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Parliament" болон "D-өргөдөл" цахим системийг иргэд олон нийтэд тайлбарлан танилцуулж, сурталчлах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаараа дамжуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	2025.02.25-ны өдрүүдэд байршуулж, Нутгийн удирдлагын ордны гадна байрлах LED дэлгэцээр иргэдэд давтамжтайгаар хүргэх ажлыг зохион байгуулсан. Хавсралт : 1 файл			
	48		3.. Энэ тогтоолын хэрэгжилтийн тайлан мэдээг УИХТГ-т тухай бүр ирүүлж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт үүрэг болгосугай.	"D-Parliament" болон "D-өргөдөл" цахим системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг УИХ-ын Тамгын газарт хүргүүлээгүй байна. Шалтгаан: ИТХ-ын ажлын албаны зохион байгуулалтаас шалтгаалан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг УИХТГ-т хүргүүлээгүй.	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	Тайланг холбогдох байгууллагад хүргүүлээгүй
28	49	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ	1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг өгч арга зүйн удирдлагаар ханган 65 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 267 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулах үеэр Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах салбар хэлэлцүүлгийг хийн Орхон, Булган, Хөвсгөл аймгийн нийт 100 төрийн албан хаагчийг хамруулсан. Үүнд Орхон аймгаас төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын төлөөлөл болох 30 төрийн албан хаагч болон Ёс зүйн хорооны дарга, ажлын албаны хамт олон оролцож ёс зүйн гомдол мэдээллийг шалган шийдвэрлэх, ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, ёс зүйн	Хэрэгжсэн - 100%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Шийдвэрээр үүрэг болгосон "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хэрэгжилтийг

				цахим санг ашиглах талаар мэдээллээр хангагдсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчиддаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Монгол улсын Ёс зүйн хорооны 06 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх аргачилал батлагдсантай холбогдуулан аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад тус тогтоолыг хүргүүлэн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын талаар бүх байгууллагад арга зүйн зөвлөмж өгч төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж байна. Хавсралт : 3 файл			тайлагнаагүй.
	50		1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг өгч арга зүйн удирдлагаар ханган 65 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 267 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг 2025 онд зохион байгуулах үеэр Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах салбар хэлэлцүүлгийг хийн Орхон, Булган, Хөвсгөл аймгийн ёс дэд хороодын төлөөлөл болох нийт 100 төрийн албан хаагчийг хамруулсан. Үүнд Орхон аймгаас төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын төлөөлөл болох 30 төрийн албан хаагч болон Ёс зүйн хорооны дарга, ажлын албаны хамт олон оролцож ёс зүйн гомдол мэдээллийг шалган шийдвэрлэх, ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				идэвхжүүлэх, ёс зүйн цахим санг ашиглах талаар мэдээллээр хангагдсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчдадаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүйн” 1 сарын аяныг зохион байгуулж Баян-Өндөр сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд зурган постер, бичлэгийн уралдаан зохион байгуулж, 15 багаас 20 ширхэг постер 8 видео бичлэгийг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар хийж бэлтгэн түгээсэн. Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооны 2 гишүүнийг Удирдлагын академид ёс зүйн чиглэлийн сургалтад хамруулж чадавхжуулсан. Хавсралт : 2 файл			
29	51	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2025-01-14 Дугаар 2025_01 ИЦББХ	1.2 . Төсвийн тухай хуулийн 28Т2.4, 291.3 заалтуудын хэрэгжилтийг хангуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаал “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын	Засгийн газрын 278-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журамд нийцүүлэн журамд нийцүүлэн 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 139.4 тэрбум төгрөгийн 20 төсөл арга хэмжээг төлөвлөн шаардлагатай төсвийг төсвийн төсөлд тусгуулахаар хөрөнгө оруулалтын удирдлага мэдээллийн системд шивж оруулснаас одоогийн байдлаар дээрх заалтад нийцсэн болон 2 шатны үнэлгээний шатанд 18 төсөл арга хэмжээ байснаас 84.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээ үнэлгээ хийгдэж Сангийн яаманд цахим системээр /pimis / хүргэгдсэн байна. Орон нутгийн төсвийн төсөлд туссан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Баян-Өндөр, Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний иргэдээс авсан саналын нэгтгэлд суурилан, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд, Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч нараас ирүүлсэн саналд үндэслэн нэгтгэн боловсрол, эрүүл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хэрэгжилтийг хангах, цахим орчинд байршуулж буй төсвийн талаарх мэдээллийг эдгээр журмуудын хавсралтад тусгасан загварт хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэх, мэдээллийг тогтоосон хугацаанд нь нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар оруулах.(Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах)	мэнд, хөдөө аж ахуй, хууль хяналтын салбар бүрээр хэлэлцүүлэн төлөвлөсөн Хавсралт : 1 файл			
30	52	Чиглэл өгөх тухай 2025-05-07 Дугаар 2025№04 ХХНББХ	1.3. Цахилгаан, эрчим хүчний хэлбэлзэлтэй байгаа сумыг найдвартай цахилгаан хангамжаар хангах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгож, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Аймгийн хэмжээнд цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх, сайжруулах зорилгоор 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажилласан. Тус ажлын хүрээнд Чингэл дэд станцаас 35/10 кВ-ын Даваат дэд станц хүртэлх 35 кВ-ын 13.059 км ЦДАШ барих ажил, 35/10 кВ-ын 2х16 МВА Даваат дэд станц барих ажил, Даваат дэд станцаас 35/10 кВ-ын Булаг дэд станц хүртэлх 35 кВ-ын 5.04 км ЦДАШ барих ажлуудыг ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож хэт ачааллаас шалтгаалан хязгаарлагдах, Бугат сумын дэд станцад гарсан гэмтлээс шалтгаалан тасралт гарах, эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээнээс шалтгаалсан хүчдэлийн уналт үүсэх зэрэг асуудлууд шийдвэрлэгдэх нөхцөл бүрдсэн. Мөн орон нутгийн төсвийн 7.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх, сайжруулах зорилготой 10кВ-ын тойрог схемд оруулах нийт 9 нэр төрлийн ажил	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				төлөвлөн 100 хувийн гүйцэтгэлтэйгээр дуусган ашиглалтад оруулсан. Тус ажлын хүрээнд 3ш дэд станц /РП/, 10кВ-ын хос 12.05 км цахилгаан дамжуулах кабель шугам барих ажлыг хийж гүйцэтгэсэнээр өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс хамаарч хүчдэлийн уналт үүсэх, мөн аваар гэмтлийн үед тасралтгүй эрчим хүчээр хангах нөөц боломж бүрдсэн байна Хавсралт : 3 файл			
	53		2.1. 2. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар: 1."Шинэ сум" төслийн хүрээнд баригдаж буй цэвэр, бохир усны төв шугамын бүтээн байгуулалтыг яаралтай ашиглалтад оруулж, шаардлагатай сумыг цаг уур, хөрсний нөхцөл байдалд тохируулан цэвэр ус түгээх болон бохир ус татан зайлуулах тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр хангах улмаар бүх сумыг цэвэр, бохир ус, дулаан хангамжийн төвлөрсөн системтэй болгох арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлэх;	2025 онд аймгийн инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн 23 ажилд 27.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 9 ажил 100 хувь дууссан, 4 ажил 50%-95% ийн биелэлттэй байна. Дээрх ажлын хүрээнд дулааны 25.6км, бохир усны 0.6км, цэвэр усны 18.6км шугамыг шинэчлэн барьж ашиглатад оруулсан. НҮБ-ын Хүүхдийн Сангийн "Барилгын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах" төслийн хүрээнд хотын төвөөс алслагдсан Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх нийт 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг хэрэгжүүлж нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх ажил бүрэн дуусаж тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэх хэмжээний бохирдлыг бууруулах боломж бүрдэнэ Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	54		2.2. Орон нутагт хэрэгжүүлж буй Сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламж барих төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад тогтмол хяналт тавьж,	Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 24 сургууль, 38 цэцэрлэг, 3 дотуур байр, Политехникийн коллеж, Насан туршийн суралцахуйн төв, их дээд сургуулиуд 100% төвийн шугамд холбогдож, эрүүл ахуйн шаардлага хангасан эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөтэй байгаа ба ариун цэврийн өрөөний урсгал засварыг жил бүр хийж өдөр тутмын ашиглалт, цэвэрлэгээ ариутгалын ажлыг хийж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			ашиглалтыг сайжруулан ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгох;	Хавсралт : 1 файл			
	55		2.5. 2025 онд багтаан ариун цэврийн байгууламжийн Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн барилга, бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулж орон нутагт хүлээлгэн өгөх;	Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 24 сургууль, 38 цэцэрлэг, 3 дотуур байр, Политехникийн коллеж, Насан туршийн суралцахуйн төв, их дээд сургуулиуд 100% төвийн шугамд холбогдож, эрүүл ахуйн шаардлага хангасан эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөтэй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
31	56	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ	1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн байгууллагууд жил бүрийн төлөвлөгөө болон ёс зүйн дэд хороодын ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчиддаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүйн” 1 сарын аяныг зохион байгуулж Баян-Өндөр сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд зурган постер, бичлэгийн уралдаан зохион байгуулж, 15 багаас 20 ширхэг постер 8 видео бичлэгийг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар хийж бэлтгэн түгээсэн. Монгол улсын Ёс зүйн хороотой холбогдож ёс зүйн цахим системд бүртгэлээ үүсгээгүй гэх 23 байгууллагын мэдээлийг авч тухайн байгууллагуудад цахим системд бүртгэл үүсгэн ёс зүйн зөрчлийн мэдээ, хийх ажлын төлөвлөгөө, тайлан зэргийг оруулж ажиллах үүрэг чиглэлийг	Хэрэгжсэн - 100%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Бүрэн хэрэгжээгүй, тайланг ЁЗХ руу явуулсан албан бичгийг хавсаргах

				өгч хяналт тавин ажилласнаар одоогийн байдлаар 9 байгууллага цахим бүртгэлээ үүсгээгүй байна. Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооны 2 гишүүнийг Удирдлагын академид ёс зүйн чиглэлийн сургалтад хамруулж чадавхжуулсан. Монгол улсын Ёс зүйн хорооны 06 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх аргачилал батлагдсантай холбогдуулан аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад тус тогтоолыг хүргүүлэн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын талаар бүх байгууллагад арга зүйн зөвлөмж өгч төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж байна. Хавсралт : 1 файл			
	57		1.1.3. З/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг төрийн байгууллагуудад өгч арга зүйн удирдлагаар ханган 72 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 305 албан хаагчид томилогдон хараат бус, бие даасан зарчмаар ажиллаж байна. 2025 онд Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллыг нийт 9 байгууллага олгосон бол бусад байгууллага нь батлагдсан төсөв хүрэхгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу олгох боломжгүй зэрэг шалтгааны улмаас олгоогүй байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчдадаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүйн” 1 сарын аяныг зохион байгуулж Баян-Өндөр сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд зурган постер, бичлэгийн уралдаан зохион байгуулж, 15 багаас 20 ширхэг постер 8 видео бичлэгийг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар хийж бэлтгэн түгээсэн. Тайлант хугацаанд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				аймгийн төрийн байгууллагуудад нийт 21 гомдол мэдээлэл ирснийг хүлээн авч шалган 13 албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсоны дагуу уучлалт гуйхыг даалгах болох сануулах арга хэмжээг авсан байна. Хавсралт : 3 файл			
	58		1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.	2025 онд Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллыг нийт 9 байгууллага олгосон бол бусад байгууллага нь батлагдсан төсөв хүрэхгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу олгох боломжгүй зэрэг шалтгааны улмаас олгоогүй байна.Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчиддаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Монгол улсын Ёс зүйн хороотой холбогдож ёс зүйн цахим системд бүртгэлээ үүсгээгүй гэх 23 байгууллагын мэдээлийг авч тухайн байгууллагуудад цахим системд бүртгэл үүсгэн ёс зүйн зөрчлийн мэдээ, хийх ажлын төлөвлөгөө, тайлан зэргийг оруулж ажиллах үүрэг чиглэлийг өгч хяналт тавин ажилласнаар одоогийн байдлаар 9 байгууллага цахим бүртгэлээ үүсгээгүй байна. Монгол улсын Ёс зүйн хорооны 06 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх аргачилал батлагдсантай холбогдуулан аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад тус тогтоолыг хүргүүлэн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын талаар бүх байгууллагад арга зүйн зөвлөмж өгч төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж байна. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	
Ерөнхийлөгчийн зарлиг							

32	59	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	2021-2024 онд монгол бичгийн анхан, дунд шатны сургалтуудад давхардсан тоогоор нийт 39 байгууллагын 1287 албан хаагчийг хамруулж, үндэсний бичгийн анхан, дунд шатны мэдлэг олгосон байна. Тайлант хугацаанд аймгийн Архивын газраас MNS 6395:2022 стандартын дагуу төрийн 47 байгууллагын давхардсан тоогоор 141 ширхэг хэвлэмэл хуудас хэвлэлийн эхийг хянаж, баталгаажуулан байгууллагуудад хүргүүлснээр аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд 100% хос бичгийн хэвлэмэл хуудсаар албан хэргийг хөтөлж байна. Аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газраас харьяа байгууллагуудад байгууллагын гадна хаяг, мэдээллийн самбар зэргийг хос бичигт шилжүүлэх тухай албан даалгаварыг хүргүүлж хэрэгжилтийг хангуулснаар төрийн байгууллагууд 100% хос бичгийн хаягтай болсон ба Баян-Өндөр суманд гудамж, талбайн нэр хаягийг бүрэн хос бичгийн хаягтай болгосон. Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс аймгийн Ахмадын хороотой хамтран Баян-Өндөр, Жаргалант сумын 24 багийн иргэд, багийн ажлын албадын дунд үндэсний бичгийн сургалт, масс олимпиад, аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран "Бийрэн бичлэг"-ийн сургагч багш бэлтгэх сургалт, иргэдэд чиглэсэн "Бийрэн бичлэг"-ийн сургалтуудыг тус тус зохион байгуулж үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлж, идэвх санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, хуулийн этгээдийг шагнаж урамшуулж орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг зарцуулсан. Мөн аймгийн хэмжээнд үндэсний бичиг соёлыг сурталчлах зорилгоор "Үндэсний бичиг үсгийн баяр-2025" арга хэмжээг "Үндэсний бичиг үсэг монгол соёлын үнэт өв" уриатайгаар 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулж аймгийн Нийтийн номын сангаас "Үндэсний бичгийн үсэглэлийн уралдаан", "Алтан хонх" тэмцээн, "Түргэн уншлага"-ын уралдаан", "Үндэсний бичигт хөрвүүлэх уралдаан", "Хичээнгүй бичгийн уралдаан" зэрэг 11 үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, 800 гаруй сурагчийг хамруулсан байна. Уг арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөг зарцуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
33	60	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 24 сургуулийн орчинд үйл ажиллагаа явуулж буй 41 хүнсний дэлгүүр, түргэн хоол үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд сургуулийн хоол зүйчид болон сургуулийн дотоод хяналтын баг төлөвлөгөөний дагуу сар бүр хяналт тавьж, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/370 дугаар тушаалаар хүүхдэд худалдаалахыг хориглосон бүтээгдэхүүний жагсаалтыг танилцуулан ажиллаж байна. Аймгийн Боловсролын газар, ЭМГ, ХХААГ-ын улсын байцаагч нартай хамтран Эрүүл мэндийн сайдын А/370 дугаар тушаалын дагуу "Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт"-ыг хүнсний дэлгүүрүүдэд хүргүүлж хэрэгжилтэд хяналт хийж ажилласан. Тайлант хугацаанд Ерөнхий боловсролын 1,4,5,8, 17, Уран эгшиг сургуулийн орчны түргэн хоолны газар, түргэн үйлчилгээний 12 цэг салбар, сургуулийн ойролцоо байрлалтай хүнсний дэлгүүр, түц, мухлаг, Есөн -эрдэнэ худалдааны төв, нийт 25 цэгт Хүнсний чанарын хяналтын улсын байцаагч, Хүнсний эрүүл ахуйн хяналтын байцаагч хамтран 4 удаа төлөвлөгөөт бус шалгалт хийж, 75 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийн 46 буюу 61.3 хувийг газар дээр нь арилгуулж, зөвлөн тусалж ажилласан. Хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад боловсролын салбарын байгууллагуудын ойр орчмын 24 объектыг хамруулж, 39 зөрчил илрүүлж 31 зөрчлийг газар дээр нь арилгуулж ажиллалаа. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
34	61	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр мод тарих, таримал ойг хамгаалах, ойн зурвас байгуулах, голын татмын ойжуулалт хийх зэрэг 440.35 сая төгрөгөөр 5 арга хэмжээнд шинээр хөрөнгө оруулалт хийж, хэрэгжүүллээ. Энэ нь аймгийн байгаль хамгаалах арга хэмжээний зардлын 9.8 хувийг эзэлж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах	Хавсралт : 2 файл			
	62		1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Аймгийн хэмжээнд Олон улсын ой модны өдрийн уриалга, олон улсад хэрэгжиж байгаа мод тарих зарим арга технологийг иргэд олон нийтэд цахимаар болон орон нутгийн ЕТВ телевиз, байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээ хуудсаар мэдээллээ. Бүх нийтээр мод тарих хаврын ажлын хүрээнд Баян-Өндөр сумын Баян-Овоот ууланд шинээр байгуулагдах 4.7 га талбай цэцэрлэгт хүрээлэнд олон нийтийн оролцоотой мод тарих арга хэмжээ зохион байгуулж, мод тарих соёлыг сурталчлан түгээж байна. Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлыг зохион байгуулж, төрийн байгууллага, Эрдэнэт үйлдвэрийн цех нэгжийн 15000 гаруй ажилтан, албан хаагчид, аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээлээ. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	63		1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	2024 онд орон нутгийн төсвийн 84.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сархиа уулын ойн төглийн модыг услах зориулалттай хөв цөөрмийн ашиглалтыг сайжруулж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлыг "Хүйс нутаг" ХХК гүйцэтгэн 1 га талбайд 850 ширхэг таримал мод услах хүчин чадал бүхий услалтын систем байгуулсан. 2025 онд мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын Ар булаг, Жаргалант сумын Зүүн булаг зэрэг гадаргын усны эх ундаргыг хашаажуулан хамгаалж, саарал буюу техникийн усыг нэвтрүүлэхэд талуудын оролцоо, санаачилгыг дэмжих зорилгоор аймгийн Байгаль орчны газар, "Галсэнтий" ХХК хамтарч ус цэвэршүүлэх технологийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулж, таримал мод услахад ашиглаж эхэллээ. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	64		1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх	Шинжлэх ухааны академын Газарзүй, геоэкологийн хүрээлэнгээр боловсруулах Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, аргачлал, технологийн нэгдсэн зөвлөмжийн дагуу тэрбум мод тарих ажилд тарих модны төрөл, зүйлийг тохируулан ажиллаж байна. 2025 онд Баян-Өндөр сумын суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бүх нийтээр мод тарих хаврын ажлын хүрээнд Хүрэн булгийн аманд 4 га талбайд, Эрдэнэтийн Дулааны цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, Шанд багийн овоот толгойд 4.7 га талбайд, нийт 9.7 га талбайд мод тарих ажлыг зохион байгуулж, Баян-Өндөр сумын тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажилласан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	65		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит	Бүх нийтээр мод тарих хаврын ажлыг "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарих хөдөлгөөн өрнүүлж 14 байршилд олон нийтийн оролцоотой болон хөрөнгө оруулалттай ажил хийж 429457 ширхэг мод тарилаа. Мөн мод бут сөөг тарих хүсэлтэй иргэд олон нийтийг тарьц	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	суулгацаар хангах зорилгоор мод, бут, сөөгний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгуулж 34058 ширхэг тарьц, суулгац борлуулагдаж, олон нийтийн оролцоотой мод тарилтын ажил зохион байгуулагдсан газруудад хар шорооны болон цэнэг усалгааны нөөц бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Бүх нийтээр мод тарих хаврын ажлын хүрээнд "Өрх бүр 5 ш мод" хөдөлгөөнийг өрнүүлж 395 өрхөд 22162 ширхэг модны тарьц, суулгацын дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн хэмжээнд "Хашаандаа 5 мод тарья" аяныг өрнүүлж 5 аж ахуйн нэгж байгууллага оролцож, 240 өрх, 1 байгууллагын хашаанд 1400 ширхэг мод тарилаа. Хавсралт : 1 файл			
35	66	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр "Эрдэнэт спортын цогцолбор"-ын зураг төсөв боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 631.0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр "Зэд прожект" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж тус цогцолборын зураг, төсвийг боловсруулж дуусган магадлал хийлгэх шатанд явагдаж байна. Тайлант хугацаанд иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг өнгөруулах, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хотын төвийн хэсэгт унадаг дугуйн зориулалтын 1.4 км зам барихад 618.9 сая, биеийн тамир 6 гадаа талбайг шинээр барих, засварлахад 1619.3 сая, Ерөнхий боловсролын 6, 7, 8, 16-р сургуулийн спорт заалыг засварлахад 1560.0 сая, БТСГ-ын А, Б заал болон Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн тогтмол зардалд 163.0 сая, нийт 3.9 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан байна. Ингэснээр аймгийн хэмжээнд иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх 120 чөлөөт цагийн гадаа талбайтай болсон байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1 фитнес клуб, 1 спорт заал шинээр баригдаж ашиглалтад оруулснаар аймгийн хэмжээнд 1 хүнд ногдох спорт заалны талбайн хэмжээг 0.01м2-аар нэмэгдүүлж 0.168м2-д хүргэсэн. Мөн иргэд, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх идэвх,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				оролцоог дэмжин 134 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж, давхардсан тоогоор 62138 иргэнийг хамруулан улсын болон орон нутгийн төсвөөс 1.2 тэрбум төгрөг зарцуулсан. Хавсралт : 2 файл			
36	67	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын иргэн бүр, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг гэрийнхээ хойморт дээдлэн залж, хүндэтгэлтэй хандах нь зөвхөн түүхийн үнэ цэнийг мөнхжүүлэх явдал бус, ирээдүй хойч үеэ үндэсний бахархал, эх оронч үзлээр хүмүүжүүлэх, эх түүхээ дээдлэх сэтгэлгээний эх сурвалж тул Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нийт 2000 гаруй эмч,эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаа 161 байгууллагад дээрхи уриалгыг Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудад танилцуулсан. Аймгийн хэмжээнд бүх төрийн байгууллага Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залсан байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	68		4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгах зорилгоор Монголын үнэт өв болох Эртний сан Субашидын "Өнчин хүүгийн есөн өрлөгтэй сэцэлсэн шастир" зохиолоор "Тэнгэрийн сургаал" түүхэн зорилтот жүжгийг 2023 онд туурвиж 3546 үзэгч, 2024 онд 2100 үзэгч, 2025 онд 19 удаа тоглогдож 2655 үзэгчдийн хүртээл болгосон. Жил бүр "Монгол бахархалын өдөр"-ийг тохиолдуулан "Эзэн богд Чингис хааны билиг сургааль" хичээлийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зохион байгуулж байна. Тайлант онд "Монгол бахархал" бүтээлч сарын аяны хүрээнд "Чингис хаан" уран сайхны киног 2 удаа үнэ төлбөргүйгээр үзэгчдэд үзүүлж, "Чингис хааны суу алдар" соёл олон нийтийн 8 арга хэмжээг зохион байгуулж 5600 хүн хамрагдсан. Мөн "Хатан сэнтийн хайлан", "Хөх төрийн бэрс" түүхэн драмын жүжгүүдийг 7 удаа тоглож, 1202 үзэгчид үзсэн нь иргэдэд эв эеэ сахин бататгах, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээхэд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хувь нэмрээ оруулсан. Хавсралт : 1 файл			
37	69	Журам шинэчлэн батлах тухай (Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам) 2024-05-27 Дугаар 2024_73	4.2.1. Энэхүү журмын 5.2.1, 5.2.2-т заасан шаардлагад нийцсэн мэдээллийг 5.3-т заасан хугацаанд Ажлын албанд ирүүлэх; (Хавсралтад заасны дагуу нийслэлд 5, аймагт 4 төрлийн мэдээлэл, ЗГХЭГ, ЗГХХГ болон яам, агентлаг тус бүрийн чиг үүрэгт хамаарах хавсралтад заасан мэдээлэл) (3.2 дахь заалт "Төрийн холбогдох байгууллагууд Зөвлөлийг энэхүү журмын хавсралтаар батлагдсан мэдээллээр тодорхой давтамжтайгаар тогтоосон хугацаанд тасралтгүй хангах үүрэг хүлээнэ")	"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-д заасны дагуу тайлант онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм, хийдүүдэд хяналт шалгалт хийсэн тайлан, Хүн ам, хүрээлэн буй орчинд аюул эрсдэл учруулж болохуйц үйл явдал, нөхцөл байдлын талаарх шуурхай мэдээ, Гадаад улсын элчин сайд болон бусад төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, санамж бичгийн мэдээ, Аймгийн нутаг дэвсгэрт байрлах оршуулгын газруудад хяналт шалгалт хийсэн тайлан мэдээ, аймгийн хэмжээнд үндэсний аюулгүй байдлыг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын тайлан зэрэг 6 удаагийн мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
38	70	Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44	1.. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай. 2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард	Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлыг зохион байгуулж Баян-Өндөр сумын байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар эмнэлгийн арын ойн санд 2.7 га талбайд хамгаалалтын хашаа барьж, Цагаанчулуутын аманд Япон улсын Оиска ТББ-ын дэмжлэгтэйгээр "Сайвар хээр" ХХК-аар 4 га талбайд хүргэлт ойжуулалт хийлээ. “Ногоон Эрдэнэт хөтөлбөрийг дэмжиж оролцох талаар Ачит-Ихт ХХК-тай байгуулсан гэрээний хүрээнд Далайн Хошууны шинэс ХХК болон Эрдмин ХХК Хангал голын голдирол дагуу 14.5 га талбайд татмын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.	ойжуулалт, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын үйлдвэрчдийн эвлэлийн холбооны нэрэмжит ойн төгөл болон Д.Түмэнбаярын нэрэмжит ойн төгөл зэргийг байгуулж нийт 1.5 га талбайд ойн төгөл, Эрдэнэтийн Дулаан цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Цагаанчулуутын амны ойн сангийн 0.1 га талбайд, Эрдэнэт голын голдирол дагуу 1.1 га талбайд, Шанд багийн авто зам дагуу 0.5 га талбайд, нийт 22.7 га талбайд 429457 ширхэг мод шинээр тарилаа. Мод бут сөөг тарьц суулгац тарих хүсэлтэй иргэд олон нийтийг тарьц суулгацаар хангах зорилгоор мод, бут, сөөгний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгуулж 34058 борлуулагдаж, нийтийн мод тарих ажлыг зохион байгуулагдсан газруудад хар шорооны болон цэнэг усалгааны нөөц бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлыг зохион байгуулж, төрийн 61 байгууллага, Эрдэнэт үйлдвэрийн цех нэгжийн 15000 гаруй ажилтан, албан хаагчдыг татан оруулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээлээ. Хавсралт : 1 файл			
ҮАБЗ-ийн зөвлөмж							
39	71	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Газар хөдлөлтийн гамшигт тэсвэргүй гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан орон сууцны 6 барилга / Говил багийн Хонхор, Дэнж хэсэгт/, ЕБС-ийн 1 дотуур байр, 1 сургууль, 1 цэцэрлэгийн барилгуудын өнөөгийн нөхцөл байдлын талаар мэргэжлийн байгууллагын саналыг хэлэлцэх, хотын ерөнхий төлөвлөлт, барилгажилтын чанар, явц, аюулгүйн талбай, орон сууцны хорооллын зам, гарцын төлөвлөлт, тусгай зориулалтын автомашинууд хүрэлцэн очих зай талбайн өнөөгийн байдал зэргийг Говил багийн Хонхор, Дэнж хэсэгт нурах эрсдэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 6 орон сууцны нийт 1,34 га талбайд дахин төлөвлөж 4-5 давхар дооройо үйлдвэрлэл үйлчилгээтэй орон сууцны хотхон байгуулах саналыг бэлтгэн аймгийн Засаг даргын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар дахин хэлэлцүүлсэн боловч дээрх 6 орон сууцны өмчлөгч, эзэмшигчидтэй тохиролцоонд хүрээгүй шалтгаанаар барилгуудыг буулган газар чөлөөлөх боломжгүй гэж шийдвэрлэсэн. Мөн орон сууцны 4 дүгээр хорооллын дам нуруугүй хучилттай 6 барилгыг хүчитгэж засварлах дүгнэлт гарсан. 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16, 17, 18, 26-р цэцэрлэг, 7, 2-р сургуулийн барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдал тогтоож, паспортжуулах ажлыг төрийн өмчийн барилгад хийлгэснээр 16,17, 26-р цэцэрлэгийн барилгын суурь зөвшөөрөгдөх хэмжээний суултыг хүчитгэх, дулаан алдагдлыг бууруулах, 18-р цэцэрлэг, 2-р сургуулийн барилгуудыг цаашид ашиглах боломжгүй гэсэн ашиглалтын төлөв байдал тогтоогдсон. Дүгнэлтийн дагуу орон нутгийн төсвөөс 346.0 сая төгрөгийг зарцуулан 26-р цэцэрлэгийн барилгын суурийг хүчитгэн засварлаж хэвийн байдалд оруулсан. Мөн дулааны алдагдлыг бууруулахад шаардлагатай цэцэрлэг, сургуулийн барилгад дулаалга хийлгэх зураг төсвийг 383.0 сая төгрөгөөр хийж, дулаалгын ажилд шаардлагатай 2.0 тэрбум төгрөгийг 2026 оны орон нутгийн төсөвт тусган батлууллаа. Хавсралт : 1 файл			
	72		3. Газар хөдлөлтийн аюул, гамшиггай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тоггмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооодог байх,	тогтоолоор батлагдсан Зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуулийг Засаг даргын 2025 оны А/208 дугаар "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах тухай" захирамжийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Засаг даргын захирамжаар баталсан Гамшгийн үед түр цуглах 20 цэгийн байршил болон өөрт хамгийн ойр байрлах цуглах цэгт Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 33, 120 аж ахуй нэгж байгууллагын 29779 иргэд очиж аюулгүй байдлыг хангах мэдээлэл авч багийн ажилтан болон Онцгой байдлын газарт утсаар бүртгүүлж идэвхитэй хамрагдлаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн төв, орон нутгийн NB HDTV, ETV, Тусгай зориулалтын 3 автомашины чанга яригчийг ашиглан иргэд, олон нийтэд Гамшгийн аюулын үед авах арга хэмжээний талаар болон дадлага сургуулийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				талаар зөвлөмж мэдээлэл хүргэж ажилласан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Эрдэнэт HDTV телевизүүдэд газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлэн байдлын талаар ярилцлага 5 удаа, 107.2 фм-д 1 удаа мэдээлэл хүргэж, 5 төрлийн видео шторкийг 3 телевизээр болон аймгийн ЗДТГ-ын лед дэлгэцээр өдрийн 3 удаагийн давтамжтай нийт 275 удаа түгээж ажиллалаа. Хавсралт : 1 файл			
40	73	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх.	Аймгийн Засаг даргын 2013 оны захирамжаар тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, жил бүр холбогдох төрийн байгууллагуудаас захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд ахуйн хэрэглээний хий болон шингэрүүлсэн шатдаг хий ашиглан хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 34 иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллан осол, гал түймэр гарахад хүргэж болзошгүй 85 зөрчил илэрснээс 16 зөрчил дутагдлыг шалгалтын явцад газар дээр нь арилгуулж, цаг хугацаа хөрөнгө хүч шаардсан 69 зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 13 албан шаардлага хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллан хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллалаа. Шалгалтаар ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөлгүй хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгж, байгууллага худалдаалсан болон насанд хүрээгүй хүүхдэд худалдаалсан зөрчил илрээгүй болно. Тус хяналт шалгалтын талаарх мэдээ мэдээлэл, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын веб хуудсанд байршуулж иргэд, олон нийтэд хүргэж ажилласан. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
41	74	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны	2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр	Аймгийн Засаг дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 онд хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн хэмжээнд байгаа нүхэн жоронгийн тооллого, судалгааны ажлыг сумдын ЗДТГ-тай хамтран зохион	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	байгуулж нийт 14194 нүхэн жорлон бүртгэгдэж, 2028 он хүртэл нүхэн жорлонгийн тоог 20%-иар бууруулах төлөвлөгөө гарган баталгаажуулж, БОУАӨЯ-нд хүргүүллээ. Тооллогоор бүртгэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эзэмшлийн 11 нүхэн жорлонг өөрчлөн, стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгуулахаар Байгаль орчны улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагуудыг хүргүүлж шийдвэрлүүллээ. "Гэр хорооллын нүхэн жорлонг шинэчлэх" БОАЖЯ/202202080 тоот гэрээний дагуу Баян-Өндөр сумын Даваат, Шанд багт Н ЭЙ БИ ХХК-ийн хэрэгжүүлсэн 1000 эко ариун цэврийн байгууламж барих ажлын дутуу хийгдсэн 275 айлын бүхээгийн ажлыг гүйцэтгүүлж, бүрэн хүлээн авлаа. Нийтийн эзэмшлийн талбайд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэт голын голдирол дагуу Цэнгэлдэх хүрээлэнгийн ард 6 хүн зэрэг үйлчлүүлэх хүчин чадал бүхий нийтийн ариун цэврийн байгууламжийг барьж, ашиглалтанд оруулаа. Аймгийн хэмжээнд 2020 оноос нүхэн жорнгийн тоог бууруулж эко ариун цэврийн байгуулж барих бодлогыг хэрэгжүүлэн ажилласнаар одоогийн байдлаар нийт 1729 эко ариун цэврийн байгууламжтай болоод байна Хавсралт : 1 файл			
	75		2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Хаягдал ус дахин боловсруулж хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг бодлогоор дэмжих ажлын хүрээнд катодын зэс боловсруулах "Гал сэнтий" ХХК, "Ачит-Ихт" ХХК-иуд ус цэвэршүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ус хангамжийн цех нь 2025 онд хаягдлын аж ахуйн далангаас 96 169 890 м3 эргэлтийн усыг ашигласан байна. Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэрэглээндээ саарал буюу техникийн усыг нэвтрүүлэхэд хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоо, санаачлагыг дэмжих зорилгоор Галсэнтий ХХК-тай хамтарч ус цэвэршүүлэх технологийг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бетон зуурмагийн үйлдвэр, автомашин угаалга, мод	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				үржүүлгийн газар, ноос угаах, газар тариалангийн салбарын төлөөллүүд оролцож, цаашид саарал усыг хэрэглээнд нэвтрүүлэх талаар санал солилцсон. Аймгийн Засаг даргын 2025 оны А/893 дугаар захирамжаар Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлсэн 6 аж ахуйн нэгжид 27.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хавсралт : 1 файл			
42	76	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	Бүх нийтээр мод тарих хаврын ажлыг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж, "Өрх бүр 5 ш мод" 121 өрхөд 10406 ширхэг модны тарьц, суулгацад дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж, төрийн 61 байгууллага болон томоохон үйл аж ахуй нэгж, байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг татан оруулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээх төдийгүй Олон улсын ой модны өдрийн уриалга, олон улсад хэрэгжиж байгаа мод тарих зарим арга технологийг иргэд олон нийтэд цахимаар болон орон нутгийн ETV телевиз, байгууллагуудын цахим хуудас, олон нийтэд сүлжээ хуудсаар 32 удаа мэдээлсэн ба цахим мэдээлэлд 29339 иргэний хандалттай байна. Мөн ЕБС-иудын анги, сурагчдын дунд “Мөстөл, Мөсөн голоо хамгаалъя” эссэ бичлэгийн, “Цэнхэр алт-Усаа хайрлая” видео контентийн уралдаан, “Байгаль хамгаалахад иргэн бүрийн оролцоо”, “Усаа хайрлая, хамгаалъя, хэмнэе” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж сурагчдын байгаль орчноо хамгаалахын ач холбогдол, экэологийн тэнцвэрт байдлыг хадгалах, усны нөөцийг зөв зохистой ашиглахад хүний оролцоо, хандлага, байгальд ээлтэй дадал хэвшлийн талаарх мэдлэгийг олгосон. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
43	77	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга	3.4. . Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг	Аймгийн хэмжээнд нийт 5188 га тариалангийн талбайтай бөгөөд талбайн ашиглалт 100 хувьтай байна. Тариалангийн талбайн газрыг нэмэгдүүлэх зорилгоор Жаргалант сум 2024 онд тариалангийн зориулалтаар 62.8 га талбай шинээр	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01	нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	олгохоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан боловч газрын нэгдмэл сангийн ангилал таарахгүй гэсэн дүгнэлтээр Засгийн газраас буцаагдсан. Баян-Өндөр сум хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 1.5 га, мод үржүүлгийн чиглэлээр 26 га газар иргэн аж ахуйн нэгжид олгосон. 2025 оны байдлаар газрын нэгдмэл сангийн тайлангаар тариалангийн зориулалттай нийт 5181.9 га талбайтай бөгөөд талбайн ашиглалт 100 хувьтай байна Хавсралт : 2 файл			
	78		3.8.. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Аймгийн хэмжээнд 101 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаас 23 иргэн мах-сүүний чиглэлийн 714 толгой үхэр, 7 иргэн махны чиглэлийн 421 толгой үхэр, 4 иргэн 130 толгой гахай, 55 иргэн 4344 толгой шувуу, 12 иргэн 242 бүл зөгийг тус тус өсгөн үржүүлж үйл ажиллагаагаа явуулж байна. "Атар-4" тариалангийн тогтвортой аяны хүрээнд хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 2 иргэн 100.0 сая төгрөг, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд "Самбо шимт сүрэг" ХХК-д 50.0 сая төгрөг, Өрхийн болон бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих сангаас 1 иргэний тахианы аж ахуйд 100.0 сая төгрөг, "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 4 хоршоонд 344.0 сая төгрөг, нийт 8 иргэн, аж ахуй нэгжийг 594.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан. "Эрдмийт" ХХК, "Жаргалант мах импекс" ХХК, "Эрдэнэт мах маркет" ХХК зэрэг махны үйлдвэрүүд нь арьс ширэн түүхий эдийн бэлтгэл, хадгалж буй ажилчдыг чадавхжуулах сургалтад хамруулж, түүхий эдийг "Дархан минж" ХХК-д нийлүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд өвлийн улиралд малчид, фермерүүдээс шингэн сүү хүлээн авч, боловсруулах үйлдвэрийн сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж Эрдэнэт хаан Сүү ХХК "Баяжуулагч Одод" ХХК-ийн сүү боловсруулах үйлдвэр шалгарч 2025 онд 2 аж ахуйн нэгж, 37 малчид, фермерээс боловсруулсан шингэн сүү 571.2 мян.л сүү хүлээн авч үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна. аргаар бэлтгэсэн сүүний хэмжээ 65.7 хувиар нэмэгдсэн байна. Статистик мэдээгээр боловсруулсан шингэн сүү 96.9, зайрмаг 2.2 дахин үйлдвэрлэлт өсөж,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт сүүний 8.0 хувь, цагаан идээний 7.7 хувийг орон нутгийн дотоодын үйлдвэрлэлээр хангасан нь өмнөх оны мөн үеэс сүүний хангамж 1.7, сүүн бүтээгдэхүүн 25.9 хувиар өссөн. Хавсралт : 1 файл			
	79		3.10.. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах	"Сургуулийн үдийн хоол" , "Бага насны хүүхдийн хоололтын онцлог", "Хүнсний шошго" зэрэг сургалтуудад нийт 1000 орчим эцэг эх асран хамгаалагч, 250 орчим багш ажилтнуудыг тус тус хамруулсан. Дэлхийн эрүүл мэндийн өдрийн хүрээнд Боловсролын газартай хамтран "Шим тэжээлийн боловсрол" нөлөөллийн аяны хүрээнд сурагчид болон тэдний эцэг эх асран хамгаалагчид, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогчдод сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, ахлах ангийн сурагчдад "Өглөөний цай ба сүү сүүн бүтээгдэхүүний зөв хэрэглээ", 6-8 дугаар ангийн сурагчдад "Зохистой хооллолтын зарчим, гэр зөвлөмж", 9-12 дугаар ангийнханд "Шим тэжээлийн дутал эрүүл мэндэд нөлөөлөх нь", 1-6 дугаар ангийн сурагчдад "Сүү, сүүн бүтээгдэхүүний ач тус", "Хооллох соёл", "Тэнцвэртэй хооллолт шим тэжээл" сургалтуудад 1-5 дугаар ангийн 11200, 6-12 дугаар ангийн 10000 орчим сурагчдыг хамруулсан. Хоолны чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр сурагчид болон эцэг эх асран хамгаалагч нарт "Аюулгүй хүнсний 5 түлхүүр" постер бэлтгэж цахимаар болон цаасан хэлбэрээр тарааж, хүнсний эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдан авах, хэрэглэгчийн хяналтыг сайжруулах, хүнсний аюулгүй байдлын шалгалтын явцын мэдээг орон нутгийн 6 телевиз, 5 сайтад байршуулж хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлж, соён гэгээрүүлэх ажлыг хийж ажиллалаа. Монгол хоолны соёлыг гадаад, дотоодод таниулах, зочлох үйлчилгээ, хотын соёлыг нэмэгдүүлэх, орон нутгийн брэнд хоол бий болгох, сурталчлах зорилгоор аймгийн "Тогоочдын холбоо" ТББ-тай хамтран "ERDENET FOOD FESTIVAL" болон "Аймгийн аварга тогооч шалгаруулах" уралдааныг нийтийн хоолны газар, хүнс үйлдвэрлэгчид, технологич, хоол зүйч нарын төлөөлөл зэрэг 30 аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан зохион байгуулж орон нутгийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				онцлог бүхий уламжлалт брэнд хоолыг олон нийтэд сурталчлан, түгээн дэлгэрүүлсэн 6 аж ахуй нэгж байгууллагыг шагнаж урамшуулсан. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр олон нийтэд түгээж, сурталчилсны үр дүнд иргэдээс ирсэн өргөдөл г Хавсралт : 1 файл			
44	80	Ашигт малтмалын тусгаи зөвшөөрлиин өнөөгиин баидал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнии тухаи 2022-11-25 Дугаар 2022_03	1.3 . Үндэснии аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод ниицүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгаи зөвшөөрлиг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэи болон хяэгаарлагдмал/ зохион баигуулах тусгаи зөвшөөрлиин талбаин хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэриин 15 хувиас хэтрүүлэхгүй байх;	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Аж үйлдвэр эрдэс баялгын яамнаас өгч байна. Орхон аймагт ашигт малтмал ашиглалтын болон түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 11, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2, ашигт малтмалын хайгуулын тусгай 5, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2 орд байна. Энэ нь нийт 17866.97 га буюу Орхон аймгийн нийт газар нутгийн 21.2 хувийг эзэлж байна. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2022 оны 379 дүгээр тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2022 оны А135 дугаар тушаал, Кадастрын хэлтсийн даргын 69 дүгээр шийдвэрээр 99.5 мянган га талбайд 6 хайгуулын тусгай зөвшөөрөл нэмж олгон, Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын системд талбайн солбицлоор бүртгэл хийгдсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас Оюут ордын нарийвчилсан хайгуулын ажлыг 3 жилийн хугацаанд хийхээр төлөвлөн ажлыг эхлүүлээд байна. Орхон аймгийн хэмжээнд уул уурхайн компаниудын уул уурхайн зориулалт болон уул уурхайн барилга байгууламжийн зориулалттай газар эзэмших болон ашиглах гэрээтэй талбай 4417га буюу нийт газар нутгийн 5 хувийг эзлэж байна. Ашигт малтмалын хайгуулын 5 болон ашиглалтын 2 тусгай зөвшөөрлийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ эзэмшиж байгаа бөгөөд 6 орд нь Булган аймаг Орхон аймгийн газар нутгийг хамарч байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
ЗГ-ын тогтоол							

45	81	“Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг батлах тухай 2021-06-01 Дугаар 2021_161	3. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.	Орхон аймгийн хэмжээнд инженерийн шугам сүлжээ хариуцсан төрийн өмчийн "ЭДЦС" ТӨХК, "ЭБЦТС" ТӨХК, орон нутгийн өмчийн "ЭУДТС" ОНӨХК-ууд үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор 2023 онд Эрдэнэ багт 35кв-ын ЦДАШ-ыг барих ажлыг ЭБЦТС ТӨХК өөрийн хөрөнгө оруулалтаар хийж ашиглалтад оруулж, 2025 онд 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож цахилгааны хүчдэлийн уналтыг шийдвэрлэсэн. Улсын төсвийн 1.37 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их залуу багт төвийн дулаан, цэвэр усны шугам шинээр тавих, ус дулаан дамжуулах төвийн барилга барих 1.7 км 3 хос гадна инженерийн шугам сүлжээ угсралтын ажлыг хийж дуусгасан. 2021 оноос “Миний гэр-бидний гудамж” төслийг хэрэгжүүлж аймгийн хэмжээнд гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажилд орон нутгийн төсвөөс нийт нийт 2.9 тэрбум төгрөг зарцуулсан байна. Уг ажлын хүрээнд гэр хорооллын 7 багт хэрэглээний халуун хүйтэн усны нийт 5.78 км төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийсэн. Ингэснээр гэр хорооллын 1245 айл инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой болсноос 307 айл өрх инженерийн шугам сүлжээнд холбогдсон байна. Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цагаанчулуут багийн өргөх насос станцаас Наран багийн Ус дулаан хангах төв хүртэлх Ф125, Ф159 мм-н 1.2 км ил дулааны шугамыг өргөтгөх ажлыг 100 хувь гүйцэтгэж улсын комисс ажиллаж хүлээн авсан. 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн нийт 23 ажилд 27.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 9 ажил 100 хувь дууссан, 4 ажил 50%-95% ийн биелэлттэй байна. Одоогийн байдлаар нийт 25.6км дулааны, 0.6 км бохирын, 18.6 км цэвэр усны шугам шинээр барьж ашиглатад оруулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

46	82	Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-10-20 Дугаар 2021_321	3. Орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд ажиллаж байгаа багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан бол зохих тэтгэмж олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулдаг байх зохицуулалт бий болгох асуудлыг судлан, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	"Эрдэнэт цогцолбор" дээд сургууль 2024 онд 79 ажилтанд 299.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бол 2025 онд 33 ажилтанд 8.4 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 9 багш, ажилтанд 117.0 сая төгрөгийн орон сууцны санхүүгийн дэмжлэг, 8 ажилтны оюутан хүүхдийн сургалтын төлбөрийн дэмжлэгт 6.6 сая төгрөг, 26 багш, ажилтан, ахмадад 2.3 сая төгрөгийн шахмал түлшний санхүүгийн дэмжлэг, 3 хүртэлх насны хүүхдийг асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд 41.5 сая, нийт 76 ажилтанд 175.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	83		4. “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг орон нутагт хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтын хөтөлбөрийн давхардлыг арилгах, тухайн орон нутгийн онцлог, бүсчилсэн хөгжлийн үзэл	"Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ыг орон нутагт байгуулахаар 50 га газрыг орон сууцны 2а хорооллын урд талд Оюут багт төлөвлөн аймгийн Засаг даргын 2012 оны 102 дугаар захирамжаар шийдвэрлэж олгосон бөгөөд хичээлийн болон дотуур байрууд, номын сан, инновацын төв, багш ажилчдын байр, эмнэлэг зэрэг 10 гаруй барилга бүхий цогцолбор бий болгохоор төлөвлөж байна. 2025 онд "Сургалт- эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоны ТЭЗҮ боловсруулах болон ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын 400.0 сая төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын худалдан авах ажиллагааны	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	

			баримтлал болон хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	төлөвлөгөөнд тусган худалдан авах ажиллагааг зарласан ч оролцогч байхгүй шалтгаанаар хэсэгчилсэн төлөвлөгөөний сонгон шалгаруулалт амжилтгүй болоод байна. ТЭЗҮ болон ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсаны дараа барилга, инженерийн байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын төсвийг төсөвт тусган батлуулж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль болон Мэдээлэл, технологийн сургуулиудыг Орхон аймагт шилжүүлэх чиглэлээр Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ШУТИС хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах аймгийн Засаг даргын албан хүсэлтийг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/529 дүгээр албан бичгээр ШУТИС-д хүргүүлсэн. Удааширч буй шалтгаан: Тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль болон Мэдээлэл, технологийн сургуулиудыг Орхон аймагт шилжүүлэх чиглэлээр Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ШУТИС хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах аймгийн Засаг даргын албан хүсэлтийг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/529 дүгээр албан бичгээр ШУТИС-д хүргүүлсэн боловч хариу өгөөгүй байна. Хавсралт : 1 файл			
	84		5. Энэ тогтоолын 1.1-д заасан төрийн өмчийн их, дээд сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд тусгахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, 1.2-т	Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ыг орон нутагт байгуулахаар 50 га газрыг орон сууцны 2а хороллын урд талд Оюут багт төлөвлөн аймгийн Засаг даргын 2012 оны 102 дугаар захирамжаар шийдвэрлэж олгосон бөгөөд хичээлийн болон дотуур байрууд, номын сан, инновацын төв, багш ажилчдын байр, эмнэлэг зэрэг 10 гаруй барилга бүхий цогцолбор бий болгохоор төлөвлөж байна. "Сургалт- эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" хотхоны ТЭЗҮ боловсруулах болон ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын 400.0 сая төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2025 оны худалдан авах ажиллагааны	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	

			заасан Шинжлэх ухаан, технологийн сургуулийн харьяа сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөв болон тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт, 1.3-т заасан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Монгол Улсын Их сургуулийн бүрэлдэхүүн “Эрдэнэт” сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болон нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрдүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд	төлөвлөгөөнд тусган худалдан авах ажиллагааг зарласан боловч амжилтгүй болсон байна. Мөн Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн үнэлгээний төвд Орхон аймаг дахь "Сургалт эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор"-ын ерөнхий төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөний техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаварт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн. Хавсралт : 1 файл			

			үйлдвэрийн сайд Г.Ёндон, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймгийн Засаг дарга С.Батжаргал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Х.Бадамсүрэн) нарт тус тус даалгасугай.				
47	85	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314	2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх чиглээр нийт 17 арга хэмжээ зохион байгуулж, 1313 иргэн, ААН-үүдийг урамшуулсан. Тухайлбал: Хүүхэд залуучуудын театрын "Үлгэрч эмээ" явуулын театр 4-6 насны хүүхдүүдэд зориулж Монгол ардын 10 үлгэрийг зохиомжлон орчин үеийн хүүхдийн нас сэтгэлгээний онцлогт тохируулан найруулж аймгийн СӨББ-тай хамтран хуваарийн дагуу хүүхдүүдэд хүргэсэн. Мөн "Эрдэнэтэд үйлдвэрлэв-2025" соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэнг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, "Оёдолчдын холбоо", "Гар урчуудын холбоо", "Зураач урчуудын холбоо" зэрэг ТББ-уудтай хамтран зохион байгуулж орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг, үндэсний хувцасны үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих "Дээлтэй Эрдэнэт-2025" арга хэмжээг зохион байгуулж 7.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Тайлант хугацаанд орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн 6 удаагийн үзэсгэлэн худалдаанд 119 иргэн, улсын чанартай 2 үзэсгэлэн худалдаанд 17 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, нийт 396.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Монголын үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих ”Монгол эв нэгдэл” төсөл, хөтөлбөр танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 100 гаруй иргэн, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 20 иргэн аж нэгжийг хамруулсан. Тус арга хэмжээний хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаатай танилцаж, уулзалт зохион байгуулан, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	үндэсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд ойртуулж, бизнесийг нь дэмжих зорилгоор Gerege App, Gerege POS, Gerege Kiosk болон GEREGESHOP-ыг нээж, орон нутгийн иргэдийн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээр хамтран ажиллаж байна Хавсралт : 1 файл			
48	86	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээг авч жил шаардлагатай төсвийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд ТББ-уудтай гэрээ байгуулан ажиллахад 60.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс тус бүрээр хуваарь батлуулан гэрээ байгуулан ажиллаж нийт 18 ТББ-тай гэрээ байгуулж хэрэглэгчийн эрх ашгийн төлөө, хувь хүний хөгжил, мониторинг, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг зэрэг 5 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллахад нийт 60.0 сая төгрөг зарцуулаад байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			(Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.				
49	87	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Шинээр баригдаж байгаа орон сууцны хорооллуудад сургууль, цэцэрлэг төлөвлөн 1а хороололд сургууль 14491 м2, цэцэрлэг 9228 м2, 2а хороололд сургууль 11000 м2, цэцэрлэг 5117 м2, Эко хороололд сургууль 4979 м2, цэцэрлэг 2900 м2, 7 дугаар хороололд цэцэрлэг 11101 м2 газруудыг аймгийн Засаг даргын захирамжаар Боловсрол, шинжлэх ухааны газарт эзэмшүүлсэн. 2А хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дахин тодотгох ажлын тендерт "Скайланд" ХХК шалгарч гэрээ байгуулан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дахин тодотгох ажлыг хийж одоогийн байдлаар магадлал хийлгэх шатанд явагдаж байна. Орон сууцны 2А хороололд 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр 150 хүүхдийн цэцэрлэг барих ажлын гүйцэтгэгчээр "Аттачир" ХХК шалгарч гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлснээр барилгын ажилын гүйцэтгэл 35 хувийн гүйцэтгэлтэй байна. Шинээр баригдаж байгаа орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд сургууль, цэцэрлэгийн барилгыг төлөвлөн тусгасан байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	88		1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан,	2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Чандмань багт 150 хүүхдийн цэцэрлэгийг ашиглалтад оруулсан. 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2А хороололд 150 хүүхдийн цэцэрлэг баригдаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалт 98.9 хувьтай байна. Тайлант хугацаанд орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, хэрэгцээ, шаардлага үүсээгүй. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.				
	89		2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан	Аймгийн хэмжээнд шинээр үүссэн суурьшлын бүсүүд болох Зэст багийн 1А хороололд 9228 м.кв, Оюут багийн 2А хороололд 4979 м.кв болон 5117 м.кв, Чандмань багийн "Эко" хороололд 2900м.кв, мөн тус багт 8385 м.кв, Найрамдал багийн "Евро эко" хороололд 3632 м.кв цэцэрлэгийн зориулалттай газрыг аймгийн Засаг даргын захирамжаар тус тус олгосон. Оюут багийн 2А хороололд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг улс төсвийн 3.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Аттачир" ХХК шалгарч барилгын ажил 35% -ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 7А хороололд дахин төлөвлөлтөөр "Инженер геодези" ХХК нь Найрамдал багийн 49-52 гудамжийг хамарсан 11.3 га газарт дахин төлөвлөлт хийгдэж байгаа ба тус байршилд 260 хүүхдийн 2 цэцэрлэг тусгагдан төлөвлөлтийг хийж аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэцүүлэн батлуулсан. Зэст багт "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Уурхайчин цогцолбор хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 280 хүүхдийн хүчин чадалтай хүүхдийн цэцэрлэгийг түлхүүр гадуулах нөхцөлтэйгөөр барих тендерийг зарлаж "Майнспринг" ХХК шалгаран одоогийн байдлаар зураг төсвийн ажлыг хийж байна. Аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 98.9 хувьтай байгаа ба шинээр үүссэн суурьшлын бүсүүд болох 2А, 7А хороололд түр цэцэрлэг байгуулах шаардлага үүсээгүй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.				
	90		3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Орон сууцны 7А хороолол болон 2А хороололд суурьших иргэдэд нормчлогдсон хүүхдийн цэцэрлэгийн тоо хүрэлцээгүй байгаа тул цэцэрлэг шинээр нэмж төлөвлөх төлөвлөлтийн арга хэмжээ авч 7А хороололын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусган баталсан. 2026 оны улсын төсөвт 7а хороололд 280 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг барихад 2.0 тэрбум төгрөгийг батлуулсан. 2А хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дахин тодотгох ажлын тендерт "Скайланд" ХХК шалгарч гэрээ байгуулан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дахин тодотгох ажлыг хийж одоогийн байдлаар магадлал хийлгэх шатанд явагдаж байна. Оюут багийн 2А хороололд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг улс төсвийн 3.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Аттачир" ХХК шалгарч барилгын ажил 35% -ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 7А хороололд дахин төлөвлөлтөөр "Инженер геодези"ХХК нь Найрамдал багийн 49-52 гудамжийг хамарсан 11.3 га газарт дахин төлөвлөлт хийх ажлыг гүйцэтгэж байгаа ба тус хэсэгт 260 хүүхдийн 2 цэцэрлэг тусгагдсан. Мөн Зэст багт "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Уурхайчин цогцолбор хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 280 хүүхдийн хүчин чадалтай хүүхдийн цэцэрлэгийг түлхүүр гадуулах нөхцөлтэйгөөр барих тендерийг зарлаж "Майнспринг" ХХК шалгаран зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Бусад суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусган ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
	91		4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2025-2026 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалт 98.9%-тай байна. 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2А хороололд 150 хүүхдийн цэцэрлэг барих ажлыг гүйцэтгэж байгаа ба барилгын ажил 30%-ийн гйүцэтгэлтэй явгдаж байна. Тайлант хугацаанд цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг худалдах санал хувийн хэвшлээс гараагүй. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
50	92	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/774 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулж, 2023 оны 1 дүгээр сард иргэд, төрийн байгууллагуудын хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан саналыг хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган 2023 оны 04 дүгээр сард аймгийн ИТХ-ын ээлжит 16 дугаар хуралдааны 15/03 дугаар тогтоолоор шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье" хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан ажлын хэсгээс 2022-2024 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, 2023 онд орон нутгийн төсвөөс 50.0 сая, 2024 онд мөн 50.0 сая төгрөг зарцуулан төлөвлөсөн арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан бол 2025 оны төсөвт 30.0 сая төгрөг тусган хэрэгжүүллээ. Аймгийн хүн амыг 20 хувь өсгөх, шилжин суурьшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хүлээн авахад ЖДҮ эрхлэх, орон сууцжуулах болон цаашдын хөгжлийн бодлогыг тодорхойлж "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье-2023" эдийн засгийн форумыг 2023 оны 06 дугаар сард	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./	зохион байгуулсан. Тус форумын үеэр "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн Смарт Эрдэнэт апплекейшны нээлтийг хийж сургалт, сурталчилгааг хийсэн. "Уулын аялал жуулчлалын цогцолбор", "Хөдөө аж ахуйн агропарк", "Эрүүл мэндийн аялал жуулчлал", "Эрдэнэт хотын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлэх орон сууцны төсөл"-үүдийг форумын үеэр танилцуулсан. Эрдэнэт хотын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хүн амын хэрэгцээг хангах зорилгоор төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу стандартын шаардлага хангасан нийтийн хоолны үйлчилгээ болон томоохон худалдааны төвүүдийг 24 цагаар ажиллуулахаар Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны А/85 дугаартай захирамжаар шийдвэрлэн хэрэгжүүлж байна. Мөн "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье" төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шилжин ирсэн иргэдэд ногоон карт олгож, төрийн үйлчилгээ болон хөнгөлөлттэй зээл тусламжид шуурхай хамрагдах, бүртгэлжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Хавсралт : 1 файл			
	93		4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/774 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулж, 2023 оны 1 дүгээр сард иргэд, төрийн байгууллагуудын хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан саналыг хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган 2023 оны 04 дүгээр сард аймгийн ИТХ-ын ээлжит 16 дугаар хуралдааны 15/03 дугаар тогтоолоор шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих "Хамтдаа Эрдэнэтэд хөгжье" хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2022-2024 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, 2023 онд орон нутгийн төсвөөс 50.0 сая, 2024 онд мөн 50.0 сая төгрөг зарцуулан төлөвлөсөн арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан бол 2025 оны төсөвт 30.0 сая төгрөг тусган төлөвлөгөөг хэрэгжүүлсэн. 2026 оны орон нутгийн төсөвт “Welcome to Erdenet” арга хэмжээний зардалд 30.0 сая төгрөгийг тусгасан. Мөн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амыг жил бүр 2%-аар өсгөхөөр төлөвлөн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	ажиллаж байна. Орхон аймагт шилжин ирэгсдийн тоо 2023 оноос эрс өссөн ба 2022 онтой харьцуулахад шилжин ирэгсэд 2023 онд 30.6 хувиар, 2024 онд 57.5 хувиар, 2025 онд 50 хувиар өссөн байна. Үүнээс Улаанбаатар хотоос шилжин ирэгсэд 2023 онд 38.3 хувиар, 2024 онд 83.5 хувиар, 2025 онд 64.6 хувиар өссөн байна. 2025 онд бусад амаг, хотоос нийт 3244 иргэн шилжин ирснээс Улаанбаатар хотоос 1164 иргэн шилжин ирсэн байна. Хавсралт : 1 файл			
51	94	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	1.12. . 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.14.ашигт	1.12. Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын төрийн захиргааны болон төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг алслагдсан сум болох Жаргалант суманд үндсэн цалингийн 60-80 хувиар / ТЗ-80, ТҮ-60 хувь /, аймгийн төсвийн суманд 40-60 /ТЗ-60, ТҮ-40/ хувиар тус тус тооцон 2025 төсөвт тусган хэрэгжүүлж ажиллаж байна. Орон нутгийн төсвийн 16 байгууллагын төрийн захиргааны 199 албан хаагч, төрийн үйлчилгээний 600 албан хаагч болон улсын төсвийн 85 байгууллагын төрийн захиргааны 338, төрийн нийтлэг үйлчилгээний 4045 албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгохоор нийт 15.3 тэрбум төгрөгийг төсөвт батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. 1.13. 2025 онд Орон нутгийн хөгжлийн санд 38.7 тэрбум төгрөгийн санхүүжилт хуваарилагдсныг баталсан аргачлалын дагуу тооцон аймагт 15.4 тэрбум төгрөг, Баян-Өндөр суманд 12.2 тэрбум, Жаргалант суманд 11.0 тэрбум төгрөгийг олгохоор хуваарилалтыг хийсэн. Төсвийн тодотголоор аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдах шилжүүлэг 12.5 тэрбум төгрөгөөр буурч нийт 26.2 тэрбум төгрөг хуваарилагдсныг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын гүйцэтгэлд үндэслэн аймагт 11.6 тэрбум, Баян-Өндөр суманд 9.2 тэрбум, Жаргалант суманд 5.4 тэрбум төгрөгийг тус тус хуваарилан олгосон. Орхон аймаг болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтран ажиллах гэрээний санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж зарцуулахаар 2025 оны төсөвт тусган батлуулсан. Төсвийн төслийг боловсруулах явцад ОНХС-ийн цахим санал асуулгаар нийт 50334 иргэн саналаа өгч	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай	идэвхтэй оролцсон байна. 1.14. Аймгийн хэмжээнд уул уурхайн ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК-уудтай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2025-2028 онд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан.... Хавсралт : 2 файл			

			шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;				
52	95	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49	Х-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;	Аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ий дагуу шүгэл үлээх ажиллагааны талаарх цахим орчинд постер, мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд сурталчилж ажилласнаар давхардсан тоогоор 113897 хүний хандалт авсан. Мөн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиудаар зохион байгуулсан сургалтуудад Авлигыг мэдээлэх 110 тусгай дугаарын утсаар АТГ-т гомдол, мэдээлэл гаргах талаар оролцогч нарт мэдээлэл өгч ажилласан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	96		Х-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний нэгдсэн системийг хөгжүүлэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд үзүүлснээр E-mongolia болон Цахим төвөөр давхардсан 78550 иргэн үйлчлүүлсэн байна. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах зорилгоор Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 02 дугаар хуралдааны тэмдэглэлээр багуудын цахим булангийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				ашиглалтыг нэмэгдүүлэх, www.irgen.erdenet.mn вэб сайтын ашиглалтыг сайжруулах иргэдэд сурталчлэх арга хэмжээ авч ажиллах талаар ирүүлсэн чиглэлийн дагуу сумдын ЗДТГ-т үүрэг, чиглэл өгч хяналт тавин ажилласнаар тус вэб сайтаар 700 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу мэдэгдэн ажилласан байна. Мөн төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт хэрэгжүүлэх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 104 төрийн байгууллагад “Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1”-д заасан төрийн байгууллагын нийтлэг үүргийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийлгэлээ. Үнэлгээний дүнгээр мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн дундаж түвшин 78% -тай дүгнэгдсэн байна. Аймгийн ИТХ, Нийгмийн даатгалын хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба зэрэг хэд хэдэн нутгийн захиргааны байгууллагууд нь салбартаа болон төрийн захиргааны байгууллагуудаа тэргүүлж “Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 370001:2016 стандартын олон улсын баталгаажуулалтын эрхтэй гэрчилгээг авч үйл ажиллагаандаа нэвтрүүлж төрийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн үр дүнд хүрч байна. Хавсралт : 1 файл			
53	97	Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63	3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг мөрдөн мөшгөх, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн болон сайжруулсан үхрийг ялган тэмдэглэж, Баян-Өндөр, Жаргалант сумдын 147 малчин өрхийн 3579 толгой сайжруулсан үүлдрийн үхрийг малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Тус ажилд шаардагдах 4.3 сая төгрөгийн зардлыг орон нутгийн төсөвт тусган батлуулж зарцууллаа. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.				
54	98	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	"Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Смарт Эрдэнэт аппликейнш дээр шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх тусгай цэс нээн хөгжүүлэлтийг хийн ашиглалтад оруулан мэдээллийн баяжуулалтыг хийж байна. Одоогийн байдлаар тус аппликейшний серверийг хувийн cloud host дээр байсныг Үндэсний дата төв рүү шилжүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд зарим холболт тохиргооны асуудлаас үүдэн түр хугацаанд ажиллахгүй байна. Хавсралт : 1 файл	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	
55	99	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	2.3. “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/12 дугаар тушаалын хавсралтын 25 дугаарт "Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. “Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2045” -ийн ТЭЗҮ хийх гүйцэтгэгчээр 2024 онд Нью урбанизм ХХК 1094.0 сая төгрөгийн үнийн саналаар шалгарч гэрээ байгуулан ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар судалгааны ажил хийгдэж байгаа ба Эрдэнэт хотын байрзүйн геодезийн зураглалын алдааг засч шинэчлэн хийх, бүс нутгийн асуудлаар Булган аймагтай санал солилцож хөрш зэргэлдээх сумдын суурьшлын бүс эдийн засгийг тэлж хамтран ажиллах санал гарсны дагуу хотын баруун талыг дулаанаар хангах дулааны станцын байршил нь Булган аймгийн Орхон сумын Халиун багт байхаар тооцоологдон Дулааны станцыг байршлын талаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 10-р сард Булган аймгийн Орхон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай хэлэлцээр хийснээр Булган аймгийн Орхон сумаас дараагийн уулзалтыг зохион байгуулах шийдвэр гаргаад байна. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	

			салбар зөвлөлийн дарга нарт;	төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болон бусад судалгааны ажил хийгдэж байгаа ба Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах ажил 35 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Хойд бүсийг байгалийн аялал жуулчлал, хүнд үйлдвэрлэлийн дэд бүс байхаар тодорхойлсны хүрээнд Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд урт хугацаанд хэрэгжүүлэх Эрдэнэт-Шинэ илгээлт төслийг санаачлан Санамж бичиг байгуулсан. Уг төслийн хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т хэрэгжих Үйлдвэр технологийн парк, Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр, Эрдэнэт машин цогцолбор, Сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор хотхон, Үүсмэл ордыг үр ашиглай ашиглах дэд төслүүд зэрэг эдийн засгийн өсөлтийг хангах томоохон төслүүд багтсан... Хавсралт : 1 файл			
	100		3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	Эрдэнэт Шинжлэх ухаан технологийн паркаас 2024 онд шинжлэх ухаан, инновацыг хөгжүүлэх чиглэлд 300 сая төгрөгийн зардалтайгаар 18 арга хэмжээ төлөвлөн ажиллаж 65 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлсэн. Дээрх батлагдсан төсвийн хүрээнд аймгийн хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр "Эрдэнэт хотын тулгамдсан асуудал, гарц шийдэл" эрдэм шинжилгээний хурал, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Эрдэнэт ШУТП нь Хойд бүсийн хэмжээнд шинжлэх ухаан, технологийн үндэслэлтэй, кластер зарчмаар хөгжүүлэх төслийн судалгаа, бизнес эрхлэгчдэд танилцуулах сургалтыг Хөдөлмөр халамжийн ерөнхий газартай хамтран Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 800 орчим иргэнд хийж, 15 кластер төслийн ерөнхий судалгааг иргэдэд танилцуулсан. Инновацын долоо хоног арга хэмжээ зохион байгуулж бизнес эрхлэгчид, залуучуудыг Инновацын түншлэл форум, Инно талк арга хэмжээнд оролцуулсан. Парк нь 2024 оны 05 дугаар сард инновацын төсөл бүртгэх, татварын хөнгөлөлт үзүүлэх салбарын яамны гэрээт Технологи дамжуулах төв болсон. "Инновац" иж бүрэн сургалтын хөтөлбөрөөр паркийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				дэргэдэх 10 компанийн 35 ажилтанд сургалт зохион байгуулснаар компаниуд инновацын бүтээгдэхүүн, төслийн хөгжүүлэлт эхлүүлсэн. Тус тогтоолд заасан Шинэ сэргэлтийн бодлогод туссан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шинжлэх ухаан, технологид тулгуурлах чиглэлээр дараах ажлыг хийж байна. Үүнд: -Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай" хуулийг үндэслэн "Эрдэнэс ҮТП" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Эрдэнэт ҮТП" төслийн хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах асуудлыг Аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн 2024 оны 18/03 тогтоолоор Уул уурхай, металлурги химийн үйлдвэрийн цогцолборын удирдлагыг хэрэгжүүлж буй "Эрдэнэт ҮТП" төслийн хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эрхлэх асуудлыг дэмжин ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хавсралт : 2 файл			
56	101	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266	3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 25 сургууль, хүүхдийн 39 цэцэрлэг, Политехникийн коллеж, Насан туршийн суралцахуйн төв болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд 100 хувь төвийн шугамд холбогдож, эрүүл ахуйн шаардлага хангасан эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөтэй байна. Тайлант хугацаанд хүүхдийн 6 цэцэрлэгийн ариун цэврийн өрөөнд 5.1 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийсэн. Мөн ерөнхий боловсролын 8-р сургууль өөрийн хөрөнгөөр ариун цэврийн өрөөндөө 31.0 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад тохируулж тохижуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны А/689, А/718 дугаар захирамжийн дагуу аймгийн Засаг даргын аваарын зардлаар төрийн өмчийн 14 цэцэрлэг, 4 сургуулийн дотор шугамын засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ ариун цэврийн өрөөг засварлаж стандартын шаардлагад нийцүүлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
57	102	Журам шинэчлэн батлах тухай	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2023-07-19 Дугаар 2023_278	бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	дагуу 2024 оны улсын төсөвт батлагдсан төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын цахим системд бүрэн оруулж санхүүжилтийг хянаж баталгаажуулан олгосон бөгөөд 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний мэдээллийг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага мэдээллийн Pimis.gov.mn цахим системд шивж оруулан батлагдсан дүнд багтаан санхүүжилтийг олгож ажиллаж байна. 2025 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 210 төсөл арга хэмжээний 73.5 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээний 8.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна. Журамд нийцүүлэн 2026 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 139.4 тэрбум төгрөгийн 20 төсөл арга хэмжээг төлөвлөн шаардлагатай төсвийг төсвийн төсөлд тусгуулахаар хөрөнгө оруулалтын удирдлага мэдээллийн системд шивж оруулснаас одоогийн байдлаар дээрх заалтад нийцсэн болон 2 шатны үнэлгээний шатанд 18 төсөл арга хэмжээ байснаас 84.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээ үнэлгээ хийгдэж Сангийн яаманд хүргэгдсэн байна.. Хавсралт : 1 файл			
58	103	Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	3. 3.Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай.	Аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлж, ашиглуулах шийдвэр гаргаагүй. Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх газрын хэмжээ байршлыг тогтоосон Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолд заасан жагсаалтын дагуу эзэмшүүлэх шийдвэрийг гарган газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авсан. Үүнд: Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох 66.56 га газрыг эзэмшүүлж тухайн арга хэмжээний биелэлт 100%-тай биелсэн. Дуудлага худалдаагаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлж, ашиглуулах 22 байршилд 4.06 га газрын 13 байршилд 3.79 га газар дээр 11 ялагч тодорч гэрээ байгуулж гэрчилгээ олгосон бол үлдсэн 9 байршилд дахин дуудлага худалдаа зарласан боловч ялагч тодроогүй байна. Өвөлжөө, хаваржааны доорх газрыг давуу эрхээр эзэмшүүлэх 16 байршлын 3.52 га газрыг, тариалангийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2023-08-16 Дугаар 2023_294		газрыг давуу эрхээр эзэмшүүлэх 18 байршлын 17.64 га газрыг, уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар эзэмшүүлэх 3947.58 га газрыг тус тус эзэмшүүлсэн. Малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх 6 байршлын 24.7 газраас 5 байршлын 23.13 га газрыг эзэмшүүлж, 1 байршилд төсөл ирээгүй ба тухайн арга хэмжээний биелэлт 93.6%-тай байна. Иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшлийн бус, амралт зугаалга, биеийн тамирын зориулалттай 1 байршлын 0.16 га газрыг нийтийн эдэлбэр газарт авсан, нөхөн олговортойгоор солих 0.11 га газрыг 2 иргэнд эзэмшүүлсэн. Мод бут сөөг тарихаар төлөвлөгдсөн Говил багийн Цагаан чулуутын аманд 1.72 га газарт мод тарьж нөхөн сэргээх ажил, Баян-Овоот багт Сум дундын ойн ангитай хамтран хамгаалалтын хашаа хийж 0,35 га газарт 6300 ш 3 төрлийн мод тарьсан, Хангал голын голдирол дагуу 1,08 га талбайд 1513 ш бургас тариалж нөхөн сэргээж дууссан. Албадан чөлөөлөх 0.27 га газрыг Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны А/303 тоот захирамжийн дагуу албадан чөлөөлснөөр тус тогтоолын хэрэгжилт 96.4%-ийн биелэлтэйгээр хэрэгжүүллээ. Хавсралт : 1 файл			
59	104	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийгмийн эрүүл мэндийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс 110.0 сая төгрөгийг зарцуулан "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт хэрэгжилт 85.7 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.4%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор тайлант хугацаанд 31 удаагийн өдөрлөг, аян, форум, 276 удаагийн сургалт сурталчилгаанд 165 байгууллагын давхардсан тоогоор 110373 иргэнийг хамруулж, 55 төрлийн сурталчилгааны материалыг 9471 иргэнд түгээсэн, цахим хуудаст 1250 гарын авлага, шторка, видео болон постер зөвлөмжийг түгээн ажиллалаа. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний хүрээнд 38 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан 12 удаагийн өдөрлөгт сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршлыг бууруулах,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох сургалт, нөлөөлийн арга хэмжээнд нийт 31245 хүнийг хамруулсан. Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 7 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулж 38 аж ахуйн нэгж, байгууллага, 36452 иргэнийг хамруулан мэдлэг, хандлага дадлыг нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 12 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн Хавсралт : 1 файл			
60	105	“Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Амны хөндийн эрүүл мэндийг сахих, зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг өрнүүлж 24 сургуулийн 25122 хүүхдийг хамруулсан байна Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 7,8,18,20, "Ирээдүйн одод" сургууль нийт 9 сургуульд 12 шүд угаах цэг байгуулагдсан. 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 17 сургууль шүд угаах орчинг нэмэгдүүлэх зорилгоор нийт 34 угаалтуур суурилуулж, шүд угаах буланг ажиллуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд "Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн"-ийг 2 удаа амжилттай зохион байгуулж, 21 багийн 168 хүүхэд оролцсон. -Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад "Зөвийг дадал болгоё" шүд, гараа зөв угааж сурах аяныг өрнүүлж, Шүдний олимпиадыг улсын хэмжээнд анх удаа Шүдний холбоотой хамтран орон нутагт зохион байгуулж, нийт 630 хүнийг хамруулсан. Сургуулийн өмнөх 36 байгууллага нь 100% эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах орчинг бүрдүүлсэн, өдөрт 2 удаа амны хөндийг зайлах, шүд угаах сургалт нөлөөллийн ажлыг 100% хэвшүүлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

61	106	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344	2.. 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн жишсэн дундаж нийт хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээг 90 хоногоор тооцоход 926.8 тонн малын мах хэрэгцээтэй бөгөөд үүний 21.5 хувь буюу 200 тонн махны нөөц бүрдүүлэхээр төлөвлөж орон нутгийн төсөвт 410.0 сая төгрөг тусган батлуулж, сонгон шалгаруулалтаар шалгарсан Эрдмийт ХХК үйлдвэрийн аргаар бэлтгэж савласан 200 тн мах бэлтгэн 2025 оны 03 сарын 15-ны өдрөөс эхлэн худалдаанд гаргаж хэрэглэгчдэд хүргэснээр зах зээлийн үнээс үхрийн мах 1 кг нь 6200, хонины мах 1 кг нь 4867, ямааны мах 1 кг нь 3700 төгрөгөөр тус тус хямд нийлүүлэгдсэн. Аймгийн жишсэн дундаж нийт хүн амын 2026 оны хаврын махны хэрэгцээг 90 хоногоор тооцоход 926.8 тонн малын мах хэрэгцээтэй бөгөөд үүний 21.5 хувь буюу 200 тонн махны нөөц бүрдүүлэхээр төлөвлөсөн. Нөөцөд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах нь MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартын шаардлага хангасан байх ба махны нийт жингийн 55 хувь буюу 110 тн үхэр, 40 хувь буюу 80 тн хонь, 5 хувь буюу 10 тн ямааны мах байхаар хүн амын 2026 оны хаврын хэрэгцээнд бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдаж нээлттэй сонгон шалгаруулалт зарлан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус ажилд шаардагдах 400.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгасан. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
62	107	Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457	2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	2025 онд Орон нутгийн хөгжлийн санд 38.7 тэрбум төгрөгийн санхүүжилт хуваарилагдсныг баталсан аргачлалын дагуу тооцон аймагт 15.4 тэрбум төгрөг, Баян-Өндөр суманд 12.2 тэрбум, Жаргалант суманд 11.0 тэрбум төгрөгийг олгохоор хуваарилалтыг хийсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

63	108	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_458	2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах	2024-2025 оны өвлийн улиралд аймгийн хэмжээнд цэнгэлдэх хүрээлэн 1, цанын бааз 1, мөсөн гулгуурын 5 талбайн хэвийн үйл ажиллагааг хангаж, хүүхэд залууст өвлийн спортоор хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.Тайлант онд өвлийн спорт аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор аймагтаа улсын аварга шалгаруулах тэмцээн 4, олон хотын болон аймгийн аварга шалгаруулах нээлттэй 7 тэмцээнийг зохион байгуулж нийт 1568 тамирчдыг хамруулсан. Үүнд: -Монголын үндэсний Мөсний шагайн шилдэг багуудын аварга шалгаруулах "Эрдэнийн цом" Тэмцээнд 8 аймгийн 35 багийн 210 харваач; -"Мөрөөдлийнхөө төлөө-Шударгаар өрсөлдье" урианы дор Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадмын цанын спортын 4 төрлийн тэмцээнийг Сархиа цанын баазад зохион байгуулж, тэмцээнд 13 аймаг, 6 дүүргийн 209 тамирчин; -Гүйлтийн цанын насанд хүрэгчдийн 2025 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд 10 аймаг, 4 дүүргийн 110 тамирчин; -Авто спортын "Ice drift-2025" улсын аварга шалгаруулах тэмцээнд 5 аймаг, дүүргийн 50 гаруй тамирчид; Мөсний сурын харвааны аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд 6 аймгийн 70 харваач; -Эрдэнэт мөнгөн өвөл-2025 аяны хүрээнд гүйлтийн цанын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд 10 аймаг, 2 дүүргийн 100 гаруй тамирчид; -Гүйлтийн цанын "Клубүүдийн аварга шалгаруулах тэмцээн"-д 8 аймаг, 2 дүүргийн 100 гаруй тамирчин, -Мөсний шагайн харвааны хаалтын харваа нээлттэй тэмцээн зохион байгуулж 5 аймгийн 79 харваач; -Төрийн байгууллагын албан хаагчдын дунд "Цасны баяр 2025" арга хэмжээний хүрээнд олс таталт, хөгжөөнт буухиа, тэшүүрийн 4х100, гүйлтийн цанын 4х100 төрлүүдээр тэмцээн зохион байгуулж, 16 байгууллагын 422 албан хаагчийг тус тус хамруулж хурд хүч, авхаалж самбаагаа сорин уралдсан. -Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэдэх Сархиа цанын баазыг тогтмол ажиллуулж байна. 2025 онд нийт 30000 гаруй иргэд, хүүхэд залуучууд үйлчлүүлж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

64	109	Мах бэлтгэхэд зориулан олгох зээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_461	4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын даргын 2025 оны "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт, хамгаалалтад хийгдэх төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжаар мал төхөөрөх, мах боловсруулах 3 үйлдвэр, малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг 2 худалдааны төв, махны төрөлжсөн 11 дэлгүүрт хяналт тавьж, шалгалтын явцад 31 зөрчил илрүүлж газар дээр нь 22 зөрчил арилгуулсан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 30 иргэнд зөвлөмж хүргүүлсэн. 2025 оны хаврын нөөцийн хэрэгцээнд гаргасан 110 тн үхрийн мах, 80 тн хонины мах, 10 тн ямааны мах, нийт 200 тн нөөцийн махны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, махны хадгалалт, жижиглэн ангилан савлалт, борлуулалт, хүртээмжийн байдалд өдөр тутмын хяналт хийх, хэрэглэгчдээс гарсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
65	110	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483	2.8.. Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, шаардлагатай газрыг чөлөөлж, олгох арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймгийн Засаг дарга нарт;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Орон сууцны хөтөлбөр”-ийг батлуулан Орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлснээр одоогийн байдлаар 4 блок 100 хувь ашиглалтад орж 17 иргэн түрээсээр, 184 иргэн хөнгөлөлттэй үнээр худалдан авч нийт 201 айл тус орон сууцанд оморсон. Тус төслийн хүрээнд Ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд өртөөний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Орлогод нийцсэн орон сууцны үнэ зах зээлийн үнээс 30-40%-иар хямд байна. Мөн "Орон сууцны хөтөлбөр"-т тусгагдсаны дагуу хот дахин төлөвлөж Баянцагаан-Эрчим хороололд 8.5 га-д, Оюут багт 4.1 га-д, 7-р хороололд 3 га-д, Уурхайчин багт 150 айлын 1.3 га-д Орлогод нийцсэн орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэхээр төсөл сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Үүнээс Баянцагаан-Эрчим хороолол, 7-р хороололд төлөвлөж байгаа орон сууцны хорооллыг төрийн болон төрийн өмчит байгууллагын албан хаагчдад олгохоор төлөвлөсөн. Мөн орон сууцны 7-р хороололд Төрийн албан хаагчдад	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр 72 айлын орон сууцыг "Хэрлэн зураглал" ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 20 хувьтай явагдаж байна. Цагаанчулуут багт төрийн албан хаагчийн 48 айлын орон сууцыг "Тэнүүн төвөргөөн" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Аймгийн хэмжээнд орон сууцжуулалтын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тайлант хугацаанд нийт 1326 айлын орон сууц ашиглалтад орж орон сууцны хангамжийг нэмэгдүүлсэн. Хавсралт : 1 файл			
	111		2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Шилжин суурьшиж байгаа иргэдийг орон сууцаар хангах, оршин сууж буй иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор орон сууцжуулах ажил төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор үе шаттай хийгдэж байна. Үүнд: Аймгийн хэмжээнд дахин төлөвлөлтийг хийхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэрлэсний дагуу Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхлүүлснээр хэрэгжилт 40 хувьтай, Эрдэнэ багт 2.5 га талбайд Эрчим хүчний хэмнэлтэй амины орон сууцны төслийн ажлын явц 40 хувьтай явагдаж байгаа бол Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багт Уурхайчин- 1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10га талбайд хийлгэж зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Мөн Оюут багт Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байгаа бол Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төслийг хийж дуусгасан. Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжих орон сууцны "Эрчим хорооллын барилгажилтын төсөл", "Х хорооллын барилгажилтын төсөл" зэрэг хорооллын зураг төсөл боловсруулах хөрөнгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 150 сая төгрөг шийдвэрлэн ажлын даалгавар боловсруулсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Орон сууцны хөтөлбөр”-ийг батлуулан Орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				ажлыг 2022 оноос эхлүүлж тус барилгын төсөвт өртөг нь 27.4 тэрбум төгрөгөөс 19.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласнаар 4 блок ашиглалтад орж иргэдийг оруулах ажлыг зохион байгуулснаар 17 иргэн түрээсээр, 184 иргэн хөнгөлөлттэй үнээр худалдан авч нийт 201 айл тус орон сууцанд орсон. Жаргалант суманд 30 айлын орон сууцыг сумын хөрөнгө оруулалтаар Сигма Эс ХХК гүйцэтгэж ашиглатад оруулаа. Хавсралт : 1 файл			
	112		2.10.. Орон нутаг дахь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Үүнд: Жаргалант суманд иргэдийн худалдан авах чадварт нийцсэн 30 айлын орон сууцны барилгыг сумын хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулсан бол Цагаанчулуут багт Татварын газрын ажилчдын 56 айлын орон сууцны барилгын угсралтын ажлыг "Тэнүүн төвөргөөн" ХХК, Найрамдал багт аймгийн БОАЖГ-ын захиалгаар алба хаагчдад зориулан 55 айлын 9 давхар орон сууцны барилга угсралтын ажлыг "Тэгш ургах" ХХК тус тус гүйцэтгэж 2025 онд ашиглалтад оруулаа. Мөн төрийн албан хаагчдад хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр 72 айлын орон сууцыг "Хэрлэн зураглал" ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 20 хувьтай явагдаж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Орон сууцны хөтөлбөр”-ийг батлуулан Орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлж тус барилгын төсөвт өртөг нь 27.4 тэрбум төгрөгөөс 19.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласнаар 4 блок ашиглалтад орж иргэдийг оруулах ажлыг зохион байгуулснаар 17 иргэн түрээсээр, 184 иргэн хөнгөлөлттэй үнээр худалдан авч нийт 201 айл тус орон сууцанд орсны 30 гаруй нь төрийн албан хаагчид байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
66	113	Фестиваль зохион байгуулах	3. Фестивалийг зохион байгуулахад зохих	"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулах тухай тогтоолыг соёл, урлагийн албан хаагчдад	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		тухай 2024-01-25 Дугаар 2024_41	дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.(1.“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.)	таниулан, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийн эхний шатыг орон нутагт зохион байгуулах удирдамжийн дагуу хийгдсэн сонгон шалгаруулалтаар уруулын цуур болон олон төрөлт оюуны оньсон болон хөлөгт тоглоом бүтээсэн 9 иргэнийг өвлөн уламжлагч бүртгэх шалгуурын дагуу бүртгэн баримтжуулж бүртгэлийн санд оруулсан. Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд Орхон аймгаас нийт 50 өвлөн уламжлагч оролцсон бөгөөд орон нутгийн төсвөөс 64.0 сая төгрөг зарцуулсан.Тус фестивалиар Орхон аймгаас шилдэг өвлөн уламжлагчаар 1 хүүхэд, шилдэг дизайнераар 1 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч иргэн тус тус шалгарсан. Хавсралт : 1 файл			
67	114	Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59	6.. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай. (5.“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.)	Тайлант хугацаанд Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн зохион байгууллаа. Үүнд: Соёлын салбарын 7 байгууллагын 8 албан хаагч морин хуурын сургалтад хамруулах төдийгүй аймгийн хэмжээнд морин хуурын 7 сургалтын төв, байгууллагад 170 хүүхэд морин хуурын сургалтад хамрагдаж байна. Тухайлбал "Уран эгшиг" хөгжмийн төрөлжсөн сургалттай сургуулийн Морин хуурын ангид 45 сурагч, Соёл спортын "Хэмнэл" төвийн өвлөн уламжлагч морин хуурын шавь сургалтад 22 хүүхдийг хамруулсан. Орхон аймагт амьдарч буй мэргэжлийн морин хуурч, морин хуур урлаачид болон соёлын байгууллагуудад ашиглагдаж буй морин хуурын судалгааг гаргаснаар 6 Соёлын төвд 33 морин хуур, бусад байгууллагуудад 53 ширхэг морин хуур ашиглагдаж байна. Мөн өвлөн уламжлагч, морин хуур урлаач Ч.Энх-Отгон Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгуудад морин хуур урлаач бэлтгэх шавь сургалтыг зохион байгуулж 15 шавийг бэлтгэсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
68	115	Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийгдаван	2 . Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн	2023-2024 оны өвөл өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан улсын нөөцөөс Орхон аймагт 135 тн тэжээл олгосныг аймгийн Онцгой комиссоос малчин, мал бүхий	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-28 Дугаар 2024_76	буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	өрхүүдэд хуваарилан олгох ажлыг зохион байгуулсан. Аймгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээл бэлтгэх ажлын хүрээнд аймгийн Онцгой комиссын зардлаас 146.0 сая төгрөг зарцуулан 2000 боодол өвс, 3928 шуудай тэжээл нөөцөд худалдан авч малчдад олгосон. Хавсралт : 1 файл			
69	116	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)	Дотоод удирдлагын программ хангамж болох И-Оффис системд хүний нөөцийн болон цаг үеийн мэдээ мэдээлэл оруулах, албаны майл, мэдээ мэдээллийг системээр дамжуулан оруулах болон илгээхдээ тус системийг ашиглах нийтлэг журам, Мэдээллийн аюулгүй байдлын журмуудыг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
70	117	Тоггоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан	Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын төрийн захиргааны болон төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг алслагдсан сум болох Жаргалант суманд үндсэн цалингийн 60-80 хувиар / ТЗ-80, ТУ-60 хувь /, аймгийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)	төсвийн суманд 40-60 /ТЗ-60, ТҮ-40/ хувиар тус тус тооцон 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Орон нутгийн төсвийн 16 байгууллагын 808 албан хаагч, улсын төсвийн 85 байгууллагын 4383 албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгохоор нийт 20.1 тэрбум төгрөгийг төсөвт батлуулан хэрэгжүүлж ажиллалаа. Хавсралт : 1 файл			
71	118	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83	3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох	Тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгох мөнгөн урамшууллыг жил бүрийн төсөвт тусган олгож байна. 2024 онд 68 албан хаагчид 443.9 сая төгрөг, 2025 онд 11 байгууллагын 27 албан хаагчид 227.8 сая төгрөгийн урамшууллыг олголоо. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.)				
72	119	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162	3 . Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	2025 онд Ерөнхий гэрээний аргаар төрийн 52 захиалагч байгууллагуудаас 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий 200 гаруй нэр төрлийн бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах саналыг авч нэгтгэн Төрийн худалдан авах ажиллагааны газарт Аймгийн Засаг даргын 01/2084 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
73	120	Журам шинэчлэн батлах тухай 2024-04-24 Дугаар 2024_168	1.. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай	Одоогоор орон нутаг үнэт цаас гаргаагүй байна.	Х.Б	Х.Б	
74	121	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187	4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын	Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XIV ээлжит хуралдааны "Сумын газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай" тогтоолоор 26 байршилд 82 га газрыг мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар эзэмшүүлэхээр хэлэлцүүлэн батлуулж, төлөвлөлтийн системд байршуулан төсөлд дүгнэлт гарган, баталгаажуулах хүсэлтийг Газар зохион байгуулалт, геодози, зураг зүйн ерөнхий газарт тавьсан. Дүгнэлтээр мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар төлөвлөсөн 8 нэгж талбарын 24.82 га газар баталгаажсан. 2024 онд эрчимжсэн мал аж ахуйн фермерийн зориулалтаар Долоон хайлаастад "Хөлгийн өвөр хөндлөн" хоршоо 2.58 га, Шувуутад Шонхорын хүч хоршоо 3.77 га, Хөшөөтөд "Арга билиг арвин сүрэг" хоршоо 4.62 га нийт 10.98 га газар эзэмшүүлсэн. 2025	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай	онд 6 хоршоонд 24.71 га талбай эзэмшүүлэхээр төлөвлөн төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар сумын Засаг даргын 2025 оны А254 дүгээр захирамжийн дагуу газрын биржийн MLE.mn сайтад байршуулж, зохион байгуулснаар 4 байршилд 5 төсөл ирсний 3 хоршоо шалгарсан, 1 байршилд төсөл ирээгүй. 2025 оны 4 дүгээр улиралд үлдсэн 3 байршилд төсөл сонгон шалгаруулалтыг дахин зарлаж 2 байршилд 3 төсөл ирснээс 2 ялагчийг шалгаруулсан. Ингэснээр 2025 онд 5 малчдын хоршоонд 23.13 га газрыг эзэмшүүлсэн байна Хавсралт : 2 файл			
75	122	Ариун цэврийн байгуулам бүхий түр буудаллах цаг, үйлчилгэний цогцолбор барьж байгуулах тухай 2024-05-01 Дугаар 2024_189	2.. Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд эзэмшүүлэх газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Улсын чанартай А1001 авто замын дагуу гадаад, дотоодын аялагчдын ая тух түр буудаллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор БОУАӨЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын түр буудаллах цэгийг Эрдэнэт хаалганы хажууд байгуулахаар шийдвэрлэж, эхний ээлжинд MNS5924:2015 стандартын шаардлага хангасан 6 хүний хүчин чадалтай эко ариун цэврийн байгууламж улсын төсвийн хөрөнгөөр баригдсан ч одоогийн байдлаар ажлыг хүлээлгэж өгөөгүй байна. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт хаалга", Жаргалант сумын "Трактортой хөшөө" орчмын 2 байршилд түр буудаллах цэг байгуулах байршлын мэдээллийг шинэчлэн гаргасан. 2025 онд Жаргалант сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Эрдэнэт угтах хаалганы урд ариун цэврийн байгууламжийн зориулалтаар 150 м.кв газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 03/08 дугаар тогтоолоор батлуулж Жаргалант сумын ЗДТГ-т 2025 оны А303 дугаар захирамжаар эзэмшүүлсэн. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	123		4.. Олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийн цэвэрлэгээ, арчлалт, хог хаягдлын асуудлыг зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай	Улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийн орчмын газрын цэвэрлэгээ үйлчилгээг 7 хоногт 2 удаа тогтмол гүйцэтгэж 152м3 хог хаягдлыг цэвэрлэн, ачиж тээвэрлэн дарж булшилаад байна. "Азза Нэгтгэл " ТӨХК-ийн Орхон аймаг дахь салбар нь Дархан-Эрдэнэт чиглэлийн А1001 дугаартай авто замын 108км, Эрдэнэт-Булган чиглэлийн А1002 дугаартай 29.7км авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг хариуцан ажиллаж 2025 онд авто замын зорчих хэсэгт гарч буй нүхэн эвдрэлийг даралтаар шүрших аргаар нийт 38000м2 талбайд, зурвас газрын талбайн хогийг цэвэрлэж нийт 500м3 хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
76	124	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хүний нөөцийн бүртгэл, үйл ажиллагааг цахимд шилжүүлэх, төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд "Төрийн албаны Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системийг нэвтрүүлэн төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлтийг хийж хяналт тавин ажиллаж байна. 2025 онд тус системд төрийн албан хаагчийн алба тушаалын тодорхойлолтуудыг шинээр оруулаа. Энэхүү системийг ашигласнаар төрийн бүхий л шатанд үйл ажиллагаа явуулж буй төрийн албан хаагчдын мэдээлэл илүү хэрэглээний түвшинд гарч, хүний нөөцийн талаар бүрэн мэдээлэл авах боломжийг бүрдүүлж байна. Тус системээр дамжин "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл"-ийн хэлэлцүүлэг хийгдсэн. 2025 онд Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг орон нутагт ажиллаж сумдын ЗДТГ болон төрийн үйлчилгээний байгууллагуудын "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн ашиглалтад хяналт хийж баяжуулалт бүрэн, сайн хийгдсэн гэж үнэлсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
77	125	Цахим шилжилтийг эрчимжүүлэх	4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад	Монгол Улсын хэмжээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлагууд, төрийн байгууллагуудтай албан бичиг солилцох дундын https://docx.gov.mn/ системд интеграци	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	хийж албан бичиг солилцох хөгжүүлэлтийг аймгийн хэмжээнд бүх төрийн байгууллагуудыг хамруулан албан хэрэг хөтлөлтийн и-оффис системд хийж холбосон ба одоогийн байдлаар тус системд холбогдсон 2672 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломжийг бүрдүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хавсралт : 1 файл			
78	126	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10	2.. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Аймгийн 2025 оны төсвийн төслийг батлагдсан төсвийн хязгаарт нийцүүлэн төсвийн орлого, зарлагыг 401.4 тэрбум төгрөөөр төлөвлөн хэрэгжүүлж ажилласан. Үүнээс аймгийн татварын болон татварын бус орлого 380.6 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 5.4 тэрбум төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлого 26.3 тэрбум төгрөг байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
79	127	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28	3.1.. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай" Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд	Орхон аймаг газар нутгийн хэмжээ багатайгаас одоогийн байдлаар атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх талбай байхгүй байна. 2025 оны байдлаар газрын нэгдмэл сангийн тайлангаар газар тариалангийн салбарт 13 аж ахуйн нэгж, байгууллага, 272 өрх үйл ажиллагаа явуулж үр тариа 3719 га, төмс 165.1 га, хүнсний ногоо 463 га, тосны ургамал 746 га, тэжээлийн ургамал 598 га-д тариалж нийт эргэлтийн талбайг 100 хувь ашиглаж байна. Хавсралт : 1 файл	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	

			атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;				
	128		3.2. . Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;	2025 онд аймаг, сумдын аюулгүйн нөөцөд 166 тн өвс, 144тн хүчит тэжээл бэлтгэхээс 190 тн өвс, 112.5 тн тэжээл бэлтгэсэн. Мөн аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 60 тн өвс, 70 тн үйлдвэрийн тэжээлийг нэмэлтээр бэлтгэсэн. 2024 оны аюулгүйн нөөцөөс үлдсэн үлдэгдэл 130 тн өвс, 87.5 тн тэжээлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж "Аюулгүйн нөөцийг хадгалах хамгаалах журам"-ын дагуу малын тэжээлийг ус чийг авч хөгц үүсэхээс сэргийлсэн агуулахад хадгалж, өвсийг галын аюулгүй байдлын дүрмийн дагуу хурааж хадгалан бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан. Аймгийн хэмжээнд 29 багийн 1102 малчин өрхөд 187.8 мянган толгой мал мал урьдчилсан байдлаар өвөлжиж байгаа бол хөрш зэргэлдээ аймаг, сумдын нутаг дэвсгэрт отроор 433 малчин өрхийн 86.2 мянган толгой мал өвөлжиж байна. Отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Булган аймгийн хил залгаа сумдын 6 байршилд явуулсан. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системээр шилжин ирж байгаа болон дамжин өнгөрч байгаа малын хөдөлгөөн, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт тавьж ажилласнаар хүн амыг эрүүл, аюулгүй хөдөө аж ахуйн гаралтай бүтэгдэхүүнээр хангах нөхцөл бүрдэж, малын халдварт, гоц халдварт өвчнөөр эрүүл тайван байдлыг хадгалж байна. 2025 онд малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 987, амьд малын шилжилт хөдөлгөөнд 378 цахим гарал үүслийн гэрчилгээ олгосон. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	129		3.3.. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт	Манай аймгаас бусад аймгийн нутаг дэвсгэрт нийт 433 өрхийн 86.2 мянган толгой мал өвөлжиж байгаагаас Булган аймагт 287өрхийн 49.5, Сэлэнгэ аймагт 136 өрхийн 34.4,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;	Хөвсгөл аймагт 3 өрхийн 0.3, Архангай аймагт 1 өрхийн 0.6, Төв аймагт 3 өрхийн 0.2, Дорнод аймагт 3 өрхийн 1.1 мянган толгой мал отроор өвөлжиж байна. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, мал байхгүй. Хавсралт : 1 файл			
	130		3.4.. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах;	Аймгийн хэмжээнд одоогийн байдлаар нийт 115 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаагийн 74 нь Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдаж 1330 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс өссөн дүнгээр 47 хоршооны 174 гишүүн нийт 6.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан байна. Үүнээс 2025 онд 176 гишүүнтэй 19 хоршоо байгуулагдан, 7 хоршооны 16 малчинд 529.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан мал, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмж /трактор, хадуур, тармуур, өвс пресслэгч/, хоршооны ажлын байрны зориулалттай хашаа байшин худалдаж авах, худаг гаргах, мах сүүний хөргүүр барих зэрэгт хөрөнгө оруулалт хийн зориулалтын дагуу ашигласан байна. Мөн малчдын хоршоонд газар эзэмшүүлэх 6 байршлын 24.7 га газрын төсөл сонгон шалгаруулалтыг газрын биржийн MLE.mn цахим хаягт байршуулж, зохион байгуулснаас 5 байршилд 8 төсөл ирснээс малчдын 5 хоршоо шалгарч нийт 23.13 газрыг эзэмшүүлсэн байна. Үүнд: Мухар буланд тахианы аж ахуйн эрхлэх зориулалтаар "Хангайн бухнууд" хоршоо 4.59 га газар, Дулааны энгэрт мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар " Аят нуур" хоршоо 4.85 га газар, Цагаан толгойд мал нядалгаа, бордооны үйлдвэрийн зориулалтаар "Үлэмж төгс төгөлдөр" хоршоо 4.75 га, мах сүүний чиглэлийн фермер эрхлэх зориулалтаар Хүрэн шандын хөлд " Тэнгэрлэг уужим нутаг" хоршоо 4.28 га газар, Шувуутад "Тэнгэрийн цэцэг хатан бэйл хоршоо"-нд 4.65 га газрыг газрыг эзэмшүүлсэн Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	131		3.6.. Амьд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах зориулалт бүхий төвлөрсөн зах, худалдааны төвийн үйл ажиллагааг хот, суурин газруудын ойролцоо явуулахыг дэмжиж ажиллахыг нийслэл, Төв, Орхон, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарт;	2016 онд аймгийн Засаг даргын захирамжаар амьд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн худалдан борлуулах зориулалт бүхий төвлөрсөн зах, худалдааны төвийг Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт байгуулахаар шийдвэрлэснээр “БҮБУ ХХК” амьд мал, малын гаралтай түүхий эд худалдан борлуулах, мал нядалгааны “Таван-эрдэнэ” худалдааны төвийг байгуулан тогтмол ажиллуулж ирлээ. Тус худалдааны төвийн үйл ажиллагааг дэмжин жил бүрийн хавар, намарт орчны бохирдол, халдвараас урьдчилан сэргийлэн ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж, худалдааны төвийн малын эмчийг цаг үеийн сургалт мэдээлэл, арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна. 2025 онд Говил багт малчдын гар дээрээс мах худалдаалах төв шинээр нээгдэж малчид мах, цагаан идээгээ зах зээлийн үнээс хямд үнээр худалдан борлуулж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	132		4.. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19/03 дугаар тогтоолоор аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөнд мал аж ахуйн чиглэлээр 12, мал эмнэлгийн чиглэлээр 4, газар тариалангийн чиглэлээр 11, хүнсний чиглэлээр 1, нийт 28 заалт бүхий арга хэмжээг тусган, хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 онд аймгийн хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 160 тн өвс, 75 тн тэжээл бэлтгэж малчдын хэрэгцээнд нийлүүлж ажилласнаар 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давсан. 2025 онд аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд орон нутгийн төсвийн 196.5 сая төгрөгөөр 166 тн өвс, 144тн хүчит тэжээл бэлтгэхээс 190 тн өвс, 112.5 тн тэжээл бэлтгэсэн. Мөн аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 60 тн өвс, 70 тн үйлдвэрийн тэжээлийг нэмэлтээр бэлтгэсэн. Малчдын түвшинд байгалийн хадлан, тэжээл, хужир, шүү бэлтгэлийн ажил 102.2 хувьтай хангагдсан. Аймгийн хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээнд (21.5 хувь) эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцсэн үйлдвэрийн аргаар бэлтгэсэн үхэр, хонь, ямааны 200 тн мах бэлтгэсэн бөгөөд 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Баян-	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Өндөр сумын 29 цэгт, Жаргалант суманд 3 цэгт үхрийн мах 1 кг нь 12300, хонины мах 1 кг нь 10300, ямааны мах 1 кг нь 8300 төгрөгийн үнээр хэрэглэгчдэд хүргэсэн. Хавсралт : 1 файл			
80	133	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_86-1	1.1.. Тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий “Теле камерын хяналтын дэд төв”-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 74 дүгээр тогтоолоор "Мэдээлэл шуурхай удирдлагын төв" УТҮГ-ыг байгуулж, 11 орон тоотойгоор ажиллаж байсныг Засгийн газрын 2024 оны 86 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус төвийг татан буулгаж, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/479 дугаар захирамжаар "Теле камерын хяналтын дэд төв"-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд шинээр байгуулсан. Тус төв нь шинэчлэн баталсан дүрэм, бүтцийн дагуу 13 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн хэмжээнд хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 26 багт нийт 1346 ширхэг камер бүртгэлтэй байгаагаас нэг чиглэлийн 1120 ширхэг, PTZ хөдөлгөөнт 184 ширхэг, хэт ягаан туяаны 2 ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 25 ширхэг, царай таних 15 ширхэг камер тус тус нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	134		1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын	Орхон аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн зам талбайд чанарын стандартад нийцсэн 1346 ширхэг камер суурилагдсан бөгөөд 100 хувь "Теле камерын хяналтын дэд төв"-д холбогдсон. Үүнээс 2025 онд орон нутгийн төсвийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар багуудын нутаг дэвсгэрт болон сургуулийн гадна орчинд шинээр тусгай зориулалтын камер 51, 360 градусын эргэлттэй камер 13, нэг чиглэлийн камер 113 нийт 177 ширхэг хяналтын камерыг дагалдах хэрэгслийн хамт суурилуулсан. Ингэснээр аймгийн хэмжээнд 26 багт нийт 1346 ширхэг камер бүртгэлтэй байгаагаас нэг чиглэлийн 1120 ширхэг, PTZ хөдөлгөөнт 184 ширхэг, хэт ягаан туяаны 2 ширхэг, ANPR дугаар таних зориулалттай 25 ширхэг, царай таних 15 ширхэг камер тус	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			дэд бүтцийг ашиглан “Теле камерын хяналтын дэд төв”-д холбох боломжийг судалж, шийдвэрлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт;	тус нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллаж байна. “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2024 оны А/648 дугаар захирамжаар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн гадна орчинд (холбогдох хуулиар хориглосноос бусад) болон нийтийн зориулалттай орон сууцны орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайд холбогдох стандартын шаардлага хангасан камер суурилуулах, суурилагдсан дүрс бичлэгийн техник, хэрэгслийг "Теле камерын хяналтын дэд төв төвийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахаар шийдвэрлэж, хэрэгжилтийг үе шаттай хангуулан ажиллаж сургууль, цэцэрлэгийн гадна орчны камеруудыг камерын хяналтын нэгдсэн сүлжээнд бүрэн холбосон. Тайлант хугацаанд 407 иргэн, ААНБ-ын хүсэлтийг хүлээн авч хяналтын камерын тусламжтайгаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан 153.0 сая төгрөгийн хохирлоос 68.0 сая төгрөгийн эд зүйлийг олж тогтоон, хохирлыг барагдуулсан. Мөн сураггүй алга болсон 14 иргэнийг олж тогтоон ар гэрт нь хүлээлгэн өгсөн. Хавсралт : 1 файл			
	135		4 . Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их	Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулж, техникийн хамгаалалтын арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлсэн. Үүнд: - Камер, NVR/DVR, серверийн хандалтын эрхийг хэрэглэгчийн түвшингээр зохицуулан нууц үг, хоёр шатлалт баталгаажуулалтыг (2FA) нэвтрүүлсэн төдийгүй видео бичлэгийг шифрлэдэг болсон. - Сүлжээний аюулгүй байдлыг firewall, VLAN, VPN ашиглан хангаж байна. - UPS болон тасралтгүй тэжээлийн эх үүсвэр ашигладаг болсон ба хуульд заасан хугацаанд бичлэг хадгалах шаардлагыг биелүүлсэн. - Камерын мэдээлэл ашиглах дотоод журам болон Дотоод хяналт, аудит хийх журам боловсруулж батлаж, мөрдөн ажиллаж байна. Камер шүүх үйл ажиллагааг цагдаагийн албан хаагч хариуцан ажиллаж, цуглуулсан дата мэдээллийг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Цагдаагийн газрын зөвшөөрлөөр гаргаж хэвшсэн. Хавсралт : 1 файл			
81	136	Журам батлах тухай “Төрийн нуцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам” 2024-10-09 Дугаар 2024_120_1	2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нуцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (З.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай)	2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусагдсан 200.0 сая төгрөгийн “Тусгай салбарын албаны бэлэн байдлыг хангах, цагийн байдлын онцлог, болзошгүй нөхцөл байдлаас шалтгаалж салбарыг заасан газарт шилжүүлэн байрлуулахад шаардагдах техник хэрэгсэл худалдан авах” төсөл арга хэмжээг Төрийн нуцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журмын дагуу зохион байгуулсан. 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусагдсан 200.0 сая төгрөгийн “Төрийн цэргийн байгууллагын шаардлагатай цахим тоног төхөөрөмж худалдан авах” төсөл арга хэмжээг Төрийн нуцад хамааруулж Онцгой байдлын газарт шилжүүлэн худалдан авах ажиллагааг “Төрийн нуцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу зохион байгуулаа. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
82	137	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ	2. 2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ	Аймгийн ЗДТГ-ын 95 ширхэг компьютер, ухаалаг төхөөрөмжид үйлдлийн систем болон албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамж суулгасан албан ёсны лицензтэй программ хангамжийг бүрэн суулган ажиллаж байна. Мөн төрийн болон орон	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163	хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	нутгийн өмчит байгууллагуудыг албан ёсны лицензтэй программ хангамж ашиглахыг зөвлөн хяналт тавин ажилласнаар төрийн байгууллагууд албан ёсны лицензтэй программ хангамжийг бүрэн суулган ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
83	138	Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-27 Дугаар 2024_191_01	2.3.. Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.	Аймгийн хэмжээнд 2025 онд зохион байгуулагдах аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг жагсаалтыг гарган Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд 2024 оны 1/356 дугаар албан тоотоор хүргүүлж аялал жуулчлалын нэгдсэн цаглабарт тусгуулан төлөвлөн ажиллаж байна. Тайлант хугацаанд Орон нутгийн онцлогт тулгуурлан шашин, соёл, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх 12 арга хэмжээ зохион байгуулж 27888 иргэдэд хүрч үйлчилсэн. Үүнд: Спортын уралдаан тэмцээнээр дамжуулан дотоодын жуулчлалыг татах, аймгийн зочид буудлын үйлчилгээ эрхлэгчид болон худалдаа эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын хүүхдийн спортын өвлийн VIII дугаар наадмын цанын төрлүүдийн шигшээ тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж 12 аймаг, 4 дүүргийн 207 тамирчин, Сагсан бөмбөгийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах U18 тэмцээнийг зохион байгуулж эрэгтэй 28, эмэгтэй 10 багийн нийт 500 гаруй тамирчид оролцсон байна. Мөн орон нутгийн онцлогтой аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох зорилготой "Зэс фестиваль" эвентийг 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулж олон нийтэд чиглэсэн соёл, урлагийн үзвэр, урлагийн тоглолт, зэсийн үзэсгэлэн худалдаа, уул уурхайн компаниудтай хамтарсан соёл, спортын арга хэмжээ зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулж орон нутгийн төсвөөс 40.0 сая	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				төгрөг зарцуулсан. Үзэсгэлэн худалдаанд нийт 200 гаруй нэр төрлийн зэсэн бүтээгдэхүүн дэлгэгдэн 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулж 300.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн тайлант хугацаанд Орхон аймагт Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв нээгдэж эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор зэргэлдээх аймаг, сумдуудаас 6088 иргэн манай аймагт хэвтэн эмчлүүлж, эрүүл мэндийн аялал, жуулчлал хөгжих нөхцөл бүрдээд байна. Хавсралт : 2 файл			
	139		5.. Жуулчдад үйлчлэх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг зохих байршилд байгуулж, байнгын ажиллагаатай байх нөхцөлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Улсын чанартай А1001 авто замын дагуу гадаад, дотоодын аялагчдын ая тух түр буудаллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор БОУАӨЯ, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын түр буудаллах цэгийг Эрдэнэт хаалганы хажууд байгуулахаар шийдвэрлэж, эхний ээлжинд MNS5924:2015 стандартын шаардлага хангасан 6 хүний хүчин чадалтай эко ариун цэврийн байгууламж улсын төсвийн хөрөнгөөр баригдсан ч одоогийн байдлаар ажлыг хүлээлгэж өгөөгүй байна. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт хаалга", Жаргалант сумын "Трактортой хөшөө" орчмын 2 байршилд түр буудаллах цэг байгуулах байршлын мэдээллийг шинэчлэн гаргасан. 2025 онд Жаргалант сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Эрдэнэт угтах хаалганы урд ариун цэврийн байгууламжийн зориулалтаар 150 м.кв газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 03/08 дугаар тогтоолоор батлуулж Жаргалант сумын ЗДТГ-т 2025 оны А303 дугаар захирамжаар эзэмшүүлсэн. Улсын хэмжээнд эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын жагсаалтыг баталсан Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолд Орхон аймгийн Жаргалант сумын Дулаан-Уул багийн нутаг дэвсгэр, Хонгор морьтод зам дугуух байршилд шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай худалдаа үйлчилгээний төв цогцолбор байгуулах зориулалтаар 2 га газрыг эзэмшүүлэхээр тусгагдсан боловч дэд бүтэц, шугам шүлжээнд холбогдох боломжгүй тул дуудлага худалдааг зохион байгуулаагүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
84	140	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217	2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Аймгийн ЗДТГ нь дэргэдэх "Цахим төв", Баян-Өндөр, Жаргалант сумандын E-Mongolia төвүүд, Төрийн цахим үйлчилгээний хэлсийн "Хур-Дан" төвүүдээр дамжуулан хүргэж байгаа бүх үйлчилгээг ХУР-ДАН системийн танилт, нэвтрэлтийн системийг ашиглан хүргэж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
85	141	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2024-12-20 Дугаар 2024_226	4. 4. Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр богино, дунд, урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга С.Одонтуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчлэн боловсруулж, БОАЖ-ын Сайд, аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/441, /А/724 тоот тушаал, захирамжаар батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Аймгийн хэмжээнд агаарын чанарыг сайжруулах 2 бүс байна. Орхон аймгийн агаарын бохирдолыг бууруулах гэр хорооллын яндангийн тоог багасгах зорилгоор "Цэвэр агаартай хот" төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөн төслийг боловсруулах, үе шаттай хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар байгуулаад байна. Эрдэнэт ШУТП гэрээгээр Цэвэр агаартай хот төслийг боловсруулж 2025 оны 5 дугаар сард болсон Эдийн засгийн форумын арга хэмжээн дээр танилцуулагдсан. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож цахилгааны хүчдэлийн уналтыг шийдвэрлэсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

86	142	Жагсаалт батлах тухай 2024-12-25 Дугаар 2024_233	2. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон аймагт хэрэгжих төсөл, арга хэмжээ байхгүй байна. Харин Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд соронзон резонант томографын аппаратыг худалдан авахаар Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангаас 2.0 тэрбум, Эрүүл мэндийн сайдын багцаас 2.0 тэрбум төгрөгийг шийдвэрлэн авахаар болсон тул тус төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ашиглагч байгууллагыг төлөөлж БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч захиралыг томилж өгөхийг хүссэн аймгийн Засаг даргын 01/1022 тоот албан бичгийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, худалдан авах ажиллагааг зарлуулсан боловч гүйцэтгэгч шалгараагүй тендер амжилтгүй болж хөрөнгө нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.2 дах заалтын дагуу төсвийн хэмнэлтэд тооцогдсон байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	143		3. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.тп)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл. арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн	2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн кодыг батлагдсан хэлбэрээр тендер шалгаруулалтыг 100 хувь цахим системээр зохион байгуулсан. 2025 онд давхардсан тоогоор нийт 317 тендерийн зарлал, нээлт, үр дүн, тендерт шалгарсан 212 төсөл арга хэмжээний гэрээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-нд тухай бүрд оруулан ил тод мэдээлсэн. Мөн аймгийн ЗДТГ-ын www.erdenet.mn, Аймгийн ИТХ-ын itkh-orkhon.gov.mn, орон нутгийн www.erdenetnews.mn, Худалдан авах ажиллагааны газрын khaag.erdenet.mn сайт, Facebook пэйж хуудсаар худалдан авах ажиллагааны мэдээллийг иргэд олон нийтэд ил тод мэдээлэхээс гадна 2025 оны Худалдан авах ажиллагааны анхны төлөвлөгөөг Хотын шуудан сонины 2025 оны 01-р сарын 28-ний өдрийн №200/200 дугаарт нийтлүүлж Орхон аймгийн иргэд, ААНБ-уудад мэдээлсэн. .	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай.	Хавсралт : 1 файл			
	144		4. 4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Аймгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ тусгагдсаны дагуу 253 арга хэмжээ буюу 95.1 хувийг хуулийн дагуу шуурхай зохион байгуулсны үр дүнд гүйцэтгэгч шалгарсан 212, тендер зарлаад амжилтгүй болсон 41 төсөл арга хэмжээ байна. Төсөл арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй шалтгаанаар 13 төсөл арга хэмжээ буюу нийт төсөл арга хэмжээний 4.9 хувийг зохион байгуулаагүй байна. Тендерт оролцогч компаниуд шаардлага хангахгүй, тендерт оролцогч байхгүй шалтгаанаар 41 тендер амжилтгүй болсон. Ингэснээр аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 79.7 хувийн биелэлттэй байна. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шуурхай зохион байгуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
87	145	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024-12-25 Дугаар 2024_238_1	2. 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Орон нутгийн төсвийн байгууллагуудын албан хаагчдын үндсэн цалингийн нэмэгдэлд шаардагдах 1.6 тэрбум төгрөгийг 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлж ажилласан. 2025 оны төсвийн жилд аймгийн төрийн захиргааны албан хаагчийн орон тоог 208-аас 206 болгон бууруулсан. Цаашид төрийн байгууллагыг цомхон, чадварлаг бүтэцтэй байх зохион байгуулалтын ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

88	146	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024-12-25 Дугаар 2024_246	5. 5. Орон нутгийн харьяалалтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийслэл хотод нийтийн тээврийн хэрэгслээр 2017-2024 оны хооронд зорчсон зардал болох нийт 1.3 тэрбум (нэг тэрбум гурван зуун сая) төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг тооцооллын дагуу нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт 2025 онд багтаан шилжүүлэн барагдуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Орон нутгийн харьяалалтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийслэл хотод нийтийн тээврийн хэрэгслээр зорчсонтой холбоотой өр авлагын асуудал үүсээгүй байна.	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	
89	147	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай 2025-01-29 Дугаар 2025_37	5. 5.“Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын чиг үүргийн шинжилгээгхийж, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Засагдаргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагийн хооронд чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/754 дүгээр албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын чиг үүргийн шинжилгээг хийж, шинжилгээний дүгнэлтийг үндэслэн албан хаагчийн чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах зохицуулалт хийж албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлах зөвшөөрлийг хүсч Төрийн албаны зөвлөлд 2025 оны 5 дугаар сард хүргүүлсэн ч өнөөг хүртэл хариуг ирүүлээгүй байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

90	148	Хүүхдийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээний тухай 2025-01-29 Дугаар 2025_41	2. 2 .Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, өвөл, хаврын улиралд зохион байгуулагдах хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 нас хүртэлх хүүхдийг аливаа хэлбэрээр оролцуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга, Цагдаагийн ерөнхий газар (Т.Сүхболд), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар (Т.Ихтамир)-т тус тус үүрэг болгосугай.	Аймгийн нутаг дэвсгэрт өвөл, хаврын улирал буюу 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох тухай аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/765 дугаар захирамж гаргаж, захирамжийн хэрэгжилтэд сумдын ЗДТГ, Цагдаагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд сумдын Засаг дарга болон Морин спорт уяачдын холбоонд 4 чиглэл бүхий нутаг дэвсгэрийн хэмжээнд хурдан морины уралдаантай холбоотой хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах талаар Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж, олон нийтийн цахим сүлжээгээр 3 постер зөвлөмжийг түгээн ажилласан. Аймгийн хэмжээнд 2025 оны 05-р сарын 01-ээс 11-р сарын 01 хүртэлх хугацаанд хурдан морины 5 уралдаан зохион байгуулагдан нийт 663 морь уралдаж, 322 унаач хүүхэд оролцсон. Уралдааны явцад Цагдаагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, БОЭТ-ийн албан хаагчид уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрхийг хамгаалах, хамгаалалтын бүрэн хувцас, хэрэглэлтэй оролцуулахад хяналт тавин ажиллаж, стандартын гутал, малгай, мөрөвч, тохойвчгүй хүүхдүүдийг тухай бүрд нь илрүүлэн уяач, морины эзэдтэй холбогдон нэн даруй зөрчлийг арилгуулан ажилласан. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
91	149	Ой тэмдэглэх тухай 2025-01-29 Дугаар 2025_44	2. 2.0йг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж, арга хэмжээний төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын	Батлан хамгаалах яамнаас гаргасан шийдвэрийн дагуу Монголын ХХ зууны түүхэнд онцгой байр суурь эзэлдэг төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын хошой баатар, өрлөг жанжин-маршал Хорлоогийн Чойбалсангийн мэндэлсний 130 жилийн ойн арга хэмжээг үндэсний батлан хамгаалахын их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнд болон Дорнод аймагт зохион байгуулахаар шийдвэрлэн түүний төрсөн нутаг болох Чойбалсан суманд зохион байгуулсан. Бусад аймаг хотод тус ойг зохион байгуулах чиглэл өгөгдөөгүй болно.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	

			сайд Ч.Номин, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хавсралт : 1 файл			
92	150	Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-02-05 Дугаар 2025_67	3. 3.Орон нутагт яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн “112” дугаарлалтаар хүлээн авах үйл ажиллагааг Теле камерын хяналтын дэд төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Орхон аймгийн хэмжээнд эмнэлэг, онцгой байдал, цагдаагийн байгууллагын яаралтай тусламжийн дуудлага мэдээллийг нэгдсэн системд холбохоор судалгааны ажил хийгдэж, "112" дугаарлалтаар хүлээн авах үйл ажиллагааг Теле камерын хяналтын дэд төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээний зардалд 164.0 сая төгрөгийг 2026 оны орон нутгийн төсөвт тусгуулж батлуулсан. Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	
93	151	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	2. 2. Томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Аймгийн хэмжээнд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөхдөө гаргасан зураг, төсвийн дагуу төлөвлөн, гадаад валютын нөөцөд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар тооцон жил бүр төлөвлөн ажиллаж байна. 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг хүлээн авахдаа зураг төсөв батлагдаж мэргэжлийн байгууллагаар магадлал хийгдсэн төсөл арга хэмжээг сонгож байна. Өнөөдрийн байдлаар 65.7 тэрбум төгрөгийн 25 төсөл арга хэмжээний саналыг хүлээн авч Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын системд 10 төсөл арга хэмжээний саналыг бүрэн байршуулсан. Орхон аймагт “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” нийт 9.0 сая еврогийн өртөг бүхий түлхүүр гардуулах нөхцөлтэй ажил гүйцэтгэх гэрээг Польш улсын “ППЭйЧ Мэлиорекс” ХХК-тай, Польш улсын Засгийн газар, Монгол	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн гэрээг тус тус байгуулсан. Одоогийн байдлаар гүйцэтгэгч компани нийт 8.1 сая еврогийн хөрөнгө оруулалтыг оруулж ажлын гүйцэтгэл 95.0 хувьтай байна. Европын сэргээн босголт хөгжлийн банкны 14 сая долларын санхүүжилтээр Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төслийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж үерийн далан барих, усан хангамжийг сайжруулах дэд төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлснээр Усан хангамжийн шугам сүлжээний засвар, шинэчлэлийн 8 ажил хийхээс 4 ажил хийгдсэн ба нийт ажлын гүйцэтгэл 66.0 хувьтай байна. Хавсралт : 1 файл			
	152		4. 4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай.	Орхон аймагт Европын Сэргээн босголтын хөгжлийн банкны хөнөглөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн "Үерийн хамгаалалтын ажил"-ын гүйцэтгэгч БНХАУ-ын Хунан Индастриал Экүйпмент Инсталэйшн ХХК болон "Усан хангамжийн сүлжээг өргөтгөх, засварлах ажил"-ын гүйцэтгэгч Престиж Инженеринг ХХК-иас дундын санхүүжилтийн төлбөр саатаж, орохгүй байгаа асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирүүлсний дагуу 2025 оны 11 дүгээр сард Төслийн ажил гүйцэтгэгчдийн гүйцэтгэлийн санхүүжилтийг баталгаажуулан олгож өгөхийг хүссэн хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн Засаг даргын 01/3043 тот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн төдийгүй тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын холбогдох удирдлагуудтай аймгийн удирдлагууд уулзалт хийсэн. Гэвч Сангийн яамнаас өн Улсын төсвийн зээлийн ашиглалт-гүйцэтгэлтэй холбогдуулан төслийн гүйцэтгэгч нарын санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд багтаан санхүүжүүлэх боломжгүй болсон тул 2026 онд дахин хүсэлтээ ирүүлэх тухай хариуг ирүүлээд байна. Дээрхээс өөрөөр гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, гадны хөрөнгө оруулалтыг татах талаар иргээс өргөдөл, хүсэлт ирүүлээгүй болно. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

94	153	Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай 2025-03-06 Дугаар 2025_119	2. 2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. /Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн “Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт”-ыг хавсралт ёсоор баталсугай/	Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 119 дүгээр тогтоолын хавсралтаар Орхон аймагт өмчлүүлэх газрын байршил батлагдаагүй байна. Хавсралт : 1 файл	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	
95	154	Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2025-03-06 Дугаар 2025_120	2. 2.Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомж, журмыг баримталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга, Чөлөөт	Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх газрын хэмжээ байршлыг тогтоосон Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолд заасан жагсаалтын дагуу эзэмшүүлж, ашиглуулах шийдвэрийг гарган газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авсан. Үүнд: Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох 66,56 га газраас 66,56 га газрыг эзэмшүүлж тухайн арга хэмжээний биелэлт 100%-тай биелсэн. Дуудлага худалдаагаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлж, ашиглуулах 22 байршилд 4.06 га газрын 13 байршилд 3.79 га газар дээр 11 ялагч тодорч гэрээ байгуулж гэрчилгээ олгосон бол үлдсэн 9 байршилд дахин дуудлага худалдаа зарласан боловч ялагч тодроогүй байна. Өвөлжөө, хаваржааны доорх газрыг давуу эрхээр эзэмшүүлэх 16 байршлын 3.52 га газрыг, тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх 18 байршлын 17.64 га газрыг, уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар эзэмшүүлэх 3947.58 га газрыг тус тус эзэмшүүлсэн. Малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх 6 байршлын 24.7 газраас 5 байршлын 23.13 га газрыг эзэмшүүлж, 1 байршилд төсөл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			бүсийн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	ирээгүй ба тухайн арга хэмжээний биелэлт 93.6%-тай байна. Иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшлийн бус, амралт зугаалга, биеийн тамирын зориулалттай 1 байршлын 0.16 га газрыг нийтийн эдэлбэр газарт авсан, нөхөн олговортойгоор солих 0.11 га газрыг 2 иргэнд эзэмшүүлсэн. Мод бут сөөг тарихаар төлөвлөгдсөн Говил багийн Цагаан чулуутын аманд 1.72 га газарт мод тарьж нөхөн сэргээх ажил, Баян-Овоот багт Сум дундын ойн ангитай хамтран хамгаалалтын хашаа хийж 0,35 га газарт 6300 ш 3 төрлийн мод тарьсан, Хангал голын голдирол дагуу 1,08 га талбайд 1513 ш бургас тариалж нөхөн сэргээж дууссан. Албадан чөлөөлөх 0.27 га газрыг Баян-Өндөр сумын Засаг даргын 2025 оны А/303 тоот захирамжийн дагуу албадан чөлөөлснөөр тус тогтоолын хэрэгжилт 96.4%-ийн биелэлтэйгээр хэрэгжүүллээ. Хавсралт : 1 файл			
96	155	Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-03-12 Дугаар 2025_132	1. Олон улсад үүсэж байгаа геополитикийн болон худалдааны хурцадмал, тодорхойгүй нөхцөл байдалтай холбогдуулан хүн амд үзүүлэх үйлчилгээний зохицуулалтын уялдааг хангах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, зөвлөл, хороо, комиссын дарга нар, бүх шатны	Аймгийн хэмжээнд төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг нэмэгдүүлээгүй болно.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.				
97	156	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2025-03-19 Дугаар 2025_141	2. 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2025 онд цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 172 иргэнийг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгаж, мөнгөн төлбөрийн орлого 314.0 сая төгрөгийг төв төрийн сангийн дансанд төвлөрүүллээ. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
98	157	2026 оныг “Боловсролыг дэмжих жил болгон зарлах тухай 2025-04-02 Дугаар 2025_158	3. 3.Боловсролыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засагдарга нарт үүрэг болгосугай.	2026 оныг улсын хэмжээнд "Боловсролыг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, боловсролын салбарт хийгдсэн судалгаанууд болон 2026 оны улс, орон нутгийн төсөвтэй уялдуулан боловсруулах чиглэлийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас даалгаж тогтоол гарсан. Тогтоолын дагуу "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сард багтаан аймгийн Засаг даргын Зөвлөлийн хэлэлцүүлж батлуулахаар төлөвлөж байна. Хавсралт : 1 файл	Х.Б	Х.Б	
99	158	Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-28 Дугаар 2025_204	1.1.1.. 1.1.1.“Хойд бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө”-г төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Соёл, спорт,	Булган аймагт зохион байгуулагдсан Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны үеэр Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо"-той аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэхэд шаардлагатай төрийн бодлого, тогтоол, шийдвэр зэрэг эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулахад санал өгөх, Орхон аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа жуулчны бааз, зочид буудал, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийн ангилал зэрэглэлийг тогтоох, аялал жуулчлалын судалгаа, дата мэдээллийг хамтран гаргах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн сүлжээний сувгаар сурталчлах, Олон	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

			аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номинд;	Улсын болон Үндэсний соёлын эвент арга хэмжээнд жуулчдыг өргөнөөр хамруулах боломжуудыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Санамж бичгийн хүрээнд аймгийн хэмжээнд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг зочид буудал, дэн буудал, ресторан, зоогийн газар, амралтын газруудад зочлох үйлчилгээ, стандартын талаар сургалт зохион байгууллаа. "Хойд бүс-Эрдэнэт 2025" эдийн засгийн форум, Хойд бүсийн аймгуудын удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөн, ОХУ-ын Улан-Үдэ хотын "Эдийн засаг, соёлын өдөр" бизнес эрхлэгчдийн форум, "Эрдэнэт медикал" эмнэлгийг түшиглэн Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв байгуулах зэрэг аймгийн хэмжээнд улсын чанартай 3, бүсийн чанартай 4, орон нутгийн 2 фестиваль, аймгийн зочид буудлуудын үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах зорилгоор 2 удаагийн сургалт нийт 15 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж 129 иргэн аж ахйун нэгжийг дэмжин оролцуулж 460.1 сая төгрөгийн борлуулалтыг хийж 28138 иргэд үйлчилгээгээ үзүүлсэн. Хавсралт : 2 файл			
	159		1.2.8.. 1.2.8.Орхон аймгийн Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг ашиглалтад оруулах ажлыг шуурхай зохион байгуулахыгХот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр нарт, тус өргөтгөлийн барилга байгууламжийг бүрэн дуусгах, туршилт, тохируулга хийх ажилд шаардлагатай санхүүжилтийг 2025 оны	2025 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 2,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг ашиглалтад оруулахаар тендер зарлагдсан боловч гүйцэтгэгч шалгараагүйн улмаас 2026 онд хэрэгжүүлэхээр хойшлогдсон.	Х.Б	Х.Б	

			хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу шийдвэрлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Г.Ёндон)-т.				
	160		1.3.1.. 1.3.1.Хойд бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан Орхон, Хөвсгөл, Булган аймгийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг байгалийн аялал жуулчлал, уул уурхай, эрчим хүчний чиглэлээр төрөлжүүлж, дэд бүтцийн төслийн хүний нөөцийг богино хугацаанд бэлтгэх, давтан сургах зорилгоор Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн дэргэд байгуулах салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад шаардагдах санхүүжилтийн асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн	Хүн ам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэнгээс зохион байгуулж буй танхимын мэргэжил олгох сургалтыг Орхон Политехникийн коллежтой хамтран оёдол, гоо сайхан, тогооч, барилгын засал, ойн аж ахуй зэрэг 5 мэргэжлээр 48 иргэнийг хамруулж 19.8 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Орхон аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэд "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль нь уул уурхай, мэдээллийн технологи, цахилгаан хангамж, санхүү нягтлан бодох бүртгэл зэрэг 20 хөтөлбөрөөр төрөлжүүлэн үйл ажиллагаагаа явуулж жил бүр бакалавр, магистрийн ангид 350 гаруй оюутныг элсүүлэн сургаж мэргэжилтэн бэлтгэж байна. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

			сайд Л.Гантөмөр, Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д;				
	161		1.3.2.. 1.3.2.Хойд бүсийн цэцэрлэг, сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Багшийн хөгжлийг дэмжих төвийг Орхон аймагт байгуулахад шаардагдах санхүүжилтийн асуудлыг судалж, танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д;	Орхон аймагт Хойд бүсийн Багшийн хөгжлийг дэмжих төвийг Баян-Өндөр сумын Чандмань багт байрлах аймгийн Боловсролын газрын нэр дээрх 2900м2 газарт барихаар төлөвлөсөн. Барилгын зургийг "Прайм Проект" ХХК-ний зурсан Баянхонгор аймагт барьсан "Багшийн хөгжлийн ордон"-ы зурагтай холболтын зураг хийх боломжтой бөгөөд холболтын зургийн зардлыг 2026 оны орон нутгийн төсөвт тусгагдсан зөвлөх үйлчилгээний зардлаас гаргуулахаар төлөвлөж байна. Хавсралт : 1 файл	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	
	162		1.4.2.. 1.4.2.Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд бүсийн хэмжээнд хог хаягдлын тээвэрлэлт, үйлчилгээний хураамжийн орлогын зарцуулалт, менежментийн хяналтыг сайжруулж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, холбогдох эрх зүйн актыг батлан мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Хойд бүсийн аймгийн Засаг дарга нарт.	Орхон аймгийн Хог хаягдлын тээвэрлэлт, үйлчилгээний хураамжийн хэмжээг Баян-Өндөр сумын 2022 оны ИТХ-ын тогтоолоор батлан мөрдлөг болгон ажиллаж, орлогыг аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэн Баян-Өндөр сумаас гүйцэтгэл, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж байна. 2025 онд хог хаягдлын тээвэрлэлт, үйлчилгээний хураамжаар 1740.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, ХТГ-ын үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 10.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож ажиллалаа. Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрнгө оруулалтаар 2023 онд 2.65 тэрбум, 2024 онд 1.9 тэрбум төгрөг зарцуулан Хот тохижуулах газрын парк шинэчлэлтийг хийсэн. 2025 онд сумын хөрөнгө оруулалтаар Хот тохижуулах газарт хог ачих машин 2 ширхэг, төмөр чингэлэг 40 ширхэг, хуванцар хогийн сав 200 ширхэг, гурван дугуйт тэрэг 5 ширхэгийг нийлүүлсэн. Үүний үр дүнд гэр хорооллын айл өрхүүдээс хог хаягдал тээвэрлэх	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				давтамж нэмэгдэж, хогийн бөөгнөрөл үүсэх асуудал шийдэгдсэн байна. Тухайлбал Хүрэнбулаг баг 11а, в хэсэг, Чандмань баг эко хороолол, Баянцагаан багийн цагаан байр буюу оношилгооны арын байр, Говил багийн ар булаг, дэнж баг элит хотхон, Хүрэнбулаг баг баян-өндөр мед эмнэлэг байршлуудад өдөр бүр хөдөлгөөнт чингэлэг шинээр байршуулан айл өрхийн хог хаягдлыг ачиж тээвэрлэж байна. Иргэдийн буруутай үйлдлээс болж ил задгай хог хаягдал ихээр үүсч, орчны бохирдол бий болж байгаа 5 байршилд камеруудыг шилжүүлэн байршуулж холбогдох арга хэмжээг авч ажилласнаар эзэнгүй, ил задгай хог хаягдал үүсэх байдал эрс багасаад байна. 2025 онд нийт 225010м3 хогийг тээвэрлэн дарж устгасан. Цаашид ХТГ-ын парк шинэчлэлт хийгдэж хүчин чадал нэмэгдсэнтэй холбогдуулан Хот тохижуулах газрын зарим үйл ажиллагааг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх, хувийн хэвшлээр зарим ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх талаар судалгаа хийгдэж байна. Хавсралт : 1 файл			
	163		1.5.1.. 1.5.1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Бүсийн дата төв, Орхон аймгийн Эрдэнэт хотод Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-Очир)-д;	Цахим хөгжил, харилцаа холбооны яам Хойд бүсийн зөвлөл болон орон нутгийн удирдлагатай хамтран бүсийн мэдээллийн технологи, инновацын төв байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сард Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн паркийн 1100м2 ажлын байранд хэмжилт, төлөвлөлт хийсэн. Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк ажлын байрыг бэлдсэн.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	
	164		1.5.2.. 1.5.2.“Цахим аймаг, ухаалаг хот” зөвлөмжийг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хойд бүсийн зөвлөл (Д.Пүрэв-	Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/86 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж Орхон аймаг Хойд бүс - Эрдэнэт 2025 эдийн засгийн форумд бүсийн болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ухаалаг хотын төслийн ерөнхий танилцуулгыг хийсэн ба тайлант онд	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	

			Очир)-д, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд.	нарийвчилсан төсөл, судалгаа, зураг, төслүүдийг боловсруулах ажлууд хийгдэж байна. 2026 онд ухаалаг хотын стандартад нийцсэн нэгдсэн удирдлагын систем (dashboard)-ийг угсрах, дата төвтэй болох зорилт тавин аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/956 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж техник эдийн засгийн тооцооллыг хийж байна. Хавсралт : 1 файл			
100	165	Ой тэмдэглэх тухай 2025-04-28 Дугаар 2025_206	3. 3.Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т, ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Ерөнхий сайд асан Агданбуугийн Амарын мэндэлсний 140 жилийн ойг 2026 онд тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэр гарсан тул хугацаа болоогүй.	Х.Б	Х.Б	
101	166	Алт олборлолтыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-30 Дугаар 2025_211	4. 4.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа алт олборлогч аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт, хайгуул, олборлолтын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учрах хор	Орхон аймагт алтны ордын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байхгүй болно.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	

			уршгийг арилгах, байгальд ээлтэй технологийн шийдлийг нэвтрүүлэх, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд тавих хяналтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах арга хэмжээг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан нарт тус тус үүрэг болгосугай.				
102	167	Тусгай зориулалтаар 2025 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай 2025-05-21 Дугаар 2025_242	2. 2.Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Манай аймагт тусгай зориулалтаар агнах амьтан байхгүй ба тус тогтоолын 1, 2 дугаар хавсралтад Орхон аймагт соёлын, спортын болон олзворын зориултаар агнах барих амьтны тоо хэмжээ батлагдаагүй тул хяналтаас хасуулах саналтай.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	
103	168	Хүн ам, орон сууцны завсрын тооллого явуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2025-05-28 Дугаар 2025_260	2. 2.Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогод ашиглах мэдээллийн сангийн мэдээллийн чанарыг сайжруулах, шинэчлэх, баталгаажуулах арга хэмжээг харьяа нутагт дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг	Хүн ам, орон сууцны завсрын тооллогод ашиглах Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн вебэд суурилсан шинэчилсэн программыг хэрэглээнд нэвтрүүлэхийн тулд 2025 оны 10 дугаар сарын 9-ны өдөр программын бүтэц, үйл ажиллагаа, санг хөтлөх журмын талаарх сургалтыг зохион байгуулж, сумдын статистик хариуцсан ажилтнууд, 29 багийн Засаг дарга, зохион байгуулагч, статистикийн хэлтсийн ажилтнууд болох нийт 80 албан хаагчийг хамруулан сургаж, дадлага хийлгэн чадавхжуулсан. Ингэснээр аймгийн хэмжээнд уг санг хөтлөх эрх бүхий 60 үндсэн болон дэд хэрэглэгчийн эрхийг нээлгүүлэн, программыг амжилттай нэвтрүүлж, өдөр тутам хүн амын хөдөлгөөнийг бүртгэж, баяжилтыг хийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			дарга нарт үүрэг болгосугай.	мэдээллийн сангийн чанарыг сайжруулан ажиллалаа. Хавсралт : 1 файл			
104	169	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279	1. 1.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амраж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиосонтой холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдөр амарсан тул бүх төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагаас тус өдрүүдийг нөхөн ажиллах тушаал гарган нөхөн ажилласан. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
105	170	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	2. 2.Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2026 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарын батлагдсан дүнд нийцүүлэн аймгийн нэгдсэн төсвийн орлогыг 405.7 тэрбум төгрөг байхаар төсвийн төслийг боловсруулж аймгийн ИТХ-ын 2025 оны 02/58 дугаар тогтоолоор батлагдсан. Үүнээс аймгийн төсвийн орлого 354.1 тэрбум төгрөг, Баян-Өндөр сумын орлого 40.9 тэрбум төгрөг, Жаргалант сумын орлого 10.7 тэрбум төгрөг байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
106	171	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар	1.6. хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн соёл, спорт, соён гэгээрүүлэх үйл	2025 оны 05 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд "Мансууруулах үйлчилгээтэй олсны ургамлыг устгах ажлын үр дүнг дээшлүүлэх нь" сэдэвт бүсчилсэн зөвлөгөөнийг Орхон аймагт зохион байгуулсан. "Устгал-2025" нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		авах зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_29	ажиллагааг идэвхжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд тайлбарлан ойлгуулах ажлыг тогтмол зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Тагнуул, Онцгой байдал, Мал эмнэлгийн газартай хамтран 2025 оны 6 сард 60 литрийн багтаамжтай ургамлын хор цацагч дроныг ашиглаж аймгийн хэмжээнд зэрлэг олсны ургамал /канабис/-ыг 60 га талбайд устгах ажлыг зохион байгуулсан. 2025 оны 9 сард Тархцын хяналт-2025 арга хэмжээг зохион байгуулж Дархан, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгаас Орхон аймагт орох, гарах хөдөлгөөнд алба хаагчдыг 24 цагийн постонд гаргаж хяналт тавьж ажилласан ба хяналтаар ямар нэг зөрчил илрээгүй байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд, залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах зорилгоор "Анзаар", "Мансуурал", "Устгал", "Тархцын хяналт" нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчид, эцэг, эхчүүд болох нийт 1567 иргэнд 10 удаагийн 10 цагийн сургалт мэдээллийн ажлыг хүргүүлж, 5300 ширхэг санамж, зөвлөмж, урьдчилан сэргийлэх чиглэлийн танилцуулга бүхий QR кодтой үзэг тарааж, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газартай хамтран бэлтгэсэн 3, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас бэлтгэсэн 16, нийт 19 мэдээлэл, постерийг цахим орчинд түгээж 41258 иргэнд мэдээллийг сурталчилж ажилласан. Хавсралт : 2 файл			
	172		3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон "Устгал-2025" арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг, аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас 70.0 сая төгрөг, нийт 80.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгон хамтран ажилласан. Тухайлбал: "Устгал-2025" нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Тагнуул, Онцгой байдал, Мал эмнэлгийн газартай хамтран 2025 оны 6 сард 60 литрийн багтаамжтай ургамлын хор цацагч дроныг ашиглаж аймгийн хэмжээнд зэрлэг олсны ургамал /канабис/-ыг 60 га талбайд устгах ажлыг зохион байгуулсан. 2025 оны 9 сард Тархцын хяналт-2025 арга	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Засаг дарга нарт даалгасугай.	хэмжээг зохион байгуулж Дархан, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгаас Орхон аймагт орох, гарах хөдөлгөөнд алба хаагчдыг 24 цагийн постонд гаргаж хяналт тавьж ажилласан ба хяналтаар ямар нэг зөрчил илрээгүй байна. Хавсралт : 2 файл			
107	173	Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2025-08-20 Дугаар 2025_56	2.3.. мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн ган, зудын зураглалыг нарийвчлан гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн батлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян)-т;	Аймгийн хэмжээнд зуд, шар усны үер, үер, томуу, хүчтэй салхи шуурга, ой хээрийн гал түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар баталсан заавар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/255 дугаар тушаалаар баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу эрсдэлийн үнэлгээг хийсэн. Үнэлгээний дүнгээр аймгийн хэмжээнд зуд бага, шар усны үер их, үер их, ой хээрийн гал түймэр бага, томуу бага, их салхи шуурга дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна. Иймд Үнэлгээний үр дүн, зөвлөмжийн дагуу эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн, урьчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах зэрэг төлөвлөлтүүдийг хийж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	174		2.4.. өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд зам, гүүрний засварын ажлыг дуусгах, улсын болон орон нутгийн чанартай авто зам, даваа хаагдахаас урьдчилан сэргийлэх, зам засвар, ашиглалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж	2025-2026 оны Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах" зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 26 заалт бүхий арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажилласнаар 96.3 хувийн хэрэгжилттэй байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын хуралдаанд тус тус танилцуулан ажилласан. Цаг агаарын байдал хүндэрч зам даваа, гүвээ хаагдах нөхцөл байдал үүсэх тохиолдолд Баян-Өндөр суманд Ковш 1, дальпуу 2, Жаргалант суманд Ковш 1, трактор LOVOL-824 6 ширхэг, YTO-1404 1 ширхэг, дугуйт тракторууд, цас ярагч дальпуу 2 ширхэг зэрэг техник	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, аймгийн Засаг дарга нарт;	хэрэгслийг ажиллуулахаар бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
	175		2.5.. аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээрийн даацад тохируулан мал өвөлжүүлж, хаваржуулах чиглэлийг тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд 29 багийн 1102 малчин өрхөд 187.8 мянган толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 525.2 мянган толгой малыг өвөлжүүлж байна. Оны эхний нийт мал сүргийн 34.9 хувь буюу 61.4 мянган толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулсан. Хөрш зэргэлдээ аймаг, сумдын нутаг дэвсгэрт отроор 433 малчин өрхийн 86.2 мянган толгой мал өвөлжиж, хаваржина. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	176		2.6.. улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малын тоо, малчин өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, орон нутгаас гаргасан судалгаанд үндэслэн отроор өвөлжүүлж, хаваржуулах боломж, нөхцөлийг бүрдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хил	Малчдын отор нүүдлийн судалгааг 2025 оны 08 дугаар сард авахад улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, мал байхгүй байна. Энэ жил Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга хадлангийн талбай олгуулах, малчдыг өвөлжүүлж хаваржуулахаар хөрш зэргэлдээ аймаг, сумдтай гэрээ байгуулж, хөрш зэргэлдээ аймаг, сумдын нутаг дэвсгэрт отроор 433 малчин өрхийн 86.2 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 30 өрхийн 2.3 толгой мал өвөлжүүлж байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн)-т;				
	177		2.7.. аймгийн болон сум дундын отрын бүс нутаг шинээр бий болгох тооцоо, судалгаа хийж, хэрэгжилтийг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт;	Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга хадлангийн талбай олгуулах, малчдыг өвөлжүүлж хаваржуулах хамтын ажиллагааны хүрээнд гэрээ хийж хөрш зэргэлдээ аймаг, сумдын нутаг дэвсгэрт отроор 433 малчин өрхийн 86.2 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 30 өрхийн 2.3 толгой мал өвөлжиж, хаваржуулна. Манай аймаг газар нутаг багатай учир шинээр аймгийн болон сум дундын отрын бүс нутаг бий болгох боломжгүй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	178		2.10.. энэ тогтоолын хавсралтаар заасан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, мал эмнэлгийн хорио, цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03/33 дугаар тогтоолоор аймгийн хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө батлагдсан. Төлөвлөгөөнд мал аж ахуйн чиглэлээр 11, мал эмнэлгийн чиглэлээр 4, газар тариалангийн чиглэлээр 10, хүнсний чиглэлээр 1, нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2016 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар"-ын дагуу мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл зохион байгуулалтын ажлыг 7 үзүүлэлтээр дүгнэхэд аймгийн хэмжээнд 96.3 хувь ханган ажилласан. МУ-ын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолоор аймаг, сумдын аюулгүйн нөөцөд нийт 166 тн бүдүүн тэжээл (өвс), 144 тн хүчит тэжээл бэлтгэхээс 190 тн өвс, 112.5 үйлдвэрийн тэжээлийг бэлтгэсэн. Мөн аймгийн Онцгой комиссын хурлаар 60 тн өвс, 70 тн үйлдвэрийн тэжээлийг нэмэлтээр бэлтгэсэн. Бусад аймаг орон нутгаас шилжин ирж байгаа болон дамжин өнгөрч байгаа малын хөдөлгөөн, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавьж 2025 онд Мал эмнэлгийн цахим системд нийт 1365 гэрчилгээ бичигдсэн. Үүнээс: Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 987, амьд малын шилжилт хөдөлгөөнд 378 цахим гарал үүслийн гэрчилгээ олгосон. Манай аймгаас бусад аймаг руу адуу 656, үхэр 384, хонь 111, ямаа 867 нийт 2018 мал отор нүүдэл, үржлээр гарч, манай аймагт адуу 390, үхэр 324,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				ямаа 92, хонь 35 нийт 841 мал бусад аймаг, орон нутгаас шилжин ирсэн. Цахим системээр бусад аймаг орон нутгаас шилжин ирж байгаа болон дамжин өнгөрч байгаа малын хөдөлгөөнд, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавьж ажилласнаар хүн амыг эрүүл аюулгүй бүтэгдэхүүнээр хангах нөхцөл бүрдэж, малын халдварт, гоц халдварт өвчнөөр эрүүл тайван байдлыг хадгалж байна. Хавсралт : 1 файл			
	179		2.13.. ургац хураалтын ажилд их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутан, сонсогч, хугацаат цэргийн алба хаагчдыг татан оролцуулах, тэдгээрийн цалин хөлс, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд П.Наранбаяр, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд ургац хураалтын ажилд шаардлагатай хүн хүчний судалгааг гаргаж, оюутан, цэргийн албан хаагчдыг татан оролцуулах ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд Орхон аймаг дахь Политехникийн коллежийн 168 оюутан, 50 хугацаат цэргийн албан хаагч, Батлан хамгаалах их сургуулийн 60 сонсогч, орон нутгийн ажилгүй иргэдийг ажиллуулахаар өдрийн 50.0-100.0 мянган төгрөгийн цалин хөлстэй ажиллуулахаар гэрээ хийж Орхон аймгийн Жаргалант сум, Сэлэнгэ аймгийн Орхон сум, Булган аймгийн Бугат суманд ургац хураалтад ажиллууллаа. Ургац хураалтад ажиллах хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, хяналт тавин ажилласан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	180		2.14.. улсын хэмжээнд шаардлагатай улаанбуудай, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээлийн хэрэгцээ,	2025 онд газар тариалангийн салбарт 13 аж ахуйн нэгж, байгууллага, 272 өрх үйл ажиллагаа явуулж 5156 га талбайд тариалалт хийхээр төлөвлөснөөс нийт эргэлтийн талбайг 100 хувь ашиглаж нийт 5691 га-д хураалт хийн, гүйцэтгэл 100 хувьтай байна. Үүнээс: 3719 га-аас 10850 тонн буюу 29.1	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хангамжид үндэслэн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын зохистой харьцааг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын нөөцийг бүрдүүлж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад анхаарч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	цн/га үр тариа , 165.1 га-аас 1959 тонн буюу 118 цн/га төмс, 463 га-аас 11035 тонн буюу 238 цн/га хүнсний ногоо, 746 га-аас 750 тонн буюу 10 цн/га тосны ургамал, 598 га-аас 1007 тонн буюу 16.8 цн/га тэжээлийн ургамал тус тус хураан авч аймгийн хүн амын хэрэгцээт төмсний 52 хувь, хүнсний ногоог 100 хувь орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. Аймгийн хэмжээнд нийт 3719 га талбайд улаанбуудай тариалж 10554 тонн буюу 27 цн/га улаан буудай хураан авсан. Улаан буудай борлуулалт өөрийн үрэнд 805 тн, гурилын үйлдвэрт 4280 тн, улсын үрийн нөөцөд 4800 тн, спиртийн үйлдвэрт 640 тн борлуулсан. Стандартын шаардлага хангасан 5605 тн үр бэлтгэсэн. Хянан баталгаанд үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 4 аж ахуйн нэгжийн 1951 га талбайд тариалсан 5 сортын улаан буудайг хамруулж хянан баталгаанд хамрагдсан таримлыг сорт тус бүрээр тайланга гарган хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн Хавсралт : 1 файл			
	181		2.17.. арилжааны зориулалтаар байгалийн хадлан бэлтгэх гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2025 онд аймгийн хэмжээнд малчдын түвшинд 17500 тн байгалийн хадлан бэлтгэхээс 17854 тн байгалийн хадлан бэлтгэсэн. Үүнд: Баян-Өндөр сум 9500 тн бэлтгэхээс 9854 тн, Жаргалант сум 8000 тн буюу 100 хувь бэлтгэсэн. Өөрийн аймгийн хадлангийн талбайгаас 2000 тн, хөрш зэргэлдээ аймаг, сумдын талбайгаас 10354 тн, зах зээлээс 5500 тн -ыг тус тус бэлтгэсэн. Аймгийн аюулгүйн нөөцөд нийлүүлэх байгалийн хадланг тендэр шалгаруулалтад оролцон шалгарсан аж ахуйн нэгж бэлтгэн нийлүүлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	182		2.19.. цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд цаг алдалгүй, шуурхай хүргэх арга	Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь http://orkhon.weather.gov.mn/, https://orkhon.namem.gov.mn/, https://control.e-mongolia.mn/, https://e-office.erdenet.mn/ сайтууд болон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв пэйж хуудсаар цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд цаг алдалгүй, шуурхай хүргэх ажлыг тогтмол хийж байна. Үүнд: Цаг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хэмжээ авч ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга), аймгийн Засаг дарга нарт.	агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээг 40 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 15 удаа, урьдчилсан сэргийлэх мэдээг 1 удаа зохиож мэдээлсэн. Ой хээрийн түймэр гарах нөхцөлийг агаарын хуурайшлын зэргээр өдөр бүр тодорхойлж гарган ой хээрийн түймрээс анхааруулах мэдээг 107, сэрэмжлүүлэх мэдээг 80, урьдчилан сэргийлэх мэдээг 51 удаа тус тус Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, аймгийн онцгой комиссын гишүүд, гэрээт байгууллагууд, малчид тариаланч, ард иргэд, хэрэглэгчдэд масс мессеж үйлчилгээ буюу гар утсанд нь давтагдсан тоогоор 11424 удаа, Е-мэйл хаягаар 57 хүнд, утсаар 365 удаа тухай бүрд нь хүргэж үйлчилсэн байна. Мэдээний таарц өмнөх жилээс 8.3 хувиар өссөн дүнтэй байна. Хавсралт : 1 файл			
	183		3.. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулахад шаардлагатай санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулах зорилгоор аймгийн ИТХ-ын тогтоолоор 2025-2026 оны ХАА-н өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахад Улсын төсвөөс 117.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 596.5 сая төгрөг, иргэн, аж ахуйн нэгжээс 1.7 сая төгрөг, нийт 716.1 сая төгрөг зарцуулсан. Үүнд: Малын вакцин тарилагад улсын төсвөөс 117.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 84.0 сая төгрөг, иргэн, аж ахуйн нэгжээс 1.7 сая төгрөг, тэжээл тариалахад Жаргалант сумын ОНХС-аас 100.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 404.4 сая төгрөг, малыг ялган тэмдэглэхэд 4.3 сая төгрөг, өвөлжилт, хаваржилтын байдалтай танилцахад 4.2 сая төгрөг тус тус зарцуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
108	184	Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай	1.. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангах зорилтын хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр барьж шинээр ашиглалтад	2025 онд орон нутгийн төсвийн 602.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар давхардсан тоогоор сургалтын 27 байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил, хэрэглэгдэхүүнээр хангасан. Үүнд: 1. Ерөнхий боловсролын сургуулиудад шинээр байгуулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд тоног төхөөрөмж	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2025-08-27 Дугаар 2025_64	оруулсан хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад шаардлагатай тавилга, тоногтөхөөрөмж нийлүүлэх ажлыг 2025 онд батлагдсан төсөвтөө багтаан, өр үүсгэхгүй, холбогдох хууль, журамд нийцүүлэн, санхүүгийн гэрээ байгуулах замаар зохион байгуулахыг Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	худалдан авахад 100.0 сая, 2. Ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хөгжлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авахад 232.9 сая, 3. Ерөнхий боловсролын 6-11-р ангиудад 1000 ном төсөл уншлагын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай худалдан авалт хийхэд 250.0 сая, 4. 13 дугаар сургуулийн Монгол хэлний кабинетэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 20.0 сая тус тус зарцуулсан. Дээрх ажлуудыг 2025-2026 оны хичээлийн жил эхлэхээс өмнө худалдан авах ажиллагааг зохион байгуулж сургуулиудад хүлээлгэн өгсөн. Хавсралт : 1 файл			
109	185	Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах зарим газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2025-09-02 Дугаар 2025_74	3. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн мэдээллийг бүрдүүлэх, газар эзэмших, ашиглах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг шуурхай шийдвэрлэх хүрээнд Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Усны тухай, Ойн тухай, Төмөр замын тээврийн тухай, Авто замын тухай, Харилцаа холбооны тухай, Эрчим хүчний тухай болон холбогдох бусад хуульд заасан байгаль орчин, уул уурхай, зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний салбарын орон	Ойн болон усан сан бүхий газруудын мэдээллийг сансрын зурагтай давхцуулан хил зааг буруу өгөгдөл мэдээллийг засварлаад байна. Цэвэр усны шугам, хамгаалалтын зурвас газар болох 150.08 га газар, Төмөр замын газарт хамаарах 137.06 га газрын хил заагийн шалган газрын нэгдмэл сангийн цахим системд оруулсан. Аймгийн хэмжээнд газрын удирдлагын нэгдсэн цахим системээр нийт 1870 хүсэлт хүлээн авсан. Үүнээс шинээр газар эзэмших 596, эзэмшиж буй газраа өмчлөх 118 хүсэлт хүлээгдэж байна. Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 358, барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх 498, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах 96, газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 4, эзэмшиж ашиглаж буй газрын зориулалт өөрчлөх 22, эзэмшил газраа бусдад ашиглуулах 2, төрөөс нөхөн олговортойгоор эргүүлэн авах 2, худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах 3, эзэмшил газраа хэсэгчлэн шилжүүлэх 24, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх дуусгавар болгох 1, газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаар авах 7, нэгж талбар нэгтгэх, хуваах 17, газрын эрхийн төрөл өөрчлөх 8, нэгж талбарыг нөхөн бүртгэх 112, газар өмчлөх	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			зайн өгөгдөл мэдээлэл бүхий мэдээллийн санг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системтэй бүрэн холбож дуусгах, газар ашиглалтын мэдээллийг тухай бүр зураглаж, нэгтгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүс, хотын захирагч нарт тус тус даалгасугай.	эрхийг эзэмших эрхүү шилжүүлэх 2 хүсэлт ирснээс судалж шийдвэрлэн нийт 886 нэгж талбарын газар ашиглалтын мэдээллийг тухай бүр зурагласан, шаардлага хангаагүй буюу хуульд нийцээгүй 270 хүсэлтийг буцаасан байна. Хавсралт : 2 файл			
110	186	Зорилт шинэчлэн батлах тухай 2025-09-10 Дугаар 2025_91	3.. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох салбар тус бүрийн зорилтыг эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Байгаль орчны салбарын байгууллагуудын албан хаагчдад хүлэмжийн хий, карбон кредитийн зах зээлийн талаар НҮБХХ-тэй хамтран сургалт зохион байгуулсан.Орхон аймгийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгарал шингээлтийг тооцоолох зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. НҮБ-ын Хүүхдийн Сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Барилгын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах" төслийн хүрээнд Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28 дугаар цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх ажил бүрэн дуусаж тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Тохируулга зүгшрүүлэлтийн үеэр Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28 дугаар цэцэрлэгийн барилгыг нэмэлт галлагаагүйгээр халааж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэх хэмжээний бохирдлыг бууруулах боломж бүрдэнэ. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	
111	187	Эрүүл мэндийн даатгалын	5.. 5.Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл	2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		сангийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-11-05 Дугаар 2025_151	мэндийн байгууллагуудын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг хуульд заасны дагуу хариуцан санхүүжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	төвийн мэс заслын вакум хагалгааны 2 өрөөг засварлаж ашиглалтад оруулсан. Мөн орон нутгийн төсвийн нийт 1389.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мэндцэцэн Өрхийн эрүүл мэндийн төвийн гадна шугам, Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төвийн гадна фасад болон дээврийн засвар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргэлтийн төвийн засвар, Гемодиализийн хэсгийн засвар, Хагалгааны нэгдсэн тасгийн дээврийн засваруудыг тус тус хийж ашиглалтад оруулснаар эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх ээлтэй орчинг бүрдүүлж тусламж үйлчилгээг бүсийн хэмжээнд үзүүлэн эмнэлгийн тусламжийн аюулгүй байдал сайжирсан байна. Хавсралт : 1 файл			
112	188	2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлах тухай 2025-11-05 Дугаар 2025_154	4.. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2027 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан тул хугацаа болоогүй	Х.Б	Х.Б	
Ерөнхий сайдын захирамж							
113	189	Үндэсний хороо байгуулах тухай /Хүчирхийллийн эсрэг үндэсний хороо/ 2025-07-30 Дугаар 1	2. Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны Ажлын албаны чиг үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаар хариуцуулан гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатарт, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн	АХүчирхийллийн эсрэг аливаа үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагааны болон иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын зардалд орон нутгийн төсөвт 40.0 сая төгрөгийг батлуулж, түр хамгаалах байрыг Баян-Өндөр сумын Чандмань багт "Хөүп таун" хотхонд 3 өрөө байр түрээслэн аймгийн "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар" хариуцан ажиллуулж байна. Тайлант хугацаанд Түр хамгаалах байранд нийт 64 үйлчлүүлэгч (үүнээс 57 нь хүүхэд, 7 нь насанд хүрсэн хүн) хүлээн авч, хүүхэд хамгааллын 6 төрлийн үйлчилгээ үзүүлэн давхардсан тоогоор нийт 121 удаагийн хариу үйлчилгээ үзүүлэн 15 хүүхдэд кейс нээн ажилласан. Энэ нь өнгөрсөн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. 3.Хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хамтарч ажиллахыг иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.	оны мөн үетэй харьцуулахад түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдийн тоо болон нээгдэж ажилласан кейсийн тоо 22.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн хохирогчдыг даван туулагч болгох зорилгоор "Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэн, "Ариунсаруулбат" ТББ-тай хамтран 2 гэр бүлийн 7 хүнд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэн ажилласан. Судалгааны дүнгээс үзэхэд, үйлчилгээ авсан хүүхдүүдийн 70.5 хувь нь суурь хүмүүжил, сэтгэл зүйн хямрал, сөрөг зуршлаас, 29.5 хувь нь бусдын нөлөөнд автсанаас шалтгаалан гэмт хэрэгт холбогдсон байна. Иймд стрессээ танин мэдэх, уур бухимдлаа зохицуулах, эерэг дадал зуршлыг төлөвшүүлэх, өөрийн мэдрэмжээ таних, бусадтай ижилсэх, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтуудыг үе шаттай зохион байгуулсан. Тухайлбал: Хүчирхийллийн эсрэг үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд сэтгэл зүй, сэтгэл заслын оношилгоо, эмчилгээ хийх зорилгоор "Гэр бүлийн гишүүдийн сэтгэл хөдлөлийн дасгалжуулалтын төв" НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан хамтран ажиллаж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан болон зан үйл засах шаардлагатай хүүхдүүдэд сэтгэл зүйн оношилгоо, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлсэн. Хавсралт : 2 файл			
114	190	Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-08-13 Дугаар 2025_64	5.. Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор өмгөөллийн "Миранда Партнерс" хуулийн фирмтэй хамтран Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар болон багуудын ажлын албаны нийт 250 албан хаагчид авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн орон нутгийн төрийн байгууллагуудын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах талаарх сургалт зохион байгуулах хуваарь гарган ХЭЗХ-ийн даргаар батлуулж, хуваарийн дагуу 11 байгууллагын 148	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.	албан хаагчдад сургалт орсон. Төрийн албан хаагчдын дунд Авлигын эсрэг дэвжээ тэмцээн зохион байгуулж, 9 байгууллагын 53 албан хаагч оролцсон. Хавсралт : 2 файл			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
115	191	2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 32 дугаар тэмдэглэл 2021-05-27 Дугаар 2021_32	ХҮ.3. . Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 5 дугаар сарын12-14-ний өдрүүдэд Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймагт ажилласан тухай Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан санал, хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнахыг Засгийн газрын холбогдох гишүүд болон бусад албан тушаалтанд даалгав.	Монгол улсын Ерөнхий сайдыг Орхон аймагт ажиллах үеэр тавьсан хүсэлтийн дагуу дараах ажлын ажлууд хийгдэж байна. Үүнд: Монгол Улсын 2024 оны төсөвт Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл 92.13 км төслийг 16.1 тэрбум төгрөг төсөвлөгдөн 8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр худалдан авах ажиллагааг ЗТЯ-наас зарлан зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Монгол ЛЗ зам гүүр” ХХК шалгарсан боловч хугацаандаа гэрээ байгуулагүйн улмаас хүчингүй болсон. Тус төсөлд 2026 оны улсын төсөвт 5.0 тэрбум төгрөгийг тусган батлуулсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг нэмэгдүүлж 50.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр 8.3 км авто зам, 23.3 км авто замын их засвар шинэчлэлтийн ажил, 5 байршилд авто зогсоол, авто замын тэмдэг тэмдэглэгээний нийт 50 ажил хийхээр төлөвлөн ажилласнаас одоогийн байдлаар 4.9 км авто замыг шинээр, 18.6 км авто замд их засвар шинэчлэлт, авто зогсоолын ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулсан бол 2026 онд 2 байршилд шинээр авто зам, 4 байршилд авто замын засвар шинэчлэлтийн ажил үргэлжлэн хийгдэнэ. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг нэмэгдүүлж 1. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил”-ыг улсын төсвийн 19.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Компорт импекс” ХХК 2022 оноос ажлыг эхлүүлснээр 2025 оны улсын төсвөөс 4.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, ажил бүрэн дуусаж ашиглалтад хүлээн авах комисс ажиллан хүлээн авлаа. 2. ДЦС-ын Ф720мм-ийн дулааны төв шугам сүлжээний өргөтгөх барилга угсралтын нийт 4321.1 сая төгрөгийн үнийн дүн бүхий ажил одоогийн байдлаар 85 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2024 оны улсын төсөвт 1682.7, 2025 онд 400.0 сая төгрөг батлагдсан. 3. Төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, УДДТ	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				барих нийт 4329.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий ажлын /Цагаанчулуут Наран баг/ барилга угсралтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2024 онд тус ажилд улсын төсөвт 1,688.0, 2025 онд 400.0 сая төгрөг тус тус батлагдсан. Хавсралт : 1 файл			
116	192	2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	YIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу аймгийн Засаг даргын А/580 захирамжаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах байнгын комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл оролцуулан ажиллаж байна. 2025 оны байдлаар Орон сууц нийтийн дэд бүтцийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах 24 удаа комисс ажиллаж тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартын шаардлагыг тавьж ажилласан. Нийтийн орон сууцны зориулалттай барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх хүртээмжийн үнэлгээний судалгааг хийж цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллэл бүхий судалгааг нэгтгэн гаргасан. Аймгийн хэмжээнд 9 сургуульд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-ыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулснаас 2025 онд шинээр 2 сургуульд орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус танхимыг байгуулсан. Эдгээр төвүүдэд ажиллах багш нарын цалин, урамшуулал, чадавхижуулах үйл ажиллагаа, хөгжлийн ялгаатай хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр 2025 оны орон нутгийн төсөвт 50.0 сая төгрөг батлуулж аймгийн Засаг даргын 2025 оны А/397 дугаар захирамжаар шийдвэрлэн 30 гаруй удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус, иргэдэд чиглэсэн сэргээн засах болон хөгжүүлэх үйлчилгээг 7 ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж орон нутгийн төсвөөс 342.7 сая төгрөгийг зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүдэд тусгайлан зориулсан хөгжлийн цогц төв байгуулах шаардлагатай байгаа тул 2024 онд 8.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн зураг, төсвийг "ЭМ ЭМ ЭЛ" ХХК-иар гүйцэтгүүлж Барилгын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хөгжлийн төвийн1272/2024 дугаар магадлалын дүгнэлт гаргуулж улсын төсөвт тусгуулахаар 2025, 2026 оны төсөвт санал өгсөн ч хасагдсан. Барилгыг барих газрыг аймгийн Засаг даргын захирамж 2024 оны А/36 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Хавсралт : 2 файл			
117	193	2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58	XII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Баян-Өндөр сумын 18 дугаар цэцэрлэгийн анхны барилга нь палкан бүтэцтэй, тоосгон өнгөлгөөтэй, нийтийн хоолны зориулалттай баригдаж, 1975 онд ашиглалтад орсон ба цэцэрлэгийн зориулалтаар 1978 оноос ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар барилгыг ашиглах боломжгүй болсон бөгөөд мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг даргы 2019 оны А/801 дүгээр захирамжаар барилгыг актлах шийдвэр гаргасан. Тус цэцэрлэг нь өнөөдрийн байдлаар Канад хийцийн барилга болон өргөтгөлийн 150 хүүхдийн барилгад үйл ажиллагаагаа явуулж байна. Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байр газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул буулгаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилгын суурин дээр шинээр 960 хүүхдийн сургууль барих ажил 2022 оноос эхэлсэн бөгөөд 2025 онд багтаан ашиглалтад оруулахаар барилгын ажил 95 хувийн гүйцэтгэлтэйгээр явагдаж байна. Тус барилгын ажилд 2022 онд 980.0 сая, 2023 онд 2,235.4 сая, 2024 онд 4,190.8 сая, 2025 8,586.1 сая төгрөг тус тус батлагдаж барилгын ажил хэвийн үргэлжилж байна. Ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга 2001 онд баригдаж эхэлсэн боловч зогссон. Тус барилгын карказ дээр барилга үргэлжлүүлж барих боломжгүй тухай барилгын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн буулгах ажилд 2025 оны орон нутгийн төсөвт 300.0 сая төгрөг батлагдаж ажил хийгдэж дууссан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
118	194	2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63	XY.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа,	Хүн амын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг хэрэглээний сагс дахь 13 бүлгийн 333 нэр төрлөөр сар бүр тогтмол судалдаг. Хэрэглээний бараа,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63	үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт;	үйлчилгээний үнийн ерөнхий индекс 2025 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар, 2024 оны 12 дугаар сараас 5.4 хувиар, өмнөх сараас 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 22.6 хувиар, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 15.2 хувиар, амралт, чөлөөт цаг, соёлын барааны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.6 хувиар, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.0 хувиар, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувиар, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.5 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.0 хувиар, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 5.8 хувиар, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.0 хувиар, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувиар, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 3.9 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувиар өссөн бол харин гэр ахуйн тавилга, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувиар буурсан байна. Гол нэрийн 66 төрлийн барааны дундаж үнийн судалгааг долоо хоног бүр зах зээлээс судалж байна. 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн үнийн мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дизель, хонины мах, савласан сүү, цагаан будаа, Аи-92 шатахуун, улаан лооль, лууван, үхрийн мах, өргөст хэмх, ямааны мах, байцаа, төмсний үнэ 4.1-63.1 хувиар нэмэгдэж, элсэн чихэр, өндөг, ургамлын тос, нэгдүгээр зэргийн гурилын үнэ 2.3-7.8 хувиар буурч, шингэн сүү, А-80 шатахууны үнэ өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлтөд гадаад валютын ханш болон импортын бараа бүтээгдэхүүн, түүхий эд материалын үнийн өсөлт, тээвэрлэлтийн хөлс нэмэгдсэн нь шууд нөлөөлж байна. Хавсралт : 2 файл			
119	195	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах	2020 оноос "Цахим аймаг" болох зорилт дэвшүүлж "Цахим Эрдэнэт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн ЗДТГ-ын дэргэ "Цахим төв"-ийг шинээр ашиглалтад оруулж төрийн 215 үйлчилгээг 24/7 цагийн турш үзүүлж	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2022-02-16 Дугаар 2022_11	шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	байна. Мөн Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН киоск машиныг аймгийн хэмжээнд 10 цэгт байршуулан үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна. "Цахим төв"-өөс иргэн, хуулийн этгээд 16 төрлийн 37 үйлчилгээ, "E-Mongolia"- Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс 73 төрлийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаас 9 төрлийн 72 үйлчилгээг үзүүлж байна. Төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, хүнд сурталгүйгээр иргэд олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор Баян-Өндөр, Жаргалант суманд E-Mongolia төвийг 2021 оноос ажиллуулж байна. ХААН банкны АТМ болон киоск машин, Төрийн банкны АТМ, төлбөр тооцооны киоск машинаар төрийн үйлчилгээ, үүрэн холбоо, авто тээвэр зэрэг 5 төрлийн 33 үйлчилгээг цахимаар хүргэн иргэдэд үйлчилж 2023-2024 онд нийт 10000 гаруй иргэн тус төвөөр үйлчлүүлж, цахим үйлчилгээ авсан. 2024 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд аймгийн алслагдсан гэр хорооллын үйлчилгээний нэгдсэн төвийн нэг давхарт иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулан хүргэх зорилгоор "Хурдан" төвийн байр талбайг тохижуулан байгуулж шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр ханган шинэ төвийг нээн ажиллуулсан. Баян-Өндөр сумын захын бүсийн иргэд Төрийн мэдээллийг "Хурдан" төвөөр дамжуулан 86 байгууллагын 1173 төрлийн лавлагаа тодорхойлолтыг холбогдох Төрийн байгууллага дээр очихгүйгээр хурдан шуурхай чирэгдэлгүйгээр авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн 2024 онд И-Монгол лавлагааны киоск машин 3 ширхгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авч Жаргалант сум, Баян-Өндөр сумын ЗДТГ, Гэр хорооллын нэгдсэн байрны ХурДан төвийн үйлчилгээний хэсэгт тус тус байршуулан хэвийн үйл ажиллагааг ханган лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Хавсралт : 2 файл			
120	196	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл	XIY.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж,	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 54 хүнсний үйлдвэр, цех, хүнсний бөөний болон худалдааны төвд байгаа 12 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүр тогтмол шинэчлэн авч, хүнсний нөөцийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2022-03-02 Дугаар 2022_14	үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	цахим системд мэдээлж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар: малын мах 589.5 тонн, төмс 1450.7 тонн, хүнсний ногоо 4315.3 тонн нөөцтэй байгаа нь жишсэн дундаж нийт хүн амд харьцуулахад малын махны 57 хоног, төмс 141 хоног, хүнсний ногоо 194 хоногийн нөөцтэй байна. Иргэдийг шинэ ургацын төмс, хүнсний ногоогоор хангах, тариаланчдын борлуулалтыг дэмжих зорилгоор Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газраас зөвшөөрсөн цэгүүд болон наадмын талбайн арын авто машины жижиг зогсоол, Уурхайчин баг, бусад зөвшөөрөгдсөн талбайд ногооны худалдааг зохион байгуулснаар Наадмын талбайн ард 12 иргэн, бусад зөвшөөрөгдсөн талбайд 10 иргэн шинэ ургацын төмс, хүнсний ногоо худалдаалсан. "Намрын ногоон өдрүүд-2025" нэгдсэн арга хэмжээ Улаанбаатар хотын Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдаж, манай аймгаас 15 иргэн, аж ахуйн нэгж оролцсон. Үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, улирлын хэрэгцээг хангах зорилгоор аймгийн жишсэн дундаж нийт хүн амын 2025 оны хаврын махны хэрэгцээг 90 хоногоор тооцож нийт 926.8 тонн малын мах хэрэгцээтэй байгаагийн 21.5 хувь буюу 200 тонн махны нөөц бүрдүүлэхээр төлөвлөж, сонгон шалгаруулалтад Эрдмийт ХХК шалгарч үхрийн мах 110 тонн, хонины мах 80 тонн, ямааны мах 10 тн, нийт 200 тонн махыг ангилж, савласан байдлаар 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Баян-Өндөр сумын 29 цэгт, Жаргалант суманд 3 цэгээр зах зээлийн үнээс үхрийн мах 1 кг нь 6200, хонины мах 1 кг нь 4867, ямааны мах 1 кг нь 3700 төгрөгөөр тус тус хямд үнээх хэрэглэгчдэд хүргэсэн. Өвлийн идэш 2025 худалдааг 12 дугаар сард зохион байгуулж Орхон, Хөвсгөл, Завхан аймгаас 23 малчин, худалдаа эрхлэгчид оролцож зах зээлийн үнээр идэшний мах борлуулсан. Хавсралт : 1 файл			
121	197	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл	XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх	Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.9 сая төгрөгийг шийдвэрлэн нээлттэй хаалганы өдөрлөг болон томоохон төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад очиж тоон	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

		2022-05-11 Дугаар 2022_28	ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	гарын үсэг олгох ажлыг зохион байгуулахад шаардагдах 4G зөөврийн тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг олговол зохих 73598 иргэн байгаагаас Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш өнөөг хүртэл 40601 иргэнд тоон гарын үсэг буюу 55.0 хувьд нь олгоод байна. Үүнээс 2025 онд 6289 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. Аймгийн хэмжээнд төрийн бүх шатны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж буй И-Оффис цахим системд тоон гарын үсгийн технологи, хэрэглээг 2025 оны I сараас эхлэн нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн. Тус тоон гарын үсгийн системийг тайлант хугацааны байдлаар и-оффис системд холбогдсон 163 байгууллагаас 15 байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хавсралт : 1 файл			
122	198	2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34	XII.10. . Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон	Ханхар уул-50 геологийн судалгааны төслийг улсын төсвийн хөрөнгөөр Орхон аймгийн 2 сумын нутаг дэвсгэрийг хамарч Гео Эко зураглал ХХК хийж, судалгааны ажлыг гүйцэтгэхэд аймаг, сумын зүгээс дэмжин ажилласан. Ханхар уул-50 төслийн талбай нь Булган аймгийн Бүрэгхангай, Орхон, Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нутгийг хамарч М-48-113-А, Б, В, Г, М-48-125-А, Б, В хавтгайн хэмжээнд нийт 2386.17кв.км талбайг эзэлж байна. 2023 онд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгав: 1. Геологийн салбарыг тэргүүн ээлжид хөгжүүлэх стратегийн бодлогыг баримталж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг төрийн удирдлагаар хангаж хот, суурин газар, бүс нутгийн хэмжээнд геоэкологи, газрын доорх ус, газар хөдлөл, хөрсний гулсалтын геологи орчинг тодорхойлох, эрдэс баялгийн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчинг бүрдүүлэх, олборлох салбарыг ашигт малтмалын найдвартай нөөцөөр хангах зорилгоор улсын төсвийн санхүүжилтээр өөрийн аймгийн нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх; 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу тухайн судалгааны ажлын үр	М-48-113-А, Б, В, Г хавтгайнуудын хэмжээнд 1193 кв.км талбайд 1:50000-ны машстабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийж гүйцэтгэн геологи, баримт бүрдэл зэрэг холбогдох зургуудыг зохиож Үндэсний геологийн албаны Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан. Уг хээрийн ажлын үед авагдсан дээж сорьцыг геологийн баримтын төв архивд тушаасан. Эдгээр сорьцын үр дүнгээр алт, зэс, цайр-төмрийн 7 ширхэг эрдэсжсэн цэг илэрсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ- нь Оюутын ордын нарийвчилсан хайгуулын ажлыг 2023 онд эхлүүлж хайгуулын урьдчилсан үр дүнгээр 0.32 хувийн зэсийн агуулгатай 357.0 сая.тн хүдрийн нөөцтэйг тогтоогоод байна. Оюутын ордод түшиглэн жилд 5-10 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэрийн өргөтгөл хийснээр нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өнөөгийн хүрсэн түвшнийг бууруулалгүйгээр хадгалж ажиллах нөхцөл бүрдсэн. Цаашид Эрдэнэтийн овоо ордын Баруун-Хойд, Төвийн хэсгүүдэд захын агуулгыг оновчлох, нөөцийг шинэчлэн тооцоолох, Оюутын хэсгийн нарийвчилсан хайгуулыг эцэслэн, ашиглалтад бэлтгэх, Эрдэнэтийн стратегийн ордын талбайн хүрээнд хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинэ нөөц тогтоох ажил үргэлжлэн хийгдэж байна. Одоогийн байдлаар хайгуулын ажил 10 хувьтай явагдаж байна. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Стратегийн ордын талбайд хамаарах хэтийн төлөв бүхий хэсгүүдэд эрэл хайгуулын ажил гүйцэтгэх, эрэл хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх төслийн төсвийг батлуулан, худалдан авах ажиллагааны хүрээнд нээлттэй тендер шалгаруулалтыг 2026 онд зарлахаар төлөвлөсөн. Хавсралт : 1 файл			

			дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах; 3. Аймаг, сумын Засаг даргын тамгын газраас төсөл хэрэгжүүлэгч тухайн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа судалгааны ажлын зорилго, үр дүнгийн талаар орон нутгийн иргэдэд таниулах, сурталчлах арга хэмжээг жил тутам зохион байгуулж байх.				
123	199	2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39	XYIII.3.1.4. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан хөгжлийн төслүүдийн бүтээн байгуулалтын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж, газрын асуудал болон эрх хэмжээний хүрээнд хамаарах тусгай зөвшөөрөл олгох, төлбөр, хураамж авах, хэлцэл хийхтэй холбоотой асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд: Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд: Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд 2024 онд БОАЖЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Баян-Өндөр сумын гэр хорооллын 19 м2 хүртэлх талбай бүхий монгол гэртэй 63 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусган айлуудтай гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. НҮБ-ын Хүүхдийн Сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Барилгын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах" төслийн хүрээнд Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28 дугаар цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх ажил бүрэн дуусаж тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэх хэмжээний бохирдлыг бууруулах боломж бүрдэнэ. Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлыг Аймгийн Засаг даргын 2025 оны А/360, А/785 дугаар захирамжуудаар мод	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				тарих ажлын төлөвлөгөө, тарих модны байршил, тоо хэмжээг батлуулж, хэрэгжүүлэн ажиллалаа. Мод тарих олон талт арга хэмжээг зохион байгуулж төрийн болон хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор Дэнж багийн Тарлан толгойн таримал ойн төгөл, Баян-Овоот уулын орчим, Жаргалант сумын цэцэрлэгт хүрээлэн, Баян-Өндөр уулын Хүрэнбулагийн ам, Далиу булаг, А1001 авто зам дагуух ойн зурвас, Эрдэнэт хаалга орчим болон Хангал голын голдирол дагуух нийт 12 байршилд бүх нийтийн мод тарих ажлыг зохион байгууллаа. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2022-2024 онд 4.839.686 ширхэг мод, 2025 онд 429457 ширхэг мод, өссөн дүнгээр 5.269.143 ширхэг мод тарьж “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны хэрэгжилтийг 100 хувьд хүргээд байна. Хавсралт : 2 файл			
124	200	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн	Дотоод удирдлагын программ хангамж болох И-Оффис системтийг 2018 оны 05 дугаар сарын 01-нээс нэвтрүүлэн төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, Засаг даргын дэргэдэх агентлаг, харъяа байгууллага, сургууль цэцэрлэгүүдийг хамарсан 163 байгууллагын 2312 хэрэглэгч албан хэрэгт ашиглаж байна. Уг системийг ажлын хэрэгцээ шаардлага, Засгийн газрын тогтоол, журмын дагуу тухай бүр өргөжүүлж хөгжүүлснээр хоорондоо уялдаа холбоо бүхий бодлого хөтөлбөр, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, захиргаа, хүний нөөц, албан хэрэг хөтлөлт, бүртгэл тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөө, харилцаа холбоо гэсэн 7 үндсэн системд 31 төрлийн дэд систем болон өргөжиж баяжсан байна. 2023 онд төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны дундын систем болох https://docx.gov.mn системд бүрэн холбогдож одоогийн байдлаар тус системд холбогдсон 2672 байгууллагатай албан бичиг солилцох нөхцөл боломж бүрдэн ажиллаж байна Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			байгууллагын удирдлагад үүрэг болгов;				
125	201	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оноос орон нутгийн өмчит 28 байгууллагын 51 тээврийн хэрэгслийг битүүмжлэх жагсаалтыг гаргаж автомашинуудыг битүүмжилсэн. Орон нутгийн өмчит 8 байгууллагад ашиглагдаж байсан элэгдлээрээ өртгөө нөхсөн, сэлбэж ашиглахад эдийн засгийн үр өгөөж муу 24 тээврийн хэрэгслийг дуудлагын худалдаагаар худалдах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 11/05 дугаар тогтоол гарсны дагуу дуудлагын худалдааг 3 удаа зохион байгуулж 7 байгууллагын 9 тээврийн хэрэгслийг 97.9 сая төгрөгөөр, 1 байгууллагын 1 үл хөдлөх хөрөнгийг 51.9 сая төгрөгөөр худалдан борлуулж, дуудлагын худалдааны орлогыг Эрдэнэт санд төвлөрүүлсэн. Тээврийн хэрэгслийг битүүмжлэх ажлыг зохион байгуулах явцад албан ажлын онцлог, чиг үүргээс шалтгаалан тухайн байгууллагад ашиглагдах зайлшгүй шаардлагатай 13 суудлын автомашин, дуудлагын автомашины зориулалтаар ашиглуулах 4 суудлын автомашин байсан. Албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас аймгийн Засаг даргын Тамгын газарт ашиглагдаж байсан Тоёота прадо маркийн 129.0 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг Жаргалант сумын Засаг даргын газарт, Жаргалант сумын Тамгын газарт ашиглагдаж байсан Тоёота кроун маркийн 33.0 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг аймгийн Засаг даргын Тамгын газарт, аймгийн Засаг даргын Тамгын газарт ашиглагдаж байсан Тоёота харриер маркийн 29.5 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг Хотын захирагчийн албанд, Эрүүл мэндийн газарт ашиглагдаж байсан Хьюндай портер маркийн 20.0 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тус тус шилжүүлсэн. 2025 онд орон нутгийн өмчит 41 байгууллагад ашиглагдаж байсан ашиглалтын хугацаа дууссан, техникийн хяналтын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй тодорхойлогдон цаашид ашиглах боломжгүй болсон 822.2 сая төгрөгийн балансын үнийн дүнтэй 19 автомашиныг акталж, 169.1 сая төгрөгийн балансын үнийн дүнтэй 7 автомашиныг үнэ тогтоон худалдсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
126	202	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	“Орон нутгийн өмчит хувьцаат компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын удирдлага зохион байгуулалт, үр ашгийг дээшлүүлэх, дүрмийг боловсруулах зөвлөх үйлчилгээ”-г авахаар шийдвэрлэгдсэний дагуу “Орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газруудын удирдлага зохион байгуулалт, үр ашгийг дээшлүүлэх, дүрмийг боловсруулах” зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж шалгарсан “Жаргалт Хаан хайрхан консалтинг” ХХК-тай гэрээ байгуулан зөвлөх үйлчилгээг авсан. Зөвлөх үйлчилгээний үр дүнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг компанийн хэлбэрт шилжүүлэх, алдагдалтай ажиллаж байгаа хуулийн этгээдийг нэгтгэх, татан буулгах, менежментийн хувьчлал хийх тухай чиглэлийг аймгийн ИТХ-аас өгсөн тул Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчлэлт, Компанийн тухай хууль шинэчлэн батлагдсаны дараа зөвлөх үйлчилгээний үр дүнг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/, 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын эрэмбэ цахим судалгааны материалуудыг байршуулж нийтэд түгээсэн. 2025 онд зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгаа байхгүй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
127	203	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10	XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөний дагуу 2025 онд шүлхий өвчний дархлаажуулалтад 35.8 мянган толгой мал, амьтан хамруулж гүйцэтгэл 96.4 хувь, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 25.1 мянган бог малын төл хамруулж гүйцэтгэл 99.8 хувь хэрэгжүүлж эрүүл тайван байдлыг хадгалж байна. Тус ажилд улсын төсвөөс 44.5 сая төгрөг зарцуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

128	204	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар 2024 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн хяналт шинжилгээ үнэлгээ хийж аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаар тайланг хэлэлцүүлж, Жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн. 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг байгууллагуудаас авч, нэгтгэн төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банк хамтран зохион байгуулж буй "Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр"-т орон нутгаас 1 эмэгтэй удирдагчийг хамруулсан. Иргэд олон нийтэд жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор "Жендэрийн ерөнхий ойлголт", "Жендэрт суурилсан хүчирхийлэл"-ийн тухай сургалтыг зохион байгуулж 5 байгууллагын 152 албан хаагчийг хамруулж, тэдний жендэрийн тухай мэдлэг ойлголтыг дээшлүүлсэн. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан ажлын байран дахь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сургалтад 12 удирдах ажилтныг цахимаар хамруулж, Өсвөр үе хүүхэд багачуудад хөгжил хамгааллын өдрийн үйлчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 2 ТББ-тай гэрээ хийж, 6.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Жендэрийн үндэсний хороотой хамтран менторшип хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төрийн байгууллагын удирдлагуудад жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сургалтад 80 албан хаагчийг хамруулахад орон нутгийн 1,8 сая төгрөг зарцуулсан. Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяны хүрээнд сургалт, цахим хичээл, контент, жендэрийн ойлголтыг галгах тест зэраг арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 3983 гаруй иргэдийг хамруулж, орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг зарцуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	205		XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн	Нас,хүйс,эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх үзлэгүүдэд хүн амыг бүрэн хамруулах чиглэлээр ажлын хэсгийн 12 удаагийн хурал, дэмжлэгт хяналт 10, идэвхжүүлэх аян 4 удаа зохион байгуулж, салбар дундын оролцоог ханган ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт 94.6%-тай байна.Тайлант хугацаанд Эрүүл мэндийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	байгууллагуудаар аймгийн хэмжээнд нийт 728121 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 260844 хийгдэж нийт үзлэгийн 35.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх үзлэгт аймгийн 69955 иргэн хамрагдан үзлэгийн хамрагдалт 65.9 хувьд хүрч улсын хэмжээнд 21 аймгаас тэргүүлж байна. Үзлэгээр нийт 28157 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс хоол боловсруулах, дотоод шүүрэл, зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл тэргүүлж байгаа бөгөөд зөвлөгөө өгсөн 3526, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад шилжүүлсэн 4660, нарийн мэргэжлийн эмчид илгээсэн 4491 иргэнийг эмчилгээ, идэвхтэй хяналтад аваад байна. ЭМДЕГ-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний 05/2192 тоот албан бичиг, ЭМС-ын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны 1а/4450 дугаар албан бичгээр ""Хүн амын нас, хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг ""-ийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоох шийдвэр гарсаныг мэдэгдсэн тул эрт илрүүлгийн үзлэгийг зогсоосон. БОЭТ, Эрдэнэт медикал, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт ходоодны уян дурангийн нийт 8 аппаратыг эрт илрүүлэг үзлэгт ашиглаж байна. Ажлын байран дахь эрт илрүүлэг үзлэгт 122 байгууллагын 4071 ажилтан лавлагаа шатлалын урьдчилан сэргийлэх багцад хамрагдсан. БОЭТөвийн Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төвд нийт 5083 иргэн хавдрын эрт илрүүлэгт хамрагдаж, шинээр 147 хавдар илэрснийг хяналтад авч эмчилж байна. Хавсралт : 1 файл			
129	206	2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13	IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн	Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх шийдвэр гаргаагүй байна. Egazar.gov.mn цахим	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.	системд бүх шатны газар зохион байгуулалтын болон хот төлөвлөлтийн баримт бичгийг ил тод байршуулж байна. Газрын удирдлагын хөгжүүлэлтийн ажил хийгдэж байгаа бөгөөд 2024 оноос цахим системээр газартай холбоотой иргэдийн шинээр газар эзэмших хүсэлтийг авч эхэлсэн бөгөөд нийт 4881 иргэн өргөдөл гаргаснаас нийт хүсэлт илгээсэн иргэдээс 644 иргэнд газар хуваарилж 38.48 га газрыг сумын Засаг даргын захирамж үндэслэн газар эзэмших эрхийн гэрээ байгуулан гэрчилгээ олгосон байна. Мөн газрын албан ёсны erdenet.gazar.gov.mn цахим сайтад Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн төлөвлөгөөг иргэд олон нийт танилцах боломжоор ханган байршуулсан. Засгийн газрын тогтоолоор 2025 онд Орхон аймагт өмчлүүлэх газрын хэмжээ батлагдаагүй болно.			

130	207	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос тайлант хугацаанд 3 зөвлөмж, 1 албан шаардлага ирсэн. Тус зөвлөмж, шаардлагын хүрээнд хийсэн үйл ажиллагаа, зарцуулсан төсөв болон төлөвлөсөн арга хэмжээ, хийсэн ажлын талаарх мэдээллийг хуулийн хугацаанд нь гарган ХЭҮК-ын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоог төлөвшүүлэх чиглэлээр гэрч хохирогчийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудыг хөгжүүлэх, сэргээн засах, байнгын асаргаа шаардлагатай иргэдийг сувилах, ээжүүдийг чадавхижуулах, залуучуудыг дэмжих, сэтгэл зүйн цогц боловсрол олгох хүрээнд төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр аймгийн ЗДТГ-аас нийт 36 төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж нийт 532.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
131	208	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Цаг агаарын нөхцөлөөр 2025 оны хавар ой, хээрийн түймрийн аюул IV зэрэгт 26 хоног, III зэрэгт 18 хоног тус тус үргэлжиллээ. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, сумдын Засаг даргын захирамжуудаар ногоон бүсийн эргүүлийн үүргийг гүйцэтгэх хуваарийг батлан сумдын нутаг дэвсгэрт 2025 оны 3-р сараас эхлэн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг Баян-Өндөр, Жаргалант сумын 13000 га талбайд төрийн байгууллагууд хамтран болон хөдөлгөөнт эргүүлээр давхардсан тоогоор 292 /өдөрт-32 албан хаагч/ албан хаагч өдөр тутмын эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж 5439 иргэн 33 ААНБ-д, 1407 айл өрх, 14 ойн нөхөрлөлд 8061 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага, сэрэмжлүүлгийг түгээж, нийт 39 удаа сэрэмжлүүлэг шторк, , гал унтраагуур хэрхэн ашиглах заавар зөвлөмж, дохио сэрэмжлүүлэг мэдээг цахимаар аймгийн олон хүн дагагчтай фэйсбүүк хуудсуудын администуудтай хамтран давхардсан тоогоор 911.0 мянган дагагчтай бүлгэмүүдэд түгээж, цаг тухай бүрт орон нутгийн телевизээр 6 удаагийн ярилцлага, радиогоор 6 удаа зэрэг нийт 331	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				мэдээллийг түгээж, давхардсан тоогоор 2752379 иргэний хандалтыг авсан байна. Мөн Орон нутгийн Тусгал, NBHD, ETV зэрэг телевизүүдтэй хамтран шар өвс, хог шатаасан зөрчлийг газар дээрээс нь сурвалжлага мэдээ авч иргэдэд ой, хээрийн түймэр болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг нийт 72 удаа өгсөн. Өнжмөл шар өвсны гал түймрийн зөрчил гаргасан 25 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 5.14.1 дэх хэсэгт заасны дагуу 2.5 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж ажилласан. Мөн гамшиг, ослын үед гал унтраах бодис зөөвөрлөх, тээвэрлэхэд ашиглах нисгэгчгүй нисэх төхөөрөмж авахад 71.5 сая, хөдөлгөөн, дулаан мэдрэгчтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмж авахад 28.0 сая, 4ш дулаан, хөдөлгөөн мэдрэгчтэй 2 нүдний дуран авахад 400.0 мянга, нийт 199.5 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлэн байдлыг хангаж, чадавхаа нэмэгдүүлж ажиллалаа. Хавсралт : 1 файл			
132	209	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Орхон аймгийн зорилго, алсын хараг 1. Нийгмийг Тогтвортой хөгжүүлэн боловсролтой, эрүүл, оюунлаг иргэнийг төлөвшүүлж бий болгох 2. Эдийн Засгийг Тогтвортой хөгжүүлэх замаар өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийн бие даасан хот болох 3. Байгаль Орчныг Тогтвортой хөгжүүлэн хүн амьдрах эрүүл аюулгүй таатай орчин бүхий ногоон хотыг байгуулах 4. Засаглалын хувьд иргэн бүрт хүртээмжтэй төрийн цахим үйлчилгээтэй Ухаалаг хот болохоор тодорхойлон Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогын баримт бичгийг боловсруулсан. Энэхүү зорилго, алсын хараг хэрэгжүүлэхээр Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр жил бүр хэрэгжилтийн тайланг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулан ажиллаж байна. 2025 оны байдлаар аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 83.7 хувьтай, хөгжлийн жилийн төлөвлөгөөнй хэрэгжилт 90.5 хувийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хэрэгжилттэй байна. Аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн 4 бүлгийн хүрээнд боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулахаар бэлтгээд байна. Хавсралт : 1 файл			
133	210	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр	Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны А/104 тоот тушаалаар мэдээлэл хариуцагч тус бүрийг томилон хэрэгжүүлэлт дээр тогтмол хяналт тавин ажиллаж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нийтэд нээлттэй ил тод байх мэдээллүүдийг "Shilen.gov.mn" 2.0 системд хуваарийн дагуу тухай бүр байршуулан ажиллаж байна. Төрийн байгууллагууд ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан https://shilen.gov.mn-д холбох нөхцөл боломжийг бүрдүүлэн 68 заалтын 113 нээлттэй мэдээллийг шууд холбоосоор тусгаж мэдээлэл авах бүх боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 114 байгууллага Шилэн индексийн үнэлгээнд хамрагдахаас 2025 оны III улиралын байдлаар 20 байгууллага мэдээллээ бүрэн оруулж үнэлгээ хийлгээгүй, 94 байгууллага хуульд заасан мэдээллээ оруулж үнэлэгдсэн ба үнэлгээний дундаж 77.8 хувьтай байна. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит хийж тухай бүрд илэрсэн зөрчил, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагуудад хүргүүлэн ажиллаж ирсэн ба 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгдсэн дүнгээр 94.74 хувьтай дүгнэгдсэн бол 2025 оны 3-р улиралд 98.4 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн. Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой үнэн зөв, бүрэн байх, нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Орхон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас нь мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан лизенцтэй программ хангамжтай, системийн хэвийн, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Мөн жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж, төрийн болон орон	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хяналт, шалгалтын нэг үзүүлэлт болгон шалгаж зөвлөгөө, мэдээллээр ханган, хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
134	211	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	"Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорлтыг аймгийн дунд болон богино хагацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж хэрэгжилтийн талаар контент, нэвтрүүлэг хийж Нутгийн удирдлагын ордны гадна байрлах дэлгэцээр сурталчлах төдийгүй Хамтдаа Эрдэнэтэд хөгжье фэйбүүк групп, Erdenet.mn сайт болон бусад мэдээ мэдээллийн суваг, телевизүүдээр тогтмол сурталчилж байна. Хавсралт : 3 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	212		XIII.10.. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн	2021 оноос "Цахим аймаг" болох зорилт дэвшүүлж Аймгийн ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор "Цахим Эрдэнэт - 1" хөтөлбөрийг 5 зорилт, 17 арга хэмжээтэй батлан хэрэгжүүлж ажилласнаар Смарт Эрдэнэт платформ, аймаг, сумдын албан ёсны веб сайт, газарзүйн мэдээллийн систем, эмнэлгийн ухаалаг таблет, багийн төвүүдийн ухаалаг төхөөрөмж, шилэн кабелийн хайгуул, цахим эрдэнэт сервер, хөдөлгөөнт холбоо гадаад гарц, мэдээллийн аудит, дугаар илрүүлэгчтэй камер суурилуулах зэрэг ажлыг бүрэн хэрэгжүүлээд байна. Одоогийн байдлаар Smart Erdenet аппликейшны мэдээлэл, сурталчилгаа, ухаалаг байгууллага аян, бизнес хөгжүүлэлтийн ажлууд үргэлжилж байна. Хотын нэгдсэн камерын ухаалаг системийг аймгийн Мэдээлэл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	шуурхай удирдлагын төвд суурилуулалах ажил хийгдэж ухаалаг камер болон хадгалах төхөөрөмжийн ухаалаг функцэд тулгуурлан зөрчлийг илрүүлэх, таних, хүн ба мал амьтан ялгах, тээврийн хэрэгслийг төрлөөр, өнгө загвараар нь ялган зэрэг үйлдлүүдийг хийж байна. Цаашид уг системийг бүрэн ашиглаж 1000 камерыг нэг системээр удирдаж илүү нарийвчлалтайгаар камерт харах боломжийг бүрдүүлэх функцийг нэвтрүүлэхээр сервер болон программ хангамжийг судлан худалдан авах шатны үйл ажиллагаа хуваарийн дагуу явагдаж байна. Тайлант онд орон нутгийн төсвийн 3.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр сумын 24 баг, 15 сургууль, 27 цэцэрлэгт нийтдээ 621 ширхэг камер суурилагдсанаар одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 1346 камер "Теле камерын хяналтын дэд төв"-д холбогдоод байна. Мөн нийтийн тээврийн хяналт, төлбөрийн цахим системийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн, Смарт Эрдэнэт аппликейшн болон бусад техникийн туршилт, холболтын ажлууд хийгдэж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2022-2024 онд дээрх хөгжүүлэлтүүдийг хийхэд орон нутгийн төсвөөс нийт 1524.9 сая төгрөг зарцуулсан. Хавсралт : 1 файл			
135	213	2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39	XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Засгийн газрын 278-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журамд нийцүүлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсвийн төсөлд тусгахаар зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн нийт 139.4 тэрбум төгрөгийн 20 төсөл арга хэмжээ төлөвлөн хөрөнгө оруулалтын удирдлага мэдээллийн системд /pimis/ шивж оруулснаас 9 төсөл арга хэмжээнд нийт 23.2 тэрбум төгрөг 2026 оны улсын төсөвт батлагдсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
136	214	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40	1.6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний	Орхон аймгийн Сургуулийн барилгын их засвар /Орхон, Баян-Өндөр сум 14 дүгээр сургууль/ төсөл арга хэмжээний хөрөнгийг орон нутгийн 2024 оны төсөвт 300.0 сая төгрөгийг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40	удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тухайн орон нутгийн 2024 оны төсөвт тусган хэрэгжүүлэх доор дурдсан төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс 2024 онд хэрэгжүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт; 1.6.1.Баянхонгор аймгийн 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар (Баянхонгор сум), Хүүхдийн зуслангийн их засвар; 1.6.2.Дархан-Уул аймгийн Цэцэрлэгийн засвар; 1.6.3.Дорноговь аймгийн 1 дүгээр сургуулийн барилгын засвар; 1.6.4.Орхон аймгийн Сургуулийн барилгын их засвар (Орхон, Баян-Өндөр сум, 14 дүгээр сургууль); 1.6.5.Өвөрхангай аймгийн Багшийн хөгжлийн ордны барилгын санхүүжилтийн 50 хувь (Өвөрхангай, Арвайхээр сум), Халамж үйлчилгээний барилга (Арвайхээр сум); 1.6.6.Өмнөговь аймгийн Ахмадын сувиллын барилга, 44 ор (Өмнөговь, Даланзадгад сум); 1.6.7.Увс аймгийн Улаангом сумын арын 4 замын уулзвараас тойрог	батлан гүйцэтгэгчээр шалгарсан Олзмандал” ХХК дутуу баригдсан барилгыг буулгах ажлыг 100 хувь гүйцэтгэж шиглалтад хүлээн авах комисс ажиллан хүлээн авсан. Хавсралт : 1 файл			

			цагаан хаалга хүртэлх авто замын шинэчлэл, гэрэлтүүлэг; 1.6.8.Ховд аймгийн Цэцэрлэгийн барилгын их засвар (Ховд, Жаргалант сум, 2, 3, 4 дүгээр цэцэрлэг).				
	215		2.56. Эрдэнэт хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрэм, журмыг салбарын бодлоготой уялдуулан боловсруулж ажиллахыг Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргалд;	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/12 дугаар тушаалын хавсралтын 25 дугаарт "Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. “Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-2045” -ийн ТЭЗҮ хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарласнаар 2024 оны 10 сарын 31- нд Нью урбанизм ХХК 1094.0 сая төгрөгийн үнийн саналаар шалгарч гэрээ байгуулан ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд орон нутагт төрийн байгууллагуудтай уулзаж санал авч, Эрдэнэт хотын байрзүйн геодезийн зураглалын алдааг засч шинэчлэн хийх, бүс нутгийн асуудлаар Булган аймагтай санал солилцож хөрш зэргэлдээх сумдын суурьшлын бүс эдийн засгийг тэлж хамтран ажиллах санал гарсны дагуу хотын баруун талыг дулаанаар хангах дулааны станцын байршил нь Булган аймгийн Орхон сумын Халиун багт байхаар тооцоологдон дулааны станцыг байршлын талаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 10-р сард Булган аймгийн Орхон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай хэлэлцээр хийснээр Булган аймгийн Орхон сумаас дараагийн уулзалтыг зохион байгуулах шийдвэр гаргаад байна. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болон бусад судалгааны ажил хийгдэж байгаа ба Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах ажил 35 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

137	216	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12	14.8. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав.” (Үндэсний судалгааны нэгдсэн платформын ажлын явцын талаар)	Sudalgaa.gov.mn флатформ дээр 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын эрэмбэ, Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийг байрлуулж хяналт тавин ажилласан. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл /Орхон, Баян-Өндөр сум/, 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын эрэмбэ цахим судалгааны материалуудыг байршуулж нийтэд түгээсэн. Төсвийн хөрөнгөөр хийгдсэн өөр судалгааны ажил байхгүй болно. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
138	217	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл	22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний	2024 онд Улсын төсвөөс 42.5 тэрбум төгрөгийн 11 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Орхон аймагт дараах яамдуудаас эрх шилжүүлсэн.Үүнд: Боловсрол шинжлэх ухааны яамнаас 37.7 тэрбум төгрөгийн 5 төсөл арга хэмжээ Хүнс хөдөө аж ахуйн яамнаас 4.5 тэрбум төгрөгийн 5 төсөл арга хэмжээ Соёлын яамнаас 250 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн. Шилжин ирсэн 11 төсөл арга	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2024-04-03 Дугаар 2024_13	худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаар 11 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан. Аймгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ тусгагдсанаас гүйцэтгэгч шалгарсан 212, тендер зарлаад амжилтгүй болсон 41, 13 буюу 4.9 хувь нь тендер зохион байгуулагдаагүй байна. Тендер зохион байгуулагдаагүй төсөл арга хэмжээний 8 нь зураг төсөв, 5 нь ажлын даалгавар ирээгүй байна. Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 79.7 хувийн биелэлттэй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2025 оны 05 дүгээр сарын 31-ний өдрийн дотор 212 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй 17.5 тэрбум төгрөгийн 41 төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.2 -д заасны дагуу төсвийн хэмнэлтэд тооцогдож байна. Худалдан авах ажиллагааны явц, үр дүнгийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд мэдээлэл бэлтгэн танилцуулж, худалдан авах ажиллагааны үр дүнд шалгарсан гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлэх төдийгүй аймгийн удирдлагууд болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоог ханган газар дээр нь 7 хоног тутамд ажиллаж тулгамдаж буй асуудал, тухайн хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн ач холбогдлын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
139	218	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл	14.17.1.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх болон газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг Газрын тухай хууль, холбогдох	2024 онд аймгийн Засаг даргын захирамжаар 385 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг шилжүүлэх, 62 иргэн аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж, СӨХ-ны орчны газрын зориулалтаар 2 байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэр, 20 төрийн байгууллагад зайлшгүй хэрэгцээнд газар эзэмшүүлэх шийдвэр гаргасныг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2024-04-10 Дугаар 2024_14	бусад хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(.Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн талаар)	баталгаажуулсан. 2025 онд аймаг болон сумдын Засаг даргын захирамжаар 201 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг шилжүүлэх, 74 иргэн аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж, 48 төрийн байгууллагад зайлшгүй хэрэгцээнд газар эзэмшүүлэх шийдвэр гаргасныг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн баталгаажуулсан. Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргах хүрээнд нэгж талбарын хил зааг, тооллогын алдаатай 9873 нэгж талбаруудын алдааг засварлаж, газар ашиглалтын зориулалтыг буруу оруулсан, мэдээлэл зөрүүтэй бүртгэсэн зэрэг 23390 нэгж талбар, нийт 33263 өгөгдөл мэдээллийг засварлаад байна Хавсралт : 1 файл			
	219		14.17.1.2. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Орхон аймгийн Газрын нэгдмэл сангийн ангиллаар Баян-Өндөр суманд бэлчээрийн газар байхгүй. Жаргалант сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ тусгагдсан. Жаргалант сумын Засаг даргын "Хадлан тариалан өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай" А/134 дүгээр захирамж гарган хэрэгжүүлэн ажилласан. Жаргалант сумын нутаг дэвсгэрт 75 га газарт хамаарах 150 орчим айл өрхийн өвөлжөөний хөл бууцанд ногоон тэжээл тариалах ажлын хүрээнд үр нийлүүлэх, хашаа барих тендерийг зарласны дагуу "Үржин дэвших заяа" ХХК шалгарч, 41 га газарт 8.2 тонн үрийг цацаж 103.9 тн ургац авсан. Орхон аймгийн Жаргалант сумын элэгдэж, эвдэрсэн газрын байршлуудыг гарган, хөрсний доройтол, цөлжилтөөс сэргийлэх ажлын төлөвлөгөө, төсвийн хамт 2025 оны 401 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. 2025 онд Өвөлжөөний хөл бууцанд ногоон тэжээл тариалахаар 112 өрх хүсэлт гаргасан. Иймд 1 өрхөд 0.5-0.6 га талбайд ногоон тэжээл тариалахаар тооцож өрх бүрд 120 кг хошуу будааны үр, 300м хамгаалалтын хашааг гэрээгээр эзэмшүүлэхээр төлөвлөж бэлтгэл ажлыг хангаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
140	220	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15	20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засагдарга нарт;(Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар)	Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/104 тоот тушаалаар мэдээлэл хариуцагч тус бүрийг томилон хэрэгжүүлэлт дээр тогтмол хяналт тавин ажиллаж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нийтэд нээлттэй ил тод байх мэдээллүүдийг "Shilen.gov.mn" 2.0 системд хуваарийн дагуу тухай бүр байршуулан ажиллаж байна. Төрийн байгууллагууд ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан https://shilen.gov.mn-д холбох нөхцөл боломжийг бүрдүүлэн 68 заалтын 113 нээлттэй мэдээллийг шууд холбоосоор тусгаж мэдээлэл авах бүх боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 114 байгууллага Шилэн индексийн үнэлгээнд хамрагдахаас 2025 оны III улиралын байдлаар 20 байгууллага мэдээллээ бүрэн оруулж үнэлгээ хийлгээгүй, 94 байгууллага хуульд заасан мэдээллээ оруулж үнэлэгдсэн ба үнэлгээний дундаж 77.8 хувьтай байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
141	221	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16	26.3.5. Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгохгүй байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт;	Аймгийн Засаг даргын 2024 оны А/77 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Орхон аймагт үйл ажиллагаа эрхэлдэг 24 Шатахуун түгээх станц, 5 авто машиныг хийгээр цэнэглэх станцын зориулалттай, нийт 29 барилга байгууламжид хяналт шалгалтыг зохион байгуулж, 18 байршилд зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авсан. Аймгийн хэмжээнд шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар эзэмшүүлээгүй. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	222		26.3.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцад орчны дүрс бичлэгийн техник, хэрэгслийг байршуулж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр болон бүх шатны Засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд 28 шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх 6 цэг байгаа ба эдгээр аж ахуй нэгжүүдийн 1 цэгт 4-12 хяналтын камер дүрс бичлэг хийж 14 хоногоос 2 сарын хугацаанд хадгалах хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж, нийт 34 цэгийн 228 хяналтын камерыг Теле хяналтын камерын дэд төвтэй холбох зардал, техник тоног төхөөрөмжийн судалгааг гарган холбогдох төсвийг 2026 оны орон нутгийн төсөвт тусган батлуулсан Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	
142	223	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1	28.3.1.. “Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хэлэлцээ хийж хамтын хэлэлцээр байгуулан, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	“Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл”, “Нийгмийн түншлэлийн гурван талт хороо”-ны 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг батлан ХАБЭА-н зөвлөлөөс 30 гаруй арга хэмжээ, Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн орон нутгийн 45.0 сая төгрөг зарцуулж ажилласан. Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хороо хуралдааныг тогтмол зохион байгуулж, 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг батлуулан ажилласан. Тайлант хугацаанд 10 аж ахуйн нэгжийн хамтын гэрээг хянаж, бүртгэн, Баян-Өндөр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог 9 үндсэн, 3 орлох гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Тус хороо нь 2025 онд нийт 12 иргэний өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн. Нийт 12 маргааны 3 нь талуудын эвлэрлээр, 9 нь шүүхийн шатанд шилжсэн. Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээр 91.7 хувьтай хэрэгжиж дүгнэгдсэн. 18 байгууллагын хамтын гэрээг хүлээн авч хянан бүртгэсэн. Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн хүрээнд “ЭРЖИЭЧ” ХХК, “Эрдэнэт чанар дистртбюшн” ХХК, “Тэмүүжин оргил” ХХК нийт 3 аж ахуй нэгжийн 75 ажилтанд мэргэшсэн зөвлөх Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч гэрээ, дүрэм, журам, зөвлөмж тус бүрт нь боловсруулж өгсөн. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн улирал тутамд хуралдааныг зохион байгуулж, гишүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөрүүд, холбогдох дүрэм журмын талаар мэдээллийг хүргэж, мөн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны сонгон шалгаруулах ажлын хэсэгт зөвлөлийн гурван гишүүн ажилласан. 2025 онд аймгийн хэмжээнд ХАБЭА-н чиглэлээр 29 төрлийн арга хэмжээ, 12 гаруй сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 1000 гаруй иргэн, ажил олгогчийг хамруулсан бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй ажлын орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан Хавсралт : 1 файл			
143	224	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1	19.3.2.. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардалд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг төсөвлөн зарцуулж ажиллалаа. 2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг авч, төлөвлөгөөг боловсруулан байгууллагуудад хүргүүлж, хамтран ажиллаж байна. Орон нутгийн жендэрийн сургагч багштай хамтран эрсдэлийн программд бүртгэлтэй 20 өрхийн 43 эрэгтэйтэй амьдралын эерэг дадал, эрүүл хоололт, амьдрах ухааны сургалтыг 6 удаа үе шаттай зохион байгуулсанаар тэд эрүүл хоололт, эерэг дадал зуршлын талаар ойлголт нэмэгдсэн. Технологид суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газартай хамтран цахим анимэшин хичээлийг бэлтгэн томоохон сайтууд болон сургуулийн нийгмийн ажилтнуудаар дамжуулан ахлах ангийн сурагчдад хүргэсэн. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн байрыг дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлттай байдлаар өөрчлөн засварлаж "Бага насны хүүхдийн хөгжлийн төв" -ийг байгуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
144	225	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1	22.5.2. Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бариагүй орон сууцны хотхон, хороолыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Орон сууцны 7А хороололд суурьших иргэдэд нормчлогдсон хүүхдийн цэцэрлэгийн тоо хүрэлцээгүй нөхцөл байдлыг арилгах зорилгоор цэцэрлэг шинээр нэмж төлөвлөх төлөвлөлтийн арга хэмжээ авах шаардлагатай байгаа бөгөөд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусган боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 06 ны өдөр аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Орон сууцны 2А хороллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дахин тодотгон хийлгүүлэх саналыг 2023 оны 02 сард ГХБХБГ-аас ерөнхий архитектор хүргүүлж, шаардагдах төсвийг шийдвэрлэн худалдан авах ажиллагааг зарласнаар "Скайланд" ХХК нь шалгарч гэрээ байгуулан ажиллаж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дахин тодотгон ажлыг дуусган магадлал хийлгэх шатанд явагдаж байна. Орон сууцны 2А хороололд 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр 150 хүүхдийн цэцэрлэг барих ажлын гүйцэтгэгчээр Аттачир ХХК шалгарч гэрээ байгуулж ажлыг эхлүүлснээр одоогийн байдлаар барилгын ажил 35 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 7А хороололд дахин төлөвлөлтөөр "Инженер геодези" ХХК нь Найрамдал багийн 49-52 гудамжийг хамарсан 11.3 га газарт дахин төлөвлөлт хийгдэж 260 хүүхдийн 2 цэцэрлэг тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлууллаа. Бусад суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусган ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
145	226	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1	19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх	2023-2024 оны мал аж ахуйн өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Засгийн газрын 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын шийдвэр, Аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд аймгийн Онцгой комиссын зардлаас 296.0 сая төгрөг шийдвэрлүүлэн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд нэмэлтээр 2000 боодол буюу 40 тн өвс, 7142 шуудай буюу 178.5 тн тэжээл, 600 кг био бэлдмэл, 1670 ширхэг долооцыг нөөцөд бэлтгэн нэг малчин өрхөд 8-15 боодол өвс, 5-8 шуудай хивэг, 2-3 ширхэг долооц, 1 кг био бэлдмэлийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн талаар)	дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Үүний үр дүнд мал сүргийн онд оролт 97.0 хувьтай орсон. Аймгийн хэмжээнд мал нь хорогдсон малчин өрхийн судалгааг нарийвчлан гаргаж малжуулах хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж байна. 2024 онд малжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан 23 иргэний өргөдлийг ажлын хэсгийн хуралд танилцуулж 11 айлыг тус хөтөлбөрт хамруулан өмнө тус хөтөлбөрт хамрагдсан буцаан төлөлт хийх 15 малчин өрхөөс 29 тугалтай үнээг буцаан төлж 11 айлд 3 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. 2025 онд Малжуулах хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр Орон нутгийн хөгжлийн санд 63.9 сая төгрөгийг батлан махны чиглэлийн үхэр сүргийн суурийг бий болгон хээлтүүлэгч бойжуулан үхэр сүргээ түлхүү өсгөн үржүүлж махны гарцыг нэмэгдүүлэх зорилготой мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа 5 малчны суурьт Герефорд, Казакын цагаан толгойт үүлдрийн өсвөр хээлтүүлэгчийг гэрээгээр хүлээлгэн өгсөн. Мөн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран малжуулах хөтөлбөрт хамрагдах малчин өрхийн судалгааг гарган Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 8 өрхөд 64.0 сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй, 36 сарын хугацаатай зээлийг олгосон. Хавсралт : 1 файл			
146	227	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22	37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай	Засгийн газраас орон даяар "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлж, хоршооны талаар сургалт сурталчилгаа хийх, зөвлөн туслахаар сургагч багш нар манай аймагт ажиллаж мал бүхий 1000 гаруй өрхөд хоршооны талаар мэдлэг олгох, хамтран хоршиж ажиллах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Баян-Өндөр сумын Засаг даргын 2024 оны А/146 дугаар захирамжаар "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий ач холбогдол, үр нөлөөг орон нутагт сурталчлах, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлын хэсэг байгуулагдаж "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, суманд шинэ хоршоо байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Тус ажлын хэсэгт сумын Хоршоо хариуцсан, Хүнс, жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан, мал аж ахуйн үйлдвэрлэл хариуцсан, бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт	мэргэжилтнүүд, багийн Засаг дарга, зохион байгуулагч нар ажиллаж бэлтгэгдсэн. Хоршоодын үйл ажиллагааг дэмжин холбогдох сургалтад хамруулж мэдээлэл зөвлөмжөөр хангаснаар 2025 онд мал аж ахуйн чиглэлийн 203 гишүүнтэй 23 хоршоо шинээр байгуулагдаж, 6 хоршооны 16 малчин 529.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Шинээр байгуулагдсан хоршоодыг чадавхжуулах мэдээлэл арга зүйгээр хангах зорилгоор 2 удаагийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж давхардсан тоогоор 56 хоршооны төлөөлөл хамрагдан. төрөөс баримталж буй бодлого, Хоршооны анхан шатны ойлголт, Татварын багц хууль, Цахим санхүүгийн тайлан, И-баланс, жилийн эцсийн тайлан хэрхэн гаргах тухай, хоршоодод газар хэрхэн олгох талаарх мэдээлэл, Хоршоо хөгжүүлэх сангийн танилцуулга, Хоршоодын сайн туршлага зэрэг мэдээллээр хангагдсан. Аймгийн хэмжээнд одоогийн байдлаар нийт 115 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаагийн 74 нь Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдаж 1330 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс өссөн дүнгээр 47 хоршооны 174 гишүүн нийт 6.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан байна. Эрчимжсэн мал аж ахуйн фермерийн зориулалтаар 2024-2025 онд нийт 8 хоршоонд нийт 31.0 га газрыг эзэмшүүлсэн. Хавсралт : 1 файл			
147	228	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31	31.9.6. 2/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудаснууд болох https://e-mongolia.mn/org/orkhongovern, https://www.gov.mn/mn/organization/erdenet нэгдсэн цахим хуудаснуудад байгууллагынхаа мэдээллийг бүрэн байршуулж, тухай бүр шинэчлэн ажиллах төдийгүй төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын бүртгэлийг үүсгэх, системд мэдээ мэдээлэл оруулах заавар зөвлөгөөг тухай бүрд өгч, хяналт тавин хамтран ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

148	229	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл 2024-09-11 Дугаар 2024_32	32.6.2.. 2.1. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр өгсөн даалгаврыг хэрэгжүүлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт, төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд()	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/12 дугаар тушаалын хавсралтын 25 дугаарт "Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын. гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарласнаар 2024 оны 10 сарын 31- нд Нью урбанизм ХХК 1094.0 сая төгрөгийн үнийн саналаар хамгийн шалгарч гэрээ байгуулан ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд орон нутагт төрийн байгууллагуудтай уулзаж санал авч, Эрдэнэт хотын байрзүйн геодезийн зураглалын алдааг засч шинэчлэн хийх, бүс нутгийн асуудлаар Булган аймагтай санал солилцож хөрш зэргэлдээх сумдын суурьшлын бүс эдийн засгийг тэлж хамтран ажиллах санал гарсны дагуу хотын баруун талыг дулаанаар хангах дулааны станцын байршил нь Булган аймгийн Орхон сумын Халиун багт байхаар тооцоологдон дулааны станцыг байршлын талаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 10-р сард Булган аймгийн Орхон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай хэлэлцээр хийснээр Булган аймгийн Орхон сумаас дараагийн уулзалтыг зохион байгуулах шийдвэр гаргаад байна. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болон бусад судалгааны ажил хийгдэж байгаа ба Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах ажил 35 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Жаргалант сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад 2025 оны орон нутгийн төсөвт 300.0 сая төгрөг тусган батлуулсан. Тус төлөвлөлтийн хүрээнд зураг төсөв боловсруулах даалгавар боловсруулан батлуулж, гүйцэтгэгчээр “Нарт дизайн” ХХК шалгарч гэрээ байгуулж ажилласнаар одоогийн байдлаар ажлын гүйцэтгэл 80 хувьтай үргэлжилж байна. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

149	230	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд 2024-10-02 Дугаар 2024_35	14.7.2.. Газрын эрхийн давхцалтай 6206 зөрчлийг арилгах, тусгай хамгаалалттай газар нутагт олгогдсон 4953 нэгж талбар газрын эрх болон уул уурхай, ашигт малтмалын зориулалтаар олгогдсон 447 нэгж талбар газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгав;	Орхон аймагт газрын эрхийн давхцалтай зөрчил одоогоор гараагүй байна. Тусгай хамгаалалттай газар нутагт олгогдсон газар байхгүй, аймгийн хэмжээнд уул уурхайн зориулалтаар эзэмшүүлсэн 12 нэгж талбарын 10371.57 га газрыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж оруулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
150	231	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.2. ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал,	Аймгийн хэмжээнд эрхэлсэн асуудал, чиг үүргийн хүрээнд гаргаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдэн мөрдөгдөж буй 8 захиргааны хэм хэмжээний актаас хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж ирүүлсэн захиргааны хэм хэмжээний акт байхгүй болно. Энэ тухай хариу мэдээллийг ХЗДХЯ-нд 2025 оны 05 дугаар сард 02/1634 тоот албан бичгээр хүргүүлсэн. Харин нийтээр дагаж мөрдөхөөр өмнө нь батлан хэрэгжүүлж байгаа боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй байгаа шийдвэрүүдийг холбогдох хуульд нийцүүлэн дахин боловсруулж, шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Тухайлбал аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх гудамж, зам хамрах хүрээ, түр саатуулах хашаа, зогсоолын нийт талбайн хэмжээ, чирэгч, ачигч автомашины тоо тогтоох тухай", аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх болон түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйлчилгээний төлбөр тогтоох тухай" тогтоолуудыг шинэчлэн боловсруулж аймгийн ИТХ-аар	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			захирамж, тогтоол байгаа эсэх; 3.3. нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.4. хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.5. хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.6. захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.7. энэ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр биелэлт ирүүлэх.	хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлсэн боловч хурлын зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 132 дугаар тогтоолын дагуу бүх төрлийн үйлчилгээний төлбөр, татвар, хураамжийн хувь хэмжээ тогтоохыг хориглосон тул тодорхойгүй хугацаагаар дээрх журмын төслүүдийг хурлын хуралдаанаар оруулахаас татгалзсан. Хотын доторх замын хөдөлгөөнд ачааны авто машиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журмыг боловсруулж, аймгийн Засаг даргын 2025 оны А/888 дугаар захирамжаар баталсан. Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу уг журмыг хянуулж, ЗХХА-ын нэгдсэн санд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн боловч дүгнэлт үйлдэн буцаасан байна. Иймд хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлтэд дурдсан ажлыг зохион байгуулан, дахин хүргүүлэхээр ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
	232		39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, сургууль цэцэрлэгүүдийг хамруулсан албан хэрэг хөтлөлтийн цогц систем болон И-Оффис системийг ажиллуулах, мэдээллийг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	хадгалах төхөөрөмж болох сервер компьютерыг 2019 оноос Үндэсний дата төвийн зогсуур түрээсийн үйлчилгээг ашиглан байршуулж хамтран ажиллаж байна. Кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусган лиценз сунгах, зөвлөн туслах үйлчилгээ авах зэргээр зарцуулан ажиллаж байна. Мөн 2025 оны орон нутгийн төсөвт кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэхээр орон нутгийн төсөвт 35.0 сая төгрөг тусган батлуулсан боловч худалдан авах ажиллагаа амжилтгүй болсны улмаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тус төсөв буцаан татагдсан. Иймд тус ажилд шаардагдах төсвийг 2026 оны орон нутгийн төсөвт тусган батлууллаа. Улсын бүртгэлийн байгууллагын Мэдээллийн технологийн албан хаагчдын нэгдсэн сургалтад УБХ-ийн Мэдээлэл технологийн ажилтныг хамруулж хиймэл оюун ухаан, сүлжээний аюулгүй байдал, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн хамгааллын чиглэлээр мэдээллээр хангагдан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн Татварын газар нь ТЕГ-ын Мэдээллийн аюулгүй байдал, технологийн газраас ирүүлсэн 27 зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллаж, байгууллагын онлайн сүлжээний хамгаалалтын Fortigate 80 төхөөрөмжийг шинэчлэн суулгаж ашиглаж байна. Хавсралт : 1 файл			
	233		39.29.11.1.2. эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас	Аймгийн хэмжээнд эрхэлсэн асуудал, чиг үүргийн хүрээнд гаргаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдэн, мөрдөгдөж буй 8 захиргааны хэм хэмжээний актаас хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж ирүүлсэн захиргааны хэм хэмжээний акт байхгүй бөгөөд энэ талаарх мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгон, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (1.1Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөв)			

	234		39.29.11.1.3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа, түүнчлэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дагаж мөрдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгосон заалтын судалгааг гаргаж, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;(1.4. цаашид нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох шийдвэрт тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж, санд хөдөлгөөн хийлгэх ажлыг хэвшүүлэх; 1.5. шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж ажиллах; 1.6. Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж,	Аймгийн хэмжээнд эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд гаргаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдэн, мөрдөгдөж буй 8 захиргааны хэм хэмжээний актаас хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж ирүүлсэн захиргааны хэм хэмжээний акт байхгүй болно. Харин нийтээр дагаж мөрдөхөөр өмнө нь батлан хэрэгжүүлж байгаа боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй байгаа шийдвэрүүдийг холбогдох хуульд нийцүүлэн дахин боловсруулж, шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. Тухайлбал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 77 дугаар тогтоолоор батлагдсан "Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх гудамж, зам хамрах хүрээ, түр саатуулах хашаа, зогсоолын нийт талбайн хэмжээ, чирэгч, ачигч автомашины тоо тогтоох тухай", аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх болон түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйлчилгээний төлбөр тогтоох тухай" тогтоолуудыг шинэчлэн боловсруулж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлсэн боловч хурлын зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 132 дугаар тогтоолоор бүх төрлийн үйлчилгээний төлбөр, татвар, хураамжийн хувь хэмжээ тогтоохыг хориглосон тул тодорхойгүй хугацаагаар дээрх журмын төслүүдийг хурлын хуралдаанаар оруулахаас татгалзсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүргээ биелүүлж ажиллах;))				
	235		39.29.11.1.7. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах	Баян-өндөр болон Жаргалант суманд аливаа нийтээр заавал даган мөрдөх захиргааны хэм хэмжээний акт батлахдаа Захиргааны ерөнхий хуульд заасныг удирдлага болгон ажиллах талаар чиглэл өгч, аймгийн хэмжээнд мөрдүүлэхээр гаргах хэм хэмжээний актын төсөл бэлтгэхэд шийдвэр гаргах ажиллагаанд холбогдох эрх ашиг нь хөндөгдөж буй оролцогчдын тайлбар, саналыг сонсох, эрх ашиг нь хөндөгдөж буй бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж талуудын оролцоог ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Захиргааны ерөнхий хуультай холбоотой зөрчил илрээгүй.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
151	236	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл 2024-11-20 Дугаар 2024_40	40.19.5.3. “Өвлийн идэш” арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжпэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.	2024 оны “Өвлийн идэш” арга хэмжээнд Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн давхардсан тоогоор 45 иргэн, хоршоо оролцож нийт 46.8 тонн малын мах, дотор мах 0.1 тонн цагаан идээ буюу 409.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн. 2025 онд Улаанбаатар хотын хүн амын өвлийн улирлын хүнсний хэрэгцээнд зориулан зохион байгуулагдах “Өвлийн идэш” арга хэмжээний талаарх мэдээллийг аж ахуйн нэгжүүд, хоршоо, малчдад хүргэн, судалгааг 2025 оны 01 дүгээр сард ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Судалгаанд мал төхөөрөх үйлдвэр, махны бөөний худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоо нийт 18 цэг, салбарыг хамруулахад үхрийн мах 352.4 тн, хонины мах 297.9 тн, ямааны мах 102.26 тн буюу нийт 747.16 тн мах хадгалагдаж, үүнээс 48 тн махыг Улаанбаатар хотод борлуулж, үлдэгдэл махыг аймгийн зах зээлд борлуулалт хийгдсэн. “Өвлийн идэш-2025” худалдааг 12 дугаар сард наадмын талбайд зохион байгуулж өөрийн аймгийн болон Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Завхан аймгаас 23 малчин, худалдаа эрхлэгчид оролцож нийт 578.0 сая төгрөгийн үнэ бүхий 47.7 тн мах, 0.9 тонн цагаан идээ борлуулсан. Тус худалдаагаар хонины мах 12.0, ямаа 9.0, адуу 10.0, үхрийн мах 14.0 мянган төгрөгөөр	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				буюу зах зээлийн бөөний үнээр борлуулагдсан байна. Хавсралт : 1 файл			
	237		40.19.7.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг сахин мөрдөж, тэдгээрээс зөрүүтэй газар зүйн нэр, зургийг үндэслэн аливаа хилийн цэстэй холбоотой маргаан үүсгэхгүй байх талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Орхон аймгийн Жаргалант сумын хилийн цэсийг УИХ-ын 1994 оны 32 дугаар тогтоолоор баталсан цагаас хойш 3 удаа хилийн цэсийн маргааныг тодруулах ажил хийгдэж 1:25000, 1:75000, 1:100000 масштабтай зураг үйлдэж зурагласан байдаг. 2024 онд Жаргалант сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр газарзүйн нэрийн тодруулалтын ажлыг хийж гүйцэтгэж суурин судалгааны ажил, хээрийн судалгааны ажил тус тус хийгдсэн. Тус хээрийн болон суурин судалгааны боловсруулалтын үр дүнд хилийн цэсийн маргаан байхгүй болохыг тодруулсан. Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын хилийн цэсийн судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
152	238	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл 2024-12-04 Дугаар 2024_43	43.6.2.. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгав	Сангийн яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу улсын төсвийн орлогын дансанд Наран багийн соёлын төвийн барилгын ажлын үлдэгдэл 193.6 сая төгрөг, Орхон аймаг, Баян-Өндөр сум, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц ажлын үлдэгдэл 84.8 сая төгрөг, Рашаант баг, 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлын үлдэгдэл 168.2 сая төгрөг, нийт 3 төсөл арга хэмжээний 446.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Мөн Аймгийн Засаг даргаас Хүүхдийн хөгжил хамгааллын төвийн барилгын ажлын гүйцэтгэгчид шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу эвлэрлийн гэрээ байгуулж 2025 оны 09 сарын 01-ны өдрийн дотор ашиглалтад оруулахаар тохиролцсон ба тус ажлын барьцаа хөрөнгийн данс дахь 364.9 сая төгрөгийн үлдэгдлийг эвлэрлийн гэрээний хугацаагаар хойшлуулж өгөх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн Иймд гэрээний дагуу дараагийн шатны арга хэмжээг авахаар гүйцэтгэгчтэй зөвшилцөн материалын үнийн зөрүүг тооцуулан ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
153	239	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэл 2024-12-30 Дугаар 2024_47	47.8.1.2. Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд бэлэн байдалд ажиллахыг Засгийн газрын гишүүд, нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов.	Шинэ жил, сар шинийн баярын өдрүүдэд аймгийн Засаг даргын захирамжаар /2024.12.23-ны өдрийн А/957, 2025.02.26-ны өдрийн А/173, 2025 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн А/1084 тоот захирамжуудаар аймгийн хэмжээнд ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг батлан, тус хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, онц чухал обьектуудын аюулгүй байдлыг хангах, болзошгүй гэнэтийн осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Хавсралт : 3 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
154	240	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44	44.22.1.12. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж, холбогдох албадын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/846 захирамжаар байгуулан зохион байгуулж, 14003 айл өрх, 11 аж ахуйн нэгжийн хүчин чадлаар ялгаатай зуух, 33854 авто тээврийн хэрэгслийг хамрууллаа. Тайлант хугацаанд 15338.2 тн нүүрс, 49457 м3 мод түлшинд зарцуулсан байна. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож цахилгааны хүчдэлийн уналтыг шийдвэрлэсэн. "Миний гэр бидний гудамж төсөл"-ийн хүрээнд гэр хорооллын 7 багт инженерийн шугам сүлжээ татагдаж, нийт 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх холбогдож, 266 өрх техникийн нөхцөлөө авсан байна. Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулаа. Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар "Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичиж танилцуулсан. 2025 оны 05 дугаар сард БНСУ болон Монгол улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд агаарын чанарын 6 үзүүлэлтийг тасралтгүй хэмжих Агаарын чанарын автомат станцыг хүлээлгэн өгсөнөөр хүхэрлэг хий, азотын ислүүд, озон, нүүрстөрөгчийн дутуу исэл, PM10 болон PM2.5 тоосонцрын агууламжийг хэмжих боломж бүрдсэн. Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар "Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичиж Эдийн засгийн форумд танилцуулсан. Хавсралт : 2 файл			
155	241	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2025-01-22 Дугаар 2025_05	5.24.10.1. Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх хүрээнд олон талт арга хэмжээ зохион байгуулж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулах төлөвлөгөөний талаар)	Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх "Бүсчилсэн хөгжил" хөдөлгөөний хүрээнд Хойд бүсийн өргөтгөсөн хуралдаанд оролцох бэлтгэл хангах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны А/272 захирамжаар байгуулан ажиллаж 2025 оны 4-р сарын 28-ны өдөр төрийн албан хаагч, ИТХ-ын төлөөлөл, ЖДҮ эрхлэгч, хоршоо, МХАҮТ-ын салбар танхим, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачид зэрэг нийт 100 гаруй хүнийг хамруулан салбар хуралдаануудад бэлтгэл ханган оролцсон. Уг хуралдааны хүрээнд Булган аймгийн төв талбайд "Түншлэл-Хамтын ажиллагаа" үзэсгэлэн зохион байгуулагдсан тус тус үзэсгэлэнд Орхон аймгаас 25 үйлдвэрлэл үйлдвэрлэгч оролцож бараа бүтээгдэхүүнээ танилцууллаа. "Төрийн албаны манлайлал" Хойд бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг 2025 оны 4-р сарын 07-08-ны өдөр аймагтаа зохион байгуулж, зөвлөгөөний үеэр Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжуудын хэрэгжилтийн талаар салбар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, төрийн албан хаагчдад тулгамдаж буй асуудал, тэдний ажлын бүтээмжийг	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				дээшлүүлэх талаар хэлэлцлээ. "Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хууль, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хойд бүсийн зөвлөгөөнийг Булган аймагт зохион байгуулж Орхон аймгаас хоршооны 20 төлөөлөл оролцож мэдээлэл авсан. Биеийн тамир спортын улсын хорооны удирдамжийн дагуу хойд бүсийн иргэдийн дундах иргэдийн спортын наадамд спортын 5 төрлөөр Булган, Хөвсгөл аймгууд болон манай аймгийн нийт 136 тамирчин амжилттай оролцсон. Тус үйл ажиллагаанд оролцоход орон нутгийн төсвөөс 10.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. Орхон аймгийн Татварын газраас Хойд бүсийн татвар төлөгчид пэйж хуудсыг ажлуулж 472 төрлийн мэдээг 1622 удаагийн давтамжтай сошиал орчинд түгээснээр нийт давхардсан тоогоор 533054 хүнд хүрсэн байна... Хавсралт : 1 файл			
156	242	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-01-29 Дугаар 2025_06	6.26.5.2.2. “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-т тусгагдсан 4 бодлогын 16 чиглэлийн 620 зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	“Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан аймагт хамаарах нийт 103 арга хэмжээниий хэрэгжилтийг зохион байгуулан ажилласнаар 2025 оны байдлаар хэрэгжилт 83.7 хувьтай байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
157	243	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл	10.19.4.2. Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах	Хууль, тогтоомжоор өгөгдсөн үүрэг даалгаварыг тухай бүр хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнах төдийгүй шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийн талаарх мэдээллийг тухай бүрд холбогдох дээд шатны байгууллагууд цахимаар мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна. Мөн Монгол улсын Ерөнхий сайдын албан даалгаварын хэрэгжилтийг сар бүр цахим системээр тайлагнаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2025-02-26 Дугаар 2025_10	арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;				
158	244	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-03-06 Дугаар 2025_11	11.6.2. Хот байгуулалтын тухай хууль тогтоомжид заасны дагуу харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээний хот, тосгон, суурин газруудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтын төслийг боловсруулан, тус тус батлуулж, хэрэгжүүлэх ажлыг яаралтай зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгав.” гэжээ.(1.Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.)	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/12 дугаар тушаалын хавсралтын 25 дугаарт "Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын. гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарласнаар 2024 оны 10 сарын 31- нд Нью урбанизм ХХК 1094.0 сая төгрөгийн үнийн саналаар хамгийн шалгарч гэрээ байгуулан ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд орон нутагт төрийн байгууллагуудтай уулзаж санал авч, Эрдэнэт хотын байрзүйн геодезийн зураглалын алдааг засч шинэчлэн хийх, бүс нутгийн асуудлаар Булган аймагтай санал солилцож хөрш зэргэлдээх сумдын суурьшлын бүс эдийн засгийг тэлж хамтран ажиллах санал гарсны дагуу хотын баруун талыг дулаанаар хангах дулааны станцын байршил нь Булган аймгийн Орхон сумын Халиун багт байхаар тооцоологдон дулааны станцыг байршлын талаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 10-р сард Булган аймгийн Орхон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай хэлэлцээр хийснээр Булган аймгийн Орхон сумаас дараагийн уулзалтыг зохион байгуулах шийдвэр гаргаад байна. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах болон бусад судалгааны ажил хийгдэж байгаа ба Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах ажил 35 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Аймгийн хэмжээнд 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөлтийн дагуу 14 бичил хороолол төлөвлөгдсөн байсан. Тус төлөвлөлтийн хүрээнд барилгажих Их залуу багийн 40.8 га, Найрамдал багийн 49-53 гудамжны 11.9 га талбайд хэсэгчилсэн төлөвлөлтийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар тус тус	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

				батлуулсан. Мөн 2а хороололд 40.8 га, Оюут багийн Дөмөг орчимд 22 га, Баянцагаан багийн Тосгон орчимд 98 га талбайд хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна. Хавсралт : 1 файл			
159	245	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-03-19 Дугаар 2025_13	13.23.3.1.1.. Харьяа хот, тосгон, бусад суурины газрын эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг Газрын тухай хуульд заасны дагуу тогтоолгох асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах; (1 .Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:)	Хот, тосгон, бусад суурины газрын эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг тогтоох ажлын хүрээнд Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн судалгааг гарган Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрт 528,49 га, Орхон сумын нутаг дэвсгэрт 12778.49 га, Бугат сумын нутаг дэвсгэрт 4492.97 га нийт 17799.95 га талбайг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг дамнасан байдалтай байхаар саналыг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 03/37 дугаар тогтоолоор батлуулан, тус тогтоолыг аймгийн Засаг даргын 02а/2311 дугаар албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн боловч бусад аймаг, сумдын хил дамнуулахгүй байхаар эдэлбэр газрын хэмжээг дахин судлаж тогтоох талаар ГЗБГЗЗЕГ-аас чиглэл ирүүлсэн байна. Иймд эдэлбэр газрын хэмжээ, байршил, заагийг тогтоох талаар дахин судалгаа хийхээр ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Ахиц гарсан - 50%	Ахиц гарсан - 50%	
	246		13.23.3.1.1.2.. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн газрыг нөхөн сэргээх, хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж,	Орхон аймгийн Газрын нэгдмэл сангийн ангиллаар Баян-Өндөр суманд бэлчээрийн газар байхгүй. Жаргалант сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ тусгагдсан. Жаргалант сумын Засаг даргын "Хадлан тариалан өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай" А/134 дүгээр захирамж гарган хэрэгжүүлэн ажилласан. Жаргалант сумын нутаг дэвсгэрт 75 га газарт хамаарах 150 орчим айл өрхийн өвөлжөөний хөл бууцанд ногоон тэжээл тариалах	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хэрэгжилтийг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;(1 .Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:)	ажлын хүрээнд үр нийлүүлэх, хашаа барих тендерийг зарласны дагуу "Үржин дэвших заяа" ХХК шалгарч, 41 га газарт 8.2 тонн үрийг цацаж 103.9 тн ургац авсан. Орхон аймгийн хөрсний доройтол, цөлжилтөөс сэргийлэх суурь судалгааны ажлыг аймгийн хэмжээнд 58900га талбайд хийлгүүлж, тус ажлын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан төсвийн хамт 2025 оны 401 дүгээр албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах ажлын хүрээнд Баян-Өндөр сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: Зөвшөөрөлгүй хашаа барьсан айлуудын газрыг албадан чөлөөлөх ажлыг 2025 оны 3 дугаар улиралд зохион байгуулж 0.27 га газрыг чөлөөлсөн. Очир төв ХХК-иар Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын урд энгэрт 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлж, Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар Баян-Овоот, Цагаанчулуутын ам, Хангал гол дагуух 3 байршилд 10.1 га талбайд мод тарьж, ойн төгөл, ойн зурвас байгууллаа.2025 онд Өвөлжөөний хөл бууцанд ногоон тэжээл тариалахаар 112 өрх хүсэлт ирсний дагуу 1 өрхөд 0.5-0.6 га талбайд ногоон тэжээл тариалахаар тооцож өрх бүрд 120 кг хошуу будааны үр, 300м хамгаалалтын хашааг гэрээгээр эзэмшүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт : 2 файл			
	247		13.23.3.1.1.3.. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон Газрын тухай хуульд заасны дагуу гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан иргэнд үнэ төлбөргүй газар эзэмшүүлэх, мал аж	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02/12 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын харилцааны талаар 2025 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл"-д тусгагдсан Баян-Өндөр сумын 4 байршилд 3,01га, Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөний дагуу 4 байршилд 0,02 га, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан Газар зохион байгуулалтын 2025 оны төлөвлөгөөний дагуу Жаргалант сумын 14 байршилд 1,03 га газарт газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээний	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд 5 га хүртэлх газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгох арга хэмжээг цахим системээр зохион байгуулж, шийдвэрлэж хэвших, иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлэл өгөх;(1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:)	дуудлага худалдаа, Малчдын хоршоонд төсөл мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорулалтаар 6 байршилд 24,7 га газарт төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулахаар төлөвлөж Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан. 2025 онд аймаг, сумдын Засаг даргын 4 удаагийн захирамжуудаар 20 байршилд газрын дуудлага худалдааг цахимаар зохион байгуулахаар газрын биржийн цахим системд оруулж зохион байгуулснаар 13 байршилд 3.79 га газар эзэмшихээр шалгарч гэрээ байгуулан газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ олгож, дуудлага худалдаанаас 1967.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Мөн малчдын хоршоонд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг газрын биржийн MLE.mn цахим хаягт байршуулж, зохион байгуулж 5 хоршоонд 23.13 га газрыг Жаргалант сумын Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн. Улсын хэмжээнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг тогтоосон Засгийн газрын 2025 оны 119 дүгээр тогтоолд Орхон аймагт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэхээр тусгагдаагүй. Хавсралт : 1 файл			
	248		13.23.3.1.1.4.. Уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.(1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:)	Уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрын эрхийг баталгаажуулах ажлын хүрээнд 5 аж ахуйн нэгжийн 235.87 га газрыг Баян-Өндөр сумын 2025 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулж батлуулахаар 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хэлэлцүүлсэн боловч тус хуралдаанаар дэмжээгүй болно. Хавсралт : 1 файл	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	
160	249	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр	14.16.7.2.. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох хүсэлтийг хүлээн авах, магадлан шалгах, шийдвэр гаргахад төрийн	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг 2023 оны 11 дүгээр сараас https://e-business.mn/ системээр хүлээн авч, ажлын хэсгийн хурлыг 3 удаа хийж тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдээр улсын тэмдэгтийн хураамж төлүүлэн, тусгай зөвшөөрлийг цахимаар хүргэж	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		хуралдааны тэмдэглэл 2025-03-26 Дугаар 2025_14	мэдээлэл солилцооны “Хур” систем, цахим төлбөрийн баримтын системийг ашиглах, шийдвэрийн талаар мэдэгдлийг “И-Монгол” цахим системээр дамжуулан иргэнд хүргэх нөхцөлийг бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн цахим систем (Liicense), Төрийн үйлчилгээний “e-business.mn” системийг ашиглах арга хэмжээг 2025 оны II улиралд багтаан хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	байна. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 121, худалдах 317, нийт 438 цэг байна. Тайлант онд согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл 37 аж ахуйн нэгжид, үйлчлэх тусгай зөвшөөрөл 37 аж ахуйн нэгжид олгож зургаан сараас дээш хугацаагаар тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулаагүй болон цуцлах хүсэлт ирүүлсэн 10 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцалсан. Аймгийн Засаг даргаас зөвшөөрлийн хуульд заасан Байгаль орчны чиглэлээр энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх, Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл нь нийтлэг, олон олгогддогүй тул Хур систем болон "И-Монгол" цахим системд бүртгээгүй байна. Аймгийн Засаг даргаас зөвшөөрлийн хуульд заасан уул уурхайн чиглэлээр Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах болон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрлийг олгоход дараах шат дараатай үйл ажиллагаа явагдаж байгаа тул хур системд оруулах боломжгүй байна. Үүнд: 1. Аймгийн ЗДТГ-т тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж өргөдөл гаргана. 2. Аймгийн ЗДТГ өргөдлийг хүлээн авч Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу шаардлага хангаж буй эсэхийг шалгана. 3.Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар болон Байгаль орчны газраас шаардлага тус хуулийн 12 дугаар хэсгийн дагуу шаардлага хангаж байгаа эсэхийг албан бичгээр тодруулж баталгаажуулна. 4. Анхан шатны шүүлтээр шаардлага хангаж байвал Ашигт малтмал газрын тосны газрын кадастрийн цахим системд өргөдлийг бүртгэл үүсгэнэ... Хавсралт : 2 файл			
161	250	Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл	15.13.4.2.. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах хүрээнд жилийн эцсийн тайлан, мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, чиглэл	2025 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 12187 өргөдөл, гомдол ирсний 421 буюу 3.4 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 11766 буюу 96.5 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Ирсэн өргөдөл, гомдлын 430 нь гомдол, 259 нь талархал,46 нь санал, 1 нь мэдэгдэл, 11451 нь хүсэлт байна. Тайлант хугацаанд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2025-04-02 Дугаар 2025_15	хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.”	үетэй харьцуулахад 30.1 хувиар өссөн байгаа нь орон сууц хүссэн өргөдөл 101.7 дахин өссөнтэй холбоотой байна. Ирсэн нийт өргөдлийг агуулгын хувьд авч үзвэл нийгмийн халамж, газар, нийтийн тээврийн асуудлаар ирүүлсэн өргөдөл 5.9-17.4 хувиар буурсан ч, цахилгаан,гэрэлтүүлэг, барилга, орон сууц, зам засварлах, халаалтын асуудлаар ирүүлсэн өргөдөл 3.5-57.4 хувиар өссөн байна. 2025 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад болон жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ хийж зөвлөмж, чиглэл өгч, тайланг тухай бүрд аймгийн Засаг даргын шуурхай хуралд танилцуулж хяналт тавин ажиллаж ирлээ. Хавсралт : 1 файл			
	251		15.13.5.1.. Нийслэлийн Шуурхай штабын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлж, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлээр даалгасны дагуу биелэлтийг тухай бүр ERP системээр тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус;	Орхон аймагт хамаарахгүй заалт тул хяналтаас хасуулах саналтай байна.	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	
162	252	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04	19.24.6.1.. Хуралдаанд оролцогчдын болон тээврийн хэрэгслийн тоог	Бүсийн хамтын ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх "Бүсчилсэн хөгжил" хөдөлгөөний хүрээнд Хойд бүсийн өргөтгөсөн хуралдаанд оролцох бэлтгэл хангах ажлын хэсгийг аймгийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-23 Дугаар 2025_19	зохистой хэмжээнд байхаар хуваарилах, оролцогчдыг аймаг хооронд зорчиход авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүд, Булган аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир, Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар, Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр нарт; (Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны дүн болон Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны бэлтгэл ажлын талаар)	Засаг даргын 2025 оны А/272 захирамжаар байгуулан ажиллаж 2025 оны 4-р сарын 28-ны өдөр төрийн албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөлөл, ЖДҮ эрхлэгч, хоршоо, МХАҮТ-ын салбар танхим, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачид зэрэг нийт 100 гаруй хүнийг хамруулан салбар хуралдаануудад бэлтгэл ханган оролцсон. Уг хуралдааны хүрээнд Булган аймгийн төв талбайд "Түншлэл-Хамтын ажиллагаа" үзэсгэлэн зохион байгууллаа. Үзэсгэлэнд Орхон аймгаас 25 үйлдвэрлэл үйлдвэрлэгч оролцож бараа бүтээгдэхүүнээ танилцууллаа. Уг хуралдаанд оролцохоор 4-р сарын 28-ны өглөө 7:30 цагаас А.Амарын талбайгаас нэгдсэн зохион байгуулалттай оролцохоор зохион байгуулж хуралдаанд оролцогч нар болон үзэсгэлэнд оролцох иргэн, аж ахуйн нэгж, тэдгээрийн ачааг тээвэрлэх дунд оврын 2 автобус, 1 портер машиныг орон нутгаас шийдвэрлэн Булган аймагруу нэг цуваанд орж, зохион байгуулалттай явсан. Мөн уг цувааг цагдаагийн маяак бүхий машин хяналт тавьж урд дагуулж явсан.			
	253		19.24.5.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ авах, дэгдэдлтийг хязгаарлах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/586 захирамжаар ажлын хэсэг байгуулж салбар дундын уялдаа холбоог ханган ажиллаж, Улаанбурхан өвчний эсрэг хариу арга хэмжээг зохион үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан 2025 оны орон нутгийн төсөвт 30.0 сая, Онцгой комиссын зардлаас 100.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж бэлэн байдлыг ханган ажилласан. Тайлант хугацаанд эрсдэлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж ажилласан. Эрсдэлийн үнэлгээгээр улаан бурхан өвчин өндөр эрсдэлтэй (3.8 оноо, улбар шар түвшин) үнэлэгдсэн үед үе шатанд тохирсон хариу арга хэмжээг авч ажилласан. Зайлшгүй шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр гарган, үнэлгээ өгч, ЭМЯ-наас зохион байгуулсан 2 удаагийн хурал, 7 удаагийн цахим сургалтад 376 эмч,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Улаанбурхан өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, холбогдох мэргэжлийн эмч, сувилагч, вакцинаторууд, хүүхдийн байгууллагын эмч нарт чиглэл тус бүрээр 4 удаагийн зөвлөгөө мэдээлэл, үүрэг чиглэл өгч, улаанбурхан өвчний эмнэлзүй, илрэх шинж тэмдэг, ялган оношилгоо авах арга хэмжээний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан дотоодын сургалтыг 14 удаа зохион байгуулж нийт эмч, эмнэлгийн ажилчдын 84,6% хамруулсан. Тайлант онд улаанбурхан өвчний сэжигтэй 86 тохиолдол бүртгэгдэж, 66 тохиолдол батлагдаж, сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьталд тандалт судалгаа хийж, голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих хүн амын 96.9 хувийг хамруулан хариу арга хэмжээг авч ажилласнаар 9-р сараас хойш улаан бурхан өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Хавсралт : 2 файл			
163	254	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-28 Дугаар 2025_20	20.1.6. Орхон аймгийн үнэт цаас гаргах асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд судалж, танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан, Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр нарт даалгав.	Орон нутгийн үнэт цаас гаргах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж дүгнэлт гаргуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч Сангийн яамнаас үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх 13 төсөл арга хэмжээнээс 12 төсөл арга хэмжээнь Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4 -т заасан шаардлагад нийцэхгүй байгаа дүгнэлтийг гаргасан. Иймд үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тооцоолол, жагсаалтыг гаргаж 2026 онд дахин Сангийн яаманд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	Х.Б	Х.Б	
164	255	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 21 дүгээр	21.11.10.1.. 0й, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлж, иргэдэд хүргэх сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн	Цаг агаарын нөхцөлөөр 2025 оны хавар ой, хээрийн түймрийн аюул IV зэрэгт 26 хоног, III зэрэгт 18 хоног тус тус үргэлжиллээ. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, сумдын Засаг даргын захирамжуудаар ногоон бүсийн эргүүлийн үүргийг гүйцэтгэх хуваарийг батлан сумдын нутаг дэвсгэрт 2025 оны 3-р сараас эхлэн ой	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		хуралдааны тэмдэглэл 2025-04-30 Дугаар 2025_21	хэрэгслээр тогтмол үр дүнтэй явуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг Баян-Өндөр, Жаргалант сумын 13000 га талбайд төрийн байгууллагууд хамтран болон хөдөлгөөнт эргүүлээр давхардсан тоогоор 292 /өдөрт-32 албан хаагч/ албан хаагч өдөр тутмын эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж 5439 иргэн 33 ААНБ-д, 1407 айл өрх, 14 ойн нөхөрлөлд 8061 ширхэг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага, сэрэмжлүүлгийг түгээж, нийт 39 удаа сэрэмжлүүлэг шторк, , гал унтраагуур хэрхэн ашиглах заавар зөвлөмж, дохио сэрэмжлүүлэг мэдээг цахимаар аймгийн олон хүн дагагчтай фэйсбүүк хуудсуудын администуудтай хамтран давхардсан тоогоор 911.0 мянган дагагчтай бүлгэмүүдэд түгээж, цаг тухай бүрт орон нутгийн телевизээр 6 удаагийн ярилцлага, радиогоор 6 удаа зэрэг нийт 331 мэдээллийг түгээж, давхардсан тоогоор 2752379 иргэний хандалтыг авсан байна. Мөн Орон нутгийн Тусгал, NBHD, ETV зэрэг телевизүүдтэй хамтран шар өвс, хог шатаасан зөрчлийг газар дээрээс нь сурвалжлага мэдээ авч иргэдэд ой, хээрийн түймэр болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг нийт 72 удаа өгсөн. Өнжмөл шар өвсны гал түймрийн зөрчил гаргасан 25 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 5.14.1 дэх хэсэгт заасны дагуу 2.5 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж ажилласан. Мөн гамшиг, ослын үед гал унтраах бодис зөөвөрлөх, тээвэрлэхэд ашиглах нисгэгчгүй нисэх төхөөрөмж авахад 71.5 сая, хөдөлгөөн, дулаан мэдрэгчтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмж авахад 28.0 сая, 4ш дулаан, хөдөлгөөн мэдрэгчтэй 2 нүдний дуран авахад 400.0 мянга, нийт 199.5 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлэн байдлыг хангаж, чадавхаа нэмэгдүүлж ажиллалаа. Хавсралт : 1 файл			
165	256	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны	25.31.1.1. 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын	2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдэд туссан арга хэмжээнүүдээс хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан хэрэгжилт удаашралтай арга хэмжээний	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		тэмдэглэл 2025-05-28 Дугаар 2025_25	Тамгын газар нь өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, дүнг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	хэрэгжилтийг эрчимжүүлэх, зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг төсвийн тодотголд тусган батлуулж хэрэгжүүлэх, арга хэмжээний хэрэгжилтийн явц, тулгамдаж буй асуудлын талаар шуурхай хуралдаанаар хэлэлцэж хариуцсан байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийн талаарх мэдээллийг 7 хоног тутамд тухайн шуурхай хуралдаанд танилцуулах, өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилттэй аймгийн Засаг дарга холбогдох байгууллагуудын албан хаагчдын хамт газар дээр нь очиж танилцах зэргээр хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Аймгийн ЗДТГ-ын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй 17, хэрэгжээгүй гэж үнэлэгдсэн 3 заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэн ажилласан ч төсөв санхүүгийн асуудлаас шалтгаалан, хэрэгжих боломжгүй болсон 2 заалтын хэрэгжилт удаашралтай байна. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хөтөлбөрт туссан арга хэмжээнүүдээс хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 24, үр дүнгүй 3 арга хэмжээ үнэлэгдсэнээс үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай 17 арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, 2024 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдээс хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 13, үр дүнгүй 10 арга хэмжээ үнэлэгдсэнээс үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай 15 арга хэмжээг 2025 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тус тус тусган хэрэгжүүлж байна. 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 03/2895 тоот албан бичгээр хугацаанд нь Засгийн газрын ХХГ-т хүргүүлсэн. Хавсралт : 1 файл			
166	257	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26	26.27.6.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад	Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ авах, дэгдэлтийг хязгаарлах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/586 захирамжаар ажлын хэсэг байгуулж салбар дундын уялдаа холбоог ханган ажиллаж, Улаанбурхан өвчний эсрэг хариу арга хэмжээг зохион үйл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-04 Дугаар 2025_26	шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх, үндэсний товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан 2025 оны орон нутгийн төсөвт 30.0 сая, Онцгой комиссын зардлаас 100.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж бэлэн байдлыг ханган ажилласан. Тайлант хугацаанд эрсдэлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж ажилласан. Эрсдэлийн үнэлгээгээр улаан бурхан өвчин өндөр эрсдэлтэй (3.8 оноо, улбар шар түвшин) үнэлэгдсэн үед үе шатанд тохирсон хариу арга хэмжээг авч ажилласан. Улаанбурхан өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, холбогдох мэргэжлийн эмч, сувилагч, вакцинаторууд, хүүхдийн байгууллагын эмч нарт чиглэл тус бүрээр 4 удаагийн зөвлөгөө мэдээлэл, үүрэг чиглэл өгч, улаанбурхан өвчний эмнэлзүй, илрэх шинж тэмдэг, ялган оношилгоо авах арга хэмжээний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан дотоодын сургалтыг 14 удаа зохион байгуулж нийт эмч, эмнэлгийн ажилчдын 84.6% хамруулсан. Тайлант онд улаанбурхан өвчний сэжигтэй 86 тохиолдол бүртгэгдэж, 66 тохиолдол батлагдаж, сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьталд тандалт судалгаа хийж, голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих хүн амын 96.9 хувийг хамруулан хариу арга хэмжээг авч ажилласнаар 9-р сараас хойш улаан бурхан өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй байна... Хавсралт : 1 файл			
167	258	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-07-30 Дугаар 2025_10	14.4.. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн	Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрт 7 бүлгийн 81 арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2025 хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, хяналт шинжилгээ хийн 91.7 хувьтай үнэлэгдсэнийг Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хорооны хуралд танилцуулж дүгнүүлсэн. 2026-2028 онд хэрэгжүүлэх хэлэлцээрийн төсөлд тусгах саналыг төрийн байгууллага, ҮЭХ, ажил олгогч эздийн холбооноос авч нэгтгэх ажил хийгдэж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинээр байгуулах хэлэлцээрийн төслийг боловсруулан 2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Хавсралт : 1 файл			
168	259	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-08-06 Дугаар 2025_11	9.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн	2025 оны аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийтийн мэдээллийн систем үүсгэх, программ хангамж худалдан авах төсөл арга хэмжээ тусгагдаагүй. Худалдан авах ажиллагааны газрын зүгээс захиалагч болон Аймгийн ЗДТГ, харьяа байгууллагуудад “Нийтийн мэдээллийн систем” үүсгэх, программ хангамж худалдан авахаар бол худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас өмнө Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, ТЭЗҮ-ийг хүргүүлж зөвлөмж, дүгнэлтийг авсаны дараа зохион байгуулах талаар тогтмол мэдээлэл, зөвлөгөөг өгч ажиллалаа.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.	Хавсралт : 1 файл			
	260		9.7.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн	2025 оны аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийтийн мэдээллийн систем үүсгэх, программ хангамж худалдан авах төсөл арга хэмжээ тусгагдаагүй. Худалдан авах ажиллагааны газрын зүгээс захиалагч болон Аймгийн ЗДТГ, харьяа байгууллагуудад “Нийтийн мэдээллийн систем” үүсгэх, программ хангамж худалдан авахаар бол худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас өмнө Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, ТЭЗҮ-ийг хүргүүлж зөвлөмж, дүгнэлтийг авсаны дараа зохион байгуулах талаар тогтмол мэдээлэл, зөвлөгөөг өгч ажиллалаа. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.				
169	261	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-08-20 Дугаар 2025_13	12.3.2.2.. нийслэл, төвлөрсөн суурин газрын агаарын чанарыг 3 жилийн дотор Монгол Улсын стандартын жилийн дундаж үзүүлэлтэд бүрэн нийцүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/846 захирамжаар байгуулан зохион байгуулж 14003 айл өрх, 11 аж ахуйн нэгжийн уурын зуух, 33854 авто тээврийн хэрэгслийг хамруулласа. Тайлант хугацаанд 15338.2 тн нүүрс, 49457 м3 мод түлшинд зарцуулсан байна. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож цахилгааны хүчдэлийн уналтыг шийдвэрлэсэн. "Миний гэр бидний гудамж төсөл"-ийн хүрээнд гэр хорооллын 7 багт инженерийн шугам сүлжээ татагдаж, нийт 1245 өрх төвлөрсөн ИШС-д холбогдох боломж бүрдсэнээс 354 өрх холбогдож, 266 өрх техникийн нөхцөлөө авсан байна. Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулласа. Аймгийн Засаг даргын 2025 оны А/65 дугаар захирамжаар "Цэвэр агаартай хот төсөл боловсруулах ажлын хэсэг"-ийг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн 24 төсөл бичиж танилцуулсан. 2025 оны 05 дугаар сард БНСУ болон Монгол улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд агаарын чанарын 6 үзүүлэлтийг	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

				тасралтгүй хэмжих Агаарын чанарын автомат станцыг хүлээлгэн өгсөнөөр хүхэрлэг хий, азотын ислүүд, озон, нүүрстөрөгчийн дутуу исэл, PM10 болон PM2.5 тоосонцрын агууламжийг хэмжих боломж бүрдсэн. Орхон аймгийн хувьд агаарын чанарын дундаж үзүүлэлтийн өвлийн саруудын дундаж нь стандартын түвшнөөс даваагүй тул стандартад нийцүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгараагүй байна. Хавсралт : 1 файл			
	262		12.3.2.4.. дотоод орчны агаарын чанарын стандартыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан батлуулж, агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс гаргахыг холбогдох Засаг дарга нарт тус тус;	Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн С/20 дугаар тушаалаар Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025 стандарт батлагдсан. Эрдэнэт хотын агаарын чанарын хязгаарлалтын бүс, бүсэд мөрдөх журмыг шинэчилж, БОАЖ-ын сайд, аймгийн Засаг даргын хамтарсан А/441/А/724 тоот тушаал, захирамжаар батлуулж мөрдөн ажиллаж байна. Тоосжилт ихтэй бүс болох Говил багийн "Эрх-бүжинхэн" цэцэрлэг, багийн байруудын цонхны салхивчинд нарийн ширхэгт PM2.5 тоос, тоосонцор, хорт утааны нано шүүлтүүр суурилуулах ажлыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын санхүүжилтээр шийдвэрлэсэн. Ингэснээр цагаан тоосны нөлөөллийн бүс болох Говил баг, Баянцагаан баг, Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүдийн цонхонд нарийн ширхэгт PM2.5 тоос, тоосонцор, хорт утааны нано шүүлтүүр суурилуулаад байна. Тайлант хугацаанд орчны агаарын чанарыг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэгүүдийн анги танхим, заал, өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн коридорт нүүрстөрөгч шингээж хүчилтөрөгч ялгаруулдаг цэцэгт болон модлог тасалгааны ургамлыг барйлуулж усалгаа, арчилгааг тогтмол хийж байна. Мөн сургууль, цэцэрлэг орчмын агаарын бохирдлыг буруулах чиглэлээр НҮБ-ын Хүүхдийн Сангийн "Барилгын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах" төслийн хүрээнд Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх нийт 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийн ажил хийгдэж, төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

				Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран гүйцэтгэснээр туршилт тохируулгын ажил хийгдэж байна. Туршилт тохируулгын үед нэмэлт галлагаагүйгээр Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийн барилгыг сэргээгдэх эрчим хүчээр халааж байна. Хавсралт : 2 файл			
	263		12.3.2.6.. угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн гэр хорооллын өрх бүрд байршуулж, хяналт тавин, мэдрэгч ажилласан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2022 онд ОББҮХ-ны хөрөнгө оруулалтаар Орхон аймагт 1100 ширхэг угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн боловч угаарын хийн хяналтын төвийг шинээр байгуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмж, программ хангамжийн зардал шийдвэрлэгдээгүйн улмаас тухайн угаарын хийн мэдрэгчийг айлуудад суурилуулаагүй, түр хадгалагдаж байна.	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	
	264		12.3.2.7.. агаарын бохирдлын талаарх мэдээллийг өдөр тутам олон нийтэд тогтмол мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн сувгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн агаарын чанарыг хотын төв болон гэр хороолол орчмоос хүхрийн давхар исэл 1218 удаагийн давталттай, азотын давхар исэл 1218 удаагийн давталттайгаар сорьц авч хяналт-шинжилгээ хийж, агаарын чанарын тайлан мэдээг https://orkhon.weather.gov.mn/ сайт, orkhon.namem.gov.mn сайт, и-оффис систем, Орхон аймгийн Ус цаг уур орны шинжилгээний төв facebook пэйж хуудсаар аж ахуйн нэгж, ард иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн Эрдэнэт хотын хэмжээнд Говил багийн нутаг дэвсгэрт болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хаягдлын аж ахуйн далан дээр суурилуулсан тоосны автомат 2 станцын хэмжилтийн дүн мэдээг www.Agaar.mn-д сайтад 7 хоног тутамд мэдээлж ирсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	265		12.3.2.9.. гэр, барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			технологи нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн дунд чөлөөт өрсөлдөөн бий болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч, агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусган 2022-2024 онд онд 182 өрхөд монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгосон. Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн 3 төрлийн багц бүтээгдэхүүнийг 2025 онд нийт 63 өрхөд хөнгөлөлттэй нөхцлөөр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулаа. Дулааны алдагдлыг бууруулахад шаардлагатай цэцэрлэг, сургуулийн барилгад дулаалга хийлгэх зураг төсвийг орон нутгийн төсвийн 383.0 сая төгрөгөөр хийж, дулаалгын ажилд шаардлагатай 2.0 тэрбум төгрөгийг 2026 оны орон нутгийн төсөвт тусган батлууллаа. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн байрыг дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлттай байдлаар өөрчлөн засварлаж "Бага насны хүүхдийн хөгжлийн төв" -ийг байгуулсан. НҮБ-ын Хүүхдийн Сангийн "Барилгын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах" төслийн хүрээнд Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх нийт 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг хэрэгжүүлж нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх ажил бүрэн дуусаж тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэх хэмжээний бохирдлыг бууруулах боломж бүрдэнэ Хавсралт : 1 файл			
	266		12.3.2.10.. шахмал түлшний стандартыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, стандартын шаардлага хангасан түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх, шахмал түлшний хэрэглээний гадаад, дотоод орчны	Орхон аймагт шахмал түлшний үйлдвэргүй тул хэрэгжээгүй	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	

			агаарын чанар, стандартад үзүүлж байгаа нөлөөллийг тогтмол хянах арга хэмжээ зохион байгуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;				
170	267	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-02 Дугаар 2025_15	10.4.1.. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/104 тоот тушаалаар мэдээлэл хариуцагч тус бүрийг томилон хэрэгжүүлэлт дээр тогтмол хяналт тавин ажиллаж төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудаснууд болох https://e-mongolia.mn/org/orkhongovern, https://www.gov.mn/mn/organization/erdenet нэгдсэн цахим хуудаснуудад болон өөрийн албан ёсны веб сайт болох https://erdenet.mn/medee дээр байгууллагынхаа мэдээллийг бүрэн байршуулан улирал бүр https://shilen.gov.mn/home системд бүрдүүлэн 68 заалтын 113 нээлттэй мэдээллийг илгээж, үнэлүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 114 байгууллага Шилэн индексийн үнэлгээнд хамрагдахаас 2025 оны III улиралын байдлаар 20 байгууллага мэдээллээ бүрэн оруулж үнэлгээ хийлгээгүй, 94 байгууллага хуульд заасан мэдээллээ оруулж үнэлэгдсэн ба үнэлгээний дундаж 77.8 хувьтай байна. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит хийж тухай бүрд илэрсэн зөрчил, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагуудад хүргүүлэн ажиллаж ирсэн ба 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгдсэн дүнгээр 94.74 хувьтай дүгнэгдсэн бол 2025 оны 3-р улиралд 98.4 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой үнэн зөв, бүрэн байх, нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Орхон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас нь мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан лизенцтэй программ хангамжтай, системийн хэвийн, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Мөн жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хяналт, шалгалтын нэг үзүүлэлт болгон шалгаж зөвлөгөө, мэдээллээр ханган, хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.			
	268		10.4.4.. Эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд буюу мэдээлэл хариуцагчдын хууль биелүүлэх үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, дадлыг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийх төлөвлөгөө гарган аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд болон төрийн өмчийн оролцоо бүхий 47 байгууллагад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, зөвлөмж зөвлөгөө өгөх, удирдлагын хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Мөн аймгийн ЗДТГ-н Хууль, эрх зүйн хэлтсийн албан ёсны пэйж хуудсанд “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийг хэрэгжүүлэх талаар рийл болон постерийг бэлтгэн хүргэх төдийгүй аймгийн хэмжээнд ашиглагддаг и-оффис дотоод системээр дамжуулан бүх байгууллагуудад дотоод мэдээ, файлын сан, аудио видео цэснүүдэд нээлттэй байдлаар байршуулснаар давхардсан тоогоор 1300 орчим иргэдэд хүрсэн. https://eoffice.erdenet.mn/modules/main/	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
171	269	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16	28.1.3.. иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг бүртгэх нэгдсэн мэдээллийн санд и-оффис цахим системийг холбох хөгжүүлэлтийг хийхэд шаардлагатай 69.0 сая төгрөгийн төсвийг 2026 оны төсөвт тусган батлуулсан. 2026 оны эхний улиралд тус системийн хөгжүүлэлтийг хийж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэлийг хийхээр төлөвлөж байна. Хавсралт : 1 файл	Х.Б	Х.Б	
	270		28.2.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгав: 1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах; 1.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг тодорхой, үнэн, зөв, хэрэгжилтийн нотлох баримтыг хавсарган тайлагнаж байна. Хяналтад байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн заалтуудад судалгаа хийж утга агуулгын хувьд давхцаж байгаа, тухайн шийдвэр хүчингүй болсон, шийдвэрт заасан хугацаа дууссан, чиг үүрэгт хамааралгүй нийт 88 заалт заалтыг хяналтаас хасуулах санал боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. Орон нутгийн түвшинд шийдвэрийн төслийг боловсруулахдаа асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулахгүйгээр боловсруулж шийдвэр гаргаж байна. 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдэд туссан арга хэмжээнүүдээс хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн төсвийн тодотголд тусган батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			тайлагнах; 1.3.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх; 1.4.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах.				
	271		28.4.2.. Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулах асуудлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, орон нутгийн түвшинд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт;	Орхон аймаг газар нутгийн хэмжээ багатайгаас одоогийн байдлаар атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх талбай байхгүй байна. 2025 оны байдлаар газрын нэгдмэл сангийн тайлангаар тариалангийн зориулалттай нийт 5181.9 га талбайтай ба талбайн ашиглалт 100 хувьтай байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	272		28.4.3.. Ургац хураалтын үед тариалангийн талбайд мал оруулахгүй байх талаар нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг тариалан бүхий аймгийн Засаг	Ургацыг малаас хамгаалах зорилгоор хаврын тариалалтаас ургац хураалтын ажил дуусах хүртэлх хугацаанд тариалангийн талбайн ойр орчимд мал бүхий иргэдийг буулгахгүй, малыг хариулга, маллагаатай болгох зорилгоор Тариалангийн тухай хууль, Жаргалант сумын Засаг даргын захирамжийг нийт малчин өрхөд танилцуулан, малчдад шаардлага тавин ажилласан. Үр тариа, тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоог мал, тэжээвэр амьтдаас хамгаалах	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			дарга нарт, тариалангийн талбайг хашиж хамгаалах, ойн зурвас байгуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт тус тус	зорилгоор таримал ургамал тариалж буй иргэд, аж ахуй нэгжүүд нийт 5180 орчим га талбайг түр болон байнгын хашаагаар хашаажуулж, харуул хамгаалалттай болгосон байна. Жаргалант сумын тариалангийн зориулалттай талбай 100 хувь хашаажуулалтад хамрагдсан. Хавсралт : 1 файл			
	273		28.4.5.. Төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгоход дундын хоршоодыг түшиглэн стандартын шаардлага хангасан зоорь, агуулах барих асуудлыг орон нутгийн түвшинд зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт, дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт тус тус	Аймгийн хэмжээнд 7628 тонн багтаамжтай 167 төмс, хүнсний ногооны зоорь ашиглаж байна. 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Жаргалант суманд төмс, хүнсний ногооны 500 тн багтаамжтай бүрэн механикжсан зоорь баригдаж ашиглалтад хүлээн авснаар стандартын шаардлага хангасан төмс, хүнсний ногооны зоорины багтаамж 500 тн-оор нэмэгдсэн. Тус зоорийг ашиглах журмыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж одоогийн байдлаар 37 иргэний 230 тн орчим төмс, хүнсний ногоо хадгалж байна. Атар-IV аяны "Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилтийн гэрээ"-ний хүрээнд тус бүр 100 тн багтаамжтай төмс, хүнсний ногооны зоорь шинээр барих зорилгоор 2 аж ахуйн нэгж 210.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан. Үүний үр дүнд стандартын шаардлага хангасан зоорины багтаамж 200 тн-оор нэмэгдсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	274		28.14.1.3.. шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллаагүй байгууллага, албан тушаалтанд хууль, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.	Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллахыг үүрэг болгосон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар эзэнжүүлэн мэдээллийг цаг тухай бүр https://shilendans.gov.mn/organization/6098?ry=2025&group=117 холбоост байршуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит хийж тухай бүрд илэрсэн зөрчил, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагуудад хүргүүлэн ажиллаж ирсэн ба 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгдсэн дүнгээр 94.74	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хувьтай дүгнэгдсэн бол 2025 оны 3-р улиралд 98.4 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой үнэн зөв, бүрэн байх, нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Мөн жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хяналт, шалгалтын нэг үзүүлэлт болгон шалгаж зөвлөгөө, мэдээллээр ханган, хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
	275		28.18.5.. тарваган тахал өвчний хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг ханган, оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулж, авто тээврийн шалган нэвтрүүлэх цэгүүдэд тавьж байгаа хяналтыг чангатгахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	"Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх тухай" эрүүл мэндийн сайдын 03 албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор тарваган тахал өвчний тандалт хяналтын арга хэмжээг эрчимжүүлэх төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг 87.5% ханган ажилласан. Тарваган тахал өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээний чадвахийг нэмэгдүүлэн ЭМБ-уудын бэлэн байдлыг хангаж ажиллан, эрсдлийн үеийн харилцаа холбоог идэвхжүүлсэн. Тайлант хугацаанд тарваган тахал өвчний сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, хариу арга хэмжээг авч ажиллан, онош үгүйсгэгдсэн. Хөвсгөл аймагт тарваган тахал өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан, иргэд олон нийтэд зориулсан сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх 23 төрлийн мэдээлэл бэлтгэн 32 удаагийн шторк, сэрэмжлүүлэг контент бэлтгэн цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр түгээж нийт 27830 иргэнд хүргэсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
172	276	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 11.1.1. 1.хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын	11.1.1. 1.хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн мөрөөр Засгийн газрын	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймагт хамаарах 103 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж, дүнг нэгтгэн яналт-шинжилгээ хийж үнэлэн хагас жил тутамд цахим	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-24 Дугаар 2025_18	үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	системээр тайлагнаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж 83.7%-тай байна. Дээрх арга хэмжээнүүдээс үр дүн хангалтгүй болон үр дүн гараагүй 13 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэлийг өгсөн. Хавсралт : 1 файл			
	277		11.2. . 11.2.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнгийн талаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагын дарга нарт даалгав.	“Орхон аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” эхний хагас жилийн байдлаар 66.9 хувьтай дүгнэгдсэн ба биелэлт хангалтгүй байсан 22 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх үүрэг чиглэлийг хэлтэс, агентлагийн дарга нарт өгч хэрэгжилтийг хангуулж ажилласнаар “Орхон аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт урьдчилсан гүйцэтгэлээр 93.0 хувьтай байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
173	278	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10	16.4.1.. Үүнтэй холбогдуулан 2025 онд багтаан дараах арга	Эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хөгжүүлсэн "Төрийн мета-	Х.Б	Х.Б	

		дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-08 Дугаар 2025_20	хэмжээг авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав: 1.эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг “Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан”-д бүртгүүлэх;	өгөгдлийн нэгдсэн сан"-д https://metadata.nso.mn/login хаягаар бүртгүүлэх хүсэлтээ нэгдсэн viber олон нийтийн харилцааны программаар гаргасан. Тус систем https://infodata.gov.mn/ болж өөрчлөгдөн шинэчлэлт хийгдэж байгаатай холбогдуулан бүртгэл идэвхижээгүй байна.		
	279		16.4.3.. 2.төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх;	Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хөгжүүлж хэрэгжүүлсэн цахим системд https://system.gov.mn хаягаар хандан бүртгүүлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	280		16.4.3.. 3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ нь дэргэдээ "Цахим төв"-ийг нээн төрийн 215 үйлчилгээг 24/7 цагаар, Баян-Өндөр, Жаргалант сумдад тус бүр "ХУР-ДАН" төвөөр дамжуулан 86 байгууллагын 1173 төрлийн лавлагаа тодорхойлолтыг, мөн Баян-Өндөр суманд байрлах хүн ам ихээр төвлөрч үйлчлүүлдэг 12 цэгт "Хурдан" киоск машин ажиллаж e-mongolia.mn системээр дамжуулан Төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
174	281	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-	8.2.3.. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, сургалтын төвүүдэд	Орхон Политехникийн коллежтой хамтран танхимын мэргэжил олгох сургалтыг 5 мэргэжлээр зохион байгуулж 48 иргэнийг, чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг “Уран гар” сургалтын төвтэй хамтран гар урлал мэргэжлээр 9	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-22 Дугаар 2025_22	мэргэжил эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжил эзэмшин хугацаат цэргийн албанаас халагдаж байгаа залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Боловсролын сайд П.Наранбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг, сургалтад тус тус хамруулж сургалтын зардалд нийт 32.2 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайлал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор цахим ур чадварын сургалтыг бүртгэл тооцоо хөтлөлт, гар урлалын мэргэжлээр сургалтын байгууллагатай хамтран явуулж 30 эмэгтэйг хамруулан чадамжийн гэрчилгээ олгож сургалтын зардалд орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөг зарцуулсан. Мэргэжил олгох танхимын болон цахим ур чадварын сургалтад нийт 87 иргэн сургалтад хамрагдаж нийт 40.8 сая төгрөг зарцуулсан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран хугацаат цэргийн албанаас халагдаж байгаа иргэдэд хавар, намар "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр нээлттэй ажлын байр, гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох, ажилд хэрхэн зуучлах зэрэг сэдвийн хүрээнд тус бүр 2 цагийн сургалтыг зохион байгууллаа. Хавсралт : 3 файл			
175	282	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-11-05 Дугаар 2025_26	13.3.1.1.. 1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээг авахыг даалгав: 1.1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр, “Нийгмийн шударга ёсыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар, “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг	Ерөнхий сайдын болон Засгийн газрын албан даалгаврыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллаж, хэрэгжилтийг сар бүр Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнаж байгаа ба 2025 оны байдлаар 93.2 хувийн хэрэгжилттэй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			чангатгах тухай” 03 дугаар, “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавраар хугацаатай өгсөн үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;				
	283		13.3.1.2. 1.2.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хангалтгүй дүгнэгдсэн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөө боловсруулах, салбарын хэмжээнд бодит үр дүнг сар бүр нэгтгэн дүгнэж, товч, тодорхой тайлагнах, өмнөх сард тайлагнасан албан даалгаврын хэрэгжилтийг давтан тайлагнахгүй байх.	Ерөнхий сайдын болон Засгийн газрын албан даалгаварт туссан заалтуудаас хангалтгүй үнэлэгдсэн ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг зохион байгуулах талаар дээд шатны байгууллагаас нэгдсэн чиглэл зөвлөмж ирээгүй байгаатай холбогдуулан тус ажил удаашралтай байна. Ерөнхий сайдын болон Засгийн газрын албан даалгаврыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллаж, хэрэгжилтийг сар бүр Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнаж байгаа ба 2025 оны байдлаар 93.2 хувийн хэрэгжилттэй байна Хавсралт : 1 файл	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	
	284		13.3.4.. Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд яам, Засгийн газрын агентлагууд иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл,	Аймгийн Засаг дарга холбогдох байгууллагуудын удирдлагуудыг оролцуулан 7 хоног бүрийн Пүрэв гаригийн 15 цагаас эхлэн иргэдийг хүлээн авч уулзан, санал хүсэлтийг нь хүлээн авч холбогдох байгууллага албан тушаалтанд үүрэг даалгавар өгч шийдвэрлэлтэд нь хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 33 удаагийн уулзалтаар 513 иргэнийг хүлээн авч уулзан холбогдох хэлтэс, байгууллагад 593 үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж ажилласнаар хэрэгжилт 85.2 хувьтай байна. Мөн Нутгийн захиргааны байгууллагууд иргэдийг аль болох чирэгдэл учруулахгүйгээр ирсэн тухай бүрд нь хүлээн авч уулзан өргөдөл хүсэлтийг нь шийдвэрлэн ажиллаж хэвшсэн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;	байна. Хавсралт : 1 файл			
	285		13.3.7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав;	Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу төсвийн байгууллагуудад шаардлагагүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах үүрэг чиглэлийг өгч, орон нутгийн төсвийн байгууллагуудад гадаад томилолтын зардлыг хянаж олгоогүй ба төсвийн урсгал зардлыг хязгаарлалттай олгож, шаардлагагүй худалдан авалт хийх боломж нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад анхааран ажиллаж байна. Мөн аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг төрийн байгууллагын зориулалтын хурлын танхимд танхимаар болон цахимаар зохион байгуулж хэвшээд байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
ЗГ-ын албан даалгавар							
176	286	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай	1.14.. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын реформыг хэрэгжүүлэхийг Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд	Хил хамгаалах ерөнхий газарт аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах бүрэлдэхүүний “Хойд бүсийн салбар зөвлөгөөн”, “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба Зэвсэгт хүчний бэлэн байдал” сэдвийн хүрээнд стратегийн цугларалтад нийт 120 гаруй алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Мөн аймгийн хэмжээнд багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалт, цэргийн алба хаасан 35 иргэнд цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний давтан бэлтгэл сургалтыг тус тус зохион байгуулснаар орон нутаг өөрийгөө хамгаалах чадавх	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

		2024-09-18 Дугаар 2024_01_1	С.Бямбацогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	нэмэгдэж байна. Орон нутгийн онцлогтой уялдуулан аливаа гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулахад чиглэлээр 2 удаагийн сургалтад Онцгой байдлын газрын 8 алба хаагч хамрагдсан. Мөн Бүс, орон нутгийн онцлогтой уялдуулан гамшиг, эрсдэлийг даван туулах чиглэлээр Хойд бүсийн хэмжээнд 2025 онд бүсчилсэн 1 удаагийн дуудлагад хамтран ажилласан байна. Хавсралт : 2 файл			
177	287	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02	1.2.13. 1.2.13.хот, суурин газарт үерийн болон бусад гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийж, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн Засаг даргын 2025 оны А/319 тоот захирамжаар Үер усны ослын эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Орхон аймагт Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн хүрээнд хийгдэх үерийн далан, суваг барих ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын Хунан Индастриал Экүйдмент Инсталэйшн ХХК шалгарч 9 байршилд 12.8 км инженерийн хийцлэлтэй үерийн далан, нийт 14000м3 багтаамжтай 4 усан сан барихаар гэрээ байгуулж, үерийн далангийн нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулан улсын магадлангаар хянуулж ажлыг эхлүүлснээр одоогийн байдлаар 8 байршилд үерийн далан барих ажил 66.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	
	288		1.2.14. 1.2.14.ус хангамж, ариутгах татуурга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын мастер төлөвлөгөөг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж аймаг, нийслэл бүрээр гаргаж, бодлогын түвшинд хэрэгжүүлэхийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн	Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй инженерийн шугам сүлжээг 2025-2028 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар санал өгсөн ч аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа тус төлөвлөгөөг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах шаардлага тулгарсан тул аймгийн ИТХ-аар хэлэлцэх асуудлал хүлээгдэж байна. Тус төлөвөлгөөний төслийг боловсруулах ажлын хүрээнд эхний ээлжинд нэн тэргүүнд хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлыг эрэмбэлэн гаргаж нийт 215.0 тэрбум төгрөг шаардлагатай тооцоо гарсан. Үүнээс: 2025 онд орон нутгийн төсвийн 27.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ус,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			сайд Л.Гантөмөр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	дулаан түгээх системүүдийг шинэчлэхээр 14ш Ус дулаан хувиарлах төвийг Үл хамаарах схемд шилжүүлэх ажил, ус дулаан түгээх төвийн гадна дулаан, цэвэр усны шугам шинэчлэх /5 хос шугам, Хүрэнбулаг багийн Уртцагааны цэвэр усны төв шугам, Оюут баг Есөн эрдэнэ зах ариутгах татуургын төв шугам, Зэст багийн нутаг дэвсгэрт байрлалтай 1-р хорооллын бохир усыг татан зайлуулах төв шугам, Дэнж багийн хэрэглэгчдийг төвийн цэвэр усны шугамнаас холбох ажил, 11-р хорооллын А хэсэг дулааны шугамын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, Их залуу багт байрлах усан сан руу дулаан, цэвэр усны шугам татах ажлуудыг хийж нийт дулааны 25.6км, бохир усны 0.6 км, цэвэр усны 18.6 км шугамыг барьж ашиглалтад оруулаа. Мөн Европын Сэргээн босголтын хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн 8 ажил хийхээр төлөвлөснөөс 4 ажлыг хийж гүйцэтгэлээ. Хавсралт : 1 файл			
178	289	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-03-07 Дугаар 2025_03	1.1. 1.1. ”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан аймаг, нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг .”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан боловсруулж аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн 2024 оны 03/15 дугаар тогтоолоор батлуулсан. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 бүлэг, 19 төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, 22 хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд нийт 249 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласнаар 2025 оны жилийн эцсийн байдлаар 83.7%-ийн хэрэгжилттэй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	290		1.2. 1.2. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг хүний хөгжлийг	2026 оны төсвийг иргэдийн эрүүл, аюулгүй орчинд, ая тухтай амьдрах, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээг сайжруулах, нийгэм, эдийн засгийн олон талт хэрэгцээнд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			дэмжсэн байхаар төлөвлөх, төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээний саналыг урьдчилан тооцоолж, бэлтгэх;	чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнүүдийг салбар бүрээс саналыг нэгтгэн боловсруулж аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн аймгийн нийт төсвийн орлого, зардалыг тус бүр 422.1 тэрбум төгрөг байхаар батлуулсан. Хүний хөгжлийг дэмжих төсөл арга хэмжээнүүдээс товч дурьдвал: Боловсролын салбарт Царцсан 3 сургуулийн барилгыг ашиглалтад оруулахад шаардлагатай хөрөнгө - 5.2 тэрбум төгрөг, - Шинээр 3 сургуулийн спорт заал барьж эхлүүлэх - 5.4 тэрбум төгрөг - 2 цэцэрлэгийн гадна фасад дулаалах ажил - 1.8 тэрбум төгрөг - 2 сургуулийн гал тогооны өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэлд - 1.4 тэрбум төгрөгийг төсөвлөлөө. - Сургууль, цэцэрлэгийн засвар үйлчилгээ, гадна талбай, замын тохижилтын ажилд 2.8 тэрбум төгрөг - Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид гэр, сургуулийн хооронд аюулгүй зорчих боломжийг бүрдүүлэх, эцэг эхийн цагийг хэмнэх зорилгоор сургуулийн автобусыг нэмэгдүүлэхэд 2.8 тэрбум төгрөг тус тус тусгалаа. Мөн Гэр хорооллын багууд дахь хөрсний элэгдэл, тоосжилтыг бууруулах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор 13 багт 70.4 км гудамж хоорондын замыг сайжруулах, хотын төвийн гэрэлтүүлгийн хүртээмж, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор 6 байршилд 256 ширхэг гэрэлтүүлгийг шинээр 4.8 тэрбум, гэр хорооллын эрчим хүчийг нэмэгдүүлэхэд 6.9 тэрбум, хотын инженерийн шугам сүлжээ засварлахад 4.6 тэрбум төгрөгийг тус тус тусгасан. Хавсралт : 1 файл			
	291		1.3. 1.3. Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг бүс бүрд зохион байгуулж, бүсүүдийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүс бүрд хэрэгжүүлэх	2025 оны 4-р сарын 28-ны өдөр Булган аймагт зохион байгуулсан "Хойд бүсийн өргөтгөсөн хуралдаан"-нд оролцох бэлтгэл хангах ажлын хэсгийг 2025 оны А/272 дугаар захирамжаар байгуулан 13 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж оролцсон. Хуралдааны үеэр бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгуулах 8 төслийн саналыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ, Хойд бүсээс сонгогдсон УИХ-ын гишүүд, Зам тээврийн яам, Боловсролын яам, Эдийн засаг, хөгжлийн яам болон Хойд бүсийн хөгжлийн төв ТББ-д тус тус хүргүүлсэн. Мөн 2025 оны 06 дугаар сард "Бүсийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			шаардлагатай 5 мега төслийн жагсаалт гаргах;	хөгжлийн зорилтот хөтөлбөр"-т тусгах 10 төслийн саналыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд хүргүүлсэн. "Хойд бүсийн өргөтгөсөн хуралдаанд санал хүргүүлсэн төслүүдээс Засгийн газрын 2025 оны 4-р сарын 28-ны өдрийн 204-р тогтоолоор Эрдэнэт-Үйлдвэр ТӨҮГ-ын харьяа "Эрдэнэт-Медикал" төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэн Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгон хөгжүүлэхээр шийдвэрлэн 2025 оны 08 дугаар сард нээлтээ хийсэн. Хавсралт : 1 файл			
	292		1.4. 1.4.Бүс, орон нутгийнхаа сайн туршлага, шинэ санаачилга, инновац нэвтрүүлсэн туршлагыг олон нийтэд таниулах, түгээх, бусад аймаг, нийслэлтэй туршлага солилцох;	Эрдэнэт ШУТП нь Хойд бүсийн хэмжээнд шинжлэх ухаан, технологийн үндэслэлтэй, кластер зарчмаар хөгжүүлэх төслийн судалгаа, бизнес эрхлэгчдэд танилцуулах сургалтыг 2024 онд Хөдөлмөр халамжийн ерөнхий газартай хамтран Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 800 орчим иргэнд хийж, 15 кластер төслийн ерөнхий судалгааг иргэдэд танилцуулсан. Инновацын долоо хоног арга хэмжээ зохион байгуулж бизнес эрхлэгчид, залуучуудыг Инновацын түншлэл форум, Инно талк арга хэмжээнд оролцуулсан. Тус Парк нь 2024 оны 05 дугаар сард инновацын төсөл бүртгэх, татварын хөнгөлөлт үзүүлэх салбарын яамны гэрээт Технологи дамжуулах төв болсон. "Инновац" иж бүрэн сургалтын хөтөлбөрөөр паркийн дэргэдэх 10 компанийн 35 ажилтанд сургалт зохион байгуулснаар компаниуд инновацын бүтээгдэхүүн, төслийн хөгжүүлэлт эхлүүлсэн. Инновацын зөвлөх үйлчилгээ, бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлж иргэдийн инновацын санаачлагыг дэмжих Mon-X арга хэмжээг орон нутагт сурталчлан ажилласан. ШУТС-аас Төв, Хэнтий, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай аймгуудад зохион байгуулсан "Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт нутагшуулъя аян"-нд паркийн дэргэдэх компаниудын бүтээгдэхүүнийг танилцуулах, гарааны бизнесийн сургалт зохион байгуулах хэлбэрээр оролцсон. 2025 оны 4-р сард Булган аймагт зохион байгуулагдсан Хойд бүсийн өргөтгөсөн хуралдааны "ТҮНШЛЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГАА" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "Хойд бүсийн тэвээр логистикийн төв", "Сургалт-эрдэм шийнжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" сэдвүүдийн хүрээнд дугуй	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				ширээний уулзалт зохион байгуулж, төслийн танилцуулгын хэсэгт Эрдэнэт үйлдвэрлэл технологийн паркийн хүрээнд хэрэгжиж буй төслүүд, Орхон аймгийн дахин төлөвлөлтийн төслүүд, Орхон аймгийн хог ангилан ялгах үйлдвэрийн төслийн танилцуулга, Материалын технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлсэн туршлага, "Их залуу дэд төв" төслийн танилцуулга, Дани-Монголын хамтарсан Хариуцлагатай тогтвортой хоршоо төслийн танилцуулга төслүүдийн мэдээллийг бэлтгэн хэвлэл мэдээллийн сувгаар сурталчилсан Хавсралт : 1 файл			
	293		1.5. 1.5. "Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хөдөөгийн сэргэлт зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, үр дүнтэй зохион байгуулах;	Аймгийн хэмжээнд 175.8 мянган толгой малтай, 101 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна. Энэ онд 13 аж ахуйн нэгж, байгууллага, 272 өрх нийт 5691 га талбайд тариалалт хийснээс 598 га талбайд малын тэжээл тариалж 1007 тонн ургац хураасан. Мөн Атар-IV тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд өвөлжөө, хаваржааны бууцны хөлд ногоон тэжээл тариалах сургалт зохион байгуулж 112 малчин өрхөд 100.0 сая төгрөгийн олон наст тэжээлийн ургамлын үр олгосноор 78 га талбайд тариалж 220 тн тэжээл хураан авсан нь тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдүүлсэн. Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд "Өрхийн тариалалтыг дэмжих" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Баян-Өндөр сумын 500 өрхийг хамруулан, сургалт арга зүйгээр хангаж, 250 м.кв талбайд тарих төмс, хүнсний ногооны үр олгож орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр 50 ширхэг хүлэмж худалдан авч өрхүүдэд олгон дэмжсэн. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор туршлага судлуулах, сургалт зохион байгуулах ажлыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 115 хоршоо үйл ажиллагаа явуулж байгаагийн 74 нь Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд байгуулагдаж 1330 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс өссөн дүнгээр 47 хоршооны 174 гишүүн нийт 6.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан байна. Үүнээс 2025 онд 176 гишүүнтэй 19 хоршоо	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				байгуулагдан, 7 хоршооны 16 малчинд 529.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан мал, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмж /трактор, хадуур, тармуур, өвс пресслэгч/, хоршооны ажлын байрны зориулалттай хашаа байшин худалдаж авах, худаг гаргах, мах сүүний хөргүүр барих зэрэгт хөрөнгө оруулалт хийн зориулалтын дагуу ашигласан байна. Мөн малчдын хоршоонд газар эзэмшүүлэх 6 байршлын 24.7 га газрын төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаар 5 байршилд 8 төсөл ирснээс малчдын 5 хоршоо шалгарч нийт 23.13 газрыг эзэмшүүлсэн байна. Хавсралт : 1 файл			
	294		1.6. 1.6. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сум, дүүргийн удирдлагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх, үйл ажиллагааг цахимжуулж, олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнаж, хяналтыг бий болгох;	Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын удирдлагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдэд байгууллагуудыг харьяалуулан хуваарилан баталгаажуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаж байна Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд "Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах"- 70353511 дугаарын утсыг ажиллуулан тус төвд утсаар болон биечлэн, www.irgen.erdenet.mn цахимаар иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэн шийдвэрлэлтийн мэдээллийг 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Цахимаар өргөдөл гаргасан иргэд өргөдлийн шийдвэрлэлтийн явц, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг цахимаар авах боломжтой болсон. Тайлант хугацаанд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 12187 өргөдөл, гомдол ирсний 421 буюу 3.4 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 11766 буюу 96.5 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Засаг дарга 7 хоног тутамд иргэдийг хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь шийдвэрлэж байгаа ба тайлант хугацаанд 31 удаагийн уулзалтаар 471 иргэнтэй уулзаж, тэднээс гаргасан санал, хүсэлтийн мөрөөр холбогдох албан тушаалтнуудад 593 үүрэг даалгавар өгсөн. Өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлт 85.2 хувийн хэрэгжилттэй байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
	295		1.7. 1.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих;	Аймгийн Засаг даргын 2025 оны А/35 дугаар захирамжаар . ”Эрдэнэт ус ДТС" ОНӨХК болон "Жаргалант ус ДТС" ОНӨХК-иудын “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах” ажлын хэсгийг байгуулан хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалт явуулж аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, Ахмадын хороо, Орхон аймаг дахь Ажил олгогч эздийн холбоо, Барилгачдын холбоо ТББ, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Орхон аймаг дахь салбарын удирдах албан тушаалтнуудтай хамтран ажилласнаар 14 хүн сонгон шалгаруулалтад оролцож ердийн болон хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэсэн. Аймгийн Засаг даргын 2025 оны А/144 дугаар захирамжаар аймгийн Засаг даргатай “Хөдөлмөрийн онцгой нөхцөл бүхий гэрээ” байгуулдаг Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчийн хувьцаат компани, улсын төсөвт үйлдвэрийн газруудын 2024 оны ажлын тайлан, 2025 оны бизнес төлөвлөгөөг хянаж үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсгийг шинэчлэн байгуулж орон нутгийн өмчит 10 байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тайланг хэлэлцэн 2024 оны ажлыг дүгнэж үнэлэн холбогдох зөвлөмжийг өгч ажилласан. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны А/710 дугаар захирамжаар "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" ОНӨГ-ын ашиглалтын өмнөх захиргаа болон "Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж" УТҮГ-уудын бүтэц үйл ажиллагааны давхардсан ижил чиг үүргийг арилгах, үр ашиг, зохион байгуулалтыг сайжруулах бүтэц орон тооны санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласнаар "Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж"-ийн газрыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хот тохижуулах газар УТҮГ-тай нэгтгэх, "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" ОНӨГ-ын ашиглалтын өмнөх захиргааны зүүн талын хэсгийн тохижилтын ажлыг яаралтай дуусгаж, үйл ажиллагааг жигдрүүлсний дараа татан буулгаж орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохоор шийдвэрлэсэн.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
	296		1.8. 1.8. Бүс, орон нутгийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх;	Орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг мэргэжлийн судалгааны байгууллагуудтай хамтран 3 сарын хугацаатай хийснээр хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн төлөв, байдал, 2030-2035 онуудад эрэлт хэрэгцээтэй байх мэргэжлүүд тодорхойлогдсон бөгөөд олон нийтэд түгээж ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн цахим мэдээллийн санд Ejob платформд 357 иргэнийг ажил хайгчаар, 310 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 1539 ажил ажлын байрны захиалга бүртгэж 1127 иргэнийг ажилд зуучилж, шинэ ажлын байранд 1100 иргэнийг бүртгэсэн. Хөдөлмөр эрхлэлтийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд нийт 86 иргэнд 879.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгосон. Үүний үр дүнд нийтдээ 86 ажлын байр хадгалагдаж 60 шинэ ажлын байр бий болсон байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа болон нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтод өрхийн 54 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 74 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 80 иргэнийг хамруулж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Эдгээр иргэдээс санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 10, мэргэжил олгох сургалтад 19 иргэн хамрагдсан. Улаанбаатар хотын “JOB CENTER” төвийн салбарыг нээж, 09 дүгээр сарын 1-нээс үйл ажиллагааг эхлүүлэн ажил олгогч болон ажилгүй иргэдийг холбон зуучлах, мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх, сургалт явуулах зэрэг ажлуудыг хийж байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 47.9 болж 4.9 пунктээр өссөн байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	297		1.9. 1.9. Бүс, орон нутагт шилжин суурьшиж буй өрх, иргэн, бизнесийн	Улаанбаатар хотоос Орхон аймагт шилжиж ирсэн 13 иргэн, аж ахуйн нэгжид орон нутагт олгогдож байгаа хөнгөлөлттэй зээл болон зээлийн батлан даалтын үйлчилгээний талаарх	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

			салбараа нээж буй аж ахуйн нэгжийг дэмжих төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах;	мэдээллийг өгч 3 төрлийн гарын авлага материалаар хангаж ажилласан. Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1 аж ахуйн нэгж ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. 2025 оны 5-р сард "Бүтээлч-Ухаалаг-Тогтвортой" уриан дор "Хойд бүс-Эрдэнэт-2025" эдийн засгийн форумыг зохион байгуулж, Эрдэнэт хотыг 2036 он хүртэл хөгжүүлэх бодлогыг танилцуулан, Ухаалаг хот, Эрүүл оюунлаг хот, Цэвэр агаартай хот төслүүд, тэдгээрийн хүрээнд хэрэгжих 60 дэд төслийг танилцуулсан. Форумд 400 -аад бизнес эрхлэгч, иргэд хамрагдан өргөн хүрээтэй зохион байгуулагдсан ба “Төрөөс бизнесийг дэмжих бодлого”-ын талаар, “Хөрөнгө оруулалтын татварын орчин” сэдэвтэй илтгэлүүдийг танилцуулан бизнес эрхлэгчдэд мэдээлэл хүргэсэн. Мөн Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд нөөц газраар тусгагдсан 313 га газарт хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах чиглэлийн хүрээнд ШУТП-г түшиглэн хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний үйлдвэрүүдийн салбар үйлдвэрлэл байгуулах газрыг төлөвлөж байна. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр “Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д агро үйлдвэрийг кластераар хөгжүүлэх зорилт тусган батлуулсан. Хавсралт : 1 файл			
	298		1.10. 1.10.Бүс, орон нутгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын бүтээн байгуулалтад шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээг салбар дундын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, төсөл, арга хэмжээтэй уялдуулж, хэрэгжүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв болон холбогдох	Аймгийн хэмжээнд хийсэн хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар тэргүүлэх чиглэлд үйлдвэрлэл, уул уурхай, барилга, тээвэр, худалдаа, эрүүл мэндийн үйлчилгээ нь эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч салбар болж 2035 он хүртэл эрэлттэй байх мэргэжилд инженер, техникч, гагнуурчин, угсрагч, оператор, эмнэлгийн ажилтан зэрэг шаардагдах бол, ойрын төлөвт менежер, худалдагч, үйлчилгээний ажилтан, тогооч, туслах, инженер техникч, хүргэлтийн ажилтан зэрэг мэргэжлүүд эрэлт хэрэгцээтэй байхаар байна. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хүрээнд 2025 онд Орхон Политехникийн коллежтой хамтран танхимын мэргэжил олгох сургалтыг хийж, оёдол, гоо сайхан, тогооч, барилгын засал, ойн аж ахуй зэрэг 5 мэргэжлээр 48 иргэнийг хамруулж 19.8 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Хүн ам,	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	

			байгууллагуудтай хамтран ажиллах;	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан ур чадварын цахим сургалтад 13 мэргэжлээр 128 иргэнийг хамруулахаар бүртгэлийг хийж SURGALT.GOV.MN цахим системд баталгаажуулсан. Энэ арга хэмжээнд нийт 338 иргэнийг хамруулсан. Хавсралт : 2 файл			
	299		1.11. 1.11. Зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх;	Орлогыг орлуулан тооцох хосолмол аргачлалаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 1789 өрхийг хамруулж өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэн бүрдүүлсэн. Зорилтот бүлгийн өрхийн гишүүн, иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 880 өрхийн 2402 насанд хүрсэн иргэн, 1997 хүүхдийг сар бүр хамруулж 272.0 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Халамжаас хөдөлмөрт бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг, нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, өрх толгойлсон эх, эцэг, халамжийн үйлчилгээ авдаг иргэн зэрэг зорилтот бүлгийн 54 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 74 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 80 иргэнийг хамруулж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 10, мэргэжил олгох сургалтад 19, нийт 237 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлсэн. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд сургалт зохион байгуулах, бүлэг бүрдүүлж төсөл хөтөлбөрт хамруулах, өдрийн үйлчилгээ үзүүлэх зэрэг чадавхжуулах арга хэмжээнд 126 иргэнийг хамруулж 50.6 сая төгрөг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	300		1.12. 1.12. Аймаг, нийслэлийн хэмжээнд оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил,	Монголын Хүний нөөцийн менежментийн холбооны дэргэдэх хувийн хөдөлмөрийн биржтэй хамтран “JOB CENTER” төвийг 2025 оны 05 дугаар сард нээж ажиллуулснаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 18	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх, нийгмийн идэвх, оролцоог дэмжих чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	иргэнд, бүлгийн зөвлөгөөг 9, 11 дүгээр ангийн 70 сурагчид өгсөн. Хувийн хэвшлийн гурван "Самушил" төв шинээр байгуулагдан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлж, түр болон цагийн ажлын байранд зуучлах, анкет бүртгэх, ажлын байрны захиалга хүлээн авах зэрэг үйлчилгээг иргэдэд хүргэж байна. "Эрдэнэт Самушил" төв, . "Эрдэнэт сайхан уул самушил" төв, “Samushil HR” төвийн Эрдэнэт салбараас нийт 360 иргэний анкетийг хүлээн авч бүртгэн 248 иргэнийг түр болон цагийн ажилд зуучилж өдөрт дунджаар 100.0-120.0 мянган төгрөгийн ажлын хөлстэйгээр ажиллуулсан байна. Ажилд орсон иргэдийн ажлын байрыг салбараар нь авч үзвэл барилгын салбар 85%, газар тариалан 18%, бусад салбарууд 15%-ийг эзэлж байна. Аймгийн ХХҮГ-аас эдгээр газруудтай хамтран бүртгэл мэдээлэлд хамруулах, хууль эрх зүйн мэдлэг мэдээллээр хангах зэргээр үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр хамтран ажиллаж байна. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох (start-up) бүсийн арга хэмжээг “Бест метод” ТББ-тай хамтран Хөвсгөл, Булган, Орхон аймгийн 156 залуучуудыг бүртгэж 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, сүүлийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 5 багт 82.0 сая төгрөгийн 36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон. Хавсралт : 1 файл			
	301		1.13. 1.13. Аймаг, нийслэлийн хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг хэвшүүлэх, биеийн тамирын дасгал сургуулилтаар хичээллэх боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх;	Тайлант онд аймгийн хэмжээнд хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчлан "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аян болон биеийн тамир чийрэгжүүлэлтийн 78 арга хэмжээнд давхардсан тоогоор 43400 иргэнийг хамруулж, улсын төсвийн 12.2 сая төгрөг, орон нутгийн төсвийн 23.4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. Үүнд: "Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж 4 удаагийн явган алхалт зохион байгуулж алхалтад 1000 иргэнийг хамруулсан ба " Бүх хайраа гэр бүлдээ 100 км" улсын хэмжээний алхалтад хамрагдах 100 иргэнд Эрүүл мэндийн газар, эм холбооноос 4.0 сая төгрөгийн үнэ бүхий амин дэмийн багцаар дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Эртэч эрдэнэтчүүд аяны хүрээнд солонго бүжгийн клубтэй хамтран өглөөний дасгал	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хөдөлгөөн, нийтийн шугаман бүжигт давхардсан тоогоор 4600 иргэнийг хамруулсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд, ахмадын хорооны чийрэгжүүлэлтийн танхимд хийн дасгалаар 800 ахмад тогтмол хичээллэж байна. "Эрдэнэт Марафон 2025" бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг 5 төрлийн гүйлтээр, Хоол зүйчдийн холбоотой хамтран Эрүүл зөв хооллолтын өдөрлөгийг зохион байгуулж 400 гаруй иргэдийн мэдлэгийг дээшлүүлсэн байна. Цагаан тоосны нөлөөллийн бүсэд амьдардаг иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд 6 удаагийн өдөрлөгөөр 1500 иргэнд дасгал хөдөлгөөний ач холбогдлын талаар, Баян-Өндөр сумын ИТХ-тай хамтран зохион байгуулсан явган алхалтад 22 сургуулийн 150 сурагчдыг хамруулан хорт зуршлаас сэргийлэх мэдээлэлэ, зөвлөмжийг тус тус хүргэсэн. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд идэвхтэй дасгал хөдөлгөөний хамрагдалт өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар нэмэгдэж, иргэдийн дасгал хөдөлгөөн эрүүл амьдралын мэдлэг хандлага сайжирсан байна Хавсралт : 1 файл			
	302		1.14. 1.14. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчилж ургуулах ажлыг эрчимжүүлэх;	Орхон аймгийн Байгаль орчны салбарын "Нээлттэй өдөрлөг"-ийг А.Амарын талбайд зохион байгуулж мод тарих, арчилж ургуулах талаар иргэд аж ахуйн нэгж байгууллагад зөвөлгөө мэдээ мэдээллийг хүргэн ажиллах төдийгүй Жаргалант суманд зохион байгуулагдсан малчид, тариаланчдын зөвлөгөөнд оролцож 100 гаруй иргэдэд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийг сурталчлан танилцууллаа. Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 21 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын мод бут сөөгний тарьц, суулгацын нөөцийн үнийн судалгааг гаргаж олон нийтэд хүргэж, үзэсгэлэн худалдааг Амарын талбайд 2 удаа 6-10 хоногийн хугацаанд зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд оролцсон иргэд аж ахуйн нэгж байгууллагууд нийт 34058 ширхэг модны тарьц суулгац худалдан борлуулж 162.28 сая төгрөгний борлуулалт хийсэн байна. Мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэн бүх нийтээр мод тарих хаврын ажлын хүрээнд төрийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				байгууллагууд болон хувийн нийт 76 байгууллагын оролцоотойгоор 14 байршилд 429457 ширхэг мод тарьлаа. Тарьсан моднуудын арчилгаа, усалгааг мэргэжлийн байгууллага Сум дундын ойн анги хариуцан ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
	303		1.15. 1.15. Хот, суурин газрын хог хаягдлын менежментийг төр-хувийн хэвшлийн оролцоотой сайжруулах, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;	Аймгийн ИТХ-ын 2022 оны 07/04 дүгээр тогтоолоор батлагдсан Орхон аймгийн Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа 2025 онд дуусч байгаатай холбогдуулан Баян-Өндөр сумын ИТХ-ын даргын 2025 оны А/19 дүгээр захирамжаар хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийг байгуулж хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. 2022 онд батлагдсан Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 6.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хот тохижуулах газрын техник тоног төхөөрөмж, машин механизмийн парк шинэчлэлтийг хийж 90 хувьд хүргэснээр хог хаягдлын татан авалтыг 3-4 удаагийн давтамжаар нэмэгдүүлж 2025 онд 250862 м.куб хог хаягдлыг дарж булшилсан. Хог хаягдлын менежментийг төр хувийн хэвшлийн оролцоотой сайжруулах, орчны бохирдлыг бууруулах зорилгоор хог хаягдлыг анхан шатанд нь ангилан ялгаж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг иргэн, хувийн хэвшлийн байгууллагууд ачиж тээвэрлэн авч, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг эрх бүхий байгууллага ачиж тээвэрлэн дарж булшлах тээвэр ложистикийн схем, зураглалыг бий болгон ажиллаж байна. Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" НҮТББ-тай 3 хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Аймгийн хэмжээнд 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 8 нэр төрлийн 121.5 тн хог хаягдлыг цуглуулан төвлөрүүлж Улаанбаатар хот руу тээвэрлэн үйлдвэрүүдэд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан. Мөн 10 үйлдвэр, ААНБ-ын 573.291тн аюултай хог хаягдал, 533ш ашиглалтаас гарсан дугуй, ерөнхий боловсролын 10 сургуульд хадгалагдаж байсан 264.7 кг устгах шаардлагатай химийн бодисыг тусгай зөвшөөрөлтэй	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлэн өгч устгууллаа.Орчны бүсийн нутаг дэвсгэрт хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг 27 ААНБ-уудын 713 ажилчдыг хамруулан ажлын 15 хоногийн хугацаанд зохион байгуулж нийт 32 цэгт хуримтлагдсан 650м3 эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэж, дарж устгууллаа. Хавсралт : 1 файл			
	304		1.16. 1.16. Саарал усны хэрэглээ, усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх;	Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй автомашин угаалгын газруудад Усны тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг шалгах, хаягдал ус дахин боловсруулах шийдлийг тодорхойлох судалгааны ажлыг аймгийн Байгаль орчны газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК хамтран зохион байгууллаа. Хяналт шалгалт, судалгааны ажлын хүрээнд нийт 27 автомашин угаалгын газар хамрагдсан бөгөөд инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон 22, усны асуудлаа зөөврөөр шийдвэрлэдэг 5 газар ажиллаж байгаагаас 5 авто угаалгын газар 259тн саарал усыг гадна угаалгад дахин ашиглаж байна. Хаягдал ус дахин боловсруулж хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг бодлогоор дэмжих ажлын хүрээнд катодын зэс боловсруулах "Гал сэнтий" ХХК, "Ачит-Ихт" ХХК-ииуд ус цэвэршүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ус хангамжийн цех нь 2025 онд хаягдлын аж ахуйн далангаас 96 169 890 м3 эргэлтийн усыг ашигласан байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/893 дугаар захирамжаар Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлсэн 6 аж ахуйн нэгжид 27.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	305		1.17. 1.17. Гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох төсөл хэрэгжүүлэх;	НҮБ-ын Хүүхдийн Сангийн "Барилгын халаалтад нүүрстөрөгч багатай эх үүсвэр ашиглах" төслийн хүрээнд Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийн барилгад нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх нийт 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг хэрэгжүүлж нүүрстөрөгч багатай, сэргээгдэх эрчим	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хүчний шийдэл ашиглах дулааны эх үүсвэрийг газрын гүний дулаанаар шийдвэрлэх ажил бүрэн дуусаж тохируулга, зүгшрүүлэлтийн ажил хийгдэж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны янданг буулгасантай тэнцэх хэмжээний бохирдлыг бууруулах боломж бүрдэнэ Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусган 2022-2024 онд онд 182 өрхөд монгол гэрийн дулаалга, цахилгаан халаалтын багц/ЧИП/-ыг олгосон. 2025 онд Хабрид хаус ХХК-тай хамтран Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 63 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулаа. Хавсралт : 2 файл			
	306		1.18. 1.18. Хот, суурин газарт үер ус зэрэг гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийж, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;	Аймгийн Засаг даргын 2025 оны А/319 тоот захирамжаар Үер усны ослын эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх болон үнэлгээ хийх, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Орхон аймагт Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн хүрээнд хийгдэх үерийн далан, суваг барих ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын Хунан Индастриал Экүйдмент Инсталэйшн ХХК шалгарч 9 байршилд 12.8 км инженерийн хийцлэлтэй үерийн далан, нийт 14000м3 багтаамжтай 4 усан сан барихаар гэрээ байгуулж, үерийн далангийн нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулан улсын магадлангаар хянуулж ажлыг эхлүүлснээр одоогийн байдлаар 8 байршилд үерийн далан барих ажил 66.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	307		1.19. 1.19. Хот, суурин газарт авто машингүй	Аймгийн хэмжээнд жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдөр "Автомашингүй өдөр"-ийг бий болгон зохион байгуулан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			гудамж бий болгох, явган хүний болон дугуйн зам, байгууламж, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх;	ажиллаж байна. Тус өдөр Холбооны уулзвараас Баян худалдааны төвийн уулзвар хүртэлх авто замыг бүрэн хааж автомашины хэрэглээнээс татгалзах, иргэдийн явган алхалтыг дэмжиж, нийтийн тээврээр олноор зорчиход чиглэж байна. Тухайн өдрүүдэд авто зам хаасантай холбогдуулан А.Амарын талбайд урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Мөн жил бүр 5 дугаар сарын 15-нд Дэлхийн гэр бүлийн өдөр-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан А.Амарын талбайд нээлтийн арга хэмжээг зохион байгуулдагтай холбогдуулан төв замыг хааж ажиллаж байна. Өдөрлөгийн үеэр хүүхэд бүрийн насны онцлогт тохирсон "Мөлхөө жаал" өртөө, "Циркийн тоглолтын" өртөө, "Эрүүл мэндийн" өртөө, Спортын өртөө, Гайхамшигт бяцхан хүмүүс өртөө, Хосын өртөө, Хамтдаа оролцъё өртөө /аав, ээждээ хэлэх үг/, Зураг бол түүх өртөө зэрэг 11 өртөөгөөр спорт, соёл урлагийн олон сонирхолтой арга хэмжээг өртөөчлөн зохион байгуулан ажиллаж хэвшсэн. Аймгийн хэмжээнд 2025 онд явган хүний болон дугуйн зам, байгууламж, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 8 байршилд авто зам, замын байгууламжийн дагуу 9.3 км дугуйн замыг шинээр барьсан. Мөн 18 байршилд 16115.16 м2 явган хүний замын ажил шинээр, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэхээр 12 байршлын 7060м2 талбайн авто зогсоолыг шинэчлэн өргөтгөлөө. Хавсралт : 3 файл			
	308		1.20. 1.20. Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай ашиглах боломж бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх нөхцөлөөр хангах;	Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай ашиглах боломж бүрдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх нөхцөлөөр хангах ажлын хүрээнд Жаргалант сумын нутаг дэвсгэрт нийт 16 байршилд 3.53 га газрыг өвөлжөө хаваржааны зориулалтаар малчдад эзэмшүүлэхээр Улсын хэмжээнд эзэмшүүлэх газрын хэмжээ байршлыг тогтоосон Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолоор батлуулж, сумын Засаг даргын 2025 оны А/213 дугаар захирамжаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлж газрын удирдлагын цахим системд бүртгэсэн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
	309		1.21. 1.21.Бүс, орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох, сүргийн шилэн сонголт хийж өсвөр хээлтүүлэгч бойжуулах арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн байгууллагын хяналтад авах ажлыг зохион байгуулах;	2024 онд 7858 толгой буюу 20.0 хувь нь цөм сүрэг, 28652 толгой буюу 71.6 хувь нь үржлийн сүрэг, 3490 толгой буюу 8.7 хувь нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдсэн. Сэлэнгэ үүлдрийн үхэрт малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлоход аймгийн хэмжээнд 2700 үхэр Сэлэнгэ үүлдрийн үндсэн хэв шинжийг хадгалж, анги чанарыг тодорхойлоход 282 толгой үхэр цөм сүрэгт бүртгэгдсэн. 2022-2024 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 140 толгой Барга, Монгол, Эрчмийн хар үүлдрийн бог малын хээлтүүлэгч худалдан авч "Манхан чүг" мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжид хариуцуулан хамтран ажиллаж байна 2025 онд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 174 малчин өрхийн 41200 толгой мал буюу 36.1 хувийг үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтад хамруулахад 8266 толгой буюу 20.1 хувь нь цөм сүрэг, 29954 толгой буюу 72.7 хувь нь үржлийн сүрэг, 2980 толгой буюу 7.2 хувь нь хэрэгцээний сүрэгт бүртгэгдэж анги чанарыг тодорхойлсон. Үүнд: үхэр 8690, хонь 17894, ямаа 14616 толгой. Үзлэг ангилалтад хамрагдсан үхэр, хонь, ямаан сүргийн 10 хувьд нь хяналтын хэмжилт хийсэн. Орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор адуун сүргийг хурдны чиглэлээр, үхэр сүргийг Сэлэнгэ,Герефорд, Алатау, Семменталь, Хар тарлан үүлдрээр, хонин сүргийг Монгол, Баяд, Барга, Дархад омгийн хуцаар, ямаан сүрэгт Өлгийн улаан, Эрчмийн хар ухна зэргийг үндсэн сайжруулагчаар ашиглаж байна. Нийт үхэр сүргийн 30% буюу 10.4 мянган толгой үхэр нь Герефорд, Сэлэнгэ үүлдрийн үндсэн хэв шинжийг хадгалсан байна. Мөн хонин сүргийн 24.3% буюу 15.5 мянган толгой хонь нь Барга үүлдрийн хэв шинжийг хадгалсанаар махны гарцыг 1.5-2.0 кг-аар нэмэгдсэн. Баян-Өндөр, Жаргалант сумдын давхардсан тоогоор 90 малчинд стандарт шаардлага хангасан хээлтүүлэгчийг хээлтүүлгийн хугацаанд түрээсээр ашиглуулснаар 150 толгой цөм сүргийн малтай болж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна...	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 2 файл			
	310		1.22. 1.22. Иргэд малчид, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллийг хүргэж, зээлийг үр дүнтэй ашиглах чадавхыг сайжруулах;	Аймгийн хэмжээнд 101 иргэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна. Үүнд: 23 иргэний мах-сүүний чиглэлийн 714 толгой үхэр, 7 иргэн махны чиглэлийн 421 толгой үхэр, 4 иргэн 130 толгой гахай, 55 иргэн 4344 толгой шувуу, 12 иргэн 242 бүл зөгийг тус тус өсгөн үржүүлж үйл ажиллагаагаа явуулж байна. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд 47 хоршооны 174 малчин 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан байна. Үүнээс 2025 оны байдлаар хөдөө аж ахуйн чиглэлийн 203 гишүүнтэй 23 хоршоо шинээр байгуулагдаж, 6 хоршооны 16 малчин 529.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлд хамрагдан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. "Атар-4" тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мах-сүүний чиглэлийн үхэр худалдан авах зориулалтаар 2 иргэнд 100.0 сая төгрөг, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд "Самбо шимт сүрэг" ХХК-д 50.0 сая төгрөг, аймгийн Өрхийн болон бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих сангаас 1 иргэний тахианы аж ахуйд 100.0 сая төгрөг, Баян-Өндөр, Жаргалант сумын "Хоршоо хөгжүүлэх сан"-аас 4 хоршоонд 344.0 сая төгрөгийн зээлийг олгож аж ахуйг нь дэмжин ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сумдын ЗДТГ, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоотой хамтран шинээр байгуулагдсан хоршоод хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хоршоодыг чадавхжуулах, мэдээлэл, арга зүйгээр хангах сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж 32 хоршооны дарга нарыг хамруулан хоршооны талаар төрөөс баримталж буй бодлого, хоршооны анхан шатны ойлголт, Татварын багц хууль, цахим санхүүгийн тайлан, И-баланс, жилийн эцсийн тайлан хэрхэн гаргах тухай, шинээр байгуулагдсан хоршоодод газар хэрхэн олгох талаарх мэдээлэл өгч, Арга билиг арвин сүрэг хоршооны сайн туршлагаас хуваалцсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	311		1.23. 1.23. Салбарын хяналт шалгалт	Аймгийн хэмжээнд нийт 102 улсын байцаагч ажиллаж хяналт шалгалтын төлөвлөгөөг гарган ажиллаж Эм	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			давхардаж байгаагаас шалтгаалж аж ахуйн нэгж, байгууллагад учирч буй хүндрэл, чирэгдлийг арилгах, давхардлыг бууруулах;	эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар 12 объект, Байгаль орчны байцаагч 3, Боловсрол байцаагч 10, ХХАА, худалдаа үйлчилгээний байцаагч 934 объект, эрүүл мэндийн хяналтын чиглэлээр 27, Хөдөлмөр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар 95 объект, стандчилал хэмжин зүйн хяналтаар 4, нийт 1396 объектод хяналт шалгалтыг хийж давхардал үүсгэлгүйгээр хамтран ажилласан. Үүнд: Хоол үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, хүнсний худалдаа, ургамал хамгаалал, газар тариалан, мал үржүүлэг, технологийн чиглэлээр төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх 697 объектод хяналт шалгалтыг холбогдох мэргэжлийн байцаагчид хамтран хийж гүйцэтгэн нийт 993 зөрчлийг илрүүлснээс газар дээр нь мэргэжил арга зүй, зөвлөмж, зөвлөгөө өгч 724 зөрчил буюу 77.8 хувийг арилгуулж, 69 аж ахуйн нэгжид ажлын байрны дүгнэлт үйлдэж ажилласан. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 29 аж ахуйн нэгж, 2 иргэнд 211 заалт бүхий албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласнаар албан шаардлагын биелэлт 89 хувьтай дүгнэгдсэн. Хөдөлмөр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар 95 объектод хяналт шалгалт хийж 1018 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 222 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн хамтарсан 796 заалттай 68 албан шаардлага хүргүүлж, 13 аж ахуйн нэгж байгууллагад 96.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт, торгууль ноогдуулж хяналт тавьж ажилласнаар албан шаардлагын хэрэгжилт 60.0 хувьтай хэрэгжсэн байна. 2025 онд Санхүүгийн хяналтын байцаагчдаас нийт 60 байгууллагад хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 21 байгууллагад дотоод аудит, 9 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэн төлөвлөгөөний хэрэгжилт 50%-ийн хэрэгжилттэй байна. Хавсралт : 1 файл			
	312		1.24. 1.24. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: Орхон аймагт Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн хүрээнд хийгдэх үерийн далан, суваг барих ажлын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			хэмжээнд зохион байгуулах;	гүйцэтгэгчээр БНХАУ-ын Хунан Индастриал Экүйдмент Инсталэйшн ХХК шалгарч 9 байршилд 12.8 км инженерийн хийцлэлтэй үерийн далан, нийт 14000м3 багтаамжтай 4 усан сан барихаар гэрээ байгуулж, үерийн далангийн нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулан улсын магадлангаар хянуулж ажлыг эхлүүлснээр одоогийн байдлаар 8 байршилд үерийн далан барих ажил 66.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй инженерийн шугам сүлжээг 2025-2028 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажилласнаар эхний ээлжинд нэн тэргүүнд хийгдэх инженерийн шугам сүлжээний ажлыг эрэмбэлэн гаргаж нийт 215.0 тэрбум төгрөг шаардлагатай тооцоо гарсан. Үүнээс:2025 онд орон нутгийн төсвийн 27.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ус, дулаан түгээх системүүдийг шинэчлэхээр 14ш Ус дулаан хувиарлах төвийг Үл хамаарах схемд шилжүүлэх ажил, ус дулаан түгээх төвийн гадна дулаан, цэвэр усны шугам шинэчлэх /5 хос шугам, Хүрэнбулаг багийн Уртцагааны цэвэр усны төв шугам, Оюут баг Есөн эрдэнэ зах ариутгах татуургын төв шугам, Зэст багийн нутаг дэвсгэрт байрлалтай 1-р хорооллын бохир усыг татан зайлуулах төв шугам, Дэнж багийн хэрэглэгчдийг төвийн цэвэр усны шугамнаас холбох ажил, 11-р хорооллын А хэсэг дулааны шугамын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, Их залуу багт байрлах усан сан руу дулаан, цэвэр усны шугам татах ажлуудыг хийж нийт дулааны 25.6км, бохир усны 0.6 км, цэвэр усны 18.6 км шугамыг барьж ашиглалтад оруулаа. Мөн Европын Сэргээн босголтын хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн 8 ажил хийхээр төлөвлөснөөс 4 ажлыг хийж гүйцэтгэлгэлээ.			
	313		1.25. 1.25. Албан даалгаврын хэрэгжилтийн явцыг сар бүр дүгнэж, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан гарсан 2025 оны 03 дугаар албан даалгаварын хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд улирал тутамд тайлагнаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Хавсралт : 1 файл			
179	314	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01	1.1.. Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах;	Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны шийдвэр гаргахад эрдэмтэн судлаачид болон иргэд, олон нийтийн байгууллагуудаас саналыг авч, эрх ашиг нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллаж байна. Жаргалант суманд шинээр баригдсан 30 айлын болон 15 дугаар байрны орон сууцыг түрээслээд өмчлөх журмын төслийн сонсголыг 2025 оны 01 дүгээр сард зохион байгуулж 180 иргэн нээлттэй сонсголд оролцсоноос 35 иргэнээс санал хүсэлт ирүүлсэн. Сонсголыг 2 үе шаттай зохион байгуулж иргэдийн саналыг тусган Жаргалант сумын ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/04 дүгээр тогтоолоор “Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам" батлагдсан. Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/100 дугаар захирамжаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд 35.2-д заасан Амьтны хүрээлэн ажиллуулах журам, Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоох, хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам, Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, оршуулгын үйл ажиллагааны жишиг үнэ, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам, Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, кабелийн шугамын ашиглалт, үйлчилгээний журам, инженерийн бэлтгэл ажлын төлөвлөлт, ашиглалт, хамгаалалтын журам зэрэг 5 журмын төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран “Амьтны хүрээлэн ажиллуулах журам”, “Мал нэвтрэхийг хориглосон бүсчлэлд мөрдөх журам”-ын төслүүдээр иргэдэд нэгдсэн хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, нийт 78 иргэн хамрагдсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	315		1.2.. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах;	Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд 2025 онд 46 байгууллагын 69 төрийн албаны удирдах болон гүйцэтгэх сул албан тушаалын захиалгыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжид нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд 11 төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн томилсон. Шилжүүлэх зараар нөхөгдөөгүй 58 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн тусгай шалгалтыг зохион байгуулснаар 42 сул орон тоо нөхөгдсөн бол 16 төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөгдөөгүй байна.Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бүх шатны байгууллагуудад тогтвортой байдлыг ханган салбарын удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн, ажиллагсадтай байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэхдээ тухайн удирдах болон гүйцэтгэх албан хаагчийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний хүртээмж, чанарыг харгалзан дүгнэж байх, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах талаар арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллаж байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	316		1.3.. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх;	Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах чиглэлээр үүрэг даалгаврыг өгч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн байгууллагууд бичиг хэргийн үйл ажиллагааг цахимаар үйлдэж бичиг хэргийн зардлыг хэмнэх, шаардлагагүй худалдан авалтыг зогсоох, салбар дундын сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах зэргээр төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор 2025 онд "Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Жаргалант сумын ЗДТГ-ын албан хаагчдын ажил, албан үүргийн оновчтой хуваарилалтыг хийх зорилгоор чиг үүргийн шинжилгээ хийж 44 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөх, 5 албан тушаалын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				тодорхойлолтын төслийг шинээр, тус тус хянуулан батлах зөвшөөрлийг хүсэж Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн ба одоогийн байдлаар аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар болон сумдын ЗДТГ-ын нийтлэг 12 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөн боловсруулж батлан мөрдөн ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
	317		1.5.. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах;	Төрийн байгууллага, төрийн албан хаагчдад төрийн албаны шинэтгэл, төрийн албаны тухай хууль, тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд төрийн байгууллагуудад хүнд суртал, шат дамжлагыг бууруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлж, шат дамжлагыг багасгах зорилгоор цахим үйлчилгээг нэмэгдүүлэх талаар сүүлийн жилүүдэд жил бүр орон нутгийн төсөвт шаардлагатай төсвийг тусган ажилласнаар аймгийн хэмжээнд 3 Цахим төвийг шинээр ашиглалтад оруулж төрийн 215 үйлчилгээг 24/7 цагийн турш үзүүлж байна. "Цахим төв"-өөс иргэн, хуулийн этгээд 16 төрлийн 37 үйлчилгээ, "E-Mongolia"- Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс 73 төрлийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаас 9 төрлийн 72 үйлчилгээг үзүүлэх төдийгүй арилжааны банкнуудын АТМ машинуудыг байршуулан ажиллуулж байна. 2025 онд аймгийн хэмжээнд ажиллаж буй Хурдан төвүүдээс нийт 35030 иргэн, төрийн үйлчилгээний цахим төвөөр 78550 иргэн үйлчлүүлж үйлчилгээ авсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд "Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах"-70353511 дугаарын утсыг ажиллуулан тус төвд утсаар болон биечлэн, www.irgen.erdenet.mn цахимаар иргэдийн өргөдөл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				гомдлыг хүлээн авч шийдвэрлэн шийдвэрлэлтийн мэдээллийг 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа нь иргэд өргөдөл, гомдлоо цаг хугацаа, орон зайны хязгаарлалтаас үл хамааран гаргах боломжийг бүрдүүлсэн. Хавсралт : 1 файл			
	318		1.6.. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээг авч жил бүр шаардлагатай төсвийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд ТББ-уудтай гэрээ байгуулан ажиллахад 60.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс тус бүрээр хуваарь батлуулан гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 онд нийт 18 ТББ-тай гэрээ байгуулан хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хувь хүний хөгжил, мониторинг, сургалт мэдээлэл, иргэдийн нийгмийн оролцоо болон хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг 10 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж нийт 60.0 сая төгрөг зарцуулаад байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	319		1.7.. Салбарын хэмжээнд нэн тулгамдсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан, шуурхай шийдвэрлэх;	Орхон аймагт бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Хойд бүсийн хавдрын дэд төв байгуулах саналыг удаа дараа холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн ба 2025 оны 4-р сарын 28-ны өдрийн Хойд бүсийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын 204 дүгээр тогтоолоор “Эрдэнэт-Үйлдвэр” ТӨҮГ-ын харьяа “Эрдэнэт Медикал” эмнэлгийг Эрүүл мэндийн яамны харьяанд шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайдад даалгасан. Үүний хүрээнд 2025 оны 8 дугаар сарын 06-ны Засгийн газрын хуралдаанаар тус эмнэлгийг Хойд бүсийн “Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв” болгохоор шийдвэрлэлээ. Мөн Эрдэнэт хот бонд гаргах тухай асуудлыг дэмжсэн Засгийн газрын тогтоол гарсны дагуу бондын хөрөнгөөр 40 жилийн насжилттай инженерийн шугам сүлжээ, хотын доторх авто замын шинэчлэл, цахилгаан эрчим хүчний сайжруулалт, эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлууд, сургууль цэцэрлэгийн	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	

				хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх асуудлуудад Сангийн яамнаас санал авч, Засгийн газраас зөвшөөрөл авахаар холбогдох материалаа хүргүүлсэн боловч 2025 оны төсвийн төсөлд тусгагдаагүй тул энэ онд бонд гаргах боломжгүй тухай шийдвэрлэсэн. Хавсралт : 1 файл			
	320		1.8.. Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах.	Аймгийн ЗДТГ-аас УИХ-ын чуулганы хуралдаанд асуудал оруулж хэлэлцүүлдэггүй тул хяналтаас хасуулах саналтай байна.	Х.Б	Х.Б	
	321		2.1.. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын дагуу гадаад улсын Элчин сайд болон бусад төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, яриа хэлэлцээний тэмдэглэл, байгуулсан гэрээ, санамж бичгийн хуулбарыг тухай бүр УАБЗ-ийн ажлын албанд мэдээлэн ажиллаж байна. Үүнд: 2025 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм, хийдүүдэд хяналт шалгалт хийсэн тайланг 2 удаа, хүн ам, хүрээлэн буй орчинд аюул эрсдэл учруулж болохуйц үйл явдал, нөхцөл байдлын талаарх шуурхай мэдээ, гадаад улсын элчин сайд болон бусад төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, санамж бичгийн мэдээ, аймгийн нутаг дэвсгэрт байрлах оршуулгын газруудад хяналт шалгалт хийсэн тайлан мэдээг тус тус мэдээлснээр тайлант онд хугацаа хоцроосон мэдээ, тайлан байхгүй байна. Манай аймаг 9 улсын 13 муж, хотуудтай харилцаа, хамтын ажиллагааны санамжийг байгуулж байгаль орчин, соёл, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажиллаж байна. Гадаад улсын муж, хотуудтай хамтран ажиллахдаа гадаад бодлогын үзэл баримтлалд заасны дагуу байгуулсан санамж бичгийн хүрээнд холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж, гадаад харилцааны талаарх тайлан мэдээллийг хагас, бүтэн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				жилээр ГХЯ-нд хүргүүлэн ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
	322		2.2.. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох яам Тамгын газраас аймгийн ЗДТГ-т ирүүлсэн Төрийн болон албаны нууцад хамаарах албан бичгийг тухай бүрт журмын дагуу бүртгэж ажиллаж байгаа бөгөөд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу хугацаа дуусаагүй тул мэдээллийг одоогоор ил болгоогүй байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг нууцад аваагүй, нийтэд ил байгаа болно.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	323		2.3.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;	Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/104 тоот тушаалаар мэдээлэл хариуцагч тус бүрийг томилон хэрэгжүүлэлт дээр тогтмол хяналт тавин ажиллаж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нийтэд нээлттэй ил тод байх мэдээллүүдийг "Shilen.gov.mn" 2.0 системд хуваарийн дагуу тухай бүр байршуулан ажиллаж байна. Төрийн байгууллагууд ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан https://shilen.gov.mn-д холбох нөхцөл боломжийг бүрдүүлэн 68 заалтын 114 нээлттэй мэдээллийг шууд холбоосоор тусгаж мэдээлэл авах бүх боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 114 байгууллага Шилэн индексийн үнэлгээнд хамрагдахаас 2025 оны III улирлын байдлаар 20 байгууллага мэдээллээ бүрэн оруулж үнэлгээ хийлгээгүй, 94 байгууллага хуульд заасан мэдээллээ оруулж үнэлүүлснээр үнэлгээний дундаж 77.8 хувьтай байна. Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой үнэн зөв, бүрэн байх, нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Орхон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас нь мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан лизенцтэй программ хангамжтай, системийн хэвийн, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Мөн жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж, төрийн болон орон нутгийн өмчит,	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хяналт, шалгалтын нэг үзүүлэлт болгон шалгаж зөвлөгөө, мэдээллээр ханган, хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилт, олон нийтэд чиглэн зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэх зорилгоор аймгийн ЗДТГ-ын гадна зориулалт бүхий led дэлгэцийг байршуулан мэдээ, мэдээллийг тогтмол хүргэн сурталчилж байна. Хавсралт : 3 файл			
	324		2.4.. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх;	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Өмгөөллийн “Миранда Партнерс” хуулийн фирмтэй хамтран Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар болон багуудын ажлын албаны нийт 250 албан хаагчид авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас 2025 оны 06 дугаар сард зохион байгуулсан цахим сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын дарга, албан хаагчдыг хамруулсан. Аймгийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг төрийн байгууллагуудад өгч арга зүйн удирдлагаар ханган 72 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 305 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчиддаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан, аян зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлсэн байна. Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооны 2 гишүүнийг Удирдлагын академид ёс зүйн чиглэлийн сургалтад хамруулж чадавхжуулсан. Мөн “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт: сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 14 байгууллагын 55 албан хаагчийг хамруулж, хэвшмэл сэтгэлгээгээ өөрчилж хөгжихүйн сэтгэлгээтэй болсноор жижиг гэхгүй зүйлээс эхлэн сэтгэлгээгээ өөрчилж хамт олноо манлайлан төрийн үйлчилгээнд ахиц, хөгжлийг би болгох сэдлийг бий болгосон үр дүнтэй сургалт болсон... Хавсралт : 3 файл			
	325		2.5.. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх;	Төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг баримтлан ажиллаж, төрийн байгууллагуудын бүтээмж, чадавхыг сайжруулахад мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. 2025 онд 46 байгууллагын 70 төрийн албаны удирдах болон гүйцэтгэх сул албан тушаалын захиалгыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжид нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд 15 төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн томилсон. Шилжүүлэх зараар нөхөгдөөгүй 55 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн тусгай шалгалтыг зохион байгуулснаар 39 сул орон тоо нөхөгдсөн бол 16 төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөгдөөгүй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	326		2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар	Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу төсвийн байгууллагуудад шаардлагагүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах үүрэг чиглэлийг өгч, орон нутгийн төсвийн байгууллагуудад гадаад томилолтын зардлыг хянаж олгоогүй ба төсвийн урсгал зардлыг хязгаарлалттай олгож, шаардлагагүй худалдан	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах.	авалт хийх боломж нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад анхааран ажиллаж байна.			
	327		3.2.. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох;	Ерөнхий сайдын болон Засгийн газрын албан даалгаврыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллаж, хэрэгжилтийг сар бүр Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнаж байгаа ба 2025 оны байдлаар 93.2 хувийн хэрэгжилттэй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	328		3.3.. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх.	Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Медикал эмнэлгийг “Хойд бүсийн Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв” болгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, “Хойд бүсийн Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төвийн нээлтийг хийсэн талаар төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, хавдрын оношилгоо, эмчилгээний хүртээмж нэмэгдэх болон үйлчилгээний шуурхай байдал хангагдах боломж бүрдэж байгаа талаар сурталчилсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
180	329	Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар 2025-07-08 Дугаар 2025_03	1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх	Төрийн байгууллага, төрийн албан хаагчдад төрийн албаны шинэтгэл, төрийн албаны тухай хууль, тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд төрийн байгууллагуудад хүнд суртал, шат дамжлагыг бууруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлж, шат дамжлагыг багасгах зорилгоор цахим үйлчилгээг нэмэгдүүлэх талаар сүүлийн жилүүдэд жил бүр орон нутгийн	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				төсөвт шаардлагатай төсвийг тусган ажилласнаар аймгийн хэмжээнд 3 Цахим төвийг шинээр ашиглалтад оруулж төрийн 215 үйлчилгээг 24/7 цагийн турш үзүүлж байна. "Цахим төв"-өөс иргэн, хуулийн этгээд 16 төрлийн 37 үйлчилгээ, "E-Mongolia"- Цахим үйлчилгээний нэгдсэн ХУР-ДАН системээс 73 төрлийн үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтсийн киоск машинаас 9 төрлийн 72 үйлчилгээг үзүүлэх төдийгүй арилжааны банкнуудын АТМ машинуудыг байршуулан ажиллуулж байна. 2025 онд аймгийн хэмжээнд ажиллаж буй Хурдан төвүүдээс нийт 35030 иргэн, төрийн үйлчилгээний цахим төвөөр 78550 иргэн үйлчлүүлж үйлчилгээ авсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд "Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах"-70353511 дугаарын утсыг ажиллуулан тус төвд утсаар болон биечлэн, www.irgen.erdenet.mn цахимаар иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэн шийдвэрлэлтийн мэдээллийг 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа нь иргэд өргөдөл, гомдлоо цаг хугацаа, орон зайны хязгаарлалтаас үл хамааран гаргах боломжийг бүрдүүлсэн. Хавсралт : 1 файл			
	330		1.2. харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх	Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах чиглэлээр үүрэг даалгаврыг өгч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн байгууллагууд бичиг хэргийн үйл ажиллагааг цахимаар үйлдэж бичиг хэргийн зардлыг хэмнэх, шаардлагагүй худалдан авалтыг зогсоох, салбар дундын сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах зэргээр төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор 2025 онд "Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Жаргалант сумын ЗДТГ-ын албан хаагчдын ажил, албан үүргийн оновчтой хуваарилалтыг хийх зорилгоор чиг үүргийн шинжилгээ хийж 44 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөх, 5 албан тушаалын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				тодорхойлолтын төслийг шинээр, тус тус хянуулан батлах зөвшөөрлийг хүсэж Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн ба одоогийн байдлаар аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар болон сумдын ЗДТГ-ын нийтлэг 12 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөн боловсруулж батлан мөрдөн ажиллаж байна. Хавсралт : 2 файл			
	331		1.3. Зарим чиг үүрэг, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар бодитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээг авч жил бүр шаардлагатай төсвийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд ТББ-уудтай гэрээ байгуулан ажиллахад 60.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс тус бүрээр хуваарь батлуулан гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 18 ТББ-тай гэрээ байгуулан хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хувь хүний хөгжил, мониторинг, сургалт мэдээлэл, иргэдийн нийгмийн оролцоо болон хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг 10 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж нийт 60.0 сая төгрөг зарцуулаад байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	332		1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	Төрийн албаны тогтвортой байдлыг хангах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах зорилгоор төрийн албан хаагчийнг томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг баримтлан ажиллаж, төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бүх шатны байгууллагуудад тогтвортой байдлыг ханган салбарын удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн, ажиллагсадтай байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ тухайн албан хаагчийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний хүртээмж, чанарыг харгалзан дүгнэж байх, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах талаар	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллаж байна. 2025 онд 46 байгууллагын 70 төрийн албаны удирдах болон гүйцэтгэх сул албан тушаалын захиалгыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжид нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн байгууллага, нэгж хооронд 15 төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн томилсон. Шилжүүлэх зараар нөхөгдөөгүй 55 сул орон тооны захиалгыг ТАЗ-д хүргүүлэн тусгай шалгалтыг зохион байгуулснаар 39 сул орон тоо нөхөгдсөн бол 16 төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөгдөөгүй байна.Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчиддаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлсэн байна. Хавсралт : 4 файл			
	333		1.5. Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх	Төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг баримтлан ажиллаж, төрийн байгууллагуудын бүтээмж, чадавхыг сайжруулахад мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна. 2025 онд 46 байгууллагын 70 төрийн албаны удирдах болон гүйцэтгэх сул албан тушаалын захиалгыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжид нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд 15 төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн томилсон. Шилжүүлэх зараар нөхөгдөөгүй 55 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн тусгай шалгалтыг зохион байгуулснаар 39 сул орон тоо нөхөгдсөн бол 16 төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөгдөөгүй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	334		1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах	Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу төсвийн байгууллагуудад шаардлагагүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллах үүрэг чиглэлийг өгч, орон нутгийн төсвийн байгууллагуудад гадаад томилолтын зардлыг хянаж олгоогүй ба төсвийн урсгал зардлыг хязгаарлалттай олгож, шаардлагагүй худалдан авалт хийх боломж нөхцөлийг бүрдүүлэхгүй байхад анхааран ажиллаж байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	335		2.1. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу албаны нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил болгох	Төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох яам Тамгын газраас аймгийн ЗДТГ-т ирүүлсэн Төрийн болон албаны нууцад хамаарах албан бичгийг тухай бүрт журмын дагуу бүртгэж ажиллаж байгаа бөгөөд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу хугацаа дуусаагүй тул мэдээллийг одоогоор ил болгоогүй байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг нууцад аваагүй, нийтэд ил байгаа болно.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	336		2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах	Аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/104 тоот тушаалаар мэдээлэл хариуцагч тус бүрийг томилон хэрэгжүүлэлт дээр тогтмол хяналт тавин ажиллаж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нийтэд нээлттэй ил тод байх мэдээллүүдийг "Shilen.gov.mn" 2.0 системд хуваарийн дагуу тухай бүр байршуулан ажиллаж байна. Төрийн байгууллагууд ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан https://shilen.gov.mn-д холбох нөхцөл боломжийг бүрдүүлэн 68 заалтын 114 нээлттэй мэдээллийг шууд холбоосоор тусгаж мэдээлэл авах бүх боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 114 байгууллага Шилэн индексийн үнэлгээнд хамрагдахаас 2025 оны III улирлын байдлаар 20 байгууллага мэдээллээ бүрэн оруулж үнэлгээ хийлгээгүй, 94 байгууллага хуульд заасан мэдээллээ оруулж үнэлүүлснээр үнэлгээний дундаж 77.8 хувьтай байна.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой үнэн зөв, бүрэн байх, нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Орхон аймгийн ЗДТГ-ын цахим хуудас нь мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан лизенцтэй программ хангамжтай, системийн хэвийн, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Мөн жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулан ажиллаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хяналт, шалгалтын нэг үзүүлэлт болгон шалгаж зөвлөгөө, мэдээллээр ханган, хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.			
	337		2.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж үйл	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Өмгөөллийн “Миранда Партнерс” хуулийн фирмтэй хамтран Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар болон багуудын ажлын албаны нийт 250 албан хаагчид авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас 2025 оны 06 дугаар сард зохион байгуулсан цахим сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын дарга, албан хаагчдыг хамруулсан. Аймгийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг төрийн байгууллагуудад өгч арга зүйн удирдлагаар ханган 72 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 305 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчиддаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			ажиллагааг нь идэвхжүүлэх	мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан, аян зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлсэн байна. Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооны 2 гишүүнийг Удирдлагын академид ёс зүйн чиглэлийн сургалтад хамруулж чадавхжуулсан. Мөн “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт: сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 14 байгууллагын 55 албан хаагчийг хамруулж, хэвшмэл сэтгэлгээгээ өөрчилж хөгжихүйн сэтгэлгээтэй болсноор жижиг гэхгүй зүйлээс эхлэн сэтгэлгээгээ өөрчилж хамт олноо манлайлан төрийн үйлчилгээнд ахиц, хөгжлийг би болгох сэдлийг бий болгосон үр дүнтэй сургалт болсон... Хавсралт : 3 файл			
	338		3.1. Улс, аймаг, сумын баяр наадам, тэмдэглэлт ой, бүх нийтийн амралтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, зам тээврийн осол аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагын удирдлага, зохицуулалт, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэг, туслалцаатайгаар хэрэгжүүлэх	Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын А/88 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагууд тохиолдол удирдлагын тогтолцоонд шилжиж, салбар дундын уялдаа холбоог ханган, эрсдэлийн үеийн мэдээллийг шуурхай солилцон, өвчлөл, тархалт, нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээг 6 удаа хийж, хариу арга хэмжээний хэрэгжилт 95.6% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.2%-иар нэмэгдсэн. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр дагуу 131.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2000 ширхэг түргэвчилсэн оношлуур, 7 төрлийн багаж тоног төхөөрөмж, N95 амны хаалт 1000 ширхгийг ЭМБ-уудад хуваарилан томуугийн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлсэн. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан салбар дундын ажлын хэсэг, Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, эрсдэлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж, ажиллаж байна. Тайлант онд Улаанбурхан өвчний сэжигтэй 86 тохиолдол бүртгэгдэж, 66 тохиолдол батлагдаж, сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьталд тандалт судалгаа хийж, голомтын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				дархлаажуулалтад хамрагдвал зохих хүн амын 96.9 хувийг хамруулан хариу арга хэмжээг авч ажилласнаар 9 сараас хойш улаан бурхан өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй байна. ЭМГ-ын гамшгийн нөөц нь 1 нэр төрлийн 4.8 сая төгрөгийн эм, 5 төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, 4.6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27.0 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй байна. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 91.0%, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 94%-тай байна. Хавсралт : 2 файл			
	339		3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, намрын ургац хураалтын бэлтгэлийг хангах, бусад аймаг, сумдаас ирэх отор нүүдлийг Засгийн газраас тогтоосон маршрутын дагуу мэргэжлийн байгууллагын хорио цээр, хяналт шалгалтын дор хэрэгжүүлэх, отроор өвөлжүүлэх, хаваржуулах ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулахад анхаарч ажиллах	Орхон аймгийн 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн аюулгүйн нөөцөд нийт 166 тн бүдүүн тэжээл, 144 тн хүчит тэжээл бэлтгэхээс 190 тн өвс, 112.5 үйлдвэрийн тэжээлийг, аймгийн Онцгой комиссын хурлаар 60тн өвс, 70тн үйлдвэрийн тэжээлийг нэмэлтээр тус тус бэлтгэсэн. 2024 оны аюулгүйн нөөцөөс үлдэгдэл 130 тн өвс, 87.5 тн тэжээлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж “Аюулгүйн нөөцийг хадгалах хамгаалах журам”-ын дагуу малын тэжээлийг ус чийг авч хөгц үүсэхээс сэргийлсэн агуулахад хадгалж, өвсийг галын аюулгүй байдлын дүрмийн дагуу хурааж хадгалан бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан. Намрын ургац хураалтад 12 комбайн, 11 хадагч /жатка/, 7 будаа цэвэрлэгч, 6 үр сортлогч, 6 будаа ачигч, 1 төмсний комбайн, 8 төмс, хүнсний ногоо ухагч, 2 төмс сортлогч, 3 баталгаажуулсан электрон авто машины жин, 1 механикжсан үтрэм, 11000 м2 талбай бүхий энгийн 5 үтрэм, 6700 тонн багтаамжтай 8 агуулах, 7628 тонн багтаамжтай 167 зоорь ажиллахаар бэлэн байдлыг хангасан. Мөн Жаргалант сумын Агро үйлчилгээний төвийн 5 трактор, 10ш ХАА-н чиргүүл, дүүжин машин, нийт 15 техникийг ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд бэлтгэл ханган ажиллууллаа. Жаргалант сумын 500 тонн ногоо хадгалах зоорины тохируулга, туршилт хийгдэж одоогийн байдлаар 37 иргэний	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				230 тн төмс, хүнсний ногоо хүлээн авч хадгалж байна. Аймгийн хэмжээнд газар тариалангийн салбарт 13 аж ахуйн нэгж, байгууллага, 272 өрх үйл ажиллагаа явуулж 5691 га талбайд тариалалт хийж, 3719 га-аас 10850 тонн буюу 30.0 ц/га үр тариа, 598 га-аас 1007 тонн тэжээлийн ургамал, 746 га-аас 750 тонн тосны ургамал, 165 га-аас 1959 тонн төмс, 463 га-аас 11894 тонн хүнсний ногоо хураан авч, ургац хураалт 100 хувьтай байна. 2025 онд Мал эмнэлгийн цахим системд нийт 1365 гэрчилгээ бичигдсэнээс малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 987, амьд малын шилжилт хөдөлгөөнд 378 цахим гарал үүслийн гэрчилгээ олгосон. Хавсралт : 2 файл			
	340		3.3. аймгийн төв, хүн ам төвлөрсөн томоохон сум, суурин газрын иргэдийн орон сууц төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагуудыг цахилгаан, эрчим хүч,% дулаан усаар найдвартай хангах, ирэгдийг ая, тухтай өвөлжүүлэх, 2025-2026 оны өвөлжилтийн үеэр гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	Орхон аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/33 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Орхон аймгийн дэд бүтцийн чиглэлээр хэрэгжүүлэх “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажил”-ын төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд хотын инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагаанд чиглэсэн хөрөнгө оруулалтын ажлууд, хангагч байгууллага буюу “ЭБЦТС” ТӨХК, “ЭДЦС” ТӨХК, “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК компаниудын урсгал их засварын ажлууд мөн Баян-Өндөр, Жаргалант сумдын иргэдийг түлээ түлшний модоор хангах ажил гэх мэт иргэдийг ая тухтай өвөлжүүлэхэд чиглэсэн 42 нэр төрлийн багц ажлыг төлөвлөгөөнд тусгасан. Төлөвлөгөөний хэрэгжилт 96.0 хувьтай байна. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд болзошгүй аваарын зардлаас 5.1 тэрбум төгрөгийг зарцуулан нэмэлтээр Гэр хорооллын 12000 орчим айл өрхийн ундны усны хангамжийн эх үүсвэрийг цахилгаан эрчим хүчээр хангадаг Бүрэнбүст багт байрлах АТП 37,38, 39 дүгээр дэд станцуудын 6кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурт намгийн хамгаалалт хийх, Зэст багийн 6/0.4кВ-ын ТП-215, ТП-216 дэд станц, Оюут багт байрлах 6/0.4кВ-ын ТП-217, ТП-218 дэд станцын 0.4кВ-ын хуваарилах байгууламжийн шүүгээг буулгаж, шинээр суурилуулж засварлах, Хүрэнбулаг багийн 11Б хэсэгт байрлах 6/0.4кВ-ын ТП-275 дэд станцын трансформаторыг буулгаж, шинээр суурилуулан, 0.4кВ-ын хуваарилах байгууламжийн засварлах, Их залуу багт байрлах 6/0.4кВ-ын	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				АТП-74 дэд станцыг буулгаж, шинэчлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ. Мөн орон нутгийн төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянцагаан багийн ПДУ, Говил багийн Илгээлтийн хэсгийн инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 2025-2026 оны өвөл манай аймагт отроор өвөлжих малчин өрх бүртгэгдээгүй байна. Хавсралт : 1 файл			
	341		3.4. Өсвөр насны хүүхдүүдийн дунд гарч байгаа улаанбурхан өвчний дэгдэлтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд бууруулах, хяналтад авах өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах	Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ авах, дэгдэлтийг хязгаарлах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/586, 2025 оны А/523 тоот захирамжуудаар ажлын хэсэг байгуулж салбар дундын уялдаа холбоог ханган ажиллаж, Улаанбурхан өвчний эсрэг хариу арга хэмжээг зохион үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан 2025 оны орон нутгийн төсөвт 30.0 сая, Онцгой комиссын зардлаас 100.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж БОЭТ-ийн Халдвартын тасагт шаардлагатай амьсгалын аппарат, СПАП аппарат, монитор зэрэг 6 тоног төхөөрөмжийг авч улаанбурхан өвчний тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангасан. Тайлант хугацаанд эрсдэлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж ажилласан. Эрсдэлийн үнэлгээгээр улаан бурхан өвчин өндөр эрсдэлтэй (3.8 оноо, улбар шар түвшин) үнэлэгдсэн үед үе шатанд тохирсон хариу арга хэмжээг авч ажилласан. Зайлшгүй шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр гарган, үнэлгээ өгч, ЭМЯ-наас зохион байгуулсан 2 удаагийн хурал, 7 удаагийн цахим сургалтад 376 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажилласан. Голомтын дархлаажуулалтад 210 хүн тун, товлолын дархлаажуулалтад 1560 хүн тун улаанбурхан, улаануудын эсрэг вакцин татан авч, нөөц бүрдүүлсэн. Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад 2687 хүүхдийг хамруулах болон цахим бүртгэлд нөхөн бүртгэснээр дархлаажуулалт 72	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хувьтай байна. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Цагдаагийн газрын удирдлагууд болон асуудал хариуцсан мэргэжилтэн, сум, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагуудын шуурхай удирдлагын багийн гишүүд зэрэг нийт 100 гаруй хүнийг хамруулж чадавхжуулах ажлыг хийсэн. ... Хавсралт : 2 файл			
	342		3.5. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл, сургууль, цэцэрлэгийн бэлэн байдлыг хангах, засварыг цаг тухайд нь хийж дуусгах, багшлах боловсон хүчний хангалтыг хэвийн болгох	Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны А/689, А/718 захирамжуудаар орон нутгийн төсвөөс 15.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 цэцэрлэг, 15 сургуулийн сантехникийн шугам, дээвэр, цонх, хаяавч, дулаалгын нийт 60 ажилд урсгал засварын ажлыг хийж бүх сургууль цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн орон нутгийн төсвийн 282.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 дугаар сургуулийн гал тогооны өргөтгөлийг барьж ашиглалтад оруулснаар тус сургуулийн 1600 гаруй хүүхэд стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байраар үйлчлүүлэх боломж бүрдсэн. Аймгийн хэмжээнд 2025-2026 оны хичээлийн жилд 38 цэцэрлэгийн 310 бүлэгт 8698 хүүхэд хамрагдаж 1 багшид ногдох хүүхдийн тоо 26.5 байна. Ерөнхий боловсролын сургуульд 830 бүлэгт 27855 сурагч хичээллэж байна. Үүнээс 1 дүгээр ангид 2649 хүүхэд элсэн суралцаж, бүлэг дүүргэлт 0.3 пунктээр буурч, бага ангийн нэг багшид 35.8 хүүхэд ноогдож байна. Хичээлийн шинэ жил эхлэхэд аймгийн хэмжээнд цэцэрлэгт 45 багш, мэргэжилтний сул орон тоо гарснаас 39 орон тоо нөхөгдөж, 2 цэцэрлэгт дуу хөгжмийн багш дутуу байна. Ерөнхий боловсролын сургуульд 92 багшийн сул орон тоо гарснаас 80 орон тоо нөхөгдөж, бага анги, биологи, физик, эрэгтэй технологи, математик, хими, дуу хөгжим бассейны 12 багшийн сул орон тоо нөхөгдөөгүй тул тэтгэвэрт гарсан 9, цагийн багш 2, хабрид ажлын байранд 4 багшийг ажиллуулан багшийн дутагдлыг нөхөн ажиллуулж байна. Энэ хичээлийн жилд шинээр төгсөж ирсэн болон Улаанбаатар хот, орон нутгаас Орхон аймагт шилжин ирж	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				ажиллаж буй 50 багшийг аймгийн Засаг дарга хүлээн авч уулзан цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах талаар уулзалт, ярилцлага зохион байгуулж, багш нарт гарын бэлэг, ажлын байранд шаардлагатай төхөөрөмж гардуулсан. Аймгийн хэмжээнд төрийн өмчийн бүх сургуульд үдийн хоолны нэгдсэн цэс гарган 7 хоногт 1 өдөр халуун боловсруулалттай цагаан хоол, бусад өдөрт боловсруулалттай махан хоолоор үйлчилснээр хоолны дундаж илчлэг 550-610 ккал байна Хавсралт : 1 файл			
	343		4.1. Ажлын байр шинээр бий болгоход шаардлагатай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжиж, хүнд суртал, шат дамжлагыг халах, хөрөнгө оруулагчдад саад, дарамт, учруулж байгаа этгээдүүдэд хууль, журмын дагуу хариуцлага тооцож ахжиллах	Орхон аймагт шинээр үйл ажиллагаагаа өргөжүүлж гадаад дотоодын ажиллах хүчин авч ажиллуулах аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хүлээн авч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд байршуулан, мэдээллийн санд бүртгэлтэй ажил хайгч иргэдтэй холбон зуучилж ажлын байрны захиалгыг иргэдэд сурталчлан танилцуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн цахим мэдээллийн нэгдсэн сан Ejob платформд 617 иргэнийг ажил хайгчаар, 365 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 1963 ажлын байрны захиалга бүртгэж, 1127 байнгын болон түр ажлын байранд ажил хайгч иргэдийг ажилд зуучилж мэдээллийн сан, бүртгэлд хамруулсан. Үүнээс 1046 нь шинэ ажлын байранд ажилд орсон байна. Орон нутагт зарлагдсан Эрдэнэт үйлдвэрийн болон бусад компаниудын дэд бүтэц, бүтээн байгуулалтын тендерт оролцох материал бүрдүүлсэн 15 аж ахуйн нэгж, байгууллагын 181 иргэнийг түр ажлын байраар хангах хүсэлтэд аймгийн ХХҮГ хамтран ажиллах гэрээ байгуулж, холбогдох тодорхойлолтыг гарган өгч хамтран ажиллаж байна. Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үерийн далан, суваг барих ажилд ажиллах хүчийг орон нутгаас ажилуулж байна. Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд нөөц газраар тусгагдсан 313 га газарт ШУТП-ыг түшиглэн хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний үйлдвэрүүдийн салбар үйлдвэрлэл байгуулахаар төлөвлөн хүнсний томоохон үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэхээр төлөвлөж байна.	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	Удаашралтай / эрчимжүүлэх шаардлагатай - 50%	

				Хавсралт : 1 файл			
	344		4.2. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ бус нутгийн эдийн засгийн хөгжлийн онцлог, нөөц боломж, давуу талыг харгалзан үзэх	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хойд бүсийн хөгжилд орон нутгийн оролцоо” бүлгийн хүрээнд 7 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. “Орхон аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г ИТХ-ын ээлжит бус VII хуралдаанаар батлаж, төлөвлөгөөнд Хойд бүсийн хөгжилд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Хойд бүсийн Сургалт-Эрдэм, шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор төслийн хэрэгжилтийг хангах, Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг батлуулах, Булган аймагтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж хэрэгжилтийг хангах, зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар барих болон Орхон аймагт Эрүүл мэнд, спортын аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан. “Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулахдаа Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд орон нутгийн онцлогт тулгуурлан Үйлдвэр, технологийн паркийг хөгжүүлэх, Хойд бүсийн тээвэр, логистикийн сүлжээг өргөтгөх, Эрэлттэй мэргэжлийг бүс орон нутагтаа бэлтгэх гэсэн хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж үйл ажиллагааг төлөвлөлөө. Хавсралт : 1 файл	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	
	345		4.3. Түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх замаар орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн нутаг дэвсгэрт орших 28 газрын 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг хулгайн гэмт хэрэг зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн хяналт, оролцоог сайжруулах зорилгоор сумдын Засаг дарга нар, 20 малчин өрхтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах гурвалсан гэрээ байгуулан ажилласан. Гэрээ байгуулан ажиллаж буй өрх бүрд тус бүр 400.0 мянган төгрөгийн урамшуулалд нийт 8.0 сая, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудад мэргэжлийн байгууллагаас хяналт тавих зардалд 2.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус зарцуулсан.	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	346		4.4. Ажилтны мэдлэг, боловсролын түвшин мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Монголын Хүний нөөцийн менежментийн холбооны дэргэдэх хувийн хөдөлмөрийн биржтэй хамтран захиргааны 4-р байранд JOB CENTER төвийг нээн 2025 оны 9 сарын 1-нээс үйл ажиллагааг эхлүүлж дараах үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Үүнд: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 220 иргэнд, бүлгийн зөвлөгөөг 573 иргэнд өгсөн. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд 1753 иргэнийг хамруулан хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах зөвлөгөөг 1161 иргэнд өгсөн. Хүн ам, хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгээс зохион байгуулж буй танхимын мэргэжил олгох сургалтыг Орхон Политехникийн коллежтой хамтран зохион байгуулж 5 мэргэжлээр 64 иргэнийг, ур чадварын цахим сургалтад 13 мэргэжлээр 128 иргэнийг тус тус хамруулахаар бүртгэлийг хийж SURGALT.GOV.MN цахим системд баталгаажуулсан. Хүн ам, хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгээс эрх авсан “Эм эс девелопмент консалтинг” ХХК-ний сургалтын төвтэй хамтран санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 130, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэнийг төсөл бичих, бизнесээ хөгжүүлэх 1-2 өдрийн сургалтад нийт 170 иргэнийг хамруулж, сургалтын зардалд 7.6 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг Орхон аймаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төвийн захиалгаар “Уран зангилаа” ХХК-ний дэргэдэх “Уран гар” сургалтын төвтэй хамтран гар урлал мэргэжлээр 9 иргэнийг сургалтад хамруулж, сургалтын зардалд 4.4 сая төгрөг, хоол унааны зардалд 1.6 сая төгрөг нийт 6.0 төгрөгийг ХЭДСангаас зарцуулсан. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд эмэгтэйчүүдэд зориулсан “Ур чадварын цахим сургалт”-ыг бүртгэл тооцоо хөтлөх нягтлан бодох мэргэжлийн чиглэлээр 15 иргэн, гар урлал мэргэжлийн чиглэлээр 15 иргэнийг тус тус сургалтад хамруулсан. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	347		4.5. Хөдөлмөр эрхлээгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэлтийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч, хөдөлмөрийн статистикийн тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанарыг сайжруулж, ажиллах хүчний болон ажлын байрны судалгааг боловсронгүй болгох ажлыг зохион байгуулах	Хөдөлмөр эрхлээгүй иргэд, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн мэдээлэл судалгааг бүртгэлжүүлэх, идэвхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн цахим мэдээллийн сан болох Ejob платформын талаарх мэдээллийг сурталчлах зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сангийн талаар ойлголт мэдээллийг багуудын ажлын албаар дамжуулан ААНБ, иргэдэд өгөх, уулзалт зохион байгуулах, байгууллагуудын пэйж хуудсаар мэдээлэл зөвлөгөөг өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласнаар 2025 онд 365 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчээс 1963 ажлын байрны захиалга хүлээн авч 1127 байнгын болон түр ажлын байранд ажил хайгч иргэдийг ажилд зуучилж мэдээллийн сан, бүртгэлд хамруулсан. Үүнээс 1046 нь шинэ ажлын байранд ажилд орсон байна. Хөдөлмөрийн зах зээлийн цахим мэдээллийн сан болох Ejob платформд 2025 онд 617 иргэн ажил хайгчаар шинээр бүртгүүлсэн байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний JOB CENTER -ийг “Монголын хүний нөөцийн менежментийн холбоо” НҮТББ-ын дэргэдэх хөдөлмөрийн хувийн биржтэй хамтарч шинээр нээж иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлсэн. Тус үйлчилгээний төвтэй хамтран ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа иргэдэд зориулж ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг Баян-өндөр, Жаргалант сумын 20 багийн 14 бүлгийн 400 гаруй иргэнийг хамруулан зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/225 дугаар захирамжаар Орхон аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн тоон болон чанарын судалгаа зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, орон нутгийн төсвөөс 48.0 сая төгрөгийг зарцуулан мэргэжлийн судалгааны байгууллагуудтай хамтран 3 сарын хугацаанд судалгааг хийж хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн төлөв байдал, 2035 он хүртэлх зах зээлд эрэлттэй ажил мэргэжлийг тодорхойлж нийтэд мэдээлсэн. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

	348		5. Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, биелэлтэд нь хяналт тавьж явц үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай.	Ерөнхий сайдын болон Засгийн газрын албан даалгаврыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллаж, хэрэгжилтийг сар бүр Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнаж байгаа ба 2025 оны байдлаар 93.2 хувийн хэрэгжилттэй байна. Хавсралт : 1 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
181	349	ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04	1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн	Засгийн газрын 04 дүгээр албан даалгавар гарсантай холбогдуулан төрийн байгууллагуудад төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй чиглэлийг төрийн байгууллагуудад өгч ажиллаж байна. Одоогийн байдлаар Эрүүл мэндийн газарт 3, Сэлэнгэ голын сав газрын захиргаанд 1, Биеийн тамир спортын газарт 3, Мал эмнэлгийн газарт 1, Нийгмийн даатгалын газарт 4, Стандарт хэмжил зүйн хэлтэст 2, Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 5, Хүнс хөдөө аж ахуйн газарт 2, Ус цаг уур орчны шинжилгээний газарт 4, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 10, нийт 35 орон тоог хасах чиглэл дээд шатны байгууллагаас ирсэн тул албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах чиглэлээр ажлын байрны шинжилгээ хийж байна. 2025 оны 07 дугаар сараас төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан тушаалтны сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байх чиглэлийн дагуу сул орон тоог нөхөх арга хэмжээг зохион байгуулах үйл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			нэгж, байгууллагын удирдлагуудад;	ажиллагааг түр зогсоосон. Тайлант хугацаанд өндөр насны тэтгэвэрт гарсны улмаас 4 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсныг нөхөөгүй, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 5 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж нөхсөн.			
	350		1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг төрийн байгууллагуудад өгч арга зүйн удирдлагаар ханган 72 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 305 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг Орхон аймагт зохион байгуулах үеэр Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах салбар хэлэлцүүлгийг хийн Орхон, Булган, Хөвсгөл аймгийн нийт 100 төрийн албан хаагчийг хамруулсан. Үүнд Орхон аймгаас төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын төлөөлөл болох 30 төрийн албан хаагч болон Ёс зүйн хорооны дарга, ажлын албаны хамт олон оролцож ёс зүйн гомдол мэдээллийг шалган шийдвэрлэх, ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, ёс зүйн цахим санг ашиглах талаар мэдээллээр хангагдсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчдадаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 2-5 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүйн” 1 сарын аяныг зохион байгуулж Баян-Өндөр сумын ЗДТГ-ын албан хаагчдын дунд зурган постер, бичлэгийн уралдаан зохион байгуулж, 15 багаас 20 ширхэг постер 8 видео бичлэгийг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар хийж бэлтгэн түгээсэн. Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн дэд	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

				хорооны 2 гишүүнийг Удирдлагын академид ёс зүйн чиглэлийн сургалтад хамруулж чадавхжуулсан. Хавсралт : 2 файл			
	351		1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг төрийн байгууллагуудад өгч арга зүйн удирдлагаар ханган 72 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 305 албан хаагчид томилогдон ажиллаж байна. Мөн Монгол улсын Ёс зүйн хороотой холбогдож ёс зүйн цахим системд бүртгэлээ үүсгээгүй гэх 23 байгууллагын мэдээлийг авч тухайн байгууллагуудад цахим системд бүртгэл үүсгэн ёс зүйн зөрчлийн мэдээ, хийх ажлын төлөвлөгөө, тайлан зэргийг оруулж ажиллах үүрэг чиглэлийг өгч хяналт тавин ажилласнаар одоогийн байдлаар 8 байгууллага цахим бүртгэлээ үүсгээгүй байна. Монгол улсын Ёс зүйн хорооны 06 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх аргачилал батлагдсантай холбогдуулан аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад тус тогтоолыг хүргүүлэн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын талаар бүх байгууллагад арга зүйн зөвлөмж өгч төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж байна. Хавсралт : 2 файл	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	
	352		1.7.. Төрийн албаны тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт оруулахгүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй	Төрийн албан хаагчийг хууль бусаар чөлөөлөх, халах, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт оруулахгүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байх зарчмыг баримтлан ажиллах, төрийн байгууллагуудын бүтээмж, чадавхыг сайжруулахад мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавин ажиллаж байна. Төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгах	Хэрэгжсэн - 100%	Хэрэгжсэн - 100%	

			байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт;	зорилгоор 2025 онд "Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газар, Жаргалант сумын ЗДТГ-ын албан хаагчдын ажил, албан үүргийн оновчтой хуваарилалтыг хийх зорилгоор чиг үүргийн шинжилгээ хийж 44 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөх, 5 албан тушаалын тодорхойлолтын төслийг шинээр тус тус хянуулан батлах зөвшөөрлийг хүсэж Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн ба одоогийн байдлаар аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар болон сумдын ЗДТГ-ын нийтлэг 12 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөн боловсруулж батлан мөрдөн ажиллаж байна. Хавсралт : 1 файл			
182	353	ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04	1.8.. ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт	Төрийн байгууллагуудад ЗГХЭГаас өгсөн чиглэлийн дагуу одоогийн байдлаар Эрүүл мэндийн газарт 3, Сэлэнгэ голын сав газрын захиргаанд 1, Биеийн тамир спортын газарт 3, Мал эмнэлгийн газарт 1, Нийгмийн даатгалын газарт 4, Стандарт хэмжил зүйн хэлтэст 2, Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 5, Хүнс хөдөө аж ахуйн газарт 2, Ус цаг уур орчны шинжилгээний газарт 4, Бүсийн оношлогоо эмчилгээний төвд 10, нийт 35 орон тоог хасах чиглэл дээд шатны байгууллагаас ирсэн тул албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах чиглэлээр ажлын байрны шинжилгээ хийгдэж байна. Тайлант хугацаанд өндөр насны тэтгэвэрт гарсны улмаас 4 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсныг нөхөөгүй, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 5 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж нөхсөн. Одоогийн байдлаар төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах талаар санал боловсруулаагүй ба цалин хөлс, нийгмийн баталгааны талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээ зохион байгуулагдаагүй байна.	Зохион байгуулалтаас - 0%	Зохион байгуулалтаас - 0%	